



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 19-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-17
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	18-140
<hr/>	
<i>1.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/</i>	<i>18-106</i>
<i>2.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<i>106-110</i>
<i>3.“Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	<i>110-113</i>
<i>4.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.04.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг</i>	<i>113-115</i>
<i>5.“Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.04.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<i>115-140</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
05 дугаар сарын 19-ний өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 73 гишүүнээс 38 гишүүн хүрэлцэн ирж, 52.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 08 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир, Ц.Мөнх-Оргил;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Ё.Баатарбилэг;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Мөнхцэцэг, Д.Өнөрболор, Ц.Цэрэнпунцаг.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Б.Пүрэвдорж нараас албан бичиг ирүүлснийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хэлэлцэж эхлэхэд Улсын Их Хурлын гишүүдийн ирц ирвэл зохих 73 гишүүнээс 59 гишүүн хүрэлцэн ирж, 80.8 хувийн ирцтэй байв.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, мөн газрын Тэргүүн дэд дарга Д.Ганбат, Дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж, мөн газрын Хуулийн багийн ахлах зөвлөх Ч.Ариунхур, Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Дондогмаа, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Ү.Амарбат, Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Ж.Эрхэмбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор Д.Бумдарь, мөн сургуулийн Эдийн засгийн тэнхимийн профессор Н.Ууганбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам нар байлцав.

Төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Х.Болорчулуун, Б.Баттөмөр, Ж.Бат-Эрдэнэ, Г.Тэмүүлэн, Ц.Идэрбат, Ж.Батсуурь, Ц.Туваан, Н.Ганибал, Ш.Адъяаа, Б.Жаргалмаа, О.Цогтгэрэл, Б.Баярсайхан, С.Ганбаатар, С.Чинзориг, Ц.Сандаг-Очир, Б.Пүрэвдорж, П.Анужин, Х.Баделхан, Н.Учрал, Д.Ганбат, Ж.Батжаргал, Д.Цогтбаатар, Ц.Анандбазар, Л.Мөнхбаатар нарын тавьсан асуултад Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд, ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн, ХҮН намын дарга Т.Доржханд, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 13 цаг 08 минутаас 14 цаг 00 минутад хуралдааныг даргалав.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав. /Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн заалт/

Нэг.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй санал:

Г.Занданшатар: 1.Монгол Улсын Үндсэн хуулийн хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“1.Улсын Их Хурал нэг танхимтай байна. Улсын Их Хурлын гишүүдийн далан зургааг мажоритар аргаар, далан зургааг пропорциональ аргаар сонгоно.” гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 63
Бүгд: 66
4.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хоёр.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

2.Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Ш.Адъяаа, Ж.Батсуурь, Т.Доржханд, Х.Нямбаатар, Д.Сарангэрэл, Д.Тогтохсүрэн, О.Цогтгэрэл, Б.Энхбаяр /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, 1.1.Төслийн 1 дүгээр зүйл буюу Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Монгол Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг олныг төлөөлөх болон хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан зургаан гишүүнийг олныг төлөөлөх, тавин гишүүнийг хувь тэнцүүлэн хуваарилах сонгуулийн аргын үндсэн дээр сонгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 61

Татгалзсан: 5
Бүгд: 66
92.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрээр санал хураалт явуулж дууслаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэхдээ Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зарчмыг баримталж, иргэдэд төслийн талаар саналаа чөлөөтэй илэрхийлэх бололцоог олгож, иргэд, улс төрийн нам, олон нийтийн байгууллагын оролцоог хангаж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол мэдээлж ажиллахыг Улсын Их Хурлын нийт гишүүд, Улсын Их Хурлын Тамгын газарт чиглэл болгов.

Уг асуудлыг 16 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, мөн газрын Тэргүүн дэд дарга Д.Ганбат, Дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж, мөн газрын Хуулийн багийн ахлах зөвлөх Ч.Ариунхур, Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Дондогмаа, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Ү.Амарбат, Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Ж.Эрхэмбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор Д.Бумдарь, мөн сургуулийн Эдийн засгийн тэнхимийн профессор Н.Ууганбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам нар байлцав.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлийн тавьсан асуултад Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Ш.Адьяа, Ж.Батсуурь, Т.Доржханд, Х.Нямбаатар, Д.Сарангэрэл, Д.Тогтохсүрэн, О.Цогтгэрэл, Б.Энхбаяр /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Хуулийн төсөлд дараах агуулга бүхий 1 дүгээр зүйл нэмэх:

“**1 дүгээр зүйл.**2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 16.4-т заасны дагуу нийтэлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 7
Бүгд: 65
89.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг 2 дугаар зүйл болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“**2 дугаар зүйл.**2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн Нэгдүгээр зүйлд заасан Улсын Их Хурлын гишүүний тоо Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдсан Улсын Их Хуралд хамаарахгүй.”

Дээрх саналыг хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

3.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн 2 дугаар зүйлийг 3 дугаар зүйл болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“**3 дугаар зүйл.**2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуулийг шинэчлэн батлах хүртэл хугацаанд тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг дагаж мөрдөнө. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг үндэслэн олныг төлөөлөх /мажоритар/, хувь тэнцүүлэн хуваарилах /пропорционал/ тогтолцоог хослуулан явуулах зохицуулалтад Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг Улсын Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 5
Бүгд: 65
92.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төсөлд дараах агуулга бүхий 4 дүгээр зүйл нэмэх:

“**4 дүгээр зүйл.**Энэ хууль Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн нэгэн адил хүчинтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55

Татгалзсан: 10
Бүгд: 65
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 9
Бүгд: 65
86.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: 4.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төсөлд дараах агуулга бүхий 4 дүгээр зүйл нэмэх:

“4 дүгээр зүйл.Энэ хууль Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн нэгэн адил хүчинтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 6
Бүгд: 65
90.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг 5 дугаар зүйл болгон өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 4
Бүгд: 65
93.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, мөн газрын Тэргүүн дэд дарга Д.Ганбат, Дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж, мөн газрын Хуулийн багийн ахлах

зөвлөх Ч.Ариунхур, Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Дондогмаа, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Ү.Амарбат, Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Ж.Эрхэмбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор Д.Бумдарь, мөн сургуулийн Эдийн засгийн тэнхимийн профессор Н.Ууганбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам нар байлцав.

Төслийг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Адъяасүрэн танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	60
Татгалзсан:	5
Бүгд:	65

92.3 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./16:22/

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.04.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимэдсүрэн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн газрын дарга Л.Энх-Амгалан, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Бад.Баярмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал:

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн Эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн 8-д тусгагдсан Засгийн газрын өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2024-2026 онд “60” гэснийг “51” гэж тус тус өөрчлөх. Үүнтэй нийцүүлэн Засгийн газрын өрийн нийт хэмжээний 2024-2026 оны мөнгөн дүнг тус тус бууруулах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн:	39
Татгалзсан:	25
Бүгд:	64

60.9 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Тав. “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.04.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй,

хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир спортын Үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Соёлын дэд сайд М.Батбаяр, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Цогтгэрэл, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга О.Цолмон, Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ч.Гандирваа, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын дарга Л.Балчинлуvsан, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хилийн боомтын хөгжил, чөлөөт бүсийн бодлогын газрын дарга Х.Эрдэнэбулган, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Хөгжлийн судалгааны газрын дарга Л.Эрдэнэбаяр, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Д.Очирваань, Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга И.Батхүү, Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, мөн газрын Хөгжлийн загвар, шинэтгэлийн хэлтсийн дарга Г.Нямцэцэг, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимэдсүрэн, мөн газрын Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Сандагсүрэн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга М.Мэндбаяр, мөн яамны Дэд бүтцийн хөгжлийн хэлтсийн дарга С.Сүхбат, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнгөншагай, мөн газрын Эдийн засгийн хөгжил, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга Д.Алтангэрэл, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Улс, нийслэлийн хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн С.Ариунцэцэг, Замын бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Б.Энхмандах, Нийгмийн бодлогын хэлтсийн Боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэн Г.Гүррагчаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл, М.Оюунчимэг, Ц.Туваан, Н.Наранбаатар, Д.Батлут, Х.Баделхан, Б.Бейсен, Б.Баярсайхан нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга М.Мэндбаяр, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын дарга Л.Балчинлуvsан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням үг хэлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 16 цаг 52 минутаас 18 цаг 12 минутад хуралдааныг даргалав.

“Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Т.Доржханд, Д.Өнөрболор, О.Цогтгэрэл, С.Чинзориг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Тогтоолын төслийн 2, 3, 4 дүгээр заалтыг 2 дугаар заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд туссан улсын төсвийн эх үүсвэрээр санхүүжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгах;

2/Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд төр, хувийн хэвшлийн түншлэл болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр тусгасан төсөл, арга хэмжээнд шаардагдах бэлтгэл хангаж ажиллах;

3/Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс жигд ханган зохион байгуулж, түүний биелэлтийг бүтэн жилээр гаргаж, Улсын Их Хуралд танилцуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27

Татгалзсан: 12

Бүгд: 39

69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төсөлд доор дурдсан агуулгатай 3 дахь заалт нэмэх:

“3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ц.Цэрэнпунцаг/-нд даалгасугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30

Татгалзсан: 8

Бүгд: 38

78.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын Монгол Улсын 2024 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн ерөнхий зүйлийн “төлөвлөж хэрэгжүүлэх,” гэсний дараа “нийлүүлэлтийн гаралтай үнийн өсөлтийг хязгаарлах,” гэж нэмж, мөн зүйлийн “мөнгөний бодлогын тохируулгыг оновчтой хийх,” гэснийг “мөнгөний бодлогыг төсвийн бодлоготой уялдуулах,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 9
Бүгд: 39
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтад “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудын нөөцийг нарийвчлан тогтоож, эдийн засгийн эргэлтэд оруулах замаар Үндэсний баялгийн сангийн тогтолцоог бий болгоно.” гэсэн агуулгатай 2.3 дахь заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 34
Татгалзсан: 8
Бүгд: 42
81.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтад “Гадаргын усны хуримтлалыг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээний судалгаа, шинжилгээний ажлыг эрчимжүүлнэ.” гэсэн агуулгатай 8.1.5 дахь дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 7
Бүгд: 42
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.2.1.1 дэх дэд заалтын “Агаарын геофизикийн 1:200000-ны масштабын судалгааны ажлыг гүйцэтгэх” гэснийг “Орчин үеийн дэвшилтэт технологи ашиглан агаарын геофизикийн цогц судалгааны ажлыг гүйцэтгэх” гэж, мөн шалгуур үзүүлэлтийн “Талбай хамрагдалт” гэснийг “Нислэгт хамрагдсан талбай” гэж, үр дүнгийн үзүүлэлтийн суурь түвшин “66” гэснийг “0” гэж, хүрэх түвшин “100” гэснийг “20” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 34
Татгалзсан: 8
Бүгд: 42
81.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.2.2 дахь заалтын “Зэсийн” гэснийг “Зэс, алт, мөнгөний” гэж өөрчилж, мөн заалтад Төсөл арга хэмжээнд “Хармагтайн зэс, алтны болон Асгатын мөнгөний ордыг ашиглалтад оруулах бэлтгэл ажил хангах” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Зорилтот түвшинд “100” гэж, Хариуцагч байгууллагад “Уул уурхай,

хүнд үйлдвэрийн яам” гэсэн 2.2.2.2 дахь дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 11
Бүгд: 43
74.4 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.2.3.4 дэх дэд заалтын Хариуцагч байгууллагад “Боловсрол, шинжлэх ухааны яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 7
Бүгд: 43
83.7 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.2.3.8 дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээний “парк” гэснийг “паркийн дэд бүтцийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 6
Бүгд: 43
86.0 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.2.3.9 дэх дэд заалтын Зорилтот түвшингийн “80” гэснийг “60” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 7
Бүгд: 43
83.7 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.3.2.5 дахь дэд заалтын Зорилтот түвшингийн “50” гэснийг “100” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 8
Бүгд: 43
81.4 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.1.3.1 дэх дэд заалтын Шалгуур үзүүлэлтэд “Судалгаа хөгжүүлэлтийн ажлын үр дүнд бий болсон бүтээгдэхүүнийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлсэн төсөл” гэж, Хэмжих нэгжид “Тоо” гэж, Суурь түвшинд “20” гэж, Зорилтот түвшинд “50” гэж, Санхүүжилтэд “2,500.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилалд “Улсын төсөв” гэж, Хариуцагч байгууллагад

“Боловсрол, шинжлэх ухааны яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 37

Татгалзсан: 5

Бүгд: 42

88.1 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.1.3.1 дэх дэд заалтын Шалгуур үзүүлэлтэд “Үр дүнд суурилсан өрсөлдөөнт болон тогтмол санхүүжилтээр хийгдсэн Шинжлэх ухаан, технологийн /суурь, хэрэглээний, технологи/ судалгаа хөгжүүлэлтийн ажил” гэж, Хэмжих нэгжид “Тоо” гэж, Суурь түвшинд “350” гэж, Зорилтот түвшинд “450” гэж, Санхүүжилтэд “-” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилалд “Улсын төсөв” гэж, Хариуцагч байгууллагад “Боловсрол, шинжлэх ухааны яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 37

Татгалзсан: 5

Бүгд: 42

88.1 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.3.1.7 дахь дэд заалтын Санхүүжилтэд “62,493.82” гэснийг “19,388.4” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 37

Татгалзсан: 5

Бүгд: 42

88.1 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 7.4.1.2 дахь дэд заалтын Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилалд “Улсын төсөв” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 36

Татгалзсан: 6

Бүгд: 42

85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын 3.1.3 дахь заалтын Шалгуур үзүүлэлтэд “Судалгаа хөгжүүлэлтийн ажилд зарцуулах төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувь” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь онд “2022” гэж, Суурь түвшинд “0.13” гэж, Зорилтот түвшинд “0.2” гэж, Мэдээллийн эх сурвалжийг “Үндэсний статистикийн хороо” гэж, Мэдээлэл цуглуулах арга зүйд “Статистик мэдээ” гэж, Мэдээлэл цуглуулах давтамжид “Жилд нэг удаа” гэж, Хариуцах байгууллагад “Боловсрол, шинжлэх ухааны яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 34

Татгалзсан: 7

Бүгд: 41

82.9 хувийн саналаар дэмжигдлээ.

“Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

17.Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшингийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын Төсөл, арга хэмжээнд “Дорноговь аймгийн Хөвсгөл сумын “Гэрэлт говь” кокс, металлургийн үйлдвэр” үйлдвэрлэл технологийн парк байгуулах” гэж, Бодлогын үндэслэлд “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр-3.2.7.1” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Үр дүнгийн үзүүлэлтэд 2022 он “-” гэж, 2024 он “100” гэж, Санхүүжилтэд “375 тэрбум төгрөг” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилалд “Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт” гэж, Хариуцагч байгууллагад “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам” гэсэн 2.2.3.10 дахь дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 35

Татгалзсан: 6

Бүгд: 41

85.4 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибалын гаргасан, Тогтоолын төслийн 2-р хавсралтын Төсөл, арга хэмжээнд “Баруун-Урт-Сүхбаатар чиглэлийн 61.9 км хатуу хучилттай авто зам, 24 у/м гүүр барих /Сүхбаатар-Баруун-Урт, Сүхбаатар сум/” гэж, Санхүүжилтэд “10 тэрбум төгрөг” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэсэн 4.3.1.20 дахь дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 36

Татгалзсан: 6

Бүгд: 42

85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын Төсөл, арга хэмжээнд “Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилга барих” гэж, Санхүүжилтэд “25 тэрбум төгрөг” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэсэн 3.3.2 дахь заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 34

Татгалзсан: 8

Бүгд: 42

81.0 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын Төсөл, арга хэмжээнд “Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн хот хоорондын А0301 авто замаас Өвөрхангай аймгийн Хужирт сумтай холбох авто зам барих” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшинд “20” хувь гэж, санхүүжилтэд “28 тэрбум төгрөг” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцагч байгууллагад “Зам, тээврийн хөгжлийн яам” гэсэн 4.3.1.20 дахь дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 33

Татгалзсан: 9
Бүгд: 42
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

21. Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, С.Чинзориг нарын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын Төсөл, арга хэмжээнд “Өвөрхангай аймгийн Арвайхээр-Баянгол-Сайхан-Овоо-Мандал-Овоо чиглэлийн хатуу хучилттай авто замын ТЭЗҮ боловсруулах” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, Суурь түвшин “-” гэж, Зорилтот түвшинд “100” хувь гэж, санхүүжилтэд “4 тэрбум төгрөг” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцагч байгууллагад “Зам, тээврийн хөгжлийн яам” гэсэн 4.3.1.21 дэх дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 10
Бүгд: 42
73.8 хувийн саналаар дэмжигдлээ.

22. Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатарын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.3.2 дахь заалтын Төсөл, арга хэмжээнд “Хөвсгөл аймгийн дулааны станцыг 21 мвт-аар өргөтгөх” гэж, Санхүүжилтэд “16 тэрбум төгрөг”, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 8
Бүгд: 41
80.5 хувийн саналаар дэмжигдлээ.

23. Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригийн гаргасан, Тогтоолын төслийн 2-р хавсралтын 3.3.2.2 дахь дэд заалтын “Улсын төсөв” гэснийг “Төр хувийн хэвшлийн түншлэл” гэж, мөн хавсралтын 3.3.2.3 дахь дэд заалтын “Төр хувийн хэвшлийн түншлэл” гэснийг “Улсын төсөв” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 10
Бүгд: 42
76.2 хувийн саналаар дэмжигдлээ.

24. Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн гаргасан, Тогтоолын төслийн 2-р хавсралтын 4.3.1 дэх заалтын Төсөл, арга хэмжээнд “Булган-Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг” чиглэлийн 133.7 км хатуу хучилттай автозамын төгсгөл 67.8 км” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “-” гэж зорилтод түвшинд “50” гэж, Санхүүжилтэд “43,677.1” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилалд “Улсын төсөв” гэж, Хариуцагч байгууллагад “Зам, тээврийн хөгжлийн яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 15
Бүгд: 42
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Г.Занданшатар: 25.Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн гаргасан, Тогтоолын төслийн 2-р хавсралтын 4.3.1.24 дэх дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Улаанбаатар-Шар хөтөл-Эрдэнэт чиглэлийн Төв аймгийн Жаргалант сумын Жаргалантын уулзвараас эхлэлтэй Сэлэнгэ аймгийн Орхон сумын А1001 авто замын Орхон сумын уулзварт төгсөх хатуу хучилттай 100 км авто зам барих” гэж нэмэх, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “-” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Санхүүжилтэд “75.17 тэрбум төгрөг” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Гадаадын зээл” гэж, Хариуцагч байгууллагад “Зам, тээврийн хөгжлийн яам” гэж нэмэх.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар төслийг анхны хэлэлцүүлэгт буцаая гэсэн горимын санал гаргав.

Г.Занданшатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 17

Татгалзсан: 25

Бүгд: 42

40.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

26.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтад “Улс төр, нийгэм, эдийн засаг, бизнесийн бүхий л харилцаа, засаглалын бүх шатанд олон ба гурван талт зөвшилцөл, түншлэл, хяналтын оновчтой, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлж, нэвтрүүлэн хэвшүүлнэ.” гэсэн 7.6 дахь дэд заалт нэмэх;

Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй санал:

1.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.3.1 дэх заалтын Төсөл, арга хэмжээнд “Хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай авто замтай Цэцэг сумыг холбох авто зам барих “32.4 км” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “-” гэж, Зорилтот түвшин “Ажлын гүйцэтгэл” гэж, Санхүүжилтэд “29 тэрбум төгрөг” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцагч байгууллагад “ЗТХЯ” гэж нэмэх;

Найруулгын санал:

1.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “Бодлогын үндэслэл” хэсгийн Алсын Хараа /АХ/, 2.3.2.16 дахь дэд заалтын “3.2.14” гэснийг “6.4.22” гэж, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл /МУХТЖҮЧ/-ийн 2.1.3 дахь заалтын “4.2.2” гэснийг “4.4.3” гэж, мөн 3.1.4.1-3.1.4.5, 3.1.4.7, 3.1.4.8, 3.1.5.1 дэх дэд заалтын “2.1.9” гэснийг “2.1.12” гэж, мөн 4.2.1.1 дэх дэд заалтын “3.6.4” гэснийг “4.2.10” гэж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр /ЗГҮАХ/-ийн 6.2.3 дахь заалтын “4.3.9” гэснийг “3.5.7” гэж, мөн тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын 2.5 дахь заалтын “бүсүүд” гэснийг “бүсүүдийн” гэж, 3.2 дахь заалтын Хэмжих нэгжийн “Хүн” гэснийг “Хувь” гэж, 3.3.2 дахь дэд заалтын шалгуур үзүүлэлтийн “хамралт” гэснийг “хамрагдалт” гэж, 3.3.3 дахь дэд заалтын Зорилтот үр дүнгийн “нэмэгдэнэ” гэснийг “нэмэгдүүлнэ” гэж, Шалгуур үзүүлэлтийн “насныхны” гэснийг “насны” гэж тус тус өөрчлөх;

2.Дээрх зарчмын зөрүүтэй саналууд дэмжигдсэнтэй холбогдуулж нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, хэсэг, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн гэсэн дээрх саналуудыг хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгч, уг саналуудаар санал хураалт явуулаагүй болно.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

“Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Бусад.Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар өнөөдөр төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарт Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн урилгаар Баянзүрх дүүргийн Ерөнхий боловсролын сургуулиудын сэтгэл зүйчид, Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 9 дүгээр ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Х.Булгантуяа, Э.Бат-Амгалан нарын урилгаар Баянзүрх дүүргийн 36 дугаар хорооны иргэдийн төлөөлөл, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Ахлах сургуулийн 12^{а, б, в} ангийн багш, сурагчид, МУИС-ын Шинжлэх ухааны их сургуулийн Улс төр судлалын 4 дүгээр дамжааны оюутны төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын урилгаар Ерөнхий боловсролын “Тэрэлж боардинг” сургуулийн сурагчдын төлөөлөл Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 8 цаг 12 минут үргэлжилж, 73 гишүүнээс 66 гишүүн хүрэлцэн ирж, 90.4 хувийн ирцтэйгээр 18 цаг 20 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр,
Баасан гараг Төрийн ордон “Их
хуралдай” танхим 10 цаг 08 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Таван асуудал хэлэлцэнэ.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл. Хоёр дахь хэлэлцүүлэг.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл. Зарчмын зөрүүтэй 5 саналтай.

Гуравдугаарт, “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Дөрөвдүгээрт, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл. Анхны хэлэлцүүлэг 06 сарын 01-ний дотор батлах ёстой. Хугацаатай асуудал учраас.

“Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Анхны хэлэлцүүлэг.

Энэ хоёр асуудлыг тухайн үеийн нөхцөл байдлаас шалтгаалаад бас хойшлуулах саналыг даргын дэргэдэх

зөвлөлийн гишүүд, Байнгын хорооны зарим дарга нар гаргаж байгаа.

Тэгэхээр үүнийг тухайн үед нь хэлэлцэн шийдвэрлэе.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-д заасны дагуу хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гарах бол 17.00 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Бөхчулууны Пүрэвдорж, Сайнхүүгийн Ганбаатар нараас албан бичиг ирүүлсэн байна.

Б.Пүрэвдорж гишүүн алга байна. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн хэлэлцэх асуудалтай холбогдуулж үг хэлнэ. Хэлэлцэх асуудалтай холбогдуулж үг хэлнэ.

С.Ганбаатар: Эрхэм гишүүд ээ, Та бүхэнд өнөөдөр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой би үг хэлье. Санал хэлье.

Өнөөдөр Улсын Их Хурлын гишүүд бид эрх мэдлээ өөрөө өөртөө эрх мэдэл нэмэх гээд, өөрөө өөртөө сандал, ширээ нэмэх гээд хэлэлцээд шийдвэр гаргах гээд сууж байгаа.

Энэ бол одоо хамгийн ноцтой асуудал. Өөрөө өөртөө. Бидний дур зоргыг хязгаарладаг Үндсэн хуулийг гишгээд ард түмнийхээ эрх ашигт нөлөөлөөд бид сууж байгаа.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай журмын тухай хуулийн 17.1-д Улсын Их Хурал төслийг хэлэлцээд тухайн нэмэлт, өөрчлөлтийг ард нийтийн санал асуулгаар оруулах нь зүйтэй гэж Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар тогтвол гэж үг дээрээ та нар анхаарлаа хандуулаад өгөөч. Тогтвол Улсын Их Хурал тогтоол гаргана гэж заасан байгаа.

Бид энэ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа бид үүнийг зүгээр өөрсдөө хаалгаа хааж байгаад дөрөвний гурваараа шийдчихдэггүй юм шүү.

Ард нийтийн санал асуухаар асуух ёстой шүү. Үүнийг тогтоорой гэж журамласан байна. Заасан байна.

Би өнөөдөр 152 уу, 126 юу. Би тэр тухай ярих гээгүй. Би байр сууриа аль хэзээний эхний хэлэлцүүлэг дээр хэлчихсэн.

Одоо энэ дээр би шийдвэрлэх арга замын талаар ярих гэсэн юм. Монголын ард түмнээс үүнийгээ асуугаач ээ. Бид хаалгаа хааж байгаад дөрөвний гурваар сандал ширээгээ нэмэх тухай шийдвэрлэж болохгүй.

Миний хэлэх гэж байгаа асуулт гэвэл ер нь энэ бол 2019 оны Үндсэн хуулийн өөрчлөлтөд яг энэ асуудал орж ирэхэд харин яг энэ 2019 онд бол Улсын Их Хурал дээр санал асууж байсан юм байна лээ шүү. Ард түмнээсээ асуух уу, танхимаараа шийдэх үү гэж. Яг үүнтэй адилхан нийт гишүүдээс энэ саналыг асууж өгөөч л гэдгийг би санал оруулж байгаа юм.

Хоёр дахь хэлэлцүүлгийн үед Үндсэн хуульд өөрчлөлт оруулах шийдвэр гаргах эрхийг ард нийтийн санал асуулгад өгөх нь зүйтэй гэж эрхэм гишүүдээсээ би гуйж байна.

Үндсэн хуулийн 25.1-д Улсын Их Хурал дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ гэж заасан байгаа. Энд 25.1.1-д хууль батлах нэмэлт, өөрчлөлт оруулах гэсэн байгаа.

Энэ дээр “Үндсэн хууль” гэж үг алга байна шүү. Яг тэр барууныхаа энэ анх гарсан онцлогдоо ч гэсэндээ “конститушн” гэж нэртэй. Үндсэн хуулийг. Хууль бол өөр нэртэй. 76 бол ард иргэдэд зориулж хууль баталдаг. Ард

иргэдэд зориулж бидэнд баталдаг хууль бол Үндсэн хууль. Бидэнд баталдаг хуулийг ард иргэдийнхээ өмнөөс бид гар дүрж оролцох гэж байгаа л гэсэн үг. Үүнийг би хэлэх үүрэгтэй. Итгэл үнэмилээрээ би хэлж байна.

Миний хэлж байгаа болохоор та нар бас үл ойшоож магадгүй. Энэ олон улсын сэтгэгчид бас ярьсан байна. Айн Рэнд /Ayn Rand/-ын үг байна. “Зөвшилцөл бол фашизм юм.” гээд нэг айхтар хатуу үг хэлж.

Сайн ухаад үзсэн илтгэл дээрээ шударга ёсонд тулгуурлаагүй зөвхөн улс төрчид хоорондоо ашиг сонирхлоороо зөвшилцвөл фашизм юм гэсэн байна. Бүр үүнийг нарийвчилж хэлэх юм бол ард түмэнтэйгээ, иргэдтэйгээ зөвшилцөхгүйгээр, улс төрчид хоорондоо хаалгаа хааж байгаад зөвшилцөх юм бол фашизм буюу төрийн эрх мэдэлд сонгуульгүйгээр хүрч байна гэсэн санаа.

Эрхэм гишүүд ээ,

Та бүхнийхээ гэгээн оюун ухаанд санал асууж өгөөч ээ гэж хүсэж байна. Анх Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт оруулах өөрчлөлтийг Улсын Их Хурал шийдвэрлэхдээ Үндсэн хуулийн 69 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу ард нийтийн санал асуулга явуулах арга замыг сонгох нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор Улсын Их Хурлын гишүүдээр санал хураалгаж өгөхийг дахин дахин хүсэж байгаа юм.

Нийгэм өөрөө. Нөгөө Жон Локк /John Locke/-ийн хэлдэг үг байна шүү дээ. “Үндсэн хууль бол нийгмийн гэрээ”. Энэ бол ард нийтийн гэрээ. Энэ бол Улсын Их Хурлын гишүүдийн хоорондын зөвшилцлийн гэрээ биш шүү. Энэ бол Улсын Их Хуралд байгаа нам нэртэй хэдэн нөхдүүдийн хоорондын гэрээ биш шүү. Энэ бол ард нийтийн гэрээ. Нийгмийн гэрээг нийгэмд нь л үлдээ.

“Ганзага гуяа дагадаг, гар гараа дагадаг” гэж үг бий.

Эрхэм гишүүд минь ээ,

Миний энэ саналыг хэлэлцэж өгч тус болооч. “Мөнх тэнгэрийн хүчин доор, их суу залийн доор Монгол Улс мандан бадрах болтугай”.

Г.Занданшатар: Ер нь Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд горимын санал гэдэг бол хэлэлцэхээр тогтсон асуудлын дарааллыг өөрчлөх асуудал нэмэх, хэлэлцэх журмын талаар гаргасан саналыг хэлнэ.

Тэгэхээр манай гишүүд энэ Үндсэн хуульд өөрчлөлт оруулах журмын тухай хуулиа бас ягитал барьж, үгээ хэлж, санал бодлоо илэрхийлбэл сайн байна.

Тухайлбал, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд зааснаар, Ард нийтийн санал асуулгын тухай хуульд зааснаар Байнгын хороон дээрээ энэ тухай саналуудыг гаргаж, тэгэхдээ гуравны нэг. Улсын Их Хурлын нийт гишүүдийн гуравны нэг санал гаргаснаар, эсвэл Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны нэгээс доошгүй нь санаачлах ёстой. Ард нийтийн санал асуулга явуулах тухай хуулиар.

Тэгэхээр гуравны нэг. Улсын Их Хурлын гишүүдийн гуравны нэг нь санаачлах ёстой. Байнгын хорооны шийдвэр гуравны хоёроор. Бүх саналуудыг гуравны хоёроор энэ энгийн саналуудыг ч гэсэн дийлэнх олонхын санал буюу гуравны хоёрын саналаар хэлэлцэн шийдвэрлэдэг байна.

Одоо Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Гишүүдийнхээ өнөөдрийн амгаланг айлтгая.

Тэгэхээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн анхны хэлэлцүүлэг хоёр долоо хоногийн өмнө тав дахь өдөр болсон.

Тэгээд үүний дараа Их Хурлын гишүүд орон нутагтаа ажиллаад явсан байгаа.

Тэгээд энэ тав дахь өдрийн хуралдаан дээр би хөдөөгүүр явж байгаа Их Хурлын гишүүддээ нэгдүгээрт 7 жилийг 5 жил болгох тухай хуулийн төслийг хэлэлцэхийг шаард аа.

Хоёрдугаарт нь, хүүхдийн мөнгийг 100 хувь олго оо.

Гуравдугаарт нь, цалин, тэтгэврээ нэм ээ гэдгийг сайн шаардаж өгөөрэй гэсэн.

Энэ маань бас тодорхой үр дүнд хүрч байна. Ямар ч байсан Сангийн сайд хүүхдийн мөнгийг бүрэн олгох. Хүссэн хүн, хүүхэд болгонд олгох тухай мэдэгдлийг хийсэн байгаа.

Тэгээд дээрээс нь Засгийн газар бас тодорхой шийдэлд хүрээд цалин, тэтгэврийг нэмэх энэ төсвийн тодотголыг энэ 7 сар дотроо багтаагаад хийх ийм шийдэлд хүрч байна.

Дээрээс нь 7 жилийг 5 жил болгох тухай хуулийн төслийг энэ намрын чуулганаар 2024 оны нийгмийн даатгалын Төсвийн тухай хууль батлахаас өмнө батлахаар Монгол Ардын намын бүлгийн дарга болон бусад гишүүдтэй байнгын хорооны дарга П.Анужсин болон Нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа нартай бид тодорхой тохиролцоонд хүрсэн байгаа.

Тэгэхээр ер нь ард иргэдийн шаардлага бол үр дүнгээ өгч байна.

Тийм учраас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Их Хурлын гишүүд яг энэ 76 дээр тойрог нь багталцахгүй Монгол Ардын намын маш олон гишүүд байгаа.

Тийм учраас өөрсдийн эрх ашгийн үүднээс 152-ыгоо 126 болгож буулгаж байгаа.

Тийм учраас дахиад хөдөө орон нутгаар явахад одоо Их Хурлын гишүүд очоод Засгийн газар цалин, тэтгэвэр нэмэхээр болсон. Хүүхдийн мөнгийг 100 хувь болгохоор болсон гэж ярьж очих байх.

Яг тэр дээр нь яг хэдэн хувиар болгох юм гэдгийг нь маш сайн асуугаад, яг хэдэн төгрөгөөр тэтгэвэр нэмэх юм гэдгийг нь хэл амыг нь сайн асуугаарай. Тэгж байж эрх ямбаа нэмэгдүүлсэн, тоогоо нэмэгдүүлсэн, жагсаалтын ард нуугдах гэсэн энэ нөхдүүдээс бас нэг өөрсдийнхөө асуудлыг шийдвэрлэх ийм зайлиггүй шаардлага байна.

Өнөөдөр энэ хүмүүс чинь зөвхөн энэ талдаа тоогоо нэмье, тогтолцоогоо өөрчилье гээд өөрсдийнхөө эрх ямбыг нэмэх тухай асуудал ярьж байна. Энэ талд ард түмний асуудлыг шийдвэрлэх ямар ч тийм Үндсэн хуулийн өөрчлөлт хийхгүй байна.

Тийм учраас шаардлага тавьж байгаад цалингаа хувиар гэж ярихгүй шүү. Хувиар гэж ярихгүй яаж дахин нэмэгдүүлэх вэ, тэтгэвэр яаж дахин нэмэгдүүлэх вэ гэдэг энэ асуудлаа манай ард иргэд тодорхой шаардлага тавьж өгөөрэй гэдгийг хүсье.

Тэгээд бидний, ялангуяа сөрөг хүчин бол яг энэ эдийн засаг хүндрэлтэй байгаа үед ард иргэдийнхээ орлогыг нэмэгдүүлэх энэ боломжийг бий болгох тал дээр байнга хамт байна. Эрх баригчдаасаа хамтдаа шаардагсаа.

Бүгдээрээ амжилтад хүрч байна. Дахиад ч хүрэх болно гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн 69 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүй ирцтэй бол түүнийг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг авч хэлэлцэхэд хүчин төгөлдөр гэж заасан.

Одоо ирц 57-гоос дээш гишүүнтэй байж Үндсэн хуулийн өөрчлөлтийг хэлэлцэх асуудал болно.

Өчигдөр 2019 он, 2015 оны Үндсэн хуулийн өөрчлөлтүүдийн бүх саналууд, протоколын тэмдэглэлийг уншиж үзлээ л дээ.

Тухайн үед Ардчилсан намын дарга С.Эрдэнэ, Ардчилсан намын бүлгийн дарга Д.Эрдэнэбат нар 108 гишүүнтэй, 54-ийг нь пропорциональ буюу олонхыг төлөөлөх гэж бичээд, 54-ийг нь пропорциональ буюу хувь тэнцүүлэх зарчмаар хослуулан явуулна гэсэн яг ийм өгүүлбэртэйгээр санал хураалт явагдаж байсан байна.

41 гишүүн дэмжээд санал хураалт дээр тэр саналыг, Д.Эрдэнэбат даргын саналыг 41 гишүүн дэмжээд 57 хүрээгүй унаж байсан байна.

Тэр бол Улсын Их Хурлын сонгуулийг олонхыг төлөөлөх болон хувь тэнцүүлэх зарчмаар хослуулан явуулна. Сонгогч тойрогт нэр дэвшсэн болон намын жагсаалтын нэр дэвшигчийг сонгоно гэсэн ийм заалтаар санал хураалгасан байна лээ. Яг томьёолол нь.

Дөрөвний гурав буюу одоо дийлэнх олонх, үнэмлэхүй олонхын ирцтэйгээр асуудлыг хэлэлцдэг.

Т.Аубакир гишүүн, С.Одонтуяа, Д.Өнөрболор, Д.Сарангэрэл гишүүн, Д.Цогтбаатар гишүүн, Б.Чойжилсүрэн гишүүн, Б.Энх-Амгалан, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд яачихсан юм бэ?

57 гишүүний ирцтэйгээр асуудал хэлэлцэж эхэлнэ.

Энэ хооронд энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүнд мэндчилгээ дэвшүүлье.

5 дугаар сарын 19-нд Улсын Их Хурлын гишүүн Энхбаярын Батиугар төржээ.

Улсын Их Хурлын гишүүн Энхбаярын Батиугарт Намбарын Энхбаяр, Ононгийн Цолмон нарын ууган хүү болж эхээс одоо 19-нд мэндэлсэн байна. 5 дугаар сарын 19-ний өдөр.

Тэгээд Улсын Их Хурлын гишүүн Энхбаярын Батиугарт төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшээ, ард түмний илч болсон Танд болон танай гэр бүлд Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх аз жаргал сайн сайхныг хүсэн ерөөе. /алга ташив/

Т.Аубакир гишүүн, Сүхбаатарын Батболд гишүүн, Жамбын Батсуурь гишүүн, Хаянгаагийн Болорчулуун гишүүн, Сандагийн Бямбацогт гишүүн, Дашдондогийн Ганбат, Салдангийн Одонтуяа, Дамдинсүрэнгийн Өнөрболор, Даваажанцангийн Сарангэрэл, Дамдины Цогтбаатар, Баттогтохын Чойжилсүрэн, Бямбасүрэнгийн Энх-Амгалан, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд нар алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орно. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын

байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд танилцуулна.

Протокол тэмдэглүүлье. Ирц 58 гишүүнтэй байна. 59 гишүүнтэй байна.

Н.Энхболд: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 05 сарын 03-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн нэг дэх хэлэлцүүлэг буюу хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2023 оны 05 сарын 05-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2023 оны 05 сарын 18-ны өдөр Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн Арван гуравдугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.11 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх санал, дүгнэлтийг танилцуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар хэлэлцэх нь зүйтэй гэж үзвэл Улсын Их Хурал төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсгийг хууль санаачлагчийг оролцуулан байгуулж болно гэж заасны дагуу Улсын Их Хурал Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх тухай 2023 оны 05

сарын 05-ны өдрийн Улсын Их Хурлын 37 дугаар тогтоолыг баталсан.

Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлдэх ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдоор ахлуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Ж.Батсуурь, Т.Доржханд, Х.Нямбаатар, Д.Сарангэрэл, Д.Тогтохсүрэн, О.Цогтгэрэл, Б.Энхбаяр нарын бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэгт хэлэлцүүлэх хоорондын хугацаа, хэлэлцэж байгаа асуудлын шинж байдал, цар хэмжээнээс хамааран долоогоос доошгүй ажлын өдөр байх бөгөөд дээд хязгаарыг нэгдсэн хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар тогтоож болно.

Энэ хугацаанд Байнгын хороо гишүүд олон нийтийн санал бодлыг сонсох, төслийг хэлэлцүүлэлт бэлтгэх ажлыг хийж санал, дүгнэлтээ гаргана.

Энэ нь тасралтгүй ажиллагаанд хамаарна гэж заасан.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.1-д Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар төсөл санаачлах үеэс эцэслэн батлах хүртэл бүхий л үйл ажиллагаанд иргэд, улс төрийн нам, олон нийтийн бусад байгууллагын оролцоог хангах, мөн зүйлийн 5.4.7-д төслийн хэлэлцүүлгийн үе шат хоорондын хугацааг иргэд, тэдгээрийн хамт олон, байгууллагад санал бодлоо илэрхийлэх боломж олгохуйцаар тогтооно гэж тус тус заасан.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо Улсын Их Хурлын Тамгын газраас дээрх зарчим болон Монгол Улсын Их Хурлын чуулганы

хуралдааны дэгийн тухай хуулийн 46.6-д заасныг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл хэлэлцүүлэхтэй холбоотой мэдээллийг олон нийтэд зарлан мэдээлэх, төслийг нийтэлж санал авах, дүнг нэгтгэн боловсруулах, танилцуулга, санал, дүгнэлт гаргах үйл ажиллагааг 2023 оны 05 сарын 03-ны өдрөөс 17-ны өдрүүдэд хариуцан зохион байгууллаа.

Улсын Их Хурлын даргын Улсын Их Хурлын гишүүд тойрогт ажиллах тухай 2023 оны 85 дугаар захирамжаар Улсын Их Хурлын гишүүд төслийн талаар иргэдийг мэдээллээр хангаж, танилцуулга хийх, олон нийтийн оролцоог хангаж санал бодлыг сонсох ажлыг зохион байгуулах зорилгоор 2023 оны 05 сарын 07-ны өдрөөс 16-ны өдрүүдэд тойрогтоо ажилласан.

Энэ хугацаанд Улсын Их Хурлын 64 гишүүн 21 аймгийн 127 сум, нийслэлийн 9 дүүрэгт ажиллаж, 62 мянга 672 иргэнд мэдээлэл хүргэж санал авсан байна.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлгийн үе шатанд Улсын Их Хурлын олон нийттэй харилцах мэдээллийн сувгаар дамжуулан 273 иргэн, байгууллагаас нийт 561 санал ирүүлснээс 264 санал буюу 47 хувь нь D-Parliament.mn цахим хаягаар, 202 санал 36 хувь нь Улсын Их Хурлын цахим хаягаар, 13 санал буюу 2.3 хувь нь цахим хаягаар, 4 санал буюу 0.7 хувь нь албан бичгээр, 44 санал буюу дөр 7.8 хувь нь албаны харилцах утсаар, 34 санал буюу 6.1 хувь нь иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд саналаа ирүүлсэн байна.

Төрийн албан хаагчдын саналыг тусгах үүднээс Улсын Их Хурлаас бүрэлдэхүүн, удирдлагыг нь сонгож томилдог 11 байгууллага, төрийн захиргааны төв 16, төрийн захиргааны 38, нийт 65 байгууллагад албан бичиг

хүргүүлж санал авах ажлыг зохион байгуулсан.

Төслийн талаар танилцуулга хийж мэдээллээр ханган, санал бодлыг сонсох, санал авах ажлын хүрээнд нийт 65 байгууллага, 1543 удаагийн уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулж, 104 мянга 323 төрийн албан хаагч, 311 мянга 980 санал ирүүлсэн байна.

Ирсэн мэдээллүүдийг боловсруулах, санал сонсох ажил үргэлжилж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13.1 дэх хэсэгт хоёр дахь хэлэлцүүлэг бэлтгэх ажлыг Төрийн байгуулалтын байнгын хороо нэгтгэн зохион байгуулна, 13.2 дахь хэсэгт бусад Байнгын хороо уг төслийн талаар тус тусын санал, хүсэлтээ Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж Төрийн байгуулалтын байнгын хороонд өгнө.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэгт Байнгын хороод Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэж, санал, дүгнэлтээ гаргана гэж тус тус заасны дагуу бусад Байнгын хороод 2023 оны 05 сарын 17, 18-ны өдрүүдийн хуралдаанаараа төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэх асуудлыг хэлэлцэн доор дурдсан санал, асуулт, дүгнэлтүүдийг ирүүлснийг танилцуулж байна.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл болон Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй.

Зарчмын зөрүүтэй санал гараагүй бөгөөд төслийг нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй буюу 72.7 хувийн саналаар дэмжсэн байна.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс төсөлтэй холбоотой асуулт гараагүй, зарчмын зөрүүтэй санал гараагүй бөгөөд төслийг нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй буюу 64.3 хувийн саналаар дэмжсэн байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо дээрх хуулийн төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс төсөлтэй холбогдуулан асуулт, зарчмын зөрүүтэй санал гараагүй. Төслийг нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр дэмжсэн байна.

Ёс зүй сахилга хариуцлагын байнгын хороо төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ асуулт асууж, хариулт авсан. Төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй. Төслийг нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй буюу 85.7 хувийн саналаар дэмжсэн байна.

Инновац, цахим бодлогын байнгын хороо дээрх хуулийн төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, зарчмын зөрүүтэй санал гараагүй. Төслийг нэгдсэн хуралдааны хоёр дахь

хэлэлцүүлэгт оруулахыг хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр дэмжсэн байна.

Нийгмийн бодлогын байнгын хороо төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг ард нийтийн санал асуулга явах замаар иргэдийн саналыг нь авч шийдвэр гаргахдаа харгалзан үзэх шаардлагатай. Энэ талаар хуулийн ямар зохицуулалт байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Ц.Идэрбат, Д.Батлут нар Улсын Их Хурлын гишүүдийг тоог нэмэгдүүлэх үндэслэлийн талаар, мөн Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг мажоритар, пропорциональ аргаар сонгох гишүүдийн тооны харьцааг хатуу тогтоох эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен Улсын Их Хурлын гишүүдийн тоог нэмэгдүүлснээр ажлын албаны тоо хэдээр нэмэгдэх. Уг төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт заасан Үндсэн хуульд өөрчлөлтийг нэгэнт оруулсан бол уг нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 8 жилийн дотор уг асуудлаар нэмэлт, өөрчлөлт дахин оруулахыг хориглох гэсэн зохицуулалттай зөрчилдөх эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат хэрэв Улсын Их Хурлын гишүүдийн тоог 126 болговол судлаачдын урьдчилан тооцсон үр дүнтэй нийцэх эсэх талаар тус тус асуулт асууж, хариулт авсан.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй. Төслийг нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй буюу 84.6 хувийн саналаар дэмжсэн байна.

Төсвийн байнгын хороо төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд Монгол Улсын Үндсэн хуулийн 22 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт

Улсын Их Хурлын гишүүнийг иргэд шууд сонгох эрхтэй гэж заасан нь хэлэлцэж байгаа төсөл туссан пропорциональ аргатай хэрхэн нийцэж байгаа талаар асуулт асууж, хариулт авсан байна.

Төслүүдийг хэлэлцэх үед гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй. Төслийг нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь буюу 84.6 хувийн саналаар дэмжсэн байна.

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо асуудлыг хэлэлцэх үед Их Хурлын гишүүн С.Ганбаатар Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг ард нийтийн санал асуулга явуулах замаар иргэдийн саналыг нь авч шийдвэр гаргахдаа харгалзан үзэх шаардлагатай бөгөөд энэ талаар хуулийн ямар зохицуулалт байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хоёр дахь хэлэлцүүлэгт бэлдэх тухай асуудлыг Байнгын хороодын хуралдаанаар хэлэлцэхээр уг төслийг өргөн мэдүүлсэн Засгийн газрын ажлын хэсэгт тайлбар өгөх бус Улсын Их Хурлаас байгуулагдсан ажлын хэсэг танилцуулга хийх боломжтой эсэх талаар асуулт асууж, хариулт авсан.

Хуулиудын төслийг хэлэлцэх үед гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй. Төслийг нэгдсэн хуралдааны хоёрдугаар хэлэлцүүлэгт оруулахыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй буюу 83.3 хувийн саналаар дэмжсэн байна.

Хууль зүйн байнгын хорооны хуралдааны үеэр төсөл хэлэлцэх үед Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар өөрийн бүрэн эрхийг өргөтгөх, хязгаарлах асуудлаар Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл санаачилж болохгүй гэж заасан

бөгөөд Засгийн газрын санаачилсан төслийн Улсын Их Хуралтай холбоотой заалтыг гишүүд санал гаргаж өөрчлөх боломжтой эсэх талаар асуулт асууж, хариултаа авсан.

Хуулиудын төслийг хэлэлцэх үеэр гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй. Төслийг нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй буюу 80 хувийн саналаар дэмжсэн байна.

Эдийн засгийн байнгын хороо дээрх хуулийн төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс төсөлтэй холбоотой асуулт, зарчмын зөрүүтэй санал гараагүй.

Төслийг нэгдсэн хуралд хуралдааны хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй буюу 80 хувийн саналаар дэмжсэн байна.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2023 оны 05 сарын 05-ны өдөр хуралдлаа.

Байнгын хорооны хуралдаанд Монгол Улсын Их Хурлын 2023 оны 37 дугаар тогтоолоор байгуулагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэг бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгээс боловсруулсан нэг саналын томъёоллоор санал хураалт явуулсан бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар, Б.Пүрэвдорж, Ж.Сүхбаатар нараас зарчмын зөрүүтэй саналын томъёолол ирүүлснийг уншиж танилцуулсан.

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 05 сарын 03-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн 1 дүгээр зүйлийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр дэмжээгүй.

Ажлын хэсгээс боловсруулсан Монгол Улсын Их Хурал нэг танхимтай, 126 гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг олныг төлөөлөх болон хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын 76 гишүүнийг олныг төлөөлөх 50 гишүүнийг хувь тэнцүүлэн хуваарилах сонгуулийн аргын үндсэн дээр сонгоно гэж өөрчлөх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй буюу 80 хувь нь дэмжсэн тул нэгдсэн хуралдаанд оруулахаар тогтсон.

Төслийг Та бүхэнд тараасан байгаа. Төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Ж.Сүхбаатар, Г.Занданшатар, Б.Пүрэвдорж, Ж.Батсуурь нар ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хууль зүйн нэр, томъёо, хэл найруулгыг сайжруулах талаар санал илэрхийлснийг Байнгын хороо хүлээн авч төсөлд тусгасан байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.11 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй буюу 86.7 хувийн саналаар дэмжиж, нэгдсэн хуралдаанаар төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулах нь зүйтэй гэж үзсэнийг танилцуулж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын сайд Даишэвэгийн Амарбаясгалан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Хишгээгийн Нямбаатар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Барсүрэнгийн Баасандорж, Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Жаргалцэнгэлийн Эрхэмбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Пүрэвжавын Сайнзориг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Үүрцайхын Амарбат, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Чулуунбаатарын Дондогмаа, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын хуулийн багийн ахлах зөвлөх Чойжилсүрэнгийн Ариунхур, Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Эдийн засгийн тэнхимийн профессор Нинжбатын Ууганбаатар, Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор Дагва-Очирын Бумдарь нар байна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд. /алх цохив/

Чимэдийн Хүрэлбаатар гишүүнээр тасаллаа. Үг тусдаа. Үг заалт тус бүр дээрээ 10 минутаар үг хэлнэ.

Б.Баттөмөр, Ц.Анандбазар. Энэ чинь юу вэ? Бүгдээрээ. Энэ чинь яагаад орохгүй байна аа? Ахиад дарчихаар энэ хүмүүс байхгүй болчихъё л доо.

Та хэд ахиад дараадхаач. Нэрийг нь гүйцээж оруулъя. Үүнийг өөрчлөхгүйгээр нээлттэй болгоод ахиад.

Содномын Чинзориг, Баагаагийн Баттөмөр, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ, Цэрэнпилийн Даваасүрэн, Бөхчулууны Пүрэвдорж, Цалдангийн Одонтуяа, Ширнэнбаньдийн Адьшаа, Наянтайн Ганибал, Тогмидын Доржханд, Хаянгаагийн Болорчулуун, Гомпилдоогийн Мөнхцэцэг, Цогточирын Анандбазар, Хассуурийн Ганхуяг, Ганзоригийн Тэмүүлэн, Ганибалын Амартүвшин, Борхуугийн Дэлгэрсайхан, Цагаанхүүгийн Идэрбат, Балжиннямын Баярсайхан.

Ахиад даръя. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүдийг дахиж бүртгэе. Болсон уу? Одоо дахиж байхгүй. Тэгээд орчихсон байгаа юм биш үү? Бүгдээрээ. Ороогүй хүмүүс байвал нэрээ өгчих.

Ингээд П.Анужин гишүүн байна, С.Чинзориг сайд байна. Та түрүүн ч байгаагүй. Одоо энд орчихсон байна шүү дээ. С.Чинзориг сайд аа. Одоо битгий үймүүлээд бай. Дахин дахин зөндөө л дарууллаа.

Микрофон дээрээ ногоон гэрэл ассан бүх хүмүүс орсон гэсэн үг. Одоо Ц.Сандаг-Очир гишүүнийх орчихсон. Тэгээд л зүгээр сууж байна. Тэгээд ороогүй нь бол одоо ингээд.

С.Бямбацогт, Л.Энх-Амгалан хоёрыг хасах уу? Байгаагүй юм чинь. Түрүүний эхний гуравт Жадамбын Бат-Эрдэнэ байсан. Одоо гуравт байна. Хэвээрээ байна.

Ингээд Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг эрье.

Сая Үндсэн хуулийн асуудлаар би тойрогтоо ажиллаад 7 газар 600 гаруй хүнтэй уулзалт хийлээ.

Тэгээд иргэд маань Үндсэн хуулийн талаар маш сайн мэдээлэл авсан байна.

Ер нь бас нэг гарч байгаа шүүмжлэл бол гуравн жилд гурав дахиа өөрчлөх гээд байна шүү гэдгийг бас нэлээн ярьж байна. 2019 онд нэг өөрчилсөн. Дараа нь нөгөө давхар дээл дээр нэг өөрчлөлт хийчихсэн. Тэгээд одоо ингээд өөрчлөх гээд байгаа болохоор энэ чинь гурав гэж ингэж үзэж байна.

Тооны хувьд ер нь дэмжиж байгаа хүн алга. Нэгээр ч нэмсэн хэрэггүй гэсэн ийм саналыг хэлж байна.

Намын жагсаалтыг бас ер нь дэмжихгүй. Тэгээд гол хардалт бол олны итгэл даахгүй, нэр хүнд муутай болсон улс төрчид орогнох нэг газар болно гэсэн ийм зүйлийг хэлж байна.

Намын жагсаалтаар хэрвээ сонгуулиар хүн гарах юм бол иргэд бидний сонгоогүй хүн явж байна л гэх яг тэр л хандлагыг хэлэх юм байна. 2012 оны тойроггүй 28 гишүүн байсан. Тэд улсын хөгжил ярьж байгаагүй. Та нараас ялгаа байгаагүй ээ. Намууд төлөвшөөд сайжирсан юм тэр үед байхгүй.

Тэгэхээр бид намын жагсаалт гэдгийг маш сайн мэднэ гэсэн ийм зүйлийг хэлж байна.

Тэгээд бид иргэд, сонгогчдын төлөөлөл. Тэгээд тангараг өргөхдөө бид юу гэдэг вэ гэхээр “ард түмнийхээ элчийн хувьд” гэж байгаа юм.

Одоо та бүгд тангаргаа санаарай. “Ард түмнийхээ элчийн хувьд нийт иргэний ашиг сонирхлыг эрхэмлэн Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахихаа чин шударгаар тангараглая” гэж ингэж тангараг өрсөн байгаа юм.

Тийм учраас олон түмний элч болж байгаа хүний хувьд би тэдний

саналыг дагана. Би тэгж угаасаа санал хураалгаад тэгж хэлсэн байгаа.

Тийм учраас Үндсэн хуулийн өөрчлөлтийг миний хувьд дэмжих боломжгүй. Яагаад гэвэл би ард түмний төлөөллийн үүрэг гүйцэтгэж байгаа учраас.

Тэгэхээр Үндсэн хууль гэдэг төр, иргэний гэрээ. Энэ гэрээ бол хоёр талаасаа үүрэг хүлээнэ гэж би ойлгож байна. Гэрээнд өөрчлөлт оруулах юм бол хоёр талаасаа ярих ёстой. Нэг нь дангаараа шийдэж болохгүй.

Тийм учраас би гишүүдийн гараад байгаа тэр ард нийтийн санал асуулга хийж шийдье гэж байгаатай санал нэг байна. Ингэж шийдэхгүй бол болохгүй юм билээ.

Яах вэ бид ингээд хүчээр шийдлээ гэхэд би сонгуулийн үр дүн ямар байхыг хэлж мэдэхгүй байна. Дараа нь ямар асуудал үүсэхийг хэлж мэдэхгүй байна.

Тийм учраас энэ дээр анхааралтай хандаарай. Тэр ер нь ард нийтийн санал асуулгаа асуугаад тэгээд иргэд юу гэж үзнэ тэр дагуу шийдсэн нь зөв байх шүү гэдгийг эцэст нь хэлье.

Тэгээд ер нь та бүгд сонгогчидтой уулзаад ганц л Хөвсгөлийнхөн өөр байсан байна гэж байхгүй шүү дээ. Би нийтээрээ иргэд тийм байсан болов уу гэж бодож байна. Тэгээд өргөсөн тангарагтаа үнэнч байгаарай гэж гишүүддээ хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Ц.Даваасүрэн гишүүн үг хэллээ. Хаянгаагийн Болорчулуун гишүүн.

Х.Болорчулуун: Баярлалаа.

2019 онд Үндсэн хуулийн өөрчлөлтийг хийсэн. Тэгээд богино хугацаанд эргээд бас өөрчлөлтийг хийх

гэж орж ирж байгаа. Бид 2019 онд төгссөн сайн хийхгүй алдаа гаргасныг хүлээн зөвшөөрөх ёстой гэж хэлэх байна.

Ер нь Үндсэн хуулийг тэр салбарын хууль шиг ойрхон өөрчлөөд байх үнэхээр болдоггүй. Буруу гэдгийг дэлхийн улс орон бүгд хэрэгжүүлдэг.

Үндсэн хууль гэдэг ард түмэн засаг төрийн эрх мэдлийн хуваарилалт. Эрх мэдлийн хуваарилалт.

Ер нь тэр битгий хэл ард түмний хамгийн том эрх мэдэл сонгох, сонгогдох эрхэд хүртэл халддаг шүү дээ. Бүр Үндсэн хуульдаа Ерөнхийлөгчийг парламентаас, Их Хурлаас сонгодог болъё хүртэл нэлээн хүчтэй яригдсан.

Харин Монгол Улсын Ерөнхийлөгч өөрөө энэ Ерөнхийлөгчийг парламент сонгодог байдлаас татгалзсан гэж байгаа юм.

Ард иргэд хэлж байна. Үгүй энэ одоо ард түмний хуралдай хийж байгаад шийдье л дээ. Үндсэн хуулийнхаа асуудлыг хүртэл санал гарч байна лээ. Сая тойргоор явж байхад.

Түүнээс гадна тоог хэтэрхий нэмэгдүүлэхийг үнэхээр дэмжихгүй байна. Тэр 152 ч байсан, 126 ч байсан хэтэрхий олон л гэж үзсэн.

Мөн намын жагсаалтыг төдийлөн дэмжихгүй байгаа. Бид энэ болгоныг бас бодолцож үзэх ёстой гэж бодож байна.

Тэр тусмаа зарим намууд, жишээ нь Ардчилсан нам гэхэд намын жагсаалтыг 40 хувь байлгая гэсэн тийм санал гаргасан. 40 хувь бол би хувь гишүүний хувьд өндөр гэж үзэж байгаа. Намын жагсаалтаар 30 хувиас илүү ороод байх шаардлага төдийлөн байхгүй гэж үзэж байна.

Ер нь аль болохоор тойргоос олон түмний шүүлтүүрээр гарч ирсний буруу гэж байхгүй. Гэхдээ яах вэ намыг бэхжүүлэх, цаашидаа нэгэнт парламент засаглалтай тодорхой 20, 30 хувьд нь тэр намын жагсаалт нь байхаас илүүгээр 40, 50 хувиар байж болохгүй гэсэн ийм бодолтой байна.

Ард иргэд тоог эсэргүүцэж байгаа. Би сая уулзалтын үеэр тайлбарлаж байгаа юм. Үгүй энэ чинь одоо хэтэрхий тоо багатай болохоор янз бүрийн хуулиуд гадна дотнын лоббигоор орж ирээд батлагдаж байна. Нэг, хоёр хүний саналаар.

Тэгэхээр та нар тэр хуулийг баталдаг босгоо өндөрсгөө, чангатгая гэвэл 51 хувиар баталдаг биш гуравны хоёроор батал л даа. Одоо 76-гийн 51 хүнээр. Тийм саналыг хүртэл тавьж байгаа шүү. Тоондоо биш ээ. Энэ 76 гэсэн тооноосоо болоод бас энэ нийгэм, эдийн засаг чинь ийм болоогүй шүү гэдгийг бас хэлж байна.

Мэдээж тэгэхдээ олонхоороо ярилцаад энэ асуудлыг шийднэ. Дахиж ард иргэдээсээ санал авч, саналыг нь тусгаж ажиллах байх гэж бодож байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Х.Болорчулуун гишүүн үг хэллээ. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: Ингээд Үндсэн хууль орж ирж байгаа.

Нэг танхимтай. Анх орж ирж байхдаа 76 пропорционалиар, 26 мажоритаритар. Тэгээд нэг танхимтай байна гэж орж ирсэн.

Бид хэд бүгд л орон нутгаараа явлаа. Бүлгийн хурлууд хийсэн. Ардчилсан нам, Ардын нам аль аль нь бүлгийн хурлаа хийсэн. Ер нь мэдээж энэ дээр ард иргэдээсээ сонссон тоо болон

пропорциональ, холимог гэсэн энэ системийнхээ талаар нэлээн ярилаа.

Ард иргэдийн хувьд үндсэндээ тоон дээр эсрэг байгаа. 156 гэдэг бол үнэхээр том тоо гэж. Би өөрийнхөө хувийн бодлоо ч хэлсэн, хувь гишүүнийхээ саналыг ч хэлсэн.

Ер нь 108. Дээд тал нь 120 хүртэл байх нь зүйтэй юм уу гэж. Ард иргэдээс ч ер нь иймэрхүү саналууд орж ирж байгаа юм.

Өнөөдөр нөхцөл байдал ер нь ямар байгаа билээ.

Бид 1992 онд Үндсэн хуулиа баталсан. Шинэ Үндсэн хууль боловсруулж батлагдсанаас хойш бид үндсэндээ 31 жилийн нүүр үзээд байна. Энэ хугацаанд бид яаж улс төрийн нөхцөл байдлыг авч явсан билээ гэж.

Ард түмэн үүнийг л асууж байгаа. Өчнөөн олон хулгайч нар төрлөө гэж байгаа. Өчнөөн олон луйвар төрлөө гэж байгаа. Энэ бол тойрог болгон дээр ярьж байгаа үг шүү.

Тэгэхээр ийм хэмжээнд бид энэ улс орныг өнөөдөр авч явжээ. Ардын нам, Ардчилсан нам гээд энэ 31 жилийн хугацаанд Ардын нам нь арай илүү авч явсан байх. Гэхдээ л ер нь энэ хугацааны хүрээнд Ардын нам нэг засаглаад л, Ардчилсан нам нэг засаглаад л. Хамтарсан засаг нэг байвал байгаад л ингээд л явсан. Энэ хугацаанд юм өөрчлөгдсөнгүй.

Өнгөрсөн 2022 оны сүүлээр 10, 11 саруудад жагсаал цуглаанууд болсон. Бас нэлээдгүй асуудлууд орж ирсэн. Нүүрстэй холбоотой асуудлууд, Хөгжлийн банктай холбоотой асуудлууд.

Өнөөдөр ч гэсэн Хөгжлийн банктай холбоотой асуудал дуусаагүй л явж байгаа. Тэгээд энэ болгон дээр ард

түмний дургүйцэл, ард түмний эгдүүцэл хүрээд байгаа шүү дээ.

Тийм ч болохоор энэ жагсаал цуглаанууд гарч ирж байгаа. Үндсэндээ энэ жагсаал цуглаан хийж байгаа залуучуудтай бас уулзаж үзсэн. Тэгээд юу хүсээд байна гэхээр ерөөсөө шударга ёсыг л хүсээд байгаа.

Тэгээд энд сууж байгаа, энэ саарал байшин дотор сууж байгаа 76 гишүүнийг үнэндээ бидний үнэлгээ унасан. Ёстой нөгөө газар унана гэдэг шигээ үнэлгээ ерөөсөө доошоо унасан.

Тэгээд энэ юунаас шалтгаалаад байгаа юм гэхээр бидний тогтолцоонд байгаад байгаа шүү дээ.

Ямар ч хүн сонгогдсон буцаад энэ тогтолцоон дээрээ орж ирдэг, намын даргатайгаа холбоотой болдог. Нам дотроо хуйвалдаг. Нам цаашаа харж байгаад бөөгнөрөөд хуйвалдаан зохион байгуулж аливаа зүйл дээр хууль бус зүйлүүдийг хийдэг.

Улаан нам байна уу, цэнхэр нам байна уу, ногоон нам байна уу үл хамаараад энэ тогтолцоо чинь өөрөө болохгүй байна гэдгийг энэ ард иргэд чинь бас хараад байгаа шүү дээ. Ямар ч хүн энэ намын босгыг алхаад орж ирсэн. Сонгогдох нь сонгогдоод, сонгогдохгүй нь үлдлээ гэхэд цаана нь сонгогдож байгаа нь буцаад энэ муу муухай зүйл рүү ингээд холбогддог ийм нөхцөл байдалд орчхоод байгаа шүү дээ. Бид нар.

Үүнийг ард иргэд ч бүгдээрээ хэлж байгаа. Ирж байгаа хүмүүс нь сонгогдох гээд орж ирж байгаа хүмүүсийг нүдээ аньж байгаад хэн нэгнийг нь дугуйлаад гаргадаг. Явсан хойноо итгэл алддаг.

Тэгэхээр ерөөсөө бид үндсэндээ энэ тогтолцоог өөрчлөхгүй бол болохгүй болчихоод байгаа ийм тогтолцоо болчихоод байна шүү дээ.

Тэгэхээр ямар ч л байсан ард иргэдтэй ярьж байхад энэ пропорциональ буюу бид нарын ярьж байгаа холимог тогтолцоо дээр бас нэлээн итгэл үзүүлээд байгаа юм. Яагаад гэхээр энд холбогдох тогтолцоогоор нэгдүгээрт энэ танхим дотор олон намын төлөөллүүд бий болж ирнэ. Бидний хамгийн том зүйл бол ардчилал шүү дээ, ардчилал, зөвшилцөл.

Тэгэхээр намуудын том одоо нэлээн төлөөллүүд олон болж ирэхэд зөвшилцөл гэдэг зүйл ардчилсан одоо үндсэн зарчим дээр зөвшилцөл гэдэг зүйл нэлээн дэлгэрэх ёстой. Нэг намын дарангуйлал гэж байхгүй болно. Нэг намын том одоо бүлэглэл гэсэн зүйлүүд байхгүй болно. Манай танай эд нар намын гэхээргүй энэ чинь том хяналт бий болно. Энэ танхим дотор том хяналтууд болно. Засгийн газраа үнэхээр сайн хянаж чадна.

Засгийн газар элдэв янзын асуудалд орооцолдоод байвал тухайн сайд нь элдэв янзын асуудалд ороод байвал тухайн одоо намууд гаргаж ирээд энэ Засгийн газар дээр тодорхой хяналт хийгээд, хариуцлага тооцоод явах нөхцөл байдал чинь өөрөө бий болоод байх юм. Нэгдүгээрт.

Тийм болохоор пропорциональ тогтолцоо болон энэ асуудал дээр юу холимог тогтолцоон дээр одоо болж байна. Энэ тогтолцоогоор явсан нь зүйтэй байх гэж дэмжиж байгаа юм.

Хоёрдугаарт, асуулт байна. 156, 152 гэсэн тоо маань 126 болж орж ирж байгаа юм. Яг үндэслэлийг нь нэг жсоохон тайлбарлаад өгөөч ээ.

Хоёрдугаарт, тогтолцоо маань өөрөө 60, 40 рүү ороод ирэх шиг боллоо. Бид нар уг нь 50, 50-аар оруулсан шүү дээ. 50, 50-аар орохын ач холбогдлыг бид нар мэдээд байгаа шүү дээ. Урьд өмнө бид нар 12 онд хийж үзээгүй биш, 12 онд хийсэн.

Үүнийгээ тэгээд орж ирэхэд нэг хэсэг нь яг орон нутгаараа сонгогдоод орж ирсэн. Энэ нь болохоор бид нар оригинал гишүүд яг ард түмэнтэйгээ тулж байгаад бид нар одоо бор зүрхээрээ үнэлэгдэж гарч ирсэн гишүүд нөгөө хэдэн үлддэг гишүүд ерөөсөө цаасны гишүүд гэсэн ийм байдалтайгаа байсан шүү дээ. Тэгээд ерөөсөө бойкотлоод тэр цаасны гишүүдийн гарч ирсэн саналыг дэмждэггүй.

Уг нь цаасны гишүүд гэж яриад байгаа жагсаалтаар орж ирж байгаа гишүүд чинь улс орны хэмжээнд ямар нэгэн тойргоос хамааралгүйгээр том том асуудлуудыг шийддэг улс орны эх орны хөгжлийг томоор нь хардаг ийм хүмүүс уг нь орж ирэх гэж бид нар энэ пропорциональ тогтолцоо холимог тогтолцоогоо оруулж ирж байгаа шүү дээ. Уг нь бол. Ач холбогдол нь үүн дээр байж байна.

Одоо буугаад дахиад буугаад хуучин руугаа ороод ирлээ шүү дээ. Нэгэнт тогтолцоогоо бид нар шинэчилж байгаа юм бол яагаад буцаад үүнээсээ буцчихав аа? Яагаад бас 40, 60 луугаа орчхов оо? Би санахдаа ойлгохдоо бол энэ Ардчилсан намын одоо санал гэж орж ирж байгаа юм.

Гэтэл нөгөө талаасаа Ардчилсан нам одоо энэ тойргоор явж байхад зүгээр попорч одоо улс төр хийж байгаа болохоос биш яг өнөөдөр энэ дээр дэмжиж байгаа гэдэг хэл үгээ бас ер нь бол гаргаж ирэхгүй байгаа шүү.

Тийм болохоор Ардчилсан намын болон энэ намуудын зөвшилцөл ямаршуу хэмжээнд явсан юм бэ? Энэ тоон дээрээ яаж зөвшилцсөн юм бэ гэдэг хоёрдугаар асуултыг бас танаас асууя.

Өөрөөр хэлбэл 50, 50 маань яагаад буцчихав. 40, 60 луу яагаад орчхов. Тэгээд энэ дээр намуудын ямар тогтолцоо, ямар саналууд энэ дээр байгаа юм бэ гэсэн зүйл

дээр 2 асуулт. Тоо болон тогтолцооныхоо хувь дээр ийм хоёр асуулт асууя. Баярлалаа.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга хариулна.

Н.Энхболд: Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэхээс өмнө энэ асуудлыг гишүүд орон нутагт яваад ирсний дараа иргэдээс авсан санал судалгаа тодорхойлсон байр сууриудыг хараад үзэхэд ер нь 152 гэдэг тоо бол өндөр байна гэдгийг дийлэнх олон хүнд хэлсэн байсан.

Зүгээр урьдчилаад ирсэн нөхцөл байдлыг ингээд харахад тоо нэмэгдүүлж болох юм. Тэгэхдээ 152 их байна. Холимгийг дэмжинэ гэсэн саналууд давамгайлж байгаа. Бид нар Байнгын хороодоос орохоос өмнө бас энэ орон нутагт ажиллаад ирсэн ажлынхаа дүнг яриад дараа нь намууд хоорондоо зөвшилцөөд бүлгүүд дээрээ яриад намын удирдлагуудын хэмжээнд яриад, ямар ч байсан 152 гэдэг бол хүлээн авахад хэцүү тоо нь байна гэдэг дээр яриад, тоог нь бууруулах ийм шаардлагад хүрсэн.

Үүнийхээ дараа одоогийн байгаа газар нутаг, хүн амын төлөөллөө бодолцон энэ 76 тойрог гэдэг тогтчихсон төлөөлж чадаж байгаа гэдэг утгаар нь ярилцсан болов уу гэж ойлгож байна. 76 Тойрог авч үлдээе гэсэн ийм, үүнийгээ бол хэвээрээ байлгая гэсэн ойлголцолд хүрсэн.

Тэгээд нэгэнт доошоо багасах гэж байгаа юм бол гэж тооцож байгаад л 2 талаасаа ярьж байгаад л үндсэндээ хүрсэн тоо нь энэ 126, дунджаар. Энэ дээр яг зөвхөн одоо бас яг Ардчилсан намын саналаар ч ингээд авчихлаа гэсэн тийм яриа тийм тооцоо байхгүй байгаа гэдгийг нэгдүгээрт хэлье. Бараг 2 асуултаар хоёулаа явчхав уу.

Г.Занданшатар: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя.

Н.Энхболд: Аан, харьцаа Бат-Эрдэнэ гишүүн ээ, би харьцааг хэлье. Тэгээд ер нь аливаа хууль, тэр тусмаа Үндсэн хуулийн тухай асуудал нэгдүгээрт одоо нийгмээрээ ярилцаж зөвшилцөх.

Хоёрдугаарт, шийдвэр гаргаж байгаа субъектүүдийн одоо хоорондын бас зөвшилцөл ойлголцол энэ бүхний л үндсэн дээр л гардаг шүү дээ. Ямар ч хууль орж ирсэн хууль одоо төслөөсөө өөрчлөгдсөн байдаг.

Ер нь бас орон нутгаар явсан санал, бусад газруудаас ирсэн саналуудыг харгалзахад одоогийн бид нарын ярьж сурснаар мажоритар тогтолцоогоор тойргоо төлөөлж сонгогдож байгаа гишүүдийнх нь тоо илүү байх ёстой шүү гэсэн саналууд нэлээд их давамгайлсан. Бүх газруудаас ирсэн тайлангуудаас харахад.

Тэгээд ярьж байгаад 76-гаа хадгалаад үлдэнэ гээд тэгэхээр үндсэн тоо доошилчихоор харьцаа хувь нь 60, 40 болоод гараад ирсэн. 60, 40 орчим, арай ч 60, 40 биш, 39, 5, 60, 61.5 ч билүү ийм хавьцаа тоо гарч ирчхээд байгаа юм. Тийм.

Г.Занданшатар: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Тэгэхээр үндсэндээ энэ нийгмийн хүсэмжлэл шаардлагаар бид нар хийж байгаа гэж ойлгож байгаа шүү дээ.

1992 оноос хойш бид нар энэ одоо нийгмийнхээ тогтолцоог өөрчилье гэж байгаа. Засгийн газраас гаргаж ирж байгаа маш том асуудлууд байж байгаа. Эрх ашгийн зөрчилтэй холбоотой хуулиуд дээр өөрчлөлт хийж байгаа тогтолцоогоо өөрчилье гэж байгаа. Шинэчлэл хийе гэж байгаа.

Үндсэндээ нийгмийн том тогтолцоон дээр том шинэчлэл хийе гэж байгаа шүү дээ. Тэгээд шинэчлэл хийе гэгчхээд буцаад 76 гишүүндээ баригдаад энэ 76 гишүүнээ буцаагаад нэг одоо амьг нь таглаж, 76-гаар нь тарааж өгөөд тэгээд дээрээс нь, яах вэ, цаана нь 50 үлдэж байгаа юм байна даа, 50-ийг нэмчихвэл яасан юм бэ гэсэн нэг ийм логик харагдаад байгаа юм, ажлын хэсгийн дарга аа.

Тэгэхээр үнэхээр шинэчлэл хийе гэж байгаа бол шинэчлэлийн хамгийн гол миний одоо хамгийн гол зориод байгаа юм энэ шүү. Шинэчлэлийн хамгийн гол утга учир чинь 50, 50-даа байгаа гэж ойлгоод байгаа шүү. Бид нар тойргийн харьяаллаас мөнгөний харьяаллаас хэн нэгэн хувь гишүүний харьяаллаас гарах гээд байгаа шүү дээ, энэ чинь.

Хамгийн гол нь ингээж байж бид нар шинэчлэл рүүгээ орох гээд байгаа шүү дээ. Зөв хүнээ томилдог болох ёстой гээд. Бид нар Сонгуулийн тухай хууль, Улс төрийн намуудынхаа хуулийг дагалдаж бид нар оруулж ирж байгаа шүү дээ.

Тэгчхээд улс орон чинь өнөөдрийн хувьд одоо юу хөгжсөн юм бэ, юу өөрчлөгдсөн юм бэ гэж яриад байгаа шүү дээ. Ард иргэд асууж байгаа шүү дээ. Энэ хугацаанд юу хийчихсэн юм та нар, юу өөрчлөөд бидний амьдралын төлөө юу сайн сайхныг хийчихсэн юм бэ. Өөрсдөө л баяжаад өөрсдөө л бололцоогоо хангаад байна гээд байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ тойргоос одоо хамааралгүйгээр улс орны хэмжээнд ард иргэдийнхээ эрх ашгийг хамгаалсан энэ одоо 50 50 байх нь зүйтэй л гэж би уг нь бол үзээд байгаа юм л даа.

Тэгэхээр одоо бид буцаад л баригдаад л зүгээр 76-даа баригдаад л, нэмэх нь яах вэ 50-ийг нэмчихье гэсэн яах вэ дээ гэсэн байдлаар л орж ирээд байна

шүү дээ. Урьдын 2019 оных дээр бид нар чинь бас ийм шинэчлэл хийсэн шүү дээ.

Дутуу хийсэн. Яах вэ дээ, шинэчилж байгаа л юм чинь Үндсэн хуульдаа гар хүрчихсэн юм чинь ингээд больчихъё гээд хаячихсан. Тийм болохоор одоо шинэчлэл хийвэл хийсэн шиг хиймээр байна. Энэ дээр нэг хариулт хэлж өгөөч?

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд дарга хариулъя.

Н.Энхболд: Томоор нь хэлбэл хувь гишүүний хувьд би шинэчлэл хийвэл хийсэн шиг хиймээр байна гэдэгтэй би бол хувь гишүүнийхээ хувьд санал нэг байгаа. Бид нарын сая хийсэн ажил бол нэгдүгээрт ажлын хэсэг.

Хоёрдугаарт, Байнгын хороо.

Гуравдугаарт, ерөнхийдөө өнөөдрийн байгаа өнөөдрийг хүртэл хоёрдугаарт хэлэлцүүлгийн хүртэлх хугацаанд ойлголцсон зөвшилцсөн зүйлүүд. Цаана нь гуравдугаарт хэлэлцүүлэг гэж бий.

Бид дахиад долоо хоног хөдөө ажиллана, тойргуудаараа ажиллана, дахиад ирнэ, ярина, зөвшилцөнө, хоёр дахь хэлэлцүүлгийн үр дүн маань ямар байх нь вэ гэдгээ бас сонсоно. Тийм ээ.

Тэгээд ингээд эргээд ерөөсөө бид нар хоёрхон л юм, үндсэндээ хоёрхон л юм ярьж байгаа шүү дээ. Тооны асуудал, харьцааны асуудал. Тэнд одоо өөрчлөлт гарахыг үгүйсгэхгүй. Яг одоогийн байдлаар л бид нар иймэрхүү түвшинд л хүрээд байна гэдгээ хэлье.

Г.Занданшатар: Ганзоригийн Тэмүүлэн гишүүн.

Г.Тэмүүлэн: Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн хоёр дахь хэлэлцүүлэг орж ирлээ. Бид бүхний хувьд энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй

холбогдуулаад тойргууд дээрээ, аймаг дүүргүүд дээр ажилласан. Энэ өөрөө том сэдэв. Нэг талдаа Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал юм боловч бид нар энэ асуудлыг бол ард түмнээр хэлэлцүүлж, ард түмнээр шийдүүлж, гарц гаргалгааг нь гаргуулж тухайн тэр хүсэмжлэлд нь хүрсэн, хүлээлтэд нь хүрсэн тэр өөрчлөлтийг бол хийх ёстой гэж харж байгаа. Энэ үндсэн дээрээ хувь хүнийхээ үүднээс ч гэсэн Архангай аймгийн төв болоод Эрдэнэбулган сум 1500 гаруй иргэдтэй уулзсан. Энэ дотроос анхаарал хандуулж голлож байгаа, ярьж байгаа хөөрч байгаа зүйл бол нэгдүгээр асуудал. Тооны асуудал байна.

Анхнаасаа Засгийн газар өргөн барьж орж ирэхэд Улсын Их Хуралд суудалтай болон суудалгүй жижиг намуудыг хүсэмжлэлд нийцүүлж тоог 152 болгож оруулж ирсэн гэдэг асуудлыг ярьсан юм. Тоо их байна гэдэг асуудлыг ярьж байгаа юм. Энэ талаар дэмжихгүй ч гэж хэлж байгаа, тоо багадаагүй ч гэж хэлж байгаа хүмүүсүүд их байгаад байна. Тэр дундаа би бүр онцолж хэлэх гээд байгаа нь манай Эрдэнэбулган сумын 4 дүгээр багийн ахмад Түгжжамба гуай бол хэлсэн. 76-аас дээшээ тоо нэмэхээр нөгөө нэг хавханд орохгүй, чавханд харвагдахгүй хууль үйлчлэхгүй гишүүд олон болчих вий дээ гэсэн болгоомжлол байгаад байгаа юм.

Нийтлэг ерөнхий хандлага бол ийм байна. Иргэдийн дунд ойлголт бас тодорхой хэмжээнд бага байна гэж хараад байгаа юм. Хөнжлийнхөө хэрээр хөлөө жийвэл яасан юм бэ. Тооноос илүү чанар, ажлаа гэх сэтгэл чухал шүү гэдэг асуудлыг яриад байгаа юм. Ажлаа гэх ч сэтгэл чухал шүү гэдэг асуудлыг.

Тэгэхээр бид нарын хувьд энэ асуудлыг бас нэлээн онцгойлж харж үзэж, ажлын хэсгийн түвшинд Улсын Их Хурал, Төрийн байгуулалтын байнгын хороон дээр ч гэсэн яг энэ 152-126 болгож бууруулж орж ирж байгаа энэ асуудал

маань бас энэ үндэслэл дээр суурилж орж ирж байгаа юм болов уу гэж хараад байгаа юм.

Тэгэхээр ард түмэн хэлээд байгаа юм. Энэ тоо нэмэхийг чинь бид нар санаачлаагүй шүү гэж байгаа юм. Уг нь энийг бид нар өргөн барихад бол 50, 50 хувиар оруулж ирэх, жагсаалтаар болоод 50 хувь нь, тойргоос 50 хувь нь сонгогддог болох асуудлыг бол жижиг суудалгүй намууд тэр дундаа, ХҮН нам Аардчилсан намаас гаргаж ирсэн саналын хүрээнд бол орж ирсэн. Одоо тэгтэл энэ бол 40, 60 болчихлоо. Энэ жижиг суудалгүй намууд болоод улс төрийн хүчнүүд ХҮН намынхан, Ардчилсан намынхан яг энэ санал дээрээ нэгдсэн юм уу?

Энэ нөгөө нэг ард иргэдийн санал гээгддэг улс төрийн нам хүчнүүдийн санал гээгдэх асуудлуудыг бид нар энэ шийдэх гарц гаргалгаа маань яг энүүгээрээ шийдэгдэж болж байгаа юм уу гэдэг дээр та бас нэг ажлын хэсгийн ахлагчийн хувиар Төрийн байгуулалтын даргын хувиар бас энэ асуултад хариулт өгөөч ээ гэж хэлэх гээд байгаа юм.

Хоёрдугаарт жагсаалттай холбоотой. Жагсаалтаар 76 гишүүн орж ирнэ ээ гэсэн бол өнөөдөр буугаад 50 боллоо. Энэ дунд хэрэв үнэхээр та нар жагсаалтыг оруулж ирэх гээд байгаа юм бол 2012 оны алдааг давтах ёсгүй. Энэ дундаа нийгмийн сегментийнхээ төлөөллийг бол тодорхой хатуу хуульчилж оруулж өгөөч гээд байгаа юм. Тэр эмэгтэйчүүдийн төлөөллийг заавал ч үгүй 40, 50 хувь байна гэдэг асуудлыг тавьж өгөөч.

Залуучуудын төлөөлөл 10, 20 хувь байна гэвэл тэрийг хатуу 35 хүртэлх насны залуучууд байна гэдгийг нь тусгаж өгөөч.

Ахмадууд хүртэл энд чинь байх ёстой. 3 үеийн хэлхээний асуудал энд тусгагдах ёстой. Тэр бизнес эрхлэгчид бол

магадгүй малчид, гадаадад байгаа иргэд 200 мянга гаран залуучууд энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллүүд хүртэл энд байх ёстой гэдэг асуудлыг тэр Үндсэн хууль дээрээ хатуу хийж өгөхгүй бол сонгуулийнхаа хууль болоод улс төрийн намын хууль дээрээ энийгээ хийнэ гэж байгаад хийхгүй ингээд жагсаалттай болчих вий дээ гэсэн болгоомжлол байгаад байна аа? Тэгэхээр суурь зарчмыг нь Үндсэн хуулиар зааж өгөх ёстой байсан юм шүү. Нийгмийн төлөөлөл нийгмийн сегментийн төлөөлөл, хүн амын төлөөлөл энэ чинь хувьчилж хатуу орж ирнэ шүү дээ гэдэг асуудлыг бид нар бас нэг тодорхой үг үсгээр заах ёстой байсан юм шүү гээд байгаа.

Үнэхээр хувь тэнцүүлж жагсаалтаар энэ иргэдийг оруулна гэвэл 2 дахь асуулт нь.

Гурав дахь нь үндсэндээ бид нар энэ ард иргэдээр сонгуулийнхаа тогтолцоог өөрчилж, ард түмнээр тоо бодуулдаг энэ зүйлээс чинь бол нэг талдаа залхсан байна. Үндсэндээ 2012 оны сонгууль холимог тогтолцоогоор, 2016 оны сонгууль жижиг мажоритараар, 2020 оны сонгууль том мажоритараар, ингээд 2024 оных нь бол дахиад холимог болоод жагсаалттайгаар ингээд орж ирдэг.

Тэгэхээр заавал нэг тэр сонгуульдаа зориулж сонгуулийн хууль өөрчлөдөг энэ буруу жишгээ халбал яасан юм бэ. Энэ сонгуулийн тогтолцоогоо өөрчлөдөг энэ буруу хандлагаасаа салбал яасан юм бэ гэдэг асуудал байна.

Нэг талдаа тоглоомын дүрэм гэж үзэх юм бол тоглоомынхоо дүрмийг өөрчлөдөг, сонгуулийнхаа тогтолцоог өөрчлөдөг, ард түмнээр сонгогчдоор тоо бодуулдаг энэ байдал чинь буруу байна шүү дээ. Шударга бус байна шүү дээ. Эрүүл бус байна шүү дээ. Тоглоомын дүрэм тэр тогтолцоо өөрөө эрүүл байх дүрэм нь байнгын тогтвортой

хөдөлгөөнгүй байх энэ асуудлаа та бүхэн хуульчилж оруулж өгөөч ээ. Үндсэн хууль дээрээ бас энийгээ нээж өгч болдоггүй юм уу? Үнэхээр үндэсний эрх ашигт нийцсэн жижиг намуудын эрх ашигийг хамгаалсан иргэдийн санал гээгдэг энэ асуудлыг бид нар энэ хуулийн хүрээнд өөрчилж байгаа юм бол энэ цаашдын тогтолцоо энэ зөв гэж үзсэн тогтолцоо цаашидаа тогтвортой баймаар байна. 12 жил магадгүй цаашидаа босго өндөр баймаар байна. Үнэхээр одоогийн бид нарын хийх гээд байгаа энэ өөрчлөлт 3, 4 сонгууль дамнаад хэрэгждэг баймаар байгаад байна. Үнэхээр шаардлага гараад энэ хэрэгжихгүй болчихлоо гэвэл тухайн тэр нийт гишүүдийнх нь юу гэдэг юм 100 хувийн саналаар ард түмний санал асуулгаар ч гэдэг юм уу энийг өөрчлөдөг болох асуудлыг нь Үндсэн хуульд тусгаж өгөх бас асуудал байгаагүй юу. Уг нь бол энийг бол гишүүн болгон бас хэлсэн гэж би бодоод байгаа юм.

Үнэхээр Үндсэн хууль дээрээ энэ суурь нарийвчилсан зохицуулалтууд орж болохгүй үгүйсгэхээр тусгаж болохгүй гэвэл Сонгуулийн хууль дээр та бас мэдээж ажиллаж таарна. Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар энэ Сонгуулийн хууль болоод Улс төрийн намуудын хуулиудын ажлын хэсгийг та ахалж таарна. Хувь хүний чинь итгэл үнэмшил энэ дээр юу байна вэ? Мэдээж Их Хурал, Байнгын хороо гэдэг бол олонхын саналаар асуудал шийдэгддэг.

Ийм асуудлуудыг бол бас яг иргэд олон нийт бол хүлээлттэй байна. Та бүхэн тоог саяын тэр асуудлыг хар. Сонгуулийн тэр жагсаалтыг хийх гээд байгаа бол цааш цаашидаа нийгмийн сегментийн төлөөлөл ордгийн асуудлыг анхаарч үз.

Цаашидаа ерөөсөө сонгуулийн тогтолцоог өөрчлөдөг тоглоомын дүрмээ өөрчлөдөг энэ асуудлаасаа бүгдээрээ салцаая гэдэг энэ уриалгыг бол дэвшүүлээд байгаа юм.

Үүнээс гадна яах вэ зүгээр Үндсэн хууль ярихаар бид нарын сая ярьсан иргэд олон нийттэй уулзахаар 20, 30 хувь нь л Үндсэн хууль руугаа төвлөрч байгаа боловч 50, 60 хувь нь бол яах вэ цаг үеийн асуудалтай холбоотой асуудлууд байна. Засгийн газрын гишүүд энд байна сонсож байгаа байх. Бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт болоод энэ үнийн өсөлт газраас тэнгэрт туллаа шүү.

2 дугаар багийн иргэн Дашизэвэг гуай бол бүүр энийг дайж хэлээрэй гэж өөрөө онцгойлж хэлсэн юм. Үндсэн хуулийнхаа хэлэлцүүлэг дээр бид нарын энэ асуудал 1 дүгээр асуудлыг та бүхэн яриач ээ. Хонгилын үзүүрт чинь гэрэл асна гэж бид нар 20, 30 жилийн өмнө ярьж байсан. Одоо тэр гэрэл чинь хэзээ асах гээд байна вэ гэдэг асуудлыг хүртэл яриад байгаа юм.

Тэгэхээр бид нар энэ дээр ч гэсэн ер нь Улсын Их Хурал, Үндсэн хууль хэлэлцэж байх цаг үеэрээ ч гэсэн тодорхой энэ үнийн өсөлтийг хязгаарлах, Засгийн газар тодорхой шаардлагуудыг тавих Монголбанканд энэ валютын ханшийн өсөлтийг ч гэсэн хязгаарлах асуудлуудаар бол бодлого гаргаж, шаардлага тавьж, хариуцлага тооцож явах бол зайлшгүй шаардлага байгаад байна. Төр үнэгүйдэж байгаа шударга бус зүйлүүд бас гарч байгаа асуудлууд дээр ярьж байна.

Нэг үхрийн эвэр доргиход мянган үхрийн эвэр доргино гэгчээр хаа хаанаа та бүхэн хариуцлагатай байгаад байгаа шүү. Бид нар энэ тооноос чинь илүү хариуцлагын чинь асуудлыг яриад байна.

Та бүхнийг чанартай хууль батлахыг чинь яриад байна. Босго өндөр даваагаар давж байх хууль батлагдах асуудлыг яриад байна гэдэг асуудлыг ярьж байгаа юм. 50 дээр нэмэх нэг биш 4-ний 3-аар хууль батлагддаг байвал яасан юм? Ирц бүрддэг байвал яасан юм бэ? Ёс зүйтэй хариуцлагатай байхыг чинь бид

бүхэн чинь шаардаж байна шүү гэдэг асуудлыг яриад байгаа юм.

Тэгэхээр энэ дээр ч гэсэн бид нар бол бас анхаарч үзэх ёстой юм байна л гэсэн энэ саналыг эцэст нь бол хэлэх гэж байгаа юм. Баярлалаа.

Г.Занданишатар: Үндсэндээ санал хэлчихлээ.

Нямаагийн Энхболд гишүүн.

Н.Энхболд: Бид нар Байнгын хороод хуралдаад дүнгүүдээ гаргаад Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаад өчигдөр энэ оруулж байгаа төслөө өчигдөр орой Байнгын хороон дээр эцэслэж тохироод ингээд оруулж байгаа юм.

Тэгэхээр яг одоогийн байдлаар 152-ыг 126 болгосон талаар бусад Их Хуралд суудалгүй бусад нам эвслүүд юу гэж яг 126 гэдэг тоон дээр үзэж байгаа талаар яг одоохондоо судалгаа алга байна. Мэдээж өнөөдөр хэлэлцээд энэ тоо гадагшаа гарахаар тэр намууд байр сууриа илэрхийлнэ. Тэрийг бид нар бас харгалзах, тооцох яагаад гэвэл бүх л намууд оролцож байж энэ асуудлыг хөндсөн шүү гэдэг утгаар ярьж байгаа болохоор энэний дараа ч гэсэн тэд нарын байр суурийг харгалзаж үзэх ийм шаардлага гарна гэж нэг дүгээрт бодож байна.

Хоёрт тэр жагсаалтад санаа зовж байгаатай санал нэг байгаа. Тэнд бид нарын хамгийн том аргумент болгож оруулж байгаа нэг зүйл маань хэрэв жагсаалтаар ингэж сонгодог болчихвол нийгмийн сегментүүдийн төлөөлөл бүгдээрээ орох ийм боломж нээгдэнэ. Зөвхөн жагсаалтад ингээд бичээд орчих биш тэнд бүүр магадгүй тодорхой хувиуд заагаад ингээд оруулсан ч ийм улс орнууд байна. Энийг бас бид нар ярьж шийдэх асуудал. Гэхдээ энэ бол ихэнх улс орнуудад яг ингэж хувилж заасан их хэтэрхий

нарийвчилж заасан зүйлүүд үндсэн хуульд нь байхгүй юм байна лээ. Бид нар бас судалж үзсэн.

Тэгээд бүх ер нь дийлэнх хороонууд бол гол төлөв намуудын хууль, Улс төрийн намын хууль, Сонгуулийн хуулиараа энэ асуудлуудыг зохицуулж байгаа.

Энэ дээр онцгой анхаарах ёстой. Ерөөсөө сая уулзалтад оролцсон хүмүүсийн дийлэнх нь хамгийн санаа зовж байгаа зүйл нь энэ л байсан. Энэний жагсаалтын ард тэгээд бас л нөгөө болохгүй бүтэхгүй ийм улсууд ороод ирэх вий тэгээд дахиад одоо янз бүрийн муу хэлэгдээд байгаа хүмүүсийн тоо нэмэгдэх вий гэсэн ийм байр суурьтай байна лээ. Тэгэхдээ энэ заавал харгалзаж үзэх ёстой. Сонгуулийн хуулийн ажлын хэсгийг Тогтохсүрэн дарга ахалж байгаа. Бид нар бас энэ дээр ярьж байгаа асуудлууд бий.

Тодорхой сегментүүдийг нийгэмд хамгийн том хувь жин дардаг сегментүүдийг тухайлбал эмэгтэйчүүдээс эхлээд бид нар оруулж ирсэн. Дараа дараагийн шатад жишээ нь ахмадууд, залуучууд, малчин, тариачин гээд энэ томоохон бүлэглэж байгаад ингээд төлөөллийг нь заавал орох асуудлыг энэ сонгуулийн хуулийн өмнө тусгах ёстой гэж би бодож байгаа. Та өөрөө сая бас хувийн байр сууриа юу гэж ямар байр суурьтай байгаа вэ гэдэг дээр.

Тэгэхээр манай Байнгын хороогоор нь энэ дээр бас анхаарч мэдээж ажиллана. Ер нь зүгээр хэлэхэд энэ бол бид нар ганцхан Үндсэн хуулийн өөрчлөлтийн асуудал ярьж байгаа биш. Энэнтэй холбогдуулаад Сонгуулийн хууль, Намын хууль, Намын санхүүжилтийн хууль энэ 3 хуулийг багцаар нь хооронд нь их уялдаа холбоотой ингэж гаргаж байж бид нарын яв тавиад байгаа зорилго хэрэгжинэ яриад байгаа ажил болно. Энэ хоорондоо яг араа шүд нь таарсан машин шиг ийм хуулиуд гаргахгүй. Зүгээр тоо нэмж орхичоод бусдыг нь хэвээр нь

орхивол эндээс ямар ч үр дүн гарахгүй. Тийм ээ намуудын хуулиа шинэчлэхгүйгээр одоогийн байгаагаараа энэ Сонгуулийн хууль, энэ Үндсэн хуулийг хэрэглээд явна гэвэл урьдын алдаанууд давтагдана л гэж бодож байгаа.

Тэгэхээр гол ялангуяа иргэдэд танилцуулахдаа энэ чинь ганц нэмэлт өөрчлөлтийн асуудал биш шүү. Энэ бол бусад хуулиудтайгаа их хамт боловсрогдож батлагдаж байж үр дүнгээ өгөх ийм том ажил явж байгаа гэдгийг тайлбарлаж ойлгуулах ёстой юм билээ.

Манай гишүүд ч гэсэн 3 дугаар хэлэлцүүлгийн үеэр явцдаа энийгээ бас анхаарч ажиллана байх гэж найдаж байна.

Г.Занданшатар: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе ээ.

Би саналаа хэлэхээсээ өмнө Улсын Их Хурлын даргаас бас нэг хүсэлт байна. Өнөөдрийн энэ парламентад суудалтай улс төрийн намууд 3 нам байгаа. Одоо бол ХҮН намын дарга байна, Доржханд гишүүн байна. Би Ардчилсан намын бүлгийн дарга Цогтгэрэл гишүүнийг бас энэ хуралд суулгаж өгөөч ээ гэж ингэж хүсэх гэж байна. Бид одоо Монгол Улсын Үндсэн хуулийн өөрчлөлтийн асуудлаар улс орон даяар л ард иргэд маань анхаарал тавьж ингэж байгаа цаг үед ажиллаж байна. Тэгээд Үндсэн хууль гэдэг улс орны хувь заяатай холбоотой асуудлууд учраас ард иргэддээ өнгөрсөн хугацаанд Хэнтий аймгаас сонгогдсон Бат-Эрдэнэ гишүүн бид хоёрын хувьд бол аймгийнхаа сумдыг 2 хуваагаад энэ бүх сумдаараа явж энэ ард олондоо өнөөдрийн байгаа нөхцөл байдлыг ямар нэгэн байдлаар гоёчлолгүйгээр яг л бодит байдал улс төрийн нөхцөл байдал, гадаад дотоод хүчин зүйл, олон зүйлийг л одообас ярьж

хэлсэн ийм уулзалтуудыг хийсэн. Нэлээн одообас дэлгэрэнгүй уулзалтууд ч болсон. Хоёроос гурван цаг хүртэл үргэлжилсэн ийм уулзалтууд болсон. Ард иргэдийн хувьд, энэ тогтолцооны хувьд бол бас үнэхээр тогтолцоог бас өөрчлөх энэ хүчин зүйлүүдийг бас тал талаас нь би ойлгож хүлээж авч байна гэж ингэж харсан. Хэлж байгаа хүмүүсийн дийлэнх нь бол энэ тогтолцоог өөрчлөх нь зүйтэй юм байна гэдэг дээр бас нэлээн. Бас саналаа хэлж байна лээ. Ер нь одооэнэ санал гээгддэг энэ парламентын тогтолцоо цаашидаа явахгүй юм байна.

Өнөөдөр бид нар 62-ын бүлэг гээд Монгол Ардын намын бүлэг байгаа боловчиг ард иргэдээс 46-хан хувийн санал авсан байна. Энэ бол тогтолцооны алдаа юм байна гэдэг дээр бас олон иргэд дэмжиж байна. Мянган хүнтэй газар 3 хүн нэр дэвшихэд 340 хүний санал авсан нь би ялчихлаа гэж ярвайгаад байгаа болохоос биш 660 хүн дэмжээгүй хүний санал хаана байгаа вэ гэдэг дээр бас эргээд бодолцох ёстой гэдэг дээр иргэд байна. Ер нь бол бидний өнөөдрийн энэ явж байгаа тогтолцоо тэр 1995 онд Санжаасүрэнгийн Зориг гэдэг хүн бол бас яг л ярьж байсан юм байна лээ л дээ. Япон, Солонгос, энэ Азийн орнууд өнөөдрийн бидний энэ тогтолцоогоор яваад 1990-ээд оны эхээр мухардалд ороод тэгээд пропорциональ руу ороод ингээд явж байгаа гээд ярьж байсан тэр бичлэг юмнууд ч бас байж байна.

Тэгэхээр ер нь 2 дугаарт бид улс орныхоо хэмжээний томоохон энэ бүтээн байгуулалт, энэ улс орныхоо бодлогыг ярихгүй бол тухайн салбар болохоо больчхоод байна гэхэд зөвхөн байшингийн дээвэр цонх ярьдаг гишүүд байгаад байдаг учраас өнөөдөр улс орон томоохон юмаа шийдэхгүй зүгээр тойрог усалдаг улс төр яваад байна гэсэн ийм зүйлүүдийг ард иргэд бас маш сайн ойлгож хүлээж авч байна.

Нэг л зүйлийг хэлээд байгаа нь 2012 онд болсон. Энэ яг бидний өнөөдөр яригдаад байгаа энэ тогтолцоогоор явсан сонгуулийн үр дүнд магадгүй тухайн үед сонгогдсон зарим нэг хүмүүст нь ард иргэд нэлээн дургүй байсан юм болов уу даа л гэсэн. Тэрнээсээ болоод нөгөө хаалгаар гаргасан чинь тооноор ороод ирлээ гэдэг юм бас энд болсон юм байна гэж ингэж ойлгоод байгаа.

Тэгэхээр ард иргэд маань энэ алдаагаа битгий давтаарай гэдгийг ер нь цаашидаа энэ Сонгуулийн хууль энэ Улс төрийн намын хууль дээрээ ер нь яг яаж тусгах вэ? Энэ дээр бас олон эргэлзээ байна. Та нар сайхан юм ярьдаг. Яг амьдрал дээр бас буруу болчих вий гэсэн нэг ийм том эргэлзээ байгаа юм. Тооны хувьд олон хүмүүс саналаа илэрхийлсэн. 152 бол дэмжихгүй ээ гэсэн зүйлийг олон иргэд хэлж байгаа юм.

Надтай уулзсан уулзалт дээр хамгийн максимум тоог нь Өмнөдэлгэр суманд Итгэлжав гэдэг хүн хэлж байна лээ. 120 багцаа байхад болно гэсэн ийм зүйлийг хэлж байна лээ. Ер нь бол яах вэ яагаад ингээд тоо нэмэхийг эсэргүүцээд байгаа юм бэ гээд ингээд цаад углуургаар нь аваад үзэх юм энэ явж ирсэн энэ түүх, одоо энэ гарч ирж байгаа энэ олон авлигал албан тушаалын гэмт хэргүүд энэ болгон чинь бас иргэдийн итгэлийг нэлээн унагаачихсан, парламентын нэр хүндийг бас давхар унагаачихсан. Одоо энэ хэдийг яая гэж байхад дахиад ингэж 2 дахин нэмж орж ирлээ гэдэг нэг ийм зүйлийг бас яриад байгаа юм иргэд бол.

Тэгэхээр би бол энэ дээр бас нэг зүйлийг хэлмээр санагдаад байгаа юм. За яах вэ алдаа оноотой өнгөрсөн 30 жил явж иржээ.

Дараагийн 30 жил бол энэ Их Хурлын гишүүн болсноороо энэ кнопоо ямар нэгэн байдлаар үнэлээд, энийгээ өөртөө давуу байдал өөрийн хамаарал бүхий хүнд давуу байдал олгодог тэр

нөхцөл байдал, энэ 2022 оны Эрүүгийн хуулийн 22 дугаар зүйлд хийсэн өөрчлөлтөөр шал өөр болсон. ЖДҮ-ийн гэмт хэрэгт оролцсон Их Хурлын гишүүн 3 жилийн ял аваад 1.5 жилийг хорих ангид очсон худгийн манаач номын санч хийж байгаад гараад ирдэг байсан бол одоогийн энэ хуулиараа 12-оос 20 жил болсон юм аа.

Дээрээс нь Ашиг сонирхлын хууль гэж энэ ЖДҮ, энэ Хөгжлийн банк, нүүрс, Боловсролын зээлийн сан, ийм мэтийн юмнуудад бол Их Хурлын гишүүд ямар ч оролцох боломжгүй болсон гээд. Тэгэхээр ерөнхийдөө бол энэ зүйлийг бас цаашаа ярихад бас нэлээн үнэхээр энэ үнэн үү гэсэн байдлаар бас эргэлзэж байна гэж ингэж хараад байгаа юм.

76-ийн 1 гэж ярьж л байгаа боловчиг яг өнөөдөр бол эрх барьж байгаа намын нэг гишүүн л гэдэг утгаараа тэр хүний кноп өнөөдөр цаасан дээр бичигдээгүй ч, амьдрал дээр асар их үнэ цэнтэй байна л гэдгийн бас илэрхийлэл явж ирсэн.

Тэгэхээр би одоо энэ улс төрийн намуудаас яг одоо энэ тоо нэмэх, тогтолцоо солих энэ асуудал дээр энэ Улсын Их Хурлын чуулганы танхимд энэ улс төрийн намын төлөөллүүд, шийдвэр гаргах түвшиний хүмүүс бас энэ 152, 126 орж ирж байгаа энэ тоо. Дээрээс нь тогтолцоо солих энэ асуудлууд дээр бас ямархуу байр суурьтай байгаа вэ?

Тухайн намын бас яг шийдвэр гэж ингэж бас ойлгож болох уу? Энэ дээр би ХҮН намаас асууж байгаа юм. Ардчилсан намаас бас тодруулж байгаа юм, нэгдүгээрт.

Хоёрдугаарт бид ингээд тойрогтоо очихоор ард иргэд маань уурлаад байна. 152-ыг дэмжихгүй байна. Одоо бид нар ингээд тоог нь буулгая. 126 дээр тогтлоо гэж. Би 152 гэдэг тоог зүгээр нэг 76-г 76 дээр нэмээд оруулж

ирсэн тоо гэж би огт бас бодохгүй байгаа шүү дээ. Энэ тогтолцооны өөрчлөлт хийе гэж байгаа. Энэ тогтолцооны өөрчлөлт хийхэд энэ Улсын Их Хурлын чадавх энэ хамгаалагдсан байдал олонхоороо ярих гээд. Энэ олон зүйлүүдийн үндэслэж гаргасан тоо юм байна гэж ингэж харж байгаа юм. Иргэд дэмжихгүй байгаа учраас одоо 126 гэж байгаа юм. Магадгүй одоо ингээд очихоор 126-г дэмжихгүй бол дахиад доошлох уу?

Хэрвээ ингээд доошлоод ирэх юм бол нөгөө тогтолцооны өөрчлөлт шинэчлэлт биш харин 76 дээр нэг хэдхэн гишүүн нэмсэн ямар ч үр дүн багатай ийм өөрчлөлт болж хувирах ийм болгоомжлол байна. Судлаачид энийг бас юу гэж үзэж байгаа вэ? Бид нар судлаачдынхаа үгийг сонсдог судлаачдын тэр үндэслэлүүдийг бас нэлээн сайн үздэг сонсдог байхгүй бол болохгүй ээ. Нөгөө араг хийнэ гэж эхлээд чигчлүүр болгочихлоо гэдэг шиг тогтолцооны өөрчлөлт шал өөр 30 жилийг босгохын төлөө энийг хийж байгаа гэж байгаа хэр нь ээ явж явж ирээд нөгөө даргын тоог хэдхэнээр нэмсэн өөрчлөлт болж бас хувирах вий гэсэн ийм 2 зүйл байгаа юм.

Гурав дахь асуулт юу вэ гэхээр ингээд гишүүдийн тоог нэмээд л янз бүр болгоод байна.

Энэ гишүүдийн ёс зүйн асуудлыг ер нь яах юм бэ? Эргүүлэн татах асуудлыг ер нь бас давхар ярьж болдоггүй юм уу? Энэ халдашгүй эрх гэдэг энэ зүйл бас яг ямар учир шалтгаантай юм. Энэн дээр бас ямар нэг зүйлийг хийх вэ гэдэг асуултуудыг бас олон асуулт яригдаж байгаа юм. Ялангуяа би нэг олзуурхаж байгаа юм нь юу гэхээр хөдөө сумдаар явахад надад 4 сум дээр энэ Их Хурлын гишүүдийн ёс зүйн асуудлыг гаргаж тавьж байна. Нэгнийгээ хулгайч зэлгийчээр нь дууддаг. Үнэхээр хулгайч бол тэр шорондоо явах ёстой. Хүнийг хулгайчаар нь гүтгэсэн бол тэр хүн хариуцлагаа хүлээх хэрэгтэй.

Г.Занданшатар: Ардчилсан намын бүлгийн дарга Цогтгэрэл яаралтай уулзалттай болоод сая 30 минутын чөлөө авсан. Орж ирээд үгээ хэлэхдээ энийг хариулах байх. Ер нь бол Байнгын хорооны санал дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж үг хэлнэ.

Байнгын хорооноос гарсан ажлын хэсэгт орсон гишүүд ажлын хэсгийн гишүүний хувьд Доржханд гишүүн асуултад хариулна. Батсуурь гишүүн бас Ардчилсан намын бүлгийг төлөөлж орж байгаа хариулж болно.

Доржханд.

Т.Доржханд: Тэгэхээр асуултад бас их талархаж байна. Тэгээд бас асуугаасай гэж бас бодож байсан асуулт байна.

Тэгэхээр Улсын Их Хуралд суудалтай намууд болон Улсын Их Хурлын гадуур намууд энийг 2 жил тойрон ярьсан, тохирсон. Санамж бичгүүдээ хоёр ч удаа бас зурсан. Тэгээд үр дүнд нь тогтолцооны асуудал 50, 50 байх юм байна. Тэгээд судлаачдынхаа байр суурийг хүндэтгэх нь зүйтэй юм байна. Тийм болохлоороо 150-аас 155 байх юм байна. Тэгэхээр 152 гэдэг тоо болж байна гэсэн ийм агуулгаар бол ярилцсан.

Үр дүнд нь Засгийн газрын зүгээс бас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг төслийг судлаачдынхаа баг бүрэлдэхүүнтэйгээр оруулж ирсэн гэж ойлгосон.

Одоо ингээд эхний хэлэлцүүлэг явсан. Эхний хэлэлцүүлгээр бол Улсын Их Хурлын гишүүд бүгд тойрог дээрээ очиж ажилласан. Тэгээд ажлын хэсгийн түвшинд ирсэн мэдээллээр бол Улсын Их Хурлын гишүүд тойрог дээр ажиллах үед иргэд 152 гэдэг тоо их байна. Тийм болохоор энийг буулгах нь зүйтэй гэсэн энэ санал давамгайлсан. Зарим нь бол 152

байх нь зүйтэй. Зарим нь бол бүүр 76-гаагаач нэмээд хэрэггүй гэсэн ийм 3 янзын саналууд байна гээд.

Тэгээд иргэдийнхээ саналыг хүндэтгээд энэ асуудлыг ярья гэж, нэг. Тэгээд ярих уулзалт хэлцлийн хувьд юу болсон бэ гэдгийг би бас тодорхой хэлье. Улсын Их Хуралд суудалтай 3 нам байгаа. Монгол Ардын нам, Ардчилсан нам, ХҮН нам. Тэгээд 3 намын удирдлагууд бас хоорондоо уулзаж нэлээн бас тодорхой ярилцсан.

Ярилцаж байх үед бол зүгээр хүн намын байр суурь бол нэгэнт шинжлэх ухаан нь гэж байдаг юм бол судлаачдын бас дүгнэлтүүд байдаг юм бол өнөөдөр бид нар бас ирээдүйгээ харж шийдвэрээ гаргах ёстой гэж байгаа юм бол 152 гэдэг тоон дээрээ хатуу байх ёстой. 50, 50 гэдэг тогтолцооныхоо зарчим дээр хатуу байх нь зүйтэй л гэсэн ийм байр суурьтай байсан.

Яагаад вэ гэхээр 2040 он гэхэд Монгол Улсын хүн ам 5 сая болно. 50, 60 он гэхэд 10 сая болно. Гэтэл хатуу тоо ингээд Үндсэн хууль дээрээ зоогоод өгчихлөөр дахиад л Үндсэн хуулийн өөрчлөлтийнхөө асуудлыг тухай болгон л ингээд ярих ийм нэг жишиг тогтоочих гээд байгаа юм.

Тэгэхлээр бид нар зөвхөн өнгөрснөө хараад өнөөдрөө хараад шийдвэр гаргах биш бас ирээдүйгээ хараад шийдвэр гаргах нь зүйтэй юм гэсэн ийм байдлаар хандаж байсан. Гэхдээ Улсын Их Хурал гэдэг нэг намын шийдвэрээр бас дагаж явах учиргүй. Мөн ард иргэдийнхээ саналыг тусгаад мөн Их Хуралд суудалтай намуудын бас байр суурийг хүндэтгээд явах нь зүйтэй. Энэ бол зөвшилцлийн аргачлал юм гээд. Тэгээд энэ агуулгаараа бол Ардчилсан намын байр суурин дээр нэгдээд дэмжээд явах нь зүйтэй юм байна л гэсэн үг. Ийм л ойлголцол дээр бол би ХҮН намын даргын хувьд, хүн амын удирдах зөвлөл холбогдох

шат шатын шийдвэр дээр үндэслээд 126 гэдэг тоог нь дэмжсэн.

Дэмжихдээ бас энэ цаад агуулга нь ямар агуулгаар юм бэ гэдгээ бас тодорхой хэлье. 1992 оны шинэ Үндсэн хуулийг хийж байхад нэг гишүүний төлөөлөх чадвар нь 27 мянган гишүүнийг төлөөлж байгаа юм байна лээ.

Өнөөдөр 3.4 сая иргэдийн төлөөлөх тэр тоо нь болохлоороо яг 27 мянга гээд нэг гишүүн төлөөлнө өө гэх юм бол 126 гэдэг тоо бас гарч ирж байгаа юм байна лээ.

Тэгэхээр ядаж 1992 оныхоо тэр төлөөлөх чадварыг буулгахгүйгээр явъя гэж. Хамгийн багадаа гэж байгаа юм.

Хоёр дахь нь авлига хулгай яагаад өсөөд байгаа юм бэ гэдэг иргэд бол бүгд энийг л асууж байгаа шүү дээ. Тэгээд таны бас хэлж байгаа энэ хүмүүст хариуцлага тооцдог Улсын Их Хурлын гишүүнээс нь эргэн татах асуудлыг тавиач ээ гэдгийг мөн иргэд ярьж байгаа. Би тантай бас санал нэг байна.

Гэтэл авлига хулгай яагаад үүсээд байгаа юм бэ гээд тэгэхээр ерөөсөө л манай парламентын гишүүдийн тоо цөөхөн байна. Олон улсад парламентын шийдвэр гаргаж байгаа бүтэц нь 120-оос доош гишүүнтэй л байх юм бол тэнд авлига, хээл хахууль, хулгай нүүрлээд, хоорондоо хуйвалдаад байдаг нь тодорхой байна.

Тэгэхээр тухайн улс хүнийхээ тоогоос үл хамаараад 120-оос дээш парламентын гишүүнтэй, мөн 800-аас ихгүй парламентын гишүүнтэй ийм л байдлаар парламентын улсууд бүгд ажиллаж байна.

Тийм болохлоор бид нар энэ 126 гэдэг тооноос цаашаа буулгах юм бол энэ өөрчлөлтийг хийгээд ч хэрэг байхгүй, үр дүн гарахгүй. Ингэсэн тохиолдолд бол

өнөөдрийнхөө хулгай, өнөөдрийн энэ ядууралтайгаа л явна гэсэн үг. Бодлого ярих ямар ч боломж байхгүй.

Хөгжил ярих ямар ч боломж байхгүй.

Хэрвээ хөгжил ярья гэх юм бол энэ парламентад байгаа улс төрийн хүчнүүд нь хөгжлийн төлөө нэгддэг, зөвшилцлийн энэ ардчиллын механизм руугаа явж байж л хөгжил ярих боломжтой болно. Яг өнөөдрийн тогтолцоогоороо чи муухай, би сайхан гэсэн бие биеийгээ харлуулдаг бие биедээ дэгээ тавьдаг, хоцрогдсон харанхуй, тэгээд хөмөрсөн тогоон дотроо байдаг хаалттай эдийн засагтай, ядуу буурай авлигатай идэгдсэн энэ улс чинь өөрчлөгдөхгүй ээ. Энэ дэлхийн түүхийн Африкийн орнууд ингээд хөгжихгүй байгаа юм 100 жил, Латин Америкийн орнууд хөгжихгүй байгаа юм. Ийм болохлоороо бид нар энэ хөгжлөө хийе ээ гэх юм бол парламентын засаглалаа бэхжүүлэх, ардчилсан улс байх, хүний эрх, эрх чөлөө, бизнесийн эрх чөлөөг дэмжээд явах. Цаашаагаа тусгаар улсууд байх юм бол парламентынхаа төлөөллийг нэмэгдүүлэх гэдэг энэ агуулгаараа бид нар бол энэ өөрчлөлтийг хийх ёстой.

Хамгийн бага тоо бол 126 дээрээ байна. Дахиад 2 дахь, 3 дахь хэлэлцүүлгийн үеэр энэ тооны асуудал сөхөгдөж гарч ирэх юм бол энийг ХҮН нам хэрхэвч хүлээж авахгүй ээ гэдэг дээр хатуу байгаа. Харин харьцааны хувьд 50, 50 гэдэг зарчим дээрээ байгаа.

Гэтэл Улаанбаатар хотоос сонгож байгаа энэ төлөөлөл чинь бас бодлогын улс төрчид байх ийм агуулгаараа бас 50, 50 байх боломжтой гэдэг энэ нөхцөлийг ярьсан.

Тэгэхээр энэ хэлцэл дээр үндэслээд ХҮН намын зүгээс тэгвэл Ардчилсан намын энэ саналаар 60, 40 гэдэг харьцааг тэгээд цаашаа 126 гэдэг нийт Улсын Их

Хурлын гишүүдийн тойрог дээр ажилласан иргэдийн бас саналыг тусгаад явах нь зүйтэй юм байна гэсэн агуулгаар ХҮН нам хандаж тэгээд энэ ажлын хэсэг дээр ч гэсэн энэ бас саналыг дэмжээд явж байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Батсуурь ажлын хэсгийн гишүүн хариулах уу?

Жамбын Батсуурь гишүүн.

Ажлын хэсгийн гишүүний хувьд сая Идэрбат гишүүний асуусан асуултад хариулъя.

Ж.Батсуурь: Идэрбат гишүүний асуултад хариулъя гэж бодож байна. Тэгэхлээр Ардчилсан намын хувьд ерөөсөө тоо ярихгүй байгаа. 60, 40 гэсэн энэ тогтолцооны өөрчлөлтийг хийх нь зөв гэж Ардчилсан намын Үндэсний бодлогын хороон дээр бас нэлээд урт хугацаанд өргөн бүрэлдэхүүнтэй ярьж хэлж энэ шийдвэрийг гаргасан.

Тэгээд энэ шийдвэр бол бас 2009 онд яригдаж байсан, 2012 онд яригдаж байсан. Ардчилсан нам бас энэ нийгмийн шинэчлэлийг хийхийн төлөө энэ тогтолцооны шинэчлэлийг хийе гэж бас олон удаа өргөн баригдаж байсан ийм зүйлүүд байдаг юм билээ. Тэгээд 60, 40-ийн хувьд бас учиртай.

Мажоритар буюу төлөөлөх зарчим нь 60, Монгол Улс бол өөрөө асар өргөн уудам нутаг дэвсгэртэй. Цөөн хүн амтай, тэгээд энэ нь өөрөө 21 аймаг, 9 дүүрэг, 300 гаруй сум, 1000 гаруй баг хороонд хуваарилагддаг.

Тэгэхээр энэ хүмүүсийн тэнд амьдарч байгаа нөхцөл байдлыг төрийн бодлогод тусгуулах мөн хөрөнгө оруулалтын тэнцвэртэй харьцааг бий болгох амьдралын чанарыг нь адил тэгш байлгахад бол төрийн бодлогыг хэрэгжүүлэх нөхцөл байдал бол ерөөсөө энэ мажоритар системийн 60 гэсэн

агуулгыг алдаж болохгүй юм л гэж байгаа юм.

Өнөөдөр хэдийгээр тогтолцооны шинэчлэлээр зарим судлаач нар зарим намынхан 50, 50 түүнээс илүү пропорциональ орж ирье гэх юм бол хөдөө хаягдана. Хөдөө хаягдана гэдэг бол өөрөө Монгол хаягдана гэсэн үг.

Өнөөдөр ер нь нэг хэсэг бол 2 өөр Монгол болчихсон байсан. Суманд яваад очиход гэрэлтэй гэгээтэй зүйл хаана байлаа. Халуун дулаан байхгүй, өвөл нь хөлдөж хөрсөн. Аймагт яваад очиход буудлаас авхуулаад соёлын үйлчилгээ нөхцөл байдал ямар хэцүү байлаа. Энэ хугацаанд өнгөрсөн 8 удаагийн сонгуулийн энэ мажоритар системийн бас давуу талыг нь, муу талыг нь хүмүүс ярьдаг боловч давуу тал нь гишүүд тойрогтоо усан бассейнтай болгоё гэдэг юм уу, хөл бөмбөгийн талбайтай болгоё, соёлын төвтэй болгоё ингэж эндээс 1000 км яваад очиход тэр Алтайн цаадах сум, Хөвсгөлийн хоймор нутаг, зүүн бус нутгийн хамгийн цаад талын сумд юу гэдэг юм Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан суманд гэж яваад очих юм бол хэрвээ Соёлын төв байхгүй бол хоорондоо яаж уулзах юм. Нэг одоо тэгэхээр тэр хүмүүст төрийн үйлчилгээг хүргэх, тэр хүмүүсийн санал бодлыг сумын түвшинд, багийн түвшинд, аймгийн түвшинд, мөн нийт цаашилбал төрийн бодлогын түвшинд зангидах тул энэ мажоритар систем нь 60 хувь байх нь бол зөв юм.

Дээр нь пропорциональ систем яагаад 40 хувь гэж Ардчилсан нам хэлээд байна вэ гэхээр төрийн бодлогын түвшинд одоо энэ том төслүүд бас яригдахгүй байна. Мөн санал гээгдэж байна гэж.

Жишээлэх юм бол өнгөрсөн 8 сонгуулийн 2-оос бусад нь Ардын нам ялж байсан. Ялах ялахдаа 70 суудал, 65 суудал, 62 суудал авч байсан. Тэгсэн мөртөө тэр

хүмүүсийг нийт сонгогчдын 50 гаруй хувь нь хүсээгүй байхад төрийн бодлогыг 100 хувь барьж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энийг судлаачид юу гэж үзээд байна вэ гэхээр санал гээгдээд байна л гэж байгаа юм. Санал гээгдээд байна.

Санал гээгдэхгүй байх зарчим нь юу вэ гэнгүүт энэ пропорцион системийн онцлог юм гэсэн байр сууриас хандаж байгаа юм.

Тийм учраас төрийн төлөөлөл, ард түмний төлөөлөл, нөгөө ард иргэдийн хэлдгээр имэрч үзэж гишүүнээ сонгодог зарчим бол 60 хувьдаа явъя. Санал гээгдэхгүй байх зарчим нь 40 хувь дээрээ явъя гэсэн энэ санааг ярьж байгаа юм.

Жишээлэх юм бол өнөөдөр сөрөг хүчинг үгүйлж байна гэж байна. Үгүйлэхээс өөр арга байхгүй. Бид нар аравхан хүн, арван нэгхэн хүн. Арван нэгхэн хүний дуу хоолой тэр 19 хүнтэй Байнгын хороон дээр 62 хүнтэй Их Хурал дээр бол асуудлаа тийм тов тодорхой хэлээд байх боломж байдаггүй.

Хэрвээ хувь тэнцүүлсэн системээр орж ирсэн өнөөдөр сөрөг хүчнээс 20 гаруй 30-аад хүмүүс сууж байх ийм боломжууд бас бүрдэх бололцоо бол 62-ын бүлгийн 2020 онд ч 65-тай 2016 онд ч тэр далан хэдтэй тогтолцоонууд дээр ч гэсэн байж байсан гэдгийг олон талаас нь ярьсан.

Тэгээд одоо 152 гэдгийг угаасаа анхнаасаа дэмжээгүй. Бидний хувьд бол энэ пропорциональ системийн элементийг оруулах юм бол саяын одоо орон нутгийн бөгөөд төрийн бодлогын тэгш харьцааг бий болгосон энэ асуудлууд бол бий болох юм гэсэн ийм байр сууриас бид бүхэн энэ пропорциональ тогтолцоог дэмжиж байгаа гэдгээ илэрхийлье.

Г.Занданшатар: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн тодруулж асууя.

Ц.Идэрбат: Тогтолцооны хувьд яг Батсуурь гишүүн бол нөгөө ард иргэдийн дэмжиж байгаа эсэхийг л яриад байна л даа. Ер нь бол энэ өнөөдрийн тоо, энэ бүх зүйлүүд, энэ улс төрийн намууд зөвшилцөлд орж ирж байгаа л гэж ингэж ойлгож байгаа.

Тогтолцооны хувьд 60 хувь байна гэдэг Ардчилсан намын тэр саналыг миний хувьд дэмжиж байгаа. Хэнтий аймгийн Дадал суманд тэднийг төлөөлсөн хүн тэнд л очиж зовлон жаргалыг нь сонсож уулзаж ярина шүү дээ. 60км газар зорьж очно. Дан пропорциональ байх юм бол Дадал суманд очихгүй энэ хэдэн телевиз сайтуудаар л гүйгээд байх юм байна лээ л дээ.

Тэгэхээр зовлон энэ пропорциональ тогтолцооны онцлог бүх юмыг ойлгож байгаа. Бид нар чинь энэ маш том нутагтай. Би ажлын хэсгээс Ардчилсан намын хэсгээс асуугаад байгаа. Энэ 126 гэсэн энэ тоог гаргаж ирэхдээ улс төрийн намууд зөвшилцөл гаргаж ирсэн үү? Энэ дээр Ардчилсан нам яг энэ 126 гэдэг энэ тоон дээр ямархуу байр суурьтай байгаа юм бэ? Иргэд ойлгохдоо болохоор эрх баригч нарт хүчээр хийчихсэн юм шиг ингэж хараад байгаа юм.

Тэгэхээр тогтолцоон дээр байгаа шигээ тоон дээр ч гэсэн Ардчилсан нам энэ тогтолцооны шинэчлэлийг хийе гэдэг дээр зоригтой байгаа юм. Нэгдсэн байр суурьтай байгаа юм.

Улс орны дараагийн хувь заяаг 30 жилийг бас бодож ярьж байгаа юм гэж би ийм л хариулт эсвэл үгүй юмаа. Хүчээр оруулаад ирсэн юм гэдгийг л аль нэгийг нь хэлээч ээ л гэж байгаа байхгүй юу.

Мөн судлаачдаас одоо ингээд 152 маань 126 боллоо. Одоо ингээд 126 гэхээр иргэд энийг дургүйцээд надад хэлсэн ганцхан хүн боо 120 гэж максимум байхгүй юу. Одоо очоод уулзахаар иргэд юу хэлэхийг бол би бас хэлж мэдэхгүй.

Бид өнөөдөр энд иргэдийнхээ дуу хоолой болж бас суух ёстой. Хэрвээ ингээд дахиад буулгаад ирэх юм бол энэ энэ өөрчлөлт маань өөрчлөлт байж чадах уу? Нөгөө нэг араг хийх гэж байгаад шүдний чигчлүүр гэдэг шиг харин бүр болиод дарга нарын тоог нэмээд хаячих уу гэдэг дээр яг судлаачид маань яг юу гэж үзэж байгаа юм бэ?

Г.Занданшатар: Батсуурь гишүүн. Нямаагийн Энхболд дарга хариулсан ч болно.

Н.Энхболд: Дараа нь Батсуурь гишүүн бас хариултаа өгнө биз дээ. Зүгээр нэг ийм л зүйлийг одоо бид нар ерөнхийдөө ажлын хэсэгт орж байгаа хүмүүс ч тэр, хууль санаачлагчид ч тэр, Их Хурлын гишүүд ч тэр ерөнхийдөө нэг ойлголттой байгаа болов уу гэж бодож байна.

Яагаад гэвэл тогтолцооны асуудлыг ярьж, хөндөж, тэрийг зөвшөөрч байгаа бол энэ яах аргагүй тоотойгоо уялдаж байгаа юм. Тоо нь өөрчлөгдөхгүйгээр холимог тогтолцоо руу орохоор олон гишүүд хэлж байна. 2012 онд бид нар ингэж нэг оролдож үзсэн. Тэндээс ямар ч үр дүн гараагүй ээ гэж. Нэгдүгээрт бид нарын туулчихсан зам энэ байгаа.

Хоёрдугаарт ерөөсөө асуудлаа томоор харъя, илүү ирээдүй рүүгээ харъя. Тэгээд нөгөө холимог тогтолцооны онцлог гол давуу тал нь ерөөсөө нийгмийн зөвшилцлийг аль болох өргөн хүрээнд явуулах тийм л бүтэц бий болгох тогтолцоо шүү дээ. Тэгээд тэрийг нэгэнт бид нар “А” гэж хэлээд тогтолцоогоо шинэчилье. Холимог болгоё гэж байгаа бол яах аргагүй араас нь “Б” гэдэг үсэг нь тоотойгоо холбогдож л гарч ирж байгаа юм. Чухам хэд байх вэ гэдэг нь л бидний ёстой олон нийтээс санал авч байгаа дотроо зөвшилцөж байгаад энэнээс доош буучихвал үр дүнгүй юм болчихдог юм байна шүү дээ гэдгээ ойлголцоод явбал 3

дугаар хэлэлцүүлгээр бас тоо гарах болов уу л гэж бодож байна.

Сая намын дарга Доржханд хэлж байна лээ. Энэнээс доошоо гарчихвал ер нь бараг үр дүнгүй болно доо. Тэгээд үргэлжлүүлээд ч хэрэггүй гэсэн маягтай ярьж байна лээ. Иймэрхүү байр суурьтай хүн олон байгаа болов уу л гэж би бодож байна. Тэгэхдээ 3 дугаар хэлэлцүүлэг явагдана. Тэрний өмнө бас дахиад сонсоно, дахиад зөвшилцөнө, ярилцана. Зүгээр дахиад давтаад хэлэхэд нэгэнт тогтолцоо ярьж байгаа бол энийг дагаж тоо хөндөгдөхөөс аргагүй ийм л.

Г.Занданшатар: Жамбын Батсуурь гишүүн.

Н.Энхболд: Үгүй ээ яах вэ Ардчилсан намын хувьд бол би сая аягүй ойлгомжтой хэлж байна шүү дээ. Бид нар тогтолцоог өөрчлөх 60, 40 гэсэн саналыг хэлсэн. Энийг бол 76 дотроо ч хийж болох юм. Ямар ч хэлбэрээр хийж болох юм гэж. Сая Нямаагийн Энхболд гишүүн хэлж байна.

Тогтолцоо тоо 2 бол зоосны 2 тал болоод байгаа юм гэж. Мөн миний өмнө танаас асуусан Доржханд болонгуут 152-оос доошлуулахгүй, 126-аас доошлуулахыг бид нар хэрхэвч хүлээн зөвшөөрөхгүй гэж хэлж байна.

Тэгэхлээр энийг чинь Ардчилсан нам тогтоож байгаа биш, ХҮН нам тогтоогоод байгаа юм биш үү. Хэрхэвч зөвшөөрөхгүй гэхээр чинь хамгийн доод тоог тэнд зааж өгч байгаа юм биш үү гэсэн ийм зүйлүүд байгаа. Мэдээж олон талаас ярьсан зүйлүүд байгаа. Ардчилсан намын хувьд бол яг Үндсэн хуулийн өөрчлөлттэй холбоотой 5 багц асуудлуудыг өргөн барьж санал болгосон юм байгаа юм.

Хүний эрхийн асуудлууд, тогтолцооны асуудлууд, мөн энэ хувийн өмч Үндсэн хуулийн цэцтэй холбоотой

асуудлууд. Хөөн хэлэлцэх хугацаатай асуудлууд гээд. Тэгээд Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээр яригдаад Ардын намын ч, Ардчилсан намын ч бусад саналуудыг бол энэ Үндсэн хуулийн өөрчлөлт, нэмэлтээр хийх шаардлагагүй юм.

Зөвхөн тоо тогтолцоотой асуудлуудыг ярих нь зүйтэй юм гэсэн байр сууриас бид нарт өргөн баригдсан Засгийн газраас өргөн баригдсан хуульд тоо тогтолцоо барьсан учраас бид нар энэ хүрээнд саналаа илэрхийлээд явж байгаа гэдгийг Идэрбат даргад гишүүнд хэлье ээ.

Би ингээд өөрийнхөө санал руу орох уу? Цагаа нольлуулчихъя.

Г.Занданшатар: Жамбын Батсуурь гишүүн.

Ж.Батсуурь: Баярлалаа.

Миний хувьд бол энэ Үндсэн хуулийн өөрчлөлттэй холбоотой асуудлуудыг гишүүн болсон цагаасаа авхуулаад 3 дахь жилдээ нэлээд илүү түлхүү ярьж байна даа. Хаврын чуулганы нээлт дээр энэ тэр бас нэлээд тод томруун ярьчихсан.

Тэгээд энэ удаад бол би өөрийнхөө хувийн байр суурийг гэхээс илүү сая бид нарын 5 сарын 5-наас эхлүүлээд 10 хоног орон нутагт нэг дүгээр хэлэлцүүлгийн дараа ард иргэдтэй уулзаад санал бодлыг нь сонсоод ир гэсэн.

Тийм учраас ард иргэдийн хэлсэн ярьсан зүйлийг Ганибал гишүүн бид 2 аудио, видео бичлэгээр мөн цаасан протоколоор маш нарийн тэмдэглэж ингэж авсан. Мэдээж энэ бусад газруудынхтай бусад гишүүдийн явж байгаа нөхцөл байдлуудтай адил байсан байх гэж ингэж бодож байна.

152 гэдэг тоог бол дэмжихгүй ээ. Дэмжиж байгаа нэг хүн байсан.

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын 1 дүгээр багийн иргэн Батмөнх гэж хүн. Бусад хүмүүс бол бүгд одоо дэмжихгүй ийм нөхцөл байдлуудыг бий болсон байгаа юм.

Ард иргэд бол нэг зүйлийг энэ та бүхэн энэ Үндсэн хуулийг өөрчилнө гэж байна. Олон ч удаа өөрчилсөн сүүлийн он жилүүдэд бас нэг нам дангаараа 65, 62-той байх үедээ 2, 3 дахь удаагаа ч өөрчилчихлөө. Ингээд 1992 онд анх Ардчилсан Үндсэн хууль байгуулагдахад төрж байсан хүүхэд өнөөдөр 31 настай болчихсон байна.

Тэгэхлээр энэ нөхцөл байдлуудыг бол энэ санах ойг нэг ахиж тодруулж хэлж ярьж өгөөч ээ гэж.

Өнөөдөр өнгөрсөн 8 сонгуульд энэ сонгуулийн тогтолцооны бүх хэлбэрийг үзсэн байгаа юм. Жижиг мажоритар, том мажоритар холимог гулсдаг гээд. Тэгээд 9 дэх сонгууль дээрээ энэ нөхцөл байдал болохгүй байна. Тооны шинэчлэл тогтолцооны шинэчлэл хийе гэж Засгийн газар өргөн барьж энэ хэлэлцүүлэг хийгдэж байгаа юм.

Тэгэхээр энэ өнгөрсөн 8 удаагийн сонгуулийн Ардчилсан нам 2 удаа л эх барьж байсан. 1996, 2012 он. Бусад 6 сонгуульд буюу 24 жилд нь бол өнөөгийн эрх барьж байгаа МАН 70-тай, 60-тай, 62-тойгоор эрх барьж 100 хувь биелүүлж байсан. Гэтэл одоо өнгөрсөн энэ 32 жилийн хугацаанд энэ дуулиант зүйлүүд ер нь шийдэгдсэн зүйл байна уу? Энийг энэ хэлэлцүүлгийн үед нэг санаж сэрэх байдлаар санамж өгөхгүй байдлаар хэлж өгөөч гэсэн ийм маш олон хүмүүс санал бодлоо хэлж байна. Жишээлэх юм бол Хадгаламж зээлийн хоршооны хэрэг гэж яригдаж байсан. Энэний асуудал ер нь шийдэгдсэн үү, ямар хүн хариуцлага хүлээсэн байдаг юм. Хүн амины улс төрчдийн амийг бүрэлгэсэн Зоригийн хэрэг, Батхүү агсны хэрэг гээд энэ нөхцөл байдлууд ямар зүйл рүү орсон. Авлигал

албан тушаалын хэргүүд ерөөсөө яриад л байх юм. Хууль нв чангараад л байна уу гэх юм.

Нүдэн дээр торгууль төлөөд л гараад байх юм. Нүдэн дээр торгууль төлөөд л гараад байх юм. Яг одоомтэр яриад байгаа шиг 10, 20 жил авчихсан авлигалын хэргээр авсан хүмүүс байхгүй байна. Тэгээд энэ Хөгжлийн банк гээд юм гараад ирлээ. Нүүрсний хулгайн асуудлууд яриад л байдаг. Шүгэл үлээгээд л байдаг, шувуу, шулам яадаг 5 ш гээд юмнууд явуулаад байдаг. Үр дүн гарахгүй байна. ЖДҮ-ийн асуудал бодит 50 гишүүн яригдаж байсан. Нэг нь ч хариуцлага хүлээгээгүй.

Тэр үеийн эрх барьж байсан намын 50 гишүүн холбогдож байсан. Нэг нь ч хариуцлага хүлээгээгүй. Дахиад бүр орж ирчихсэн дараагийнхаа хэргийг яриад л сууж байх жишээний. Төмөр замын асуудал, долларын ханшийн асуудал. Та нарын анхны ардчилсан Үндсэн хуулиа баталж байхад доллар 35 төгрөг болчихсон байсан байна.

Өнөөдөр 8 удаагийн сонгуулийн дараа бүрэн шинэчлэл хийнэ гэж ярихад чинь 3500 болчихжээ. 100 дахин өссөн байна. Тэгэхээр шударга ёс 100 дахин алдагдсан байна. Үнийн өсөлтийн асуудал 100, түүнээс ч илүү зарим үед 1000 хувь өссөн байна.

Зээлийн хүүгийн асуудлыг бууруулах асуудлууд юу болж байна вэ? Энийг нэг сануулж хэлж өгөөч. 2019 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулахад төгс хууль боллоо гэсэн.

Дараа нь энэ төгс хууль чинь арай төгс биш юм. Давхар дээл өмсөхгүй бол дөрөвхөн хүн давхар дээлтэй улс орны үйл ажиллагааг явуулж чадахгүй байна гээд хоёр, гуравхан цагийн дотор бүгдээрээ давхар дээл өмссөн. Одооцаашилбал тогтолцооны шинэчлэл хийе гэж байна. Энэ шинэчлэлүүдийг хийхэд саяын

дээрийн яриад байгаа тэр Хадгаламж зээлийн хоршоо, Боловсролын зээлийн сан ч гэдэг юм уу. Өнөөдөр Боловсролын зээлийн сангаас авч байгаа, тэрийг хэрэглэсэн, эргэн төлнө, төлөхгүй, минийх байсан, миний хүүхдийнх биш байсан би мэдээгүй гэж байгаа зүйлүүд бол дандаа эх баригчдын үр хүүхэд, төрөл саднууд байна. Тэгээд энэ нөхцөл байдал чинь энэ тооны бөгөөд тогтолцооны шинэчлэлийн цаана үнэхээр засагдана гэсэн ийм одоо итгэл үнэмшил байна уу? Энийг одоо хэлж өгөөч ээ гэсэн ийм зүйлийг бас хэлж байгаа.

Дээр нь энэ Үндсэн хуулийн цэцтэй холбоотой асуудлуудыг үнэхээр их гаргаж ирж тавьж байна.

Монголын төрийг ерөөсөө сүүлийн он жилүүдэд буужигнуулж байгаа. Төрийн эргэлтийн шинж чанартай зүйлүүдийг хийж байгаа зүйлийг Үндсэн хуулийн цэцээс гарч ирж байна л гэж бодож байна.

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн байна гэсэн ийм шийдвэр гаргаж Монголын төрийг буужигнуулж байгаа үйл ажиллагаа хийж байгаа тэр 9 хүнтэй хариуцлага тооцохгүй юм уу?

Тэрийг яагаад ингээд хадгалаад байдаг юм бэ? Яагаад тэрүүгээр улс төрч нар гар хөлөө хийгээд байдаг юм бэ гэсэн асуудлуудыг л гаргаж ирж тавьж байна.

Дээр нь энэ мажоритар тогтолцоо буюу төлөөллийн зарчмыг бол 60-аас доош оруулж болохгүй гэж сая би Идэрбат гишүүний асуултад хариулахдаа хэлсэн. Монгол Улс бол маш том газар нутагтай. Цөөхөн хүн амтай. Тэгээд засаг захиргааны нэгжээрээ 21 аймаг, 9 дүүрэг, 300 гаруй сум, мянга гаруй баг, хороонд харьяалагддаг. Тэр хүмүүсийн эрх ашиг төрийн бодлогод орохгүй болох энэ боломжийг хааж болохгүй. Орох боломжийг. Тийм учраас энэ мажоритар

тогтолцоог бол тэр ард иргэн өөрийнхөө төлөөллийн Их Хурлын гишүүнийг үзэж байж, гар барьж байж, ёстой имэрч үзэж байж, санал бодлоо солилцож байж, сайн муугаа ярилцаж байж ингэдэг сонгодог энэ зарчмыг 60 хувиас доош буулгаж болохгүй гэсэн.

Дээр нь тогтолцооны шинэчлэлээр намын нэр хүнд жагсаалт гэж орж ирвэл энд одоо хуучны 32 жилд будилаан хутгасан нөхдүүдийг аль ч нам оруулахгүй байхыг тусгайлан хэлж өгөөрэй. Тэр Ардын нам байна уу, Ардчилсан байна уу? Шинээр буй болох гээд байгаа тэр ХҮН нам нь байна уу? Өөр одоо бусад парламентад суудалгүй ямар намууд байна вэ? Энд нэр хүнд бүхий шунал багатай яг ард иргэдийн төлөө ажиллах чадвартай ийм хүмүүсийг жагсаалтад оруулж өгөөч ээ.

Энэ бүхний үүднээс шударга ёсыг тогтоож чадна. 32 жилийн хугацаанд энэ 8 сонгуулийн үед хийгдэж байсан энэ арчаагүй зүйлүүд таслан зогсоогдоно гэх юм бол дараагийн хэлэлцүүлгийн үед чинь бас бид нар санал бодлоо солилцох боломжтой юм.

Дээр нь Ардчилсан намын гишүүнтэй газар бол Ардын намын Их Хурлын гишүүд, Ардын намтай Их Хурлын гишүүд дээр бол Ардчилсан намын гишүүд.

Г.Занданшатар: Санал хэллээ. Цэвэгдоржийн Туваан гишүүн.

Ц.Туваан: Бид нар энэ эцэг хууль. Үндсэн хуульдаа нэмэлт оруулах асуудлыг хэлэлцэж байна. Маш чухал асуудал.

Тэгэхээр ер нь бол Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг бол би дэмжиж байгаа. Энэ хууль гэдэг чинь өөрөө энэ нийгэмд болж байгаа харилцааг зохицуулж явж байх, зохицуулахдаа муужруулж биш сайжруулж зохицуулж явж байх ёстой. Тэгэхээр бид нар

сайжруулах тал руу нь өөрчлөлт хийх нь зөв гэж ингэж бодож байгаа юм.

Бид хэд сая Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг яриад өнгөрсөн жилээс хойш ер нь 2 дахь удаагаа, миний хувьд бол бараг 3 дахь удаагаа ингээд явлаа. Төв аймгийн 27 сумаар явлаа. 97 багийнхаа бас нэлээдээр нь ингээд явлаа.

Тэгэхээр ард иргэдийн хувьд бол энэ 152 гэдэг тоонд мэдээж дургүй байна. Тэгэхдээ та хэд сайн өнгийгөөд ингээд үзээд харах юм бол энэ тоондоо ч биш, ер нь бол энэ төрдөө Улсын Их Хурал, Засгийн газар энэ удирдаж байгаа хүмүүстээ сэтгэл ханамжгүй байдал, дээрээс нь энэ юмны үнийн өсөлт амьжиргаа дордсон ядуурал руу орсон байдалтай л уур хүрч бухимдлаа энэ рүү гаргаад байна.

Монголчууд бол төрдөө хайртай ийм ард түмэн. Төрөө шүтдэг, дээдэлдэг, залбирдаг ийм ард түмэн.

Тэгэхээр энэ дээр бид нарын энэ эрх барьж байгаа бид бүхний энэ арчаагүй олхиогүй байдал л тэд нарыг ингэж бухимдуулахад хүргээд байна гэсэн миний хувийн бодол ийм байгаа. Монголчууд ер нь нүүдэлчин ард түмэн. Тэгээд энэ өөрчлөлт шинэчлэлт шинэ юманд таатай ханддаг ийм ард түмэн.

Тэгэхээр бол би бас энэ 152 энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт тоондоо бас биш. Энэ амьжиргаа муудсандаа бас асуудал байна уу гэж ингэж харж байгаа.

1992 оны анхдугаар ардчилсан Үндсэн хууль одоо бид нар тэр Үндсэн хуулийнхаа будаг нь хангалсан машиныг 1992 онд унаад гарсан. Энэ машин маань 31 жил явлаа. Дундуур нь сайн сайн сайхан зүйл байсан. Чамлаад яах вэ гэж бид хэд Монгол Улс тодорхой хөгжссөн тэрэндээ ахиц дэвшилүүд зөндөө байгаа.

Өнөөдөр манай энэ 31 жил унаж байгаа машин маань ерөнхийдөө хуучирлаа. Мотор юм хум нь суларлаа. Бензин тос их иддэг боллоо. Урагшаа энэ Монголчуудын амьдралыг дээшлүүлэх тал руу асуудлыг авч явж чадахгүй байгаа. Шүүмжлэл их дагуулдаг байдал иргэдийн дунд гарч байна. Байрандаа зогсдог боллоо. Бүүр дээрээс нь хойшоо ухардаг боллоо. Бид нар нэг бороотой юм уу, хаврын хайлмаг цасан дээр нэг өөд газар өгсөж байна гэж бодоход машин маань өгсөж чадахаа байгаад тоормослоод зогсохоор тэндээ зогсдог биш ухраад байна.

Тэгэхээр бид нарт одоо өөрчлөлт хэрэгтэй. Энэ өөрчлөлт бол бид нарын эцэг хуульд хийх өөрчлөлт. Энэ хууль бол тогтолцооны өөрчлөлт байх болов уу гэж ингэж бодож байна.

Иргэд маань ч гэсэн ийм бодолтой байна. Тэгэхээр энийг бид нар хийж өөрчлөлтөө хийж ард түмнийхээ сайн сайхан амьдралын төлөө бас ингэж явах ёстой гэж ингэж бодож байгаа. Иргэдтэй уулзаад явахад энэ тоон дээр мэдээж 152 биш ээ арай олон байна гээд ингээд ярьж байгаа юм. Ардчилсан намын байр суурийг ч гэсэн та бүхэнд хэлсэн. 76 гишүүн дээр жишээлбэл Төв аймагт гэхэд 3 хүн байгаа. Манай аймаг бол Монгол Улсын хамгийн олон сумтай аймаг.

Энэ аймгаар ингээд явахад Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр Улсын Их Хурлын чуулганы хуралдах хугацааг нэмсэн. Чуулганы хооронд яваад амжих ямар ч боломжгүй болсон. Тэгэхээр гишүүдийн тоо бас бага байна л гэсэн үг.

Тэгэхээр энэ асуудал дээр яваад хүрэхгүй байгаа дээр энэ тооны гишүүд 76 гэсэн тооны гишүүд дотроо тогтолцооны өөрчлөлт хийвэл яг та бүхнийг иргэдийг шууд төлөөлөх гишүүдийн тоо бол буурна.

Тэгэхээр энэ 76 гэдэг тоон дээрээ байя. Энэнээс цааш өөрчлөлтийг бас жоохон нэмэх байдлаар хийх нь зөв гэж ингэж бодож байгаа. Тэгэхдээ 152 биш гэдэг дээр. Холимог тогтолцоон дээр иргэдийн ерөөсөө айдаг ганцхан зүйл байгаа шүү дээ. Хулгайч авлигач муу нэртэй улсууд намын листний ард жагсааж орж ирэх буюу ард иргэдийн үгээр хаалгаар гаргаад хаяхаар тооноор ороод ирнэ гэж байгаа юм. Ийм зүйлийг хийхгүй бол ард иргэд энэ жагсаалтаас чинь айхгүй байна.

Би бол чуулган дээр бас хэлсэн. Ардчилсан нам бол ер нь тооноо торлоно, гагнана, хулгайч нарыг энэ тооноороо оруулахгүй ээ гэдэг ийм зүйлийг тодорхой хэлж байгаа. Ардчилсан намын дарга Лувсаннjamын Гантөмөр яг ийм зүйлийг иргэдэд ярьж яваа. Иргэдийн бүлэглэлийн бүлэг, хүмүүсийн сектор, сегментийн төлөөллүүдийг тодорхой хэлэх юм бол хуульчид, малчид, тариаланч, ногоочид, багш, эмч, инженер, эдийн засагчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэн буюу тусгай хэрэгцээт иргэдийн төлөөллийг тэдний дуу хоолой болж чадах хүмүүсийг оруулна гэж байгаа юм.

Би бас Монгол Ардын намын дарга, Ерөнхий сайд Лувсаннjamсүрэн Оюун-Эрдэнийг бас эн яг ингэж ярьж байгаа гэж ойлгож байгаа.

Тэгэхээр одоо энэ холимог тогтолцоон дээр иргэдээ битгий та нар юу гэдэг юм. Итгэлийг нь алдаарай. Иргэд маань ч гэсэн хэрсүү болсон. Сонгогчдын боловсрол дээшилсэн. Хэрвээ Ардчилсан нам, Монгол Ардын нам гээд энэ төрийн голлох хүчнүүд листдээ хулгайч авлигач, муу нэртэй хүмүүсийг бичээд ороод ирэх юм бол тэд нарт битгий саналаа өг. Тэр намын өөрсдийн чинь хүсэн хүлээж байгаа хүмүүсийг оруулж ирсэн тэр намд нь саналаа өг. Ингэж байж иргэдийн сонгогдох сайн зүйлд тэмүүлэх энэ хүсэл биелнэ гэж ингэж харж байгаа.

Ингэхээр энэ 2 намын удирдлагуудад сануулж хэлэхэд одоо та бүхэн энэ листээс айгаад байгаа хүмүүсийнхээ итгэлийг битгий алдаарай.

Дээрээс нь та хэдээс би энэ зүйлийг байнга асуух болно. Саяхан манай парламент дээр энэ нийтийн сүлжээнд Хүний эрхийг хамгаалах тухай хууль орсон.

Бид хэд Ардчилсан намын бүлэг хаяад гарсан. Дараагаар нь үлдсэн хэд маань үлдээж байгаад 3, 4 буцааж байгаад батална лээ. Сошиалаар нэг юм болсон. Эргээд Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавьсан. Дахиад бид нар хоригийг хүлээж авсан. Энэ парламент буюу Монголын төр чинь ийм эргүү хурга шиг шийдвэр эргээж буцсан шийдвэр гаргаад байх ёстой юм уу.

Тэгэхээр энэ дээр энэ мэргэжлийн хуульчид энэ сайн парламентчид дутагдаж байна шүү дээ. Дээрээс нь энэ эмч, багш энэ төлөөллүүдээ бас оруулж ирнэ гэдэг үгэндээ хүрэх хэрэгтэй.

Хуучин Монгол Улсын Баатар Завхан аймгаас Намхайнямбуу гээд хүн орж ирээд сууж байсан. Малчдын төлөө маш сайн үгийг дуугардаг байсан. Тэгэхээр ийм хүмүүсээ оруулж ирж Их Хурал дээр батлагдаж байгаа хууль шийдвэрүүдэд амьдралтай сайн шийдвэрүүдийг тусгуулах асуудлыг энэ секторын төлөөллүүдэд оруулах ёстой.

Монгол Улсын хүн амын 3 хувийг эзэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллийг 2 нам урдуураа нэг нэг хүн оруулж ирэх хэрэгтэй. Тэр хүмүүсийн зовлонг тэр хүмүүс л өөрсдөө мэднэ. Бид нар ойлгох гэж хичээгээд ч амжихгүй.

Тэгэхээр товчхондоо хэлэхэд энэ Үндсэн хуулийн энэ нэмэлт, өөрчлөлт бол тогтолцооны өөрчлөлтийн эхлэл болох ёстой. Юм зөв голдиролдоо орох юм бол

Монгол Улсыг хөгжүүлэх ард иргэдээ гар газар, хөл хөсөр амьдруулах амархан гэдгийг бас.

Г.Занданшатар: Үг хэлчихлээ. Наянтайн Ганибал гишүүн.

Н.Ганибал: Өдрийн мэнд. Тойрогтоо очоод ажиллалаа.

Сая Батсуурь гишүүн бас тодорхой ярьж байна. Ер нь иргэд маань энэ асуудал дээр маш их мэдээлэлтэй байна. Тэгээд ер нь ард иргэд маань биднээсээ ч илүү ер нь энэ тогтолцооны өөрчлөлт юунд хүргэдэг юм, яадаг ийдэг гээд ер нь бараг л бүгдийг мэдээж байна. Тэгээд санаа оноонуудаа хэлж байна. Тооны хувьд нь 152 гэдэг тоон дээр үнэхээр бухимдалтай хүлээж авсан. Ер нь ард иргэдийн маань бухимдал мэдээж өнөөдөр хаврын тарчиг цаг, хөдөө орон нутаг, Улаанбаатарт хаа сайгүй, ер нь юмны үнэ өсчихсөн. Хүмүүсийн гэр рүү эдийн засгийн энэ хямрал яваад орчихсон. Энэ бухимдлын илэрхийлэл нь өнөөдөр энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр л гарсан л даа.

Тэрийг бол бүгдээрээ бас тойргоороо яваад харсан байх. Иргэд маань гаргаж байгаа бухимдал дотроо олон асуудлыг ярина, ярьж байсан. Гэхдээ тэр тоо гэдэг дээр илүү их реакци өгч байсан. Ер нь тэгэхдээ Ардчилсан намын зүгээс бол мэдээж Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд хэд хэдэн асуудлуудыг оруулсан. Ер нь тогтолцоог өөрчиллөө гэдэг дээр бол Ардчилсан нам бол байнга байр сууриа илэрхийлдэг. Энэ холимог тогтолцоо дэлхийн улс орнуудын, хөгжссөн улс орнуудын ашигладаг ийм тогтолцоо болоод байгаа юм. Хөгжиж байгаа, ядуу буурай улс орнууд энэ мажоритар тогтолцоог дангаар нь ашигладаг нь бол бас дэлхийн улс орнуудад харагдаад байна л даа.

Монгол Улс улсад ч гэсэн өнөөдөр улс төрийн хувьд шийдээж чаддаггүй хэд

хэдэн асуудал өнөөдрийг хүртэл хүлээгээд байж байна. Газрын тухай багц хууль орж ирээд л татагддаг. Бэлчээрийн асуудал өнөөдрийг хүртэл хэлэлцдэггүй. Ашигт малтмалын тухай хууль өнөөдрийг хүртэл улс төрч нар зориг гаргаж оруулж ирж шийдүүлдэггүй. Тэр үйлдвэржилтийн асуудлууд маань өнөөдрийг хүртэл явдаггүй тэр аж үйлдвэрийн паркуудын асуудлууд. Энэ болгон өнөөдөр тойрог тойргоос сонгогдсон дахиж Улсын Их Хуралд сонгогдох гэсэн насаараа Их Хурлын гишүүн байх гэсэн энэ улс төрчдийн хүслээс болж тэр зоригтой шийдвэрүүд гарахгүй байгаа юм. Энийг л өөрчлөх ёстой юм.

Түрүүн бас зарим гишүүд яриад байна л даа 2012-2016 онд холимог систем үр дүнд хүрээгүй гээд. Үр дүнд хүрсэн юм, хүрч байсан юм. Гаргасан шийдвэрүүд нь зоригтой хүчтэй байсан учраас өнөөдөр Монгол Улсад түүний үр ашгийг нь Монголын иргэд, ард түмэн хүртэж бас чадаж байгаа юм. Тэгэхдээ хангалттай бус хэд хэдэн асуудал байгаа л даа. Оюу Толгойн асуудал байна. Тэрийг бас зоригтой шийдэж байсан. Эрдэнэтийн 49-ийг Монголдоо аваад л ирж л байсан. Тавантолгойн асуудлыг явуулсан. Бүх аймгуудаа засмал замаар холбосон. Эрчим хүчний эх үүсвэрийг тэр цаг хугацаанд хангалттай хэмжээнд бас бий болгож чадаж байсан юм аа. Тэгэхдээ тэр дотор бас алдаатай, дутагдалтай, хэрэгжүүлэлт дээрээ алдсан юмнууд байгаа.

Тэрийгээ ч гэсэн ард түмэн манай намынхан Ардчилсан намынхан өнөөдөр ард түмнийхээ өмнө нээлттэйгээр төрдөө шүүлгээд чадаж байгаа.

Ингээж явж чадах юм бол улс орон цаашаа цэвэршээд явна. Тоон дээр яриад л байна. 126, 152.

Мэдээж 60, 40 гэдэг бол Япон, Солонгос гээд дэлхийн өндөр хөгжилтэй орнууд бүгд ашиглаж байна.

Хэрвээ 99 ч юм уу, 108 ч юм уу гээд ямар нэгэн байдлаар тоогоо багасгаад байх юм бол энэ 76-гаа өөрчлөх хэрэггүй л дээ. 1992 онд Үндсэн хуулийг хэлэлцэж байхад 120 гэдэг тоог гаргаж ирсэн юм байна лээ.

Энэ нь бол дэлхийн улс орнуудын парламентын засагтай улс орнуудын хэрэглэдэг хамгийн оновчтой л хэлбэр байсан. Тэгээд тэрэн дээр тэр үед бас олон байна аа, их байна аа, зардал өндөр байна гэж ярьсаар байгаад 76 дээр л аваад ирсэн юм байна лээ шүү дээ. Бид нар өнөөдөр 76 гэдэг тоогоо бас гаргаж ирэхэд яам ямар үндэслэлээр гарч ирсэн юм бэ гэхээр бас нэг их мэддэггүй юм байна лээ. Тэр үедээ л багасгасаар байгаад л 76 болчихсон. Тэгэхээр бидний хувьд 126 гэдэг тоо Ардчилсан намын хувьд 60, 40 гэсэн пропорциональ холимог системийг оруулж ирж байна.

Дээрээс нь 1992 онд нэг Их Хурлын гишүүн 27 мянган хүнийг төлөөлдөг байсан бол өнөөдрийн 126 бол одоо яг бас тэр хавьцаа 27 мянган хүнийг төлөөлөх ийм боломжтой л харагдаж байгаа юм. Тэгэхдээ 2 дахь хэлэлцүүлгээр бас иргэдтэйгээ уулзаж энэ асуудлуудаа ярьж ойлголцох байх. Ер нь иргэд ер нь яагаад хүнд байгаа юм бэ? Мэдээж экспорт импортын бүхий л өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнүүд үнэтэй байна. 2-оос 3 дахин үнэтэй болсон. Инфляц сар болгон л 10-аас дээш хувьтай.

Харин нөгөө үндэсний үйлдвэрлэдэг хоёрхон бүтээгдэхүүн байгаа. Өргөн хэрэглээний мах, гурил. Инфляцаа дагаад тодорхой хэмжээнд гурилын үнэ өссөн байна. Махны үнэ яагаад өссөн бэ гэж малчид маань өөрсдөө борцоо идэж байна хөдөө. Өөрсдөө бас гаргаад идчих шинэ хонины мах идэх ийм боломж алга. Энэ

болгоныг цогцоор нь шийдэх энэ цаг хугацаа болсон. Энэ ажлуудыг мэдээж зөвхөн 330 сум сумаар нь төлөөлдөг, 21 аймгийг төлөөлдөг гишүүд бас хийхгүй байна. Энийг эр зоригтой шийдвэр гаргах ёстой. Энэ бол өөрөө холимог тогтолцоо гэсэн ийм л байр сууриуд илэрхийлж байна.

Тэгээд иргэдийнхээ бас хэлсэн үгийг бас та бүхэндээ дамжуулъя. Түрүүн Батсуурь гишүүн хэлж байгаад микрофон нь, хугацаа нь дуусчихлаа. Эрх баригч нарыг бид нарыг дагуулаад ирээч ээ гэсэн. Хоёр дугаар хэлэлцүүлэг дээр.

Тэгээд тэр хүмүүстэй бид нар саналаа бас солилцмоор байна. Гаргаж байгаа шийдвэрүүд, эдийн засаг нийгмийн энэ асуудлуудыг шийдэж байгаа энэ байдал дээр өөрсдийнхөө дуу хоолойг сонсгомоор байна. Та 2 маань хэлээд байдаг, хэлээд байдаг, хүлээж авдаггүй юм байна.

Иргэд бас тэр дуу хоолойг ойлгуулж хэлж өгье гэсэн ийм байр суурийг илэрхийлсэн. Боловсрол, эрүүл мэнд, соёлын ажилчид, явж байгаа арга зам, нийгмийн ялгарал энэ болгоныг яаралтай шийдэх хэрэгтэй байна гэдгийг бас хэлсэн. Хөдөө, орон нутаг, улсын сургууль, хувийн сургууль хоёрын ялгаа, хувийн эмнэлэг, улсын эмнэлэг хоёрын ялгаа. Хөдөөгийн иргэд Улаанбаатар хотод хүрч ирж эмнэлэгт хэвтэх тэр боломжийг хангаж өг. Соёлын салбарт ажиллаж байгаа ажилчид 500 мянгаас 700 мянган төгрөгийн цалин авч байна. Энэ болгоны асуудлыг шийдэх эр зоригтой шийдвэрүүд өнөөгийн парламент, Засгийн газарт зайлиггүй хэрэгтэй байна гэдгийг бас дамжуулсан байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Үг хэлчихлээ. Одоо Ширнэнбаньдийн Адьшаа гишүүн.

Ш.Адьшаа: Өнөөдөр Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Улсын Их Хурал

хэлэлцэж байгаа. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлт гэдэг бол үндэсний зөвшилтийн бичиг баримт. Энийг бид улс төрийн намуудын хүрээнд парламент суудалтай, парламент суудалгүй, түүнчлэн нийгмийн зөвшилтийн төлөөллүүд, ард иргэд, ард түмний төлөөлөл болсон Улсын Их Хурлын гишүүд энд маш хариуцлагатай хандаж, Үндсэн хуулийг өөрчлөх асуудал Монгол Улсын төрийн тогтолцооны өөрчлөлт хийх энэ асуудал дээр бид өнөөдөр маш хариуцлагатай хандаж, олон талаас нь ярьж, хэлж цаашид гарч болох эрсдэл Монголын төрийн өнөөдрийн энэ гацаанд орсон, тогтолцооны гажуудалд орсон, төрд итгэх итгэл алдарсан улс төрийн намуудын төлөвшил байхгүй болсон энийг засах асуудал бол өнөөдөр ард түмний эрх ашиг, нийгмийн захиалга байгаа гэж ингэж ойлгож энэ Үндсэн хуулийг өөрчлөх асуудал дээр бас ард түмний төлөөллийн хувьд тодорхой бас оролцож, байр сууриа илэрхийлж байгаа.

Хөдөө орон нутагт очиж, ард иргэдтэй уулзсан,. Олон янзын л ойлголттой байгаа. Тэгэхдээ бид өнөөдөр энэ асуудлыг олон талаас нь ярьж хэлэлцэх нь нийт Монголын ард түмний эрх ашиг, нийт иргэдийн эрх ашиг гэж ингэж ойлгож байгаа юм.

Надад нэг суулт байгаа. Тэрийг хэн хариулах юм. Энэ Үндсэн хуулийн өөрчлөлт дээр энэ Улсын Их Хурлын сонгуулийг олны төлөөллийг гэдэг энэ асуудлаа бас тайлбарлаж өгөөрэй. Олны төлөөлөл гэж байх юм уу, олонхын төлөөлөл гэж байх юм уу, саналын эрхтэй ард иргэдийн төлөөлөл гэж байх юм уу. Ингээд энэ Үндсэн хуулийн нэг үс, өгүүлбэр гэдэг бол Монголын төрийн бичиг баримтын, үзэл бодлын, бодлогын асуудал учраас энд бол бид нэг үсэг, өгүүлбэр бүрээр нь энийг ярих ёстой. 92 оны Үндсэн хууль дээр бид чинь энэ Үндсэн хуулиа өөрчлөхийн тулд хэдэн сар манай Монгол Улсын Их Хурлын тухайн үеийн Ардын Их Хурлын 400 гаруй депутат ямар

хариуцлагатай хандаж, ямар ажиллаж байсныг бид өнөөдөр бас энэ түүхэн баримтыг үзэж харж байгаа. Энэ дээр хариулт авъя.

Хоёрдугаарт нь энэ Улсын Их Хурлын гишүүн Ганбаатараас надад бас ийм дэмжиж өгөөч гэсэн хүсэлт ирүүлсэн байгаа. Тэр өнөө өглөө Ганбаатар гишүүн Улсын Их Хурлын чуулган дээр бас байр сууриа илэрхийлчих шиг боллоо. Тэгэхдээ өнөөдөр бас ингээд энэ үндэсний зөвшилтийн бичиг баримт, нийгмийн гэрээг бид олон талаас ярьж үзэх ёстой. Төрийн 2 Байнгын хороон дээр зарчмын зөрүүтэй саналын асуудлыг ярихад бас хүлээж авахгүй хууль зүйн үндэслэлийг тайлбарлаж бас санал хураалтад оруулаагүй юм шиг байгаа юм. Энэ дээр бас хүндэтгэлтэй хандаж, нэгэнт ард түмний төлөөлөл энэ Их Хурлын гишүүдийнхээ тэр зарчмын зөрүүтэй санал оруулах тэр үндсэн эрхийг нь бас хүндэтгэж байвал бас зүйтэй байх гэсэн ийм саналаа би Ганбаатар гишүүний надад ирүүлсэн албан бичгийн хариуд би хэлчихье гэж бодож байна.

Монгол Улсын энэ Үндсэн хуулийг батлаад дараа нь олон үр дагавар гарч ирдэг. Түүний нэг үр дагавар. Өнөөдөр Монгол Улсын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 2, Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно гэж байгаа. Энэ асуудал бол сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд олон маргаан дагуулж, Монгол Улсын Үндсэн хуулийн цэц дээр очиж Монгол Улсын Үндсэн хуулийн цэц хоёр удаа хоёр өөр дүгнэлт гаргаж, тэгээд сүүлд нь энийгээ бид хоёулыг нь нэгтгэж байгаад мухарласан гэдэг ийм ойлголтыг өгч байгаа юм.

Би энд их шүүмжлэлтэй ханддаг хүн. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц гэдэг энэ байгууллага бол хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлдэг байгууллага

биш. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц гэдэг бол өөрийн даасан бие даасан хуультай. Монгол Улсын Үндсэн хууль бусад гарсан хууль тогтоомжийг батлахад Үндсэн хуулийн үзэл баримтлал зөрчигдсөн, зөрчигдөөгүй гэдгийг л иргэдийн гомдлоор магадлан шалгаж, тэнд дүгнэлт гаргадаг Үндсэн хуулийн манаач буюу шүүх эрх мэдлийн байгууллага. Энийг би удаа дараа хэлж байгаа. Тэгээд Үндсэн хуулийн цэц 10 жилийн өмнө гаргасан тухайн үед үед энэ хүмүүс байгаагүй үеийн их суудлын хуралдаанаар, дунд суудлын хуралдаанаар аваад эцсийн шийдвэр гаргасан ийм хэрэг маргаануудыг авч ирээд шийддэг. Тэгээд энэ дээр бол манай Доржханд тэргүүтэй хүмүүс яриад байгаа шүү дээ. Үндсэн хуулийн цэц ингээд шийдчихсэн одоо энэ дээр шууд сонгоно гэдэг чинь энд ямар ч асуудалгүй болсон гэж байна. Энийг нэг тийшээ би зориуд протоколд тэмдэглүүлж байна. Энэ бол маш хариуцлагатай асуудал.

Яагаад гэхээр энэ нууцаар хураана гэдэг. Тэгтэл өнөөдөр энэ намын жагсаалтаар орж ирж байгаа энэ хүмүүсийг бид сонгоогүй, бид нарын энэ нууцаар санал хураана гэдэг чинь энэ 30 хүний, 50 хүн байна шүү дээ энэ 50 хүн дээр чинь бид энэ нууцаар санал хураана гэдэг асуудал яаж яригдах юм бэ гэдгийг надаас маш олон иргэд, сонгогчид асуугаад байна. Энэ дээр бас тодорхой хариултыг, тодорхой бодлогыг, тодорхой шийдлийг энэ Үндсэн хууль хэлэлцэх энэ протокол, бусад зүйл дээр энэ Засгийн газрын ажлын хэсэг, энэ Улсын Их Хурлаас байгуулагдсан ажлын хэсэг энэ дээр тодорхой байр суурийн дүгнэлтийг гаргаж, тэмдэглүүлэх нь эцэст нь маргаан мэтгэлцээн гарах энэ асуудлыг шийдэхэд Монгол Улсын Үндсэн хуулийн цэц болон бусад байгууллагын хэрэг маргааныг шийдэхэд бас тодорхой нотлох баримтын, ард түмний төлөөллийн баримт болно шүү гэдгийг нь би хариуцлага.../минут дуусав./

Г.Занданшатар: Эхлээд Нямаагийн Энхболд дарга.

Н.Энхболд: Адьшаа гишүүний асуултад хариулъя. Ганбаатар гишүүний тавьж байсан саналтай холбоотой хариултыг түрүүн хурлын эхэнд Занданшатар өгчихсөн, дарга өгсөн. Тийм учраас би орхиё.

Олныг төлөөлөх гэдэг дээр хариулт өгье. Ер нь сонгуулийн тогтолцоо бол бүх дэлхий дээр үндсэндээ хоёрхон л арга, зарчим хэрэглэж явж байгаа. Мажоритар, пропорциональ гээд энэ хоёр үгийг манайхан олонхыг төлөөлөх, хувь тэнцүүлэх гэдэг үгээр орчуулж хэрэглэж ирсэн.

Мажоритар тогтолцоог манайд яаж хэрэглэж байна гэхээр өнөөдөр тухайлбал тухайн тойрог дээр нэр дэвшсэн хүмүүсээс хамгийн олон санал авсан, хамгийн олон санал авсан олонхын биш ийм хүмүүс сонгогдож ирж байгаа. Ийм тохиолдолд бусад улс орнуудад хэрэглэдэг үг нь бол тэр мажоритар гэдгийн мажорити гэдэг нь мажоритар. Тэр нь 50 дээр нэмэх нь нэг гэсэн утгаараа ойлгож явдаг. Энэ талаар бас Байнгын хороон дээр, ажлын хэсэг дээр гишүүдийн дунд асуудал үүсэж, маргаан үүсэж ер нь бид нар олонхын гэдэг үгээр орчуулаад, олонхыг төлөөлөх гэдэг үгээр орчуулаад яваад байгаа нь буруу юм байна. Яагаад гэвэл тэр мажоритар гэдэг нэрийн доор явдаг олон зарчим, аргууд байдаг. Хамгийн олон нь, ердийн олонх, үнэмлэхүй олонх гээд энэ бүх тойргоос сонгодог гишүүдийг гаргаж ирдэг аргыг бол ийм мажоритар гэдэг ерөнхий үгэн дор яваад байдаг.

Тэгээд тэр үгээр нь ингээд хэрэглэхээр Засгийн газраас орж ирэхдээ мажоритар, пропорциональ гэсэн үгтэй орж ирсэн тийм ээ? Тэгээд ярьж байгаад Үндсэн хуульд аль болохоор цөөн гадаад үг оруулах шаардлагатай юм байна гээд хуучин хэрэглэж байсан олонхыг төлөөлөх, хувь тэнцүүлэх гэдэг

тогтолцоогоо энэ нэрээрээ хэрэглээд явъя гэж ажлын хэсэг дээр яригдаад, Байнгын хороон дээр танилцуулахад ер нь олонхыг төлөөлнө гэдэг чинь 50-аас дээш хувийг хэлж байгаа юм.

Тэгэхээр бидний өнөөдөр хэрэглэж байгаа арга маань бол 50-аас дээш биш ерөөсөө тухайн тойргоосоо хамгийн олон хүн санал авсан хүмүүс нь сонгогдож байгаа учраас яг тэр нэр томъёонд тохирохгүй байна гээд ярьж байгаад ер нь олныг нь, хамгийн олныг гэдэг утгаар нь олныг төлөөлөх гэдэг үгээр ингэж оруулъя. Тэгвэл тэр мажоритар чинь дотроо яг ингээд манайх шиг олныг төлөөлөх аргыг хэрэглэдэг тэр орчныг нь бүхэлд нь плюрагети /plurarety/ гэж байгаа юм Англиар.

Тэгээд яг энэ талаас нь хэдүүлээ ярьж үзэж байгаад ерөөсөө олныг төлөөлөх гэдэг ийм нэр томъёогоор оруулъя. Зөв ч юм байна. Хамгийн олон гэдэг утга нь ч гарна. Түүн дотроосоо санал авсан хүмүүс дотроосоо хамгийн олон гэдэг утга энд ингэж гарах юм байна гээд. Зарим гишүүд маань бас хэлний зөвлөлийнхөнтэй ч бас зөвлөлдөж, санал солилцсон юм. Би ингэж байгаад бид хуучин мажоритар олонхыг төлөөлөх гэж яриад ирсэн зүйлүүдээ ерөөсөө олныг төлөөлөх гэдэг ийм томъёоллоор хуульдаа тусгаж явъя гэж тохироод оруулж ирээд одоо явж байгаа.

Адьяаа гишүүний асуусан нь их сайн боллоо. Яагаад гэвэл энэ урьд нь хэрэглэгдэж байгаагүй томъёолол, нэр томъёо. Цаашидаа ингээд гишүүд дэмжээд, батлагдаад Үндсэн хуульд ороод явчихвал манайд жишээ нь бусад орнуудад тэр плюрализм /plurasim/, плюрагети/plurarety/ гэдэг үгээр хэрэглэгддэг арга нь манайд олныг төлөөлөх гэдэг утгаараа явж, ийм үгээр явж байгаа юм байна гээд хэвшин яваад яваандаа юу гэдэг юм шинжлэх ухааны, улс төрийн хэллэгийн энэ эргэлтэд ороод

явах ийм боломжтой юм байна гэж үзээд оруулж байгаа юм.

Тэгээд дахиад товчоор дахиад хэлэхэд хуучин бид нар мажоритар гэж нэрлээд байсан, олонхыг төлөөлөх гэж хэлээд байсан зүйлээ илүү ойлгомжтой, ялгаатай болгож ийм үгээр томъёолъё л гэж шийдсэн юм байгаа юм. Тийм.

Г.Занданшатар: Адъяаа гишүүн яг Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдолтой хамгийн чухал асуудлыг хөндлөө л дөө. Тэгэхээр Үндсэн хууль тогтоогчид болон хууль тогтоогчид протоколд энийг тэмдэглэж үлдээгээд, хожим гарч болзошгүй маргаан, сонгуультай холбоотойгоор болон Цэц дээр үүсэж болзошгүй гэж сэргийлж энийг тэмдэглэж үлдээх ёстой юм байгаа юм.

Тийм учраас энэ ажлын хэсэг дээр яригдсан, энийг томъёолсон агуулга бол олныг төлөөлөх гэдэг нь мажоритар тогтолцоо гэдгийг ер нь мажоритар сонгуулийн системийг олныг төлөөлөх гэж нэрлэе. Энэ олныг төлөөлөх гэдэг агуулга дотор хамгийн олон буюу плюрал /plural/энэ сайн тодорхой хэлэхгүй бол энэ бүгд орж байгаа юм шүү гэдэг агуулгаар. Үндсэн хууль ерөнхий байх ёстой шүү дээ. Хамгийн олон, олон гэж байгаа юм. Ердийн олонх, олонх, дийлэнх олонх, үнэмлэхүй олонх гэсэн ийм Үндсэн хууль эрх зүйн нэр томъёо, ойлголтууд байгаа юм.

Энийг Үндсэн хуулийн эрх зүйд яах вэ, Англи хэл дээрээ мажорити /majority/, гэж явж байгаа боловч симпл мажорити /simple majority/, абсолют мажорити /absolute majority/, тэгээд спешл мажорити /special majority/ буюу квалифайд мажорити /qualified majority/ гэхээр одоо Үндсэн хуулийг 3/4-ын олонх бол энэ спешл мажорити /special majority/ буюу квалифайд мажорити /qualified majority/ 2/3. Тэгээд Үндсэн хуульд байдаг энэ олонхын томъёоллууд 2/3, 3/4. Нийт

гишүүний олонх гэж байгаа. Энийг абсолют мажорити /absolute majority/ гээд байгаа юм. Нийт гишүүний олонх. Өөрөөр хэлбэл сонгуульд бас саналаа өгсөн хүмүүсийн олонх биш, нийт гишүүний олонх гэж. Жишээлбэл, бид хэрэглэдэг энийг абсолют мажорити /absolute majority/ гэж нэрлэдэг юм байна лээ бүүр. Симпл мажорити /simple majority/ бол ердийн олонх оролцсон хүмүүсийн олонхын санал. Одоо манай Үндсэн хуульд байгаа агуулгаараа олонх гэдэг үг бол нийт гишүүний олонх гэсэн агуулгатай, бас практикт хэрэглэж байгаа энэ санал өгсөн хүмүүсийн олонх гэсэн ийм 2 агуулгаар яваад байгаа учраас энийг ер нь ингээд хууль зүйн нэр томъёо болгоод энэ үг зүй, өгүүлбэр зүй, Хэлний зөвлөлтэй ч бас зөвлөлдөж үзээд ингээд оноосон нэр өгөөд, энд протоколд энийг мажоритар тогтолцоо буюу хамгийн олон, ердийн олонх, олонх, дийлэнх олонх, үнэмлэхүй олонхыг багтаасан ийм Үндсэн хууль эрх зүйн ойлголт гэж үзэж явах нь зүйтэй юм гэдгийг энд протоколд тэмдэглэх нь зүйтэй байх.

Нөгөө талаас тогтолцоо гэдэг үг бол өргөн ойлголт. Арга гэдэг бол тусгай ойлголт. Тийм учраас энэ дээр нэлээн өчигдөржин маргалдаж, олон талаас нь үзэж байгаад олон улсын нэр томъёо ч гэсэн судалж үзсэн. Орос хэлэндээ яах вэ гэвэл большинство гээд орчуулчихсан байгаа мажорити Үндсэн хуулийн эрх зүйн нэр томъёо гээд. Тэгээд большинство, относительное большинство гэхээрээ харьцангуй олонх гэж манайх орчуулаад байгаа. Англи хэл дээр плюрал буюу рилетэм мажорити гэж орчуулсан байна лээ. Тэгээд супер мажорити гэж байна. Супер мажорити 2/3, супер мажорити, квалифайд мажорити /qualified majority/, спешл мажорити /special majority/ гэсэн нэр томъёонуудыг олон улсын Үндсэн хуулийн эрх зүй, парламентын эрх зүйд ашиглаж байна. Энэ саналыг цөөнхийн эрх ашгийг хамгаалахдаа олонхыг, олонхоор асуудал шийдэхдээ цөөнхийг хүндэтгэх ардчиллын

болон парламентын ардчиллын зарчимд нийцүүлж ийм супер мажорити, симпл мажорити /simple majority/, абсолют мажорити /absolute majority/ гэсэн ийм олон ойлголтууд байгаа. Энэ бол манай Монгол хэлэнд хамгийн олон, ердийн олонх, олонх, дийлэнх олонх, үнэмлэхүй олонх гэсэн ийм агуулгуудаар нийт гишүүний олонхоор хуулийг эцэслэн баталж байгаа, хуулийг дэмжих асуудал бол зүгээр хуралд оролцсон гишүүдийн, санал өгсөн гишүүдийн олонхоор баталж байгаа.

Тэгэхээр нийт гишүүдийн олонх гэдгийг тэр абсолют мажорити гэж нэрлэдэг. Харин манайх яах вэ харьцангуй олонх гээд нэрлэхээрээ энэ абсолют мажорити тэр плурарети 2-ын дундуур ойлгогдоод байгаа учраас Орос хэлэнд бас яг абсолютный, зүгээр большинство ба энгийн, ер нь большинство, тэгээд относительное большинство, супер, абсолютный большинство энэ тэр гээд бас дөрөв, таван ангилалтай юм байна лээ. Олонх гэдэг юм байна лээ.

Тэгээд ер нь хэрэглээнийхээ явцад олонх нь хамгийн олон санал авсан ч болдог болчихсон. Анх үүсэхдээ ингээд мажорити гээд үүсчихсэн учраас энэ их хожим заавал 50 дээр нэмэх нэгээр сонгуульд ялах ёстой ч гэдэг юм уу маргаан гаргаж болиггүй учраас олонхыг төлөөлж байснаас зайлсхийгээд олныг төлөөлөх гэдэг ийм оноосон нэр болгож ингэж Үндсэн хууль тогтоож, нэр томъёо болгож жигдлэх гэж байгаа юм гэдгийг протоколд тэмдэглэж үлдэх ёстой гэж Үндсэн хууль тогтоогч депутатууд бид нарт бас хэлж байгаа юм. Ингэвэл хожим Цэц дээр маргаан үүсэхэд яг энэ протоколоор цаашидаа авч үзэх ёстой.

Тийм учраас та маш чухал асуулт асуугаад Ардчилсан намын бүлэг ч, Ардын нам бүлэг ч энэ дээрээ цаашидаа ер нь бусад намууд ч гэсэн нэг ийм ойлголттой байна. Энэ бол олныг төлөөлөх хамгийн

олон олныг төлөөлөх гэдэг маань мажоритар тогтолцоо болж байгаа. Энийг Дагаж мөрдөх журмын тухай хуулиараа бас тодорхойлохыг хичээсэн. Тэгээд энийг бол ингээд цаашидаа ойлгоод энэ протоколд албан ёсоор тэмдэглүүлж, ингэж цаашидаа ойлголттой явъя. Дараагийн гишүүд ч гэсэн энийг анзаарч явъя гэдэг дээр ойлгох нь зүйтэй байх гэж үзэж байгаа юм.

Ер нь Үндсэн хууль нь 3/4, 2/3, 1/4, нийт гишүүдийн олонх, нийт саналын олонх гэсэн ийм тоонууд байгаа. Өчигдөр зарим хүмүүс дээр хамгийн олон суудал авсан намтай бас холиод байгаа юм. Тэр бол сонгуулийн тогтолцоотой холбоотой биш, парламентын олонх гэсэн бас өөр ойлголт байна. Тэгээд энэ хоёр сонгуулийн тогтолцоо, парламентын олонх гэдэг бас өөр ойлголт. Тэгэхээр энэ бүхнийг парламентын олонх, цөөнх гэдэг бол тэгээд энийг цаашид нэг мөр ойлгож авах нь зүйтэй юм байна лээ гэдгийг онцолж тэмдэглэх хэрэгтэй байгаа юм.

Шатарбалын Раднаасэд гишүүн алга байна. Нанзадын Наранбаатар гишүүн.

Н.Наранбаатар: Төрийн байгуулалтын байнгын хорооноос зарчмын зөрүүтэй саналаар анхны хэлэлцүүлэг дээр, төсөл дээр байсан 152 гэдэг тоо багасаад 126 болж орж ирж байна. Гишүүд бас тойрогтоо ажиллаж, иргэдтэй уулзаж Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн талаар танилцуулсан. Энэ дээр ер нь ихэнх уулзалтууд иргэдийн дийлэнх олонх нь бол тоон дээр багасгах шаардлагатай гэдэг санал хэлсэн. Үүнийг тусгаж, бас багасгаж орж ирж байна гэж ойлгож байгаа.

Миний хувьд бас тойргийнхоо иргэдтэй уулзаж явж байхад бас л яг л ийм саналтай байсан. Тоон дээр бол өндөр байна. 152 гэдэг тоо бол их байна. Та бүхнийг тоогоо нэмээдэх гээгүй, хариуцлага, ёс зүй, сахилга хариуцлагаа

сайжруул гэсэн болохоос тоо нэм гэж хэлээгүй гэдэг ийм зүйлийг ярьж байсан. Хэрвээ тоо нэмэх шаардлагатай бол 99-өөс 120-ийн хооронд нэмбэл яасан юм гэдэг ийм зүйлийг бол ярьж байсан.

Тогтолцооны хувьд бол ер нь иргэд бол энэ холимог тогтолцоог ер нь дэмжиж байсан. Олонх нь. Ингэхдээ анхааруулж хэлж байгаа зүйл бол тэр намын жагсаалтаар орж ирж байгаа хүмүүсийнхээ энэ жагсаалт дээр онцгой анхаарах хэрэгтэй. Элдэв хэл аманд орсон ийм хүмүүс жагсаалтаар орж ирэх вэ гэдгээс маш их болгоомжилж хэлж байсан.

Үнэхээр бас энэ нийгмийн төлөөлөл, салбарын төлөөлөл, эмч багш, малчдын төлөөлөл гээд энэ залуучууд, эмэгтэйчүүдийн төлөөллийг тэнцүү оруулж ирэх нөхцөлд бол энэ холимог тогтолцоо болох юм, үүнийг яаж энэ төлөөллийг оруулж ирэх дээр анхаарах юм, хаанаа, ямар хуульдаа үүнийгээ тусгах юм бэ гэдэг зүйлүүд дээр бас их санаа зовж, асууж байсныг бас хэлэх нь зүйтэй байна.

Мөн манай тойргийн хувьд бас иргэдийн уулзалт болгон дээр ярьж байгаа асуудал бол энэ Өмнөговь аймгаас төлөөлж байгаа Улсын Их Хурлын энэ төлөөллийн тоо, гишүүдийн тоо цөөхөн байна. Энэ газар нутгийн хэмжээгээрээ бол хамгийн өргөн том уудам газар нутагтай. Мөн эдийн засгийн хувьд бол Монгол Улсын нийт эдийн засгийн тал хувь нь Өмнөговьд бий болж байдаг улсын төсөвт төвлөрүүлэх орлого хамгийн өндөр байдаг. Сүүлийн үед томоохон бүтээн байгуулалтууд хийгдэж, мөн хун амын тоо механикаар хурдацтай өсөж байгаа ийм бүс нутгийн хувьд бол энэ Өмнөговь аймгийг төлөөлөх гишүүний тоог нэмэгдүүлэх шаардлагатай гэдэг ийм саналуудыг бол бас манай тойргийн иргэд бол хэлж байсныг бас энэ протоколд тэмдэглүүлж үлдээе гэж бодсон юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Үг хэллээ. Цогтгэрэл гишүүнийг хойшлууллаа. Бадарчийн Жаргалмаа гишүүн.

Б.Жаргалмаа: Та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая. Тойргоороо ажиллаад ирсэн. 1400 гаруй сонгогчдын саналыг сонссон. Дэмжсэн, дэмжээгүй олон санал хэлсэн бас сонгогчдодоо бас талархлаа илэрхийлсэн. Ер нь иргэдийн идэвх оролцоо бол бас өндөр байсан гэж хэлж болно. Залуучууд маань бас идэвхтэй оролцсон. Залуучуудын төлөөллийг ер нь парламентад яаж оруулах юм бэ гэдэг зүйлийг бас залуучууд маш ихээр асууж байсныг бас энд дурдах нь зүйтэй байх гэж бодож байна. Жагсаалтаар орж байгаа одоо бид нар 40, 60 гээд ярьж байх шиг байна тийм ээ? 40 буюу 50 нэрсийн жагсаалтад залуучуудын төлөөлөл, сегментийн төлөөлөл хэрхэн яаж орох юм бэ гэдэг дээр бас маш ихээр асуулт ирсэн. Өөрөөр хэлэх юм бол эмэгтэйчүүдийн төлөөлөл, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллөө хэрхэн яаж оруулах юм бэ гэдэг зүйлийг бас асуусан. Энэ дээр бас тайлбар хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна.

Би бас Монгол Улсын Үндсэн хуулийн эх сурвалж гэсэн ном бариад сууж байна. Үндсэн хууль алганд багтсан Монгол Улс юм гэж. Алганд багтсан Монгол Улсынхаа энэ хуульд ер нь бид нар 19 онд сүүлийн удаа гар хүрсэн бол одоо дахиад 2023 онд дахин шинэчлэл хийхээр сууж байна.

Ер нь энэ хуулийг харж байхад энэ Үндсэн хуулийн эрх баригч хэмээгддэг Чимэд гуайн хэлсэн үг бол ерөнхийдөө алдагдаж байгаа. 92 оны шинэ ардчилсан Үндсэн хуулийг баталж байх тэр явцад би яг л хараад л сууж байна. 91 оны 12 сарын 3-ны өдөр хэрхэн, ямар хуралдаан ямар зохион байгуулалтаар орж байсан бэ гэдгийг энэ Үндсэн хуульд оруулчих юм бол хөдлөхгүй гэдэг ийм зүйл яригдаж байсан

боловч бид нар өнөөдөр бас Үндсэн хуульдаа өөрчлөлт хийх гэж байна.

Гэхдээ бид энийг бол улс орны хөгжлийн шилжилтийн үед бид өөрчлөх зайлиггүй шаардлагатай, үүссэн учраас хөндөж байна гэдэг ийм бодолтой сууж байна. Яг 91 оны 12 сарын 3-ны өдөр Үндсэн хуулийн 21.1 дүгээр заалт буюу парламент нэг танхимтай байна, Улсын Их Хурал нэг танхимтай байна, Улсын Их Хурлын гишүүдийн тавиас доошгүй хувийг тухайн аймаг, тойрогт оршин суугаа иргэдийн дотроос сонгоно гэсэн энэ нэр томъёоллоор бас баталж байсан байна.

Тэгэхлээр одоо яг энэ тухайн аймаг орон нутгаас сонгогдсон нэрт төлөөлөл буюу одоо бид нар 76 гэж яриад байгаа тийм ээ? 76 тойргийн төлөөллийг иргэд тухайн тойрогтоо ажиллах хүн, тухайн тойрогт бараг л өдөр бүр сонгогчтойгоо нүүр тулж ажиллах хүн гэж ойлгож байгаа юм. Яг өнөөдөр сонгогчтойгоо ингээд уулзаад явж байхад нөгөө л гэрэлтүүлгийн асуудал, нөгөө л худаг усны асуудал, нөгөө л хаягжилтын асуудал гэдэг юм уу ийм асуудлыг Их Хурлын гишүүдээсээ нэхэж байдаг.

Уг нь бол энэ дүүрэг, нийслэлээс сонгогдсон төлөөлөл бас хийх ёстой. Бид хуулиа батлах ёстой гэж байгаа боловч иргэд өнөөдөр Их Хурлын гишүүдээсээ тийм юм шаардах эрхтэй гэдэг ийм ойлголттой байсаар байгаа. Тэгэхлээр иргэдийн мэдлэг, мэдээллийг бас нэмэгдүүлэх зайлиггүй шаардлага байгаа юм.

Өөрөөр хэлэх юм бол парламент чадавхтай байх, парламент мэргэшсэн байх гэдэг дээр бид иргэдээ мэдээллээр хангах тэр үйл ажиллагаа орхигдож байна гэдгийг бас харах нь зүйтэй болов уу. Одоо жагсаалтаар орж ирэх гэж байгаа 50 хүн маань мэргэшсэн байна гээд байгаа юм. Юугаар мэргэшсэн байх юм гэдэг асуултыг бас иргэд асууж байна.

Дан хуульчид байх юм уу? Тийм ээ? Энэ дээр ер нь энэ зүйлийг хэрхэн, яаж оруулж өгөх юм бэ гэдэг зүйлийг иргэд асуусан.

Нөгөөтээгүүр сая бас асуулаа л даа. Нөгөө мажоритар буюу пропорциональ гэдэг энэ үгийг Монголд нэр томъёолол оруулж өгөөч гэж. Дийлэнх олонх, ердийн олонх гэдгээр сая бас Их Хурлын даргад тайлбарлаж өгч байна. Энэ дээр иргэдээ мэдээллээр хангах энэ ажлыг ер нь хэн хийх вэ? Яг өнөөдөр бид нар нөгөөд Их Хурлын Тамгын газраас өгсөн цэнхэр номоо тараасны дараа иргэд маань ерөөсөө Их Хуралд чинь Их Хурлын гишүүдийн ажлын ачаалал маш өндөр байдаг юм байна. Хангалттай хууль бүрдээ хүрч ажиллаж чаддаггүй юм байна. Тийм учраас нэг байнгын хороонд нэг мэргэшсэн талдаа ажиллах тэр боломжийг нь нээж өгөхийн тулд Их Хурлын гишүүдийн ачааллыг бас хөнгөлөх ёстой юм байна, ийм учраас гишүүдийн тоог нэмэх ёстой юм байна гэдэг ойлголтыг авсан.

Тэгэхлээр энэ ажил дээр бид ер нь хэрхэн яаж ажиллах ёстой юм бэ? Сонгогч иргэдээ мэдээллээр хангах тал дээр. Бид нар одоо хоёр дахь хэлэлцүүлгээ хийх гээд явах гэж байна ирэх долоо хоногоос.

Тэгэхлээр иргэд маань хангалттай мэдээллийг авч чаддаггүй юм байна гэдэг энэ нөхцөл байдал бидэнд харагдаад байгаа шүү дээ. Тэгэхлээр энэ дээр ер нь бид яаж ажиллах ёстой юм бол? Зөвхөн 21.1 гэдэг заалтыг хэлэлцэж байхаас гадна бид бас сонгогчдыг мэдээллээр хангах тэр ажил дутагдалтай байна гэдэг л ийм шүүмжлэлийг би хэлэх гээд байна л даа. Энэ дээр тайлбар өгөх хүн байгаа болов уу? Ер нь сонгогчдын боловсрол төв гээд байдаг. Зүгээр төрийн бус байгууллагууд иргэний нийгмийн байгууллагууд л ажилладаг. Энэ дээр төр ер нь өөрсдөө хэрхэн яаж ажиллах ёстой юм бэ гэдэг дээр бас тайлбар өгөөч.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя Улсын Их Хурлын гишүүн Энхтайвангийн Бат-Амгалангийн урилгаар Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын сэтгэл зүйчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажлын өндөр амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе.

Хэн хариулах вэ? Нямаагийн Энхболд дарга хариу мэдээлэл өгье.

Н.Энхболд: Монгол Улсын Үндсэн хууль 1992 онд батлагдаад бид нар энэ олон намын тогтолцоо, зах зээл, ардчиллын замаар яваад энэ хугацаанд алдсан, оносон олон зүйл байдаг. Энэ дотроос жишээ нь миний өөрөө бодож явдаг нэг зүйл бол бид нар үнэхээр энэ шинээр сонгож авсан нийгмийнхээ мөн чанар, зарчмууд ямархуу байх ёстой, тэн дотор нь иргэд ямар үүрэгтэй оролцох юм гэдэг тал дээр иргэддээ танин мэдүүлэх, нийгмийнхээ мөн чанарыг сурталчлах, ойлгуулах тал дээр хамгийн их алдсан байна даа гэж би боддог юм.

Энэ дээр бүгдээрээ л буруутай бол бүгд л буруутай. Бүх улс төрийн намууд сонгуульд оролцохдоо юм уу, улс төрийн ажил хийхдээ ялахаа бодож, нарийн яривал, муу үгээр хэлбэл бие биеийнхээ дээр гарахыг бодож л асуудалд хандаж байсан улс гэхээс биш иргэд, сонгогчидтой энэ нийгэм чинь ийм учиртай, ийм хуультай, энэ хуулийн дагуу явбал ийм байдаг юм энэ хууль зөрчигдвөл ингэдэг юм гэдэг талаар үнэхээр бид нар бага ажил хийж байсан. Энийгээ бол хүлээн зөвшөөрөх ёстой.

Тэгээд сая иргэдтэй уулзаад нийгмийг хамарсан их томоохон асуудлуудаар юм яриад явж байхад хүртэл, танилцуулаад явж байхад энэ дутагдалтай байгаа нь үнэхээр харагдаж байгаа юм. Жишээ нь би хэд хэдэн газар

дээр. Би бол 8 сумаар явсан. 1700 орчим хүнтэй уулзахад зарим уулзалтуудын өмнө, орохын өмнө олон жил бид нартай хамтарч бас явж байсан хүмүүс хүртэл үгүй энэ 76 дээрээ байх нь хэвээр шүү дээ. Юун тоо нэмэх гэж ярьж байсан. Би ийм байр суурьтай байгаа шүү гээд ярьж байсан хүмүүс дараа нь гишүүд очоод уулзаад өнөөдрийн үүсээд байгаа нөхцөл байдал, энэнээс гарах арга зам, яагаад тогтолцоогоо өөрчилбөл энд илүү их түлхэц болох юм хөгжил ийм асуудлууд гээд ингээд. Тэгээд тал талаас нь тайлбарлаад ингээд ярихаар өө нээрээ бодох юм байгаа юм байна шүү. Би ер нь байр сууриа өөрчиллөө гэдэг хүн хэд хэд таарч байсан. Би энийг ганцаараа хэлж байгаа юм биш манай бүлэг дээр жишээ нь орон нутагт явсан тайлангаа ярьж байхад ч гэсэн хүмүүс ярьж байна лээ.

Тэгэхээр үнэхээр иргэдэд мэдээлэл хүргэнэ гэдэг бол их хоцрогдож байгаа ажлын нэг, хамгийн их бид нарын хийх уулзалт, гишүүд уулзалт, ярилцлага хийхдээ зөвхөн хийж байгаа ажил, хийх гэж байгаа ажлын тухай биш энэ талынх нь, энэ нийгмийнх нь мөн чанарын талаар ойлголт өгөх, авах гэж байгаа арга хэмжээний цаад утга учир энэ тэрийг тайлбарлаж явах хэрэгтэй юм байна лээ гэдгийг товч хэлчихье зүгээр.

Сая бид нарыг эхний ээлжид ингээд тойроод явахад бас Улсын Их Хурлын Тамгын газраас, мөн намуудын зүгээс ч гэсэн тодорхой материалуудыг бэлдэж үүсээд байгаа нөхцөл байдал, өөрчлөх шалтгаан, гарах үр дүн, сайн, муу талынх нь талаар нэлээн материалууд бэлдэж өгсөн. Тэгээд хэрэг болж байна лээ. Одоо энэ удаа ч гэсэн жишээ нь эхний хэлэлцүүлгийн дүнгээр ямархуу байр суурь, санаа бодол илэрхийлэгдэв, тэрэнд нь таарсан асууж байсан асуултуудад нь хариулсан ийм дахиад тэгээд хоёр дахь хэлэлцүүлгээр орж байгаа томъёоллуудаа тайлбарласан ийм гарын авлага, материал иргэдэд танин мэдүүлэх, сурталчлах материал бас бэлдэж байгаа.

Өнөөдөр бараг эцэслээд гарах байх. Бид нарыг ингээд нэг дэх өдрөөс юм уу, маргааш, нөгөөдрөөс хөдөө явахад энийг гар дээр нь.

Тэгэхдээ энэ бол 1 удаагийн л ажил. Бид ер нь ийм ажлыг байнга хийж байх ёстой юм байгаа юм. Ер нь Улсын Их Хурлын ажлын нэг нь бол энэ шүү дээ. Ийм л товч хариулт өгье дөө.

Г.Занданшатар: Санал дараа нь л даа. Энэ асуулт явж байгаа шүү дээ. Тодруулна, тодруулж болно. Дараа нь үг, холбогдох саналууд дээр үг хэлнэ. Асуух юм уу, асуух юм байгаа юм уу? 1 минут. Жаргалмаа гишүүн, Бадарчийн Жаргалмаа гишүүн.

Б.Жаргалмаа: Яг ингээд хэлэлцүүлэг явж байгаа цаг мөчид бид нар бас өөр хоорондоо хэлэлцэхээс гадна эрдэмтэн, судлаачдынхаа үг, саналыг бас маш ихээр сонсож байна л даа. Өмнө нь бид нар бас ард нийтийн саналыг бас сонссон байгаа. 152-оо бид нар 123 болгож байна. Ингэснээрээ бид нөгөө хүрэх үр дүндээ хүрч чадах уу, үгүй юү? 123 гэдэг тоог хэрхэн, яаж гаргаж ирсэн юм бэ? Олон нийт энийг маш ихээр асууж байна. Үр дүндээ хүрэх үү? Түүрүүн Бат-Эрдэнэ гишүүн хэлсэн, Ж.Бат-Эрдэнэ гишүүн цаасны гишүүд гээд. Цаасны гишүүд маань улсын хөгжлийг ярих уу? Монгол Улсын хөгжил яагаад орхигдоод байна вэ гэвэл яг тойргийнхоо хөгжлийг, тойрогтоо хийх бүтээн байгуулалтаа бид нар ярьчихсан болохоос биш эрчим хүчээ яриагүй. Өнөөдөр бид нар тойрогтоо орон сууц бариулья гэхлээр цахилгаан эрчим хүчний чинь чадал нь дийлэхгүй, цахилгаан станц чинь хүрэхгүй шүү дээ гэдэг зүйлийг яриад байгаа байхгүй юу. Тэгвэл улсаа 1 тойрог гэж харах улсуудыг бол бид нар пропорционалиар орж ирэх нэрс нь жагсах гишүүдээ гэж харж байгаа.

Г.Занданшатар: Энэ завшааныг ашиглаад би бас нэг зүйл уншаад өгчихье

гэж бодож байгаа юм. Гишүүдийн тоотой холбоотой. Энэ 2019 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл, тухайн үеийн Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт төслийн талаарх саналаа танилцуулсан дэг байгаа юм. Тэн дээр Ардчилсан намаас гарч байгаа саналыг үндэслээд Улсын Их Хурлаас гарч буй хууль бус шийдвэрийг чанартай, үр нөлөөтэй болгох, Засгийн газрын тогтвортой байдал цөөн тооны гишүүдэд шууд нөлөөлж, хуйвалддаг жишигийг халах, Улсын Их Хурлын гишүүд зүй бус нөлөөнд автах эрсдэлийг илэрхий бууруулах, Засгийн газарт тавих парламентын хяналтыг үр нөлөөтэй болгох зүй ёсны шаардлагын хүрээнд Улсын Их Хурлын гишүүдийн тоог нэмэгдүүлэх нь зөв гэж үзэж байна. Ингээд энэ тоо өссөнийг, өгөх тоо баримтуудыг дурдаад хүн амын тоо 1/3-ээр өссөн байхад Улсын Их Хурлын гишүүдийн тоо хүн амын тоотой харьцуулахад цөөн хувиар байгаа нь төрийн эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцэл алдагдахад нөлөөлж, парламентад зүй бус нөлөөлөл орох эрсдэлийг нэмэгдүүлдэг нь судалгаагаар тогтоогдсон байдаг. Аливаа улсын парламент хууль тогтоох, ард түмнийг төлөөлөх, гүйцэтгэх эрх мэдэлд хяналтад тавих чиг үүргээ чанартай хэрэгжүүлэхийн тулд хэдэн гишүүнтэй байвал зохистойг тооцоолон гаргадаг аргачлал байдаг. Энэ аргачлалаар тооцвол манай улсын парламент 114 орчим гишүүнтэй байх боломжтой учраас би 108 гэсэн саналыг гаргаж байна. Ардчилсан намын бүлэг, Монгол Улсын Ерөнхийлөгч.

Энэ нь Улсын Их Хурлын төлөөлөх чадвар, сонгогдсон гишүүний ажлын ачаалалд тохирох хамгийн боломжтой хувилбар гэж үзэж байна. Монгол Улсын Их Хурал цөөн тооны буюу 76 гишүүнтэй байгаагаас аливаа асуудлыг ердийн олонхоор шийдвэрлэх, хэт цөөн гишүүн

хууль батлах, улс орны амин чухал асуудлыг шийдвэрлэхэд хэт сөрөг нөлөөллүүд үүсэж байна. Тодруулж хэлбэл, Улсын Их Хурлын нийт гишүүний олонх нь буюу 39 нь хүрэлцэн ирснээр ирц бүрдэж, ердөө 20 гишүүний саналаар буюу 1/3-ээс бага хуулийг батлах боломжтой байгаа нь чанаргүй амьдралд буухааргүй, тогтворгүй, үр нөлөөгүй хууль гарах сөрөг үр дагаврыг бий болгож байгаа юм.

92 оноос хойших парламентын 7 удаагийн сонгуулиас хойших 2010 оны сонгуулийг л холимог тогтолцоогоор явуулсан. Сонгуулийн жил болгонд Сонгуулийн хуулийг өөрчилдөг жишиг тогтсон нь сонгогчдын боловсролд ч, төр засгийн тогтвортой байдалд ч сөрөг нөлөөтэй байна гээд ийм тодорхой үндэслэл, саналуудыг маш их ярьсан байдаг л даа.

Тэгэхээр би энэ үндэслэлүүдийг бас энд сануулж хэлэх нь зүйтэй байх гэж бодож байгаа юм. Энэ бас нэлээн хэдэн өдрийн яриа хэлэлцүүлэг болж байсан. Тэгээд сонгуулийн жил болсон учраас сонгуулийн жилээс сар гаруй, хэдэн сарын хугацаа дутуу байгаа учраас энэ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт энэ чиглэлээр оруулахгүй гэж үзээд тэгээд 108-ыг 99 гэж хэлэлцэж байгаад, тэгээд энэ холимог тогтолцоон дээр ийм санал хураагдсан юм байна лээ.

Улсын Их Хурлын сонгуулийг тойргоос, Улсын Их Хурлын сонгуулийг олонхыг төлөөлөх болон хувь тэнцүүлэх зарчмыг хослуулан явуулна. Сонгогч, тойргоос нэр дэвшигч, намын жагсаалтын нэр дэвшигчид санал өгнө гэсэн агуулгатай заалтыг 20 гишүүн санаачлаад Ардчилсан намын бүлэг, Ардын намын бүлэг хамтраад санаачлаад, тэгээд чуулган дээр 41 гишүүн дэмжээд 57 хүрээгүй учраас энэ санал унасан.

Мажоритар, пропорциональ гэдэг гадаад үг тэр үед оруулахыг ярьж

байгаад ерөөсөө гадаад үгийг яг ч нөгөө сонгогчдын боловсролд тайлбарлах, буулгах олон асуудал үүсдэг учраас хэрэглэхгүй гэж тогтсон. 92 оны Үндсэн хууль дээр ч гэсэн тийм зарчим барьсан.

Харин стратегийн гэдэг, стратегийн орд газар гэдэг үгийг онцгой ач холбогдолтой гэж орчуулж үзээд тэр нь ерөөсөө орчуулагдахгүй. Манай 25 гишүүн стратегийн орд газарт төрийн мэдэлд, ард түмний мэдэлд байна гэсэн саналыг манай Бат-Эрдэнэ, Даваасүрэн нарын Аюурсайхан нарын гишүүд гаргаад тэгээд тэр стратегийн гэдэг үг эцсийн хэлэлцүүлэг дээр дэмжигдээд орчихсон. Тэрийг хэлний зөвлөх хянаж үзээд онцгой ач холбогдолтой орд газар гэж нэрлэсэн боловч агуулга нь гарахгүй байна, хэлсэн нэршил, тэгээд тухайн үеийн бас улс төрийн нөхцөл байдлаас болоод нэг үг ингэж орсон нь хожим ахиж үг оруулахгүй шүү гэсэн тийм хаалт, хашилт хийе гэсэн. Дараа нь маш олон гомдол санал гарсан.

Тийм учраас энэ бас мажоритар, пропорционалийг аль болох ашиглахгүй дараа нь бас маш их асуудал гардаг учраас энийг ингэж оноож хэрэглээд, тайлбарлаад, үг зүй, нэр томъёоны тольдоо суулгаад, баталгаажуулаад явах нь зүйтэй гэж үзсэн гэдгийг бас иргэдэд мэдээлэл өгөх нь зүйтэй.

Ер нь үндсэн хуулийн боловсрол, парламентын боловсролыг ерөнхий боловсролын сургуулиудад хичээл заадаг улсууд байна. Тийм учраас энэ ардчиллын боловсрол, хүний эрхийн боловсролыг энэ сургуулийн программд орох асуудлыг энэ Боловсрол, шинжлэх ухааны яам судалж, хэрэгжүүлэх нь бас зүйтэй байж магадгүй.

Одоо Одонгийн Цогтгэрэл гишүүн. Ардчилсан намын бүлгийн дарга.

О.Цогтгэрэл: Үндсэн хуулийн асуудал, Үндсэн хуулийн өөрчлөлтийн

асуудал нийгэм даяар, ард түмэн даяар ингээд хэлэлцүүлэг өрнөж байна л даа. Монгол Улсын Үндсэн хуулийн хамгийн эхний өгүүлбэр Монголын ард түмэн бид гэж эхэлдэг, Монголын ард түмэн бид. Тэгэхээр энэнд хамаарахгүй зүйл, асуудал байхгүй нь тодорхой.

Тэгэхээр ер нь энэ Үндсэн хуулийн асуудлыг яагаад бас ярих хэрэгцээ шаардлага үүссэн бэ, Үндсэн хуульд тэр тодорхой хэмжээний энэ тоо, тогтолцоо, парламенттай холбоотой асуудлыг ярих шаардлага үүссэн бэ гэдэгт бид нар бас бүгдээрээ бас өөр өөрийн байр суурьтай ингээд оролцож байгаа.

Мэдээж аливаа асуудлыг тэр тусмаа улсын засаглалын асуудлыг ярихад гадаад, дотоод нөхцөл байдал, ямар хэрэгцээ, шаардлага байв гэдэг асуудал мэдээж гарч таарна. Тэгэхээр ингээд дотоодоосоо хэлбэл яг үнэндээ бүх зүйл хуучнаараа байвал парламентад 76 гишүүн гэдэг зүйл өөрөө бас яг хэвээрээ байхад шаардлага хангаж байгаа юу? Ард иргэд дотоод нөхцөл байдлын хувьд таалагдаж байгаа юу? Төвчхон хэлэхэд л 76 худалч, 76 хулгайч гэдэг ийм л нэршил рүү явчихлаа. Энэний цаана бас олон зүйл болохгүй байгаа, улсын нэгдсэн бодлого, дахиад тогтолцооны хувьд тэр санал гээгддэг олон зүйл энэний цаана бас ингээд агуулагдаад энэ тодорхой хэмжээний дотоод нөхцөл байдлын хувьд, дотоод асуудлын хувьд бас маш их том хуримтлагдсан зүйлс байдаг.

Харин гадаад нөхцөл байдлын хувьд бас цөөн зүйл бас хэлье гэж бодож байна. Ер нь бид нар дэлхий нийтийг больё зүгээр. Бүс нутгийн хувьд манай урд хөрш Хятад ард улс тэрбум гурван зуугаад сая хүнтэй. 1 хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн бараг 12 мянган доллар болчихлоо. Манайхаас 5 дахин их 1 хүн нь орлоготой. 5 дахин их орлоготой, дахиад цаана нь бараг 400 дахин их хүн амтай. Бараг манайхаас мянга дахин том эдийн засаг, тэгсэн мөртөө тийм эдийн засаг

мөртөө 1 хүнд ноогдох бүтээгдэхүүн нь манайхаас үндсэндээ 3 дахин ийм том ийм улс орон тэнд ингээд бид нарын энэ хил залгаа оршиж байгаа юм.

Хойд талд бас яг тийм хэмжээний 1 хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн нь 12 мянган доллартой, 140 сая хүнтэй. Манайхаас 100 дахин том эдийн засаг. Тэгэхээр бид бүгд тэд нараас цөөн хүн амтай, жижиг эдийн засагтай. Тэгсэн мөртөө 1 хүнд ноогдох нь ядуу. Энэ улсад бид нар яаж энэ хөгжлөөрөө ойролцоо очих вэ, яаж урд нь гарах вэ гэдэгт ялт ч үгүй тэд нараас бид хуучин явж ирсэн замаасаа тодорхой хэмжээний өөрчлөлт оруулах ийм хэрэгцээ, шаардлага гарчхаж.

Тэгвэл юугаараа ялгаатай байх юм бэ гэвэл бид бүгдийн хувьд ялт ч үгүй энэ парламентын засаглалын төгөлдөршил гэдэг зүйлээрээ, ард түмэн нь засгаа барьдаг парламентын засаглалтай улс гэдэг. Энэ парламентаа бэхжүүлэх, батжуулах гэдэг ийм гадаад нөхцөл байдал шаардлага Монгол Улсын хувьд ялт ч үгүй ингээд үүсчхээд байна гэдэг ийм байр сууриуд тал талдаа нэгдэж байгаа байх.

Тэгэхээр бид нарын хувьд тэгвэл парламентын засаглалаа яаж бэхжүүлэх юм? Энэ нь яаж ард түмнээ бүрэн дүүрэн төлөөлж чаддаг, санал нь гээгддэггүй, бодлого шийдвэр нь улсынхаа бодлого шийдвэрийг нэгэн зүгт чиглүүлж чаддаг парламент тэгвэл яаж бүрэлдэж бий болох юм гэдэг асуудал өнгөрсөн хугацаанд бас бид нарт ингээд хуримтлагдаж ирж.

Ер нь Ардчилсан намын бүлгийн зүгээс Ардчилсан намын зүгээс үе үед парламентын төгөлдөршлийн, парламентын тогтолцооны төгөлдөршлийн тухай байнга саналаа илэрхийлж ирсэн. Энийг ялт ч үгүй тэр пропорциональ тогтолцоо, пропорциональ элемент, нийгмийн

бүлгүүдийн төлөөлөл ордог, санал бага гээгддэг энэ тогтолцоог Ардчилсан намын хувьд байнга л илэрхийлж ирсэн.

Ийм ч учраас сая энэ хэлэлцүүлгийн эхэнд Үндсэн хуулийг хэлэлцэж эхлэхээс өмнө Ардчилсан намын бүлгээс төлөөлөд 76 гишүүн хэвээрээ байя. Энэ нь дотроо тэр холимог тогтолцоо гэдэг зүйлийг оруулъя, тэгэхдээ энэ 60, 40 гэдэг харьцааг баримталъя, 48, 28 гэдэг ийм саналыг Ардчилсан намын бүлгийг төлөөлөд миний бие бас хуулийн төсөл өргөн барьж байсан. Энэ бол Монголын парламентын төгөлдөршилтэй холбоотой зайлигүй хийх ёстой зүйл гэдэг.

Мэдээж энэ ажил хэрэг болохын тулд Үндсэн хууль дээр бичсэнээр Монголын ард түмэн бид гэдэг энэ хүрээнд мэдээж энэ бол томоохон тийм харилцан ойлголцол, зөвшилцлийн хүрээнд энэ асуудал хийгдэх ёстой. Ийм ч учраас саяын тэр тогтолцооны өөрчлөлтийг орохын тулд хуучин 76 гэдэг тоон дотроо багтаж энийг хийх боломжгүй юм гэдэг тал талын ингээд ойлголцол, онолын асуудлууд ч олон зүйл давжаа парламент байна гэдэг олон зүйл гарч ирсэн учраас парламентын гишүүдийн тоотой холбоотой асуудал дээр харилцан ойлголцохоос өөр бүүр арга замгүй болж. Ийм учраас парламентын гишүүдийн тоог өсгөх гэдэг энэ шинэ тооны асуудлууд бас ингээд гарч ирсэн.

Харин энэ дээр 152 гэдэг энэ хэт 2 дахин өсөж байгаа хэт их том тоо гэдэг дээр ард иргэдийн санаа бодол ийм байгаа учраас дахиад ер нь яг бодит төлөвлөх чадварын хувьд ч гэсэн 1992 онд Монгол Улс 2 сая 50 мянган хүнтэй байж. Өнөөдөр 3 сая 400 мянга. Энэ яг ямар ч бутархай тоогүйгээр бүхэл тоогоороо 65 хувь Монголын хүн ам өссөн. Харин 76-г 126 болгож, болж байгаа нь дахиад ямар ч бутархай тоогүйгээр яг бүхэл тоогоороо парламентын гишүүдийн тоо 65 хувиар өсөж байгаа. 50-аар өсөж

байгаа нь төлөөлөх чадварын хувьд яг ингээд адил. Энэ бол өөрөө бас тооны хувьд бас байх боломжтой юм.

Тэгэхдээ хамгийн гол үзэл санаа бол энэ тогтолцооны өөрчлөлт, холимог тогтолцоо, пропорциональ гэдэг элемент ордог, энэ нь өөрөө ард иргэдийг төлөөлөх чадвар гэдэг энэ олон зүйлтэй илүү холбоотой юм гэдэг үүднээс Ардчилсан намын зүгээс, Ардчилсан намын төлөөллийн байгууллагуудын шийдвэрийн дагуу бид бүгд энэ өөрөө нийгмийн зөвшилцлийн хүрээнд байж болох боломжтой ийм хувилбар гэдэг дээр байр сууриа илэрхийлээд энэ хэлэлцүүлгүүдэд ингээд оролцоод явж байгаа.

Мэдээж энэ Үндсэн хуулийн асуудал өөрөө 4 үе шаттай. Одоо дөнгөж хоёрдугаар үе шатан дээр явж байна. Дахиад ард иргэдийн санаа бодлыг сонсох гэдэг ийм үе шат энэний цаана явагдана. Тэгэхээр энэ бүгд дээр бас ард иргэдийн санаа бодол олон зүйлийг тусгаад, тэгэхдээ бас онол, ном дүрмийнхээ хувьд гадаад нөхцөл байдал, дотоод нөхцөл байдал, олон зүйлээ харгалзаад бас энэ хэлэлцүүлгүүдэд ингээд оролцоод явж байгаа.

Тэгэхээр надад бол мэдээж энд ажлын хэсгийн гишүүний хувьд бас асуулт бол алга. Тэгээд санаа бодлоо бас цааши цаашид бид бүгд бас ингээд илэрхийлээд, байр сууриа илэрхийлээд, ард иргэдийн санаа бодлыг бас тусгаад ингээд ажиллана гэдгээ бас хэлье.

Г.Занданшатар: Таныг эзгүйд Цагаанхүүгийн Идэрбат гишүүн бас асуулт асуусан. Ажлын хэсгийн гишүүний хувьд. Ардчилсан намын бүлэг, Ардчилсан намын бүлгийн даргаас тэр ажлын хэсгийн гишүүний хувьд 126 гэдэг дээр Доржханд гишүүн хариулчихсан. Ямар байр суурьтай байгаа юм бэ? Идэрбат гишүүнээ таны асуултад одоо хариулна. Та 2 минут хүлээчих. Гүйцээгээд Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Би бас түрүүн хэллээ. Ер нь энэ Үндсэн хуулийг хэлэлцүүлэхэд Ардчилсан намын баримталж байгаа байр суурь бол энэ пропорциональ элемент, санал гээгддэггүй байх, санал бага гээгддэг байх, нийгмийн төлөөллүүд орох боломжтой байх, улсын хэмжээний нэгдсэн бодлого явах, боломжтой байх гэдэг үүднээс энэ пропорциональ элемент орох ёстой.

Тийм ч учраас 76 дотроо, 76 дотроо 48, 28-аар пропорциональ болчихъё гэдэг эхний саналыг Ардчилсан нам гаргаад ажиллаж байсан. Яг нөхцөл байдлын хувьд, онол номынх нь хувьд энэ давжаа парламентын хүрээнд саяын элемент ороход өөрөө бас учир дутагдалтай байна гэдэг онолын хэлэлцүүлэг, улс төрийн намуудын байр суурь, олон талууд нэгдсэн учраас тодорхой хэмжээнд тоог нэмэгдүүлж болох юм гэдэг байр суурийг намын төлөөллийн төв байгууллага болоод, намын удирдлага олон талаас бас санал нэгдсэн.

Тэгвэл шинэ тэр нэмэгдэж болох тоо хэд вэ, тэр онолынх нь тоо хэд вэ, практик дээр ард түмэн бас юу хүсээд байна вэ гэдэг дээр тал талын хэлэлцүүлэг өрнөөд, 152 бол хэт их байна. Тэгсэн мөртөө нэгэнт өөрчлөлт хийснийх бас төлөөлж чадах тоон дээр бас очих ёстой. Хэрвээ энэ хэлэлцүүлэг энэ үе шатнаас уначих юм бол 152 биш 76-гаар явъя гэхэд энэ асуудал дахиад 8 жилийн хугацаанд хэлэлцэгдэхгүй болох нь. Дэгийн тухай хуулиар. 2030 он хүртэл, 31 он хүртэл энэ асуудал хэлэлцэгдэхгүй болох нь. Энэ өөрөө бас улс орны эрх ашигт нийцэхгүй зүйл юм.

Тэгэхээр ямар ч байсан тодорхой харилцан буулт хийж, тодорхой тоон дээр очигцоох ёстой гэдэг ийм саналууд гарсан учраас 126 гэдэг тоог тал талаас бас гаргаж ирээд, энэ дээр зөвшилцөөд ингээд ойлголцоод явж байгаа. 126 гэдэг

тооны хувьд төлөөллийг нь үзэх юм бол 1992 онд 76 гишүүнд хуваагдахад 2 сая 50 мянган иргэнийг хуваахад 1 иргэн нь 26970 иргэнийг төлөөлж байсан юм байна лээ. 27 мянган иргэнийг тэр үед төлөөлж байсан.

Өнөөдрийн 126-г тэр үеийн төлөөлөл Үндсэн хууль боловсруулагчдын авсан тэр 27 мянгад хуваагаад үзэх юм бол яг цэвэр 125.9 гэдэг тоо гарч байгаа юм. 125.9 буюу 92 оны Үндсэн хуулийн үзэл санаа өнөөдөр яг энэ 126 гэдэг.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Хариулт хангалттай юу та? Одоо Балжиннямын Баярсайхан гишүүн асуултаа асууя.

Б.Баярсайхан: Баярлалаа. Өнөөдөр улс орны хувьд хөгжлийн болоод тогтолцооны том шинэчлэл хийх гэж байгаа ийм түүхэн цаг үе явж байна. Энэ үед Монголын нийт ард иргэд Үндсэн хуулиа өөрчлөх шаардлагатай юу, сонгуулийн тогтолцоонд өөрчлөлт оруулах шаардлагатай юу, мөн гишүүдийн тоог нэмэх шаардлагатай юу гэдэг дээр өөрсдийнхөө санал бодлыг хэлж байгаа.

Миний хувьд өнөөдөр Завхан аймгийнхаа 12 сумаар ажиллаад, нийтдээ 1552 хүнтэй уулзаж санал бодлыг нь сонслоо. Ер нь бол сүүлийн 30 жил бид нар ардчилал зах зээлийн нийгэмд явахдаа бидэнд алдсан зүйл ч байгаа, оносон зүйл ч байгаа. Энэ хамгийн энэ алдаатай зүйл гэвэл сонгуулийн тогтолцоогоо бид нар буруу хийснээс өнөөдөр сүүлийн 30 жил нэг Засгийн газрын эрх барих хугацаа 1,5 жилээр үргэлжилж, эдийн засгийн болон хөгжлийн тогтворгүй ийм байдлыг бий болгосон гэдгийг ард иргэд ойлгож байна.

Ийм учраас сонгуулийн тогтолцоогоо өөрчлөхийг дэмжиж байна. 152 гэдэг тоог Завханы нийт иргэд бараг дэмжээгүй. Ер нь бараг 98, 99 хувь нь дэмжээгүй гэдгийг хэлье. Мөн энэ

жагсаалтаар орох гэж байгаа иргэдэд манай аймгаас төрсөн Хөдөлмөрийн баатар Намхайнямбуу гуай нэгэн цагт Ардын Их Хурлын депутатаар ажиллаж, Улсын Их Хурлын чуулганы танхим төдийгүй Монгол улсын хэмжээнд мал аж ахуй яагаад чухал юм, малчин хүний хөдөлмөр ямар хүнд хүчир байдаг юм, мал аж ахуйн салбарын үнэ цэн нь юу юм бэ гэдгийг Монголын нийт ард иргэдэд соён гэгээрүүлж байсан ийм малчдын төлөөлөл болж байсан ийм сайхан хүн байдаг.

Тэгэхлээр яг Намхайнямбуу гуай шиг энэ нийгмийн төлөөллүүдийн дуу хоолой, яг тэр итгэмжит тэр төлөөлөгч болж чадах хүмүүсийг өнөөдөр жагсаалтад оруулбал бас бид нар дэмжинэ. Тэгэхээс биш ямар нэгэн байдлаар ёс зүйн асуудалд хутгалдсан, нэр муутай, үйлс муутай ийм хүмүүсийг жагсаалтад оруулж ирэх юм бол тухайн намыг яасан ч дэмжихгүй шүү гэдэг ийм хатуу байр суурийг бас илэрхийлсэн гэдгийг дамжуулж хэлж байна.

Мөн жишээлбэл ахмадуудын төлөөлөл Түдэвтэй сумын өндөр настан Мөнх-Эрдэнэ, мөн Тосонцэнгэл сумын өндөр настан Раднаасэнгэ гуай нарын ахмадуудаас энэ олон намын төлөөллийг оруулж ирнэ гээд байгаа нь сайн боловч энд төлөвшөөгүй нам, төлөвшөөгүй улс төрч ингэж орж ирэх маш их эрсдэл харагдаад байна. Энийг яах юм бэ? Төлөвшөөгүй нам, улс төрийн хүчний балаг энэ нийгэмд ямар их хор уршиг тарьдаг гэдгийг бид нар бас сүүлийн 30 жилийн энэ хөгжлийнхөө энэ түүхээс бид нар ханатлаа харж байна.

Хэрвээ энэ төлөвшөөгүй нам Улсын Их Хуралд ороод ирэх юм бол дахиад л нөгөө өмнөх түүх давтагдаад Засгийн газар байгуулагдахгүй удах, тал тал тийшээ ингээд хараад суучих ийм нөхцөл байдал үүсэх ийм эрсдэлтэй байна гэдгийг бас ахмадууд маань сануулж байгааг бас дамжуулж хэлье.

Ер нь бид нар Үндсэн хуульдаа хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм гэж байгуулна гэж зорьсон. Гэтэл өнөөдөр хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг хүнлэг, ёс суртахуунтай, сайн зан чанартай иргэн бүрдүүлнэ гэдгийг ерөөсөө ухаарч өгөхгүй байна. Сүүлийн 30 жил бид нар мөнгө, эдийн засгаа хөгжүүлэх, баяжих, алдар нэр амархан олох, албан тушаалд амархан хүрэх гэдэг юм уу хүний хөгжлийг орхигдуулсан, илүү салбарын хөгжлийг чухалчилсан уул уурхайн салбарын хөгжил, эдийн засгийн хөгжил энэ нь зөв л дөө.

Гэхдээ төрийн бодлого гэр бүлийн хүмүүжилд хүнээ хөгжүүлэх, хүнээрээ хүн хийх, сайн хүн бий болгох гэдэг дээр бид нар алдсан. Тийм учраас өнөөдөр төрийн түшээд нь цэвэр ёс суртахуунтай хүмүүс байх ёстой гэдэг юм уу, төрийн албан хаагчид нь ёс суртахууны өндөр төлөвшилтэй хүмүүс байх гэдэг юм уу, хувийн бизнес аж ахуйн нэгжүүд нь хүртэл сайн зан чанартай ёс суртахууны эрэлд ингээд хатчихсан. Улс нийгмээрээ сайн зан чанартай сайн хүн хайсан ийм л нийгмийг бид нар бий болгочихжээ.

Тэгэхлээр энэ тогтолцооны өөрчлөлт, сонгуулийн тогтолцоонд өөрчлөлт орсноороо бид нар эдийн засаг, Засгийн газар тогтвортой ажиллахын сацуугаар өнөөдөр бидэнд хамгийн ус, агаар мэт хэрэгтэй байгаа энэ Монгол Улсыг цаашид нь авч явах энэ иргэдийн төлөвшил, Монгол улс цаашидаа улс орон байх юм уу, хүчтэй улс орон байх юм уу гэдгийг хамгийн их шийдэх энэ улс орны хамгийн үнэ цэнтэй баялаг болсон тэр хүн, хүнээ бэлдэх, хүүхдээ бэлдэх, хүүхдээ сайн хүн болгох гэдэг дээр энэ улс орон тэр чигтээ анхаарах ёстой. Энэ нь зөвхөн Их Хурлын ажил биш, Засгийн газрын ажил биш өнөөдөр эцэг эх болсон хүн нэг бүрийн журамт, бүүр тэр ариун хариуцлагатай үүрэг юм гэдгийг бас ойлгох шаардлагатай байна.

Тэгээд хүн байхгүй бол Монгол Улс байхгүй шүү дээ. Хүнээ төлөвшүүлэхгүй бол бид нар энэ ёс суртахууныхаа энэ асуудлаас гарч чадахгүй. Төлөвшөөгүй хүн хэчнээн сайхан боловсрол эзэмшээд хэдэн хэлээр яриад ч өөрийнхөө боловсролын түвшинд хулгай хийж чаддаг, эх орноо худалдаж чаддаг, бүүр тэр хулгай хийх зам нь илүү нарийсаж чаддаг гэдгийг бид нар хангалттай харлаа. Тийм учраас хүний төлөвшил дээр энэ хаа хаанаа бид нар анхаарах цаг болчихсон шүү гэдгийг хэлье. Хүний хөгжлийн бодлогыг энэ “Шинэ сэргэлтийн бодлого” “Алсын хараа- 2050”-д бид нар цөм болгоод өнөөдөр явж байгаа боловч эдийн засаг хөгжсвөл хүн нь хөгжинө гээд байна. Үгүй шүү дээ. Эдийн засгаа хөгжүүлэхийн сацуу бид нар хүнийхээ хөгжлийг, хүнийхээ зан чанарын хөгжлийг, ёс суртахууны хөгжлийг бид нар хамтад нь аваад явах юм.

Тэгээд нийгмийн сэтгэлгээ, нийгмийн энэ хандлага хаашаа яваад байна энэ сошиалд энэ ямар харанхуй зүг рүү биднийг хөтлөөд байна гэдгийг бас бид нар анхаарах ёстой. Яг энэ зүйлийг бид нар хамтад нь аваад анхаараад явах ёстой гэдэг ийм зүйлийг хэлье. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Балжиннямын Баярсайхан гишүүн Үндсэн хуулийн өөрчлөлттэй холбогдуулан байр сууриа илэрхийлж, үг хэллээ. Мөн Завхан аймгийн иргэдээс Үндсэн хуулийн өөрчлөлттэй холбогдуулан гаргасан саналуудыг танилцууллаа гэж ойлголоо. Асуулт байхгүй тийм ээ? Үг хэллээ гэж ойлголоо. Дараагийн гишүүн асууя. Одоо Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуултаа асууя.

С.Ганбаатар: Би хэдэн өдөр Үндсэн хуулийн үзэл баримтлал, онолыг л ярилаа. Ойлгож байгаа ч хүн алах шиг байна даа чааваас. Би тэгээд нарийн яривал тэр тоо ч би яриагүй шүү дээ. Сүүлдээ бүүр энэ дээр бид энэнд гар дүрэх эрх байгаа юу, үгүй юү? Энэ асуудлыг

асуух механизм дээрээ би хүртэл ярьж байгаа шүү дээ. Бид яг зөв арга замаар асуугаад байгаа юу, зөв арга замаар саналаа, шийдвэрээ гаргаж байгаа юу? Их Хурал өнөөдөр өөрөө өөрийнхөө сандал ширээг нэмэхдээ ядаж ичих сэтгэлтэй байх ёстой. Би ерөөсөө энэ олон тоог 300 байсан ч хамаагүй. Тэр тоо яриагүй шүү дээ. Шийдэх арга зам, механизмаа ярьж байгаа. Тэгээд би одоо бол хэдэн нарийн хуулийн асуултуудыг асууя. Та нар маань үзэг, цаасаа бэлдээд яг хууль, зүйл, заалтаар надад ажлын хэсэг хариулж өгөөрэй гэж би хүсэж байна.

Нэгдүгээрт, би 4 асуулт байгаа. Үндсэн хуульд өөрчлөлт оруулах талаар Улсын Их Хурал хэлэлцэж шийдвэрлэх гээд байна. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 15.2-т, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24^б.2-т заасан үндэслэлээр гаргасан саналын томъёоллыг уншиж, томъёолол тус бүрээр санал хураана гэсэн байгаа. Энэ хэсгийг 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан гэжээ. Яг энийг би энэ 26^б-ыг бүтэн 7 хоног хайлаа байхгүй. Та нар одоо надад гаргаад өг.

Би юу юун дээр хайсан бэ гэвэл 2022 оны 9 сарын 6-ны өдөр хэвлэсэн, тараасан Тамгын газрын ном байна. 102 ба 119 дэх хуудаст хуулбарыг нь би энэ гишүүдэд бүгдэд нь өгсөн. Хуулбарыг нь хавсаргачихсан байгаа. Байхгүй. Legalinfo гээд дээр хамгийн чухал байдаг юм гэж байна. Байхгүй бас. Би энэ Их Хурлын гишүүд бүгдэд нь legalinfo-оос хавсаргаад одоо авчихсан. Байхгүй.

Тэгэхлээр би миний асуулт, нөхөд минь ээ, миний ойлгосноор Улсын Их Хурлын энэ удаагийн Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг гурав дахь хэлэлцүүлгийг хийх үедээ ямар ч хуулийн боломжгүй болчихлоо шүү дээ. Та нар энэ 24^б.2 гэдэг хуулийнхаа өөрийнх нь заалт нь байхгүй. Яг одоо наад яг хариулахдаа

гаргаж өгнө шүү. Байгаа бол камерт харуулаарай.

Хоёрдугаар асуулт. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 15 дугаар зүйлийн гурав дахь хэлэлцүүлэг явуулах журам гэдэг дээр бас яг энэ байгаа. Гурав дахь хэлэлцүүлгийг явуулахдаа бас энийг барина. Байхгүй. 15-ыгаа та нар хараарай. 15.2-т заасан дагуу санал хураалт хэрхэн явагдах вэ? Гурав дахь хэлэлцүүлгийг явуулахдаа журмын 15.2-т заасан дагуу санал яаж явуулах вэ? Энэ дээр та нар ажлын хэсэг мэргэн ухаандаа аль хэзээний бодчихсон байгаа байх. Хариулах байх гэж найдаж байна.

Би өчигдрөөс хойш асуугаад байгаа. Байнгын хороонуудаар байнга асуусан. Өөрийнхөө харьяалдаг Байнгын хороонуудаар байнга асуусан. Засгийн газар надад хариулт өгч байгаа, ингэж хариулж байгаа юм. Миний асуулт их ойлгомжтой шүү дээ. Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт оруулах өөрчлөлтийг Улсын Их Хурал шийдвэрлэхдээ Үндсэн хуулийн 69 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу ард нийтийн санал асуулга явуулах арга замыг сонгох нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураагаад өгөөч л гэдгийг би хүсэж байгаа юм. Би томъёоллоо хүртэл хэлж байгаа юм.

Тэгэхлээр өөдөөс хэлж байгаа юм нь эднүүс өөрсдөө Ард нийтийн санал асуулгын тухай хуулийг ярьж байгаа. Ард нийтийн санал асуулгын хуулийн 5 дугаар зүйл дээр. Санал асуулга санаачлах эрх бүхий этгээд 5.1-д ард нийтийн санал асуулга явуулахыг Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын Их Хурлын нийт гишүүний 1/3-ээс доошгүй нь санаачлах нь эрхтэй гэж байгаа. Намайг ингээд 25 гишүүний эрэлд хатааж байгаа юм. Олдохгүй байна. Тэгээд би энэ дээр бүтэхгүй байгаадаа биш. Миний барьж байгаа баримтлал юу вэ гэвэл Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 53.2-ыг

зааж байгаа. 53.2-ыг та нар хараарай. Төрийн байгуулалтын байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар Ард нийтийн санал асуулга явуулах тухай тогтоолын төслийг хэлэлцэж, Улсын Их Хурлын нийт гишүүний 2/3-оос доошгүйн саналаар батална гэж байгаа юм. Энийг л 2/3-оор санал асуугаад өг л гэж би гуйж байгаа байхгүй юу. Энэ дээр 53.3-д Төрийн байгуулалтын байнгын хороо Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан гэж байгаа юм. Энэ 2 дугаар хэлэлцүүлгээ ярьж байгаа юм. Нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр дэмжигдсэн саналыг өөрчлөх буюу хүчингүй болгох санал, дүгнэлт гаргах гишүүн, цөөнх хоёр дахь хэлэлцүүлгээр баталсан саналаасаа зөрүүтэй болон өөр зүйл, хэсэг, заалт, нэмэлт гаргахыг тус тус хориглоно гэж байгаа юм.

Миний, би санаагаа илэрхийлж чадсан байх л гэж итгээд байна. Өөрөөр хэлбэл өглөө би асуусан. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 17.1-д заасан Улсын Их Хурлын төслийг хэлэлцээд тухайн нэмэлт, өөрчлөлтийг ард нийтийн санал асуулгаар оруулах нь зүйтэй гэж Улсын Их Хурлын нийт гишүүний 2/3-оос доошгүйн саналаар тогтвол гэж байгаа юм. Та нар хуулийн хувьд тогтвол гэдэг чинь, бид өнөөдөр тогтчихсон юм уу? Зүгээр л чимээгүй бие бие рүүгээ хараад тогтчихсон юм уу? Тогтвол гэдгийг яаж тогтоох юм? Саналаа өргөж, гараа өргөж юм уу, эсвэл кнопоо дарж тогтоно гэж би итгэж байгаа. Зүгээр чимээгүй ингээд тогтдог юм уу? Хуулийн тайлбарыг нь надад энэ дээр гаргаж өгөөч. Тогтвол гэсэн үг яг анхаарал татаж байна.

Би дөрөв дэх асуултаа асууя. Ер нь бол хуулийн зүйл, заалт яривал толгой эргээд эхлэх байх л даа. Улсын Их Хурлын гишүүд ард түмний элчийнхээ хувьд сонгогчид ард нийтийн саналын үндсэн дээр Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг

ёсчлон батлах гэж үг байгаа шүү дээ. Ёсчлох ёсчлох гэдэг бол бид хэлбэржүүлнэ, нарийн бичгийн даргын ажлыг хийнэ л гэсэн үг. Яг батална гэсэн үг алга. Энэ дээр хуулийн ямар тайлбар байдаг юм бэ?

Эцэст нь нэг асуулт асуухад Улсын Их Хурлын гишүүд энэхүү асуудлыг хэлэлцэхдээ бид нар юуг барьж байгаа шүү дээ 25.1 дэх Улсын Их Хурал дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд шийдвэрлэнэ гэж байгаа. Тэгэхээр Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэр гаргах эрхийнхээ хүрээнд 25.1.1-д ингэж зааж байна. Улсын Их Хурал нь хууль батлах нэмэлт, өөрчлөлт оруулах гэсэн заалтдаа оруулаад бид хууль баталж байгаа, өнөөдөр. Энэ дотор яг Үндсэн хууль гэдэг юм орж байгаа юу? Хууль гэдэг дотор. Надад хуулийн тайлбарыг бас гаргаж өгөөч. Би өглөө бас хэлсэн юм шүү дээ. Үндсэн хууль хууль гэдэг бол энэ Үндсэн хууль, бид импортоор орж ирсэн санаа. 2 өөр нэр томъёотой байгаа шүү дээ.

Нэг нь бол хууль. 850-аад гэлүү дээ, хуулийг Улсын Их Хурал ард түмэндээ зориулж баталдаг, үүнийг хууль гэж хэлж байгаа. Энэ 76 болон Ерөнхий сайд, Ерөнхийлөгч, Дээд шүүхийн ерөнхий шүүгч гэсэн 80 хүнд зориулж ард түмэн бидэнд зориулсан хууль бол Үндсэн хууль. Энэ 2 ялгаатай. Хууль гэдэг малгайн дотор үүнийг оруулж бодох нь зөв үү? Би ийм бараг 6 асуулт асуучихлаа. Асуулт болгон дээрээ би хариулт авъя.

Л.Мөнхбаатар: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн 6 асуулт асуулаа. Энэ дээр хариултуудыг нь бас их тодорхой өгье. Дандаа хууль зүйн асуудлууд байна. Дээр нь дэгтэй холбоотой асуудал асуулаа. Ард нийтийн санал асуулгатай холбоотой гээд, тэгээд ёсчлон батлахтай холбоотой гээд хэд хэдэн асуултууд байна.

Хэн хариулах вэ? Ажлын хэсэг эхлээд хариулж байх юм уу? Дараа нь хэн Энхболд дарга дараа нь нэмэх үү, эхлэх юм уу? Ажлын хэсгээс хэн хариулах вэ? Ажлын хэсэг эхлээд хариулаад явж байх юм уу? Энхболд дарга яах юм, Та. Төгсгөлд нь хариулах юм уу? Ажлын хэсэг хариулъя. Хэн хариулах вэ? Баасандорж дарга хариулах уу даа, 80 дугаар микрофон өгье. Барсүрэнгийн Баасандорж.

Баасандорж Засгийн газрын Хэрэг эрхлэх газар. Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Чуулганы хуралдааны дэгтэй холбоотой асуудал Их Хурлын Тамгын газраас хариулах байх.

Ганбаатар гишүүн Үндсэн хуулийн 68 дугаар зүйлийн 2-той холбоотой, өөрөөр хэлбэл Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар Улсын Их Хурлын гишүүний 3-ны 2-оос доошгүйн саналаар ард нийтийн санал асуулга явуулж болно. Санал асуулгыг Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16-д заасан үндэслэлийн дагуу явуулна гэдэг зүйлийг асуулаа.

Мөн та, тэгэхээр Үндсэн хуулийн, өөрөөр хэлбэл энэ Үндсэн хуулийн 68 дугаар зүйлийн 2 дахь хэсэг дээр маш тодорхой бичсэн байгаа. Тэгэхээр энэ 68 дугаар зүйлийн 2-оороо Үндсэн хууль маань Үндсэн хуулийн өөрчлөлтийн төсөл маань хэлэлцэгдээд явах байх аа.

Та мөн Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуультай холбоотой буюу энэ Үндсэн хуулийг ёсчлохтой холбоотой, өөрөөр хэлбэл хэвлэн нийтлэхтэй холбоотой, албан ёсны эхтэй холбоотой асуулаа. Тэгэхээр журмын тухай хуулийн 16.4 мөн, журмын тухай хуулийн 18.13 дээр, 16.4 дээр Ерөнхийлөгч нотлон баталгаажуулсан уг эхийг Үндсэн хуульд байршуулж, төрийн мэдээллийн бэлтгэлд нийтлэх бөгөөд түүнийг албан ёсны эхэд тооцно. Мөн журмын тухай хуулийн 15.8

дээр Улсын Их Хурлын нийт гишүүний 4-ний 3, түүнээс дээш хувь нь батлах санал өгсөн бол Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг батлагдсанд тооцож, батлагдсанд тооцож нийтэд мэдээлнэ гэж байгаа юм.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгээс өөр нэмж хариулах зүйлүүд байна уу? Хэн. тогтмол гээд энэ 17.1 дүгээр заалттай холбоотой тэр Тамгын газар нэг хариулт өгчих. 1.

Ер нь энэ Үндсэн хуулийн өөрчлөлттэй холбоотой хоёр дахь хэлэлцүүлэг явагдаж байна. Тэгэхээр ер нь бол хэлэлцэх эсэх дээрээ яригдах ёстой асуудлуудыг өнөөдрийн чуулганаар үг хэлж байгаа, асуулт асууж байгаа гишүүд их олноор асууж байна.

Өнөөдөр дэгээрээ Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбоотой асуудлуудыг л асуух асуулт байвал нь асуух ёстой юм шүү. Их Хурлын Тамгын газраас Ганбаатар гишүүний асуултад товч хариулт өгье. Үнэнбат дарга хариулъя. Улсын Их Хурлын Тамгын газрын тэргүүн дэд дарга.

М.Үнэнбат: Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Одоо бол Үндсэн хуулийн өөрчлөлтийн хоёр дахь хэлэлцүүлгийг чуулганы нэгдсэн хуралдаанаар явж байгаа. Тэгээд хоёр дахь хэлэлцүүлгийг бол 50 дугаар зүйлд заасан журмын дагуу хэлэлцэх журамтай. Тэгээд 50-ийн энэ журмын дагуу хэлэлцээд явж байна. Саяын таны тэр 24-ийн 6 итрих 1-д заасан гэсэн ийм асуудал асуусан. Энэ бол 2007 оноос 2020 он хүртэл үйлчилж байсан Монгол Улсын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд байсан заалтын эшилсэн заалт байна. Тэгэхээр энэ бол одоо гурав дахь хэлэлцүүлэг буюу гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх гээд энэ хүрээнд яригддаг энэ асуудал дээр байгаа энэ зохицуулалтууд бол яг энэ дэгийн хууль

дээр бол бүгд тусчихсан явж байгаа. Монгол Улсын чуулганы хуралдааныг бол чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан зохицуулалтын хүрээнд явагдах ёстой.

Тэгээд 50.4, 50.3, 50.2 гээд өнөөдөр бол яг энэ хоёр дахь хэлэлцүүлэгт заасан журам дэгээр бол ингээд зохицуулагдаж явж байгаа гэдгийг танд хэлье.

Л.Мөнхбаатар: Ганбаатар гишүүн тодруулах юм уу? Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулж асууя, 2 минут.

С.Ганбаатар: Эрхэм ухаантай ажлын хэсгийн нөхөд ээ, би яг энэ хэлэлцэх эсэхийн үед үүнийг бас асууж байсан. Би яг зүйл заалтаар нь асууж байсан. Та нар протоколоор үзээрэй. Тэгээд хэлэлцэх үед надад ам тагласан юм нь болохоор наадхыг чинь хэлэлцэх 2 дугаар хэлэлцүүлгийн үеэр ярьдаг юм л гэсэн. Миний асуулт их тодорхой. Улсын Их Хурлын төслийг энэ хуулийн 14 дүгээр зүйлд зааснаар хэлэлцээд нэмэлт, өөрчлөлтийг ард нийтийн санал асуулгаар оруулах нь зүйтэй гэсэн томьёоллоор 3-ны 2-оос доошгүй саналаар тогтвол гэдэг үг байгаа шүү дээ. Бид тогтоогоогүй шууд ингээд алгасаад явчихсан. Дараа нь нүдний булай болов оо гэдэг дээр би хариулт авч чадсангүй.

Сая 24 дүгээр итрих 6, 2 гэж Улсын Их Хурлын дэгийн тухай хууль дээр Улсын Их Хурлын энэхүү чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 итрих 6, 2-оор зүйл, заалт бүрээр санал хураалт явуулна гэдэг заалт байхгүй байгаа. Би хайгаад олоогүй. Одоо энэ тэгээд дараа нь бид хүнд байдалд орох вий. Үүнийг хэн нэг нь асуух ёстой байх. Бүгдээрээ зүгээр л нэг ярихын төлөө, асуухын төлөө жүжиглэж үүнийг ингэж хамаг цагаа үрэхгүйгээр яг зүрх сэтгэлээрээ үүнийг би асууж байна. Энэ дээр би хариулт авсангүй.

Дараагийн ёсчилно гэдэг дээр яг хуулийн ямар тайлбар байдаг юм бэ? Би хариулт авсангүй.

Дэгийн тухай хууль дээр би хариулт авсангүй.

Ингээд би холбогдох газар нь энэ асуудлыг тавихаас өөр аргагүй байдалд орлоо.

Л.Мөнхбаатар: Сайнхүүгийн Ганбаатар гишүүний асуултад Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд хариулъя. 2 асуудал байна. Түүн дээр нь тодорхой хариулт өгчихье.

Н.Энхболд: Яг Ганбаатар гишүүний тавиад байгаа ард нийтийн санал асуулгын тухай хүсэлт бичиг манай Байнгын хороо дээр 2 дугаар хэлэлцүүлэг явахаас өмнө ирээгүй, 1 дүгээрт, тийм, 1 дүгээрт.

Тийм учраас 2 дугаар хэлэлцүүлэг дээр энэ асуудал хөндөгдөж яригдаагүй. Зүгээр би миний ойлгож байгаагаар ч гэж дээ ер нь хуульд заасан ерөөсөө ард нийтийн санал асуулгыг санаачлах 3 субъект л байгаа. Асуудлыг нь эхэлж тавих. Ерөнхийлөгч, Засгийн газар Улсын Их Хурлын гишүүдийн 3-ны 1 буюу 25 орчим гишүүн. Тэгээд сая та өөрөө хэлсэн бас үгэндээ. Би буруу сонсоогүй бол. Тийм санаачилга гаргах гэхээр энэ гишүүд олдохгүй байна гэж. Тэгэхээр нэгэнт жишээ нь гишүүдийн, Ерөнхийлөгч санаачлаагүй байна, ЗГ санаачлаагүй байна, гишүүдийн 3-ны 1 нь одоо

Л.Мөнхбаатар: 3-ны 2 шүү дарга аа.

Н.Энхболд: 3-ны 2 ард нийтийн санал асуулга явуулъя гэсэн санал гаргаагүй болохоор үүнийг хөндөж ярих ийм бололцоо хуулийн хувьд байхгүй байна л гэж харж байна. Ийм л хариу өгөх байна, Ганбаа гишүүн ээ.

Л.Мөнхбаатар: Ганбаатар гишүүн 8 минутад багтааж асуусан. Дээр нь нэмэлтээр 2 минутаас илүүг тодруулж асуулаа. Нийт асуулт асуух хугацаа бол 10 минутад багтана гэсэн зохицуулалттай учраас таны тодруулах хугацаа бол дууссан байна. Үг хэлж болно, дараа нь. Асуулт хариулт дууссаны дараа.

Дараагийн гишүүн асуултаа асууя. Содномын Чинзориг гишүүн асуултаа асууя.

С.Чинзориг: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулаад 2, 3 асуулт байгаа юм. Энэ 152 гишүүнтэй байна гэсэн ийм санал Их Хуралд орсон. Тэгээд Байнгын хорооны санал, дүгнэлтээр 126 болоод орж ирж байгаа юм байна. Тэгэхээр энэ 126 гэдэг тоог ямар судалгаан дээр үндэслээд, ямар үндэслэлээр 126 гэж тооцож байгаа юм. Ямар аргачлалаар энэ 126 гэж тоо бас гарч ирж байгаа юм. Үүнийг бас Байнгын хороо юу гэж үзэж энэ 126 гэдгийг гаргасан юм бэ гэсэн. Нэг бас асуулт байна.

2 дахь асуудал нь Үндсэн хуульдаа иргэд энэ төр төлөөлөх төлөөллөө шууд сонгоно гэсэн Үндсэн хууль заалттай. Тэгэхээр энэ 50 гишүүнийг хувь тэнцүүлэн хуваарилах сонгуулийн аргаар, 76 гишүүнийг олныг төлөөлөх сонгуулийн аргаар гээд. Тэгэхээр олныг төлөөлөх сонгуулийн арга гэдэг ямар арга гээд байгаа юм? Нөгөө бидний хуучин яриад хэвшсэн нөгөө мажоритар аргаа шууд сонгоно гэдгээ олныг төлөөлөх гээд байгаа юм уу? Би тэр Үндсэн хуульд байгаа үгийг нь аваад шууд 76 гишүүнийг шууд буюу олныг төлөөлөх сонгуулийн аргын үндсэн дээр сонгоно гээд уг нь томъёолбол илүү бас оновчтой болох болов уу гэж л бодоод байгаа юм. Шууд буюу олныг төлөөлөх гэсэн. Одоо бол олныг төлөөлөх гэх дээр чинь яаж сонгох гээд байгаа нь их тодорхой болчихоод байна шүү дээ. Нөгөө мажоритар хэлээд

байгаа юм уу, шууд сонгохоо хэлээд байгаа юм уу? Олныг төлөөлөх л гээд байна л даа. Тэгээд тэрийгээ бүр л тодорхой болгоод тэр Үндсэн хуулийнхаа үгийг аваад шууд буюу олныг төлөөлөх сонгуулийн аргын үндсэн дээр сонгоно гээд ингээд тодорхойлчихож болохгүй юм уу? Үүнийг та бүхэн бас Байнгын хороо дээр нэлээн ярьсан уу, үгүй юү гэдэг ийм 2 дахь асуулт.

Хөдөөгийн иргэдтэй уулзахаар иргэд ер нь бол намуудын боловсон хүчний бодлогуудыг яаж тодорхой болгох юм бэ? Тоглоомын дүрэм нь нэлээн их тодорхой байвал их сайн байна. Ер нь бид энэ тоондоо биш энэ чанартаа асуудал анхаарах хэрэгтэй юм биш үү? Төрийн төлөө гэсэн сонгогдсон ард түмнийхээ төлөө гэсэн сэтгэлтэй хүн байвал энэ нэг тоо ч нэг их чухал биш дээ гэдэг асуудал маш их яриад байгаа юм. Үүнийг бас Байнгын хороо дээр бас яригдсан уу, үгүй юү?

Энэ хувь тэнцүүлэн хуваарилах гэдэг энэ арга дээр яах вэ, нэг үеэ бодвол иргэд энэ хувь тэнцүүлэх буюу нөгөө бидний ярьж заншсан нөгөө пропорциональ аргыг сонгуулийн тогтолцоонд оруулахыг бас дэмждэг болчихсон юм шиг байдал ажиглагдаад байгаа юм. Хамгийн гол нь намууд ямар бодлогоор, ямар хүмүүсийг гаргаж ирэх вэ гэдгээ нэлээн тодорхой болгооч ээ л гэдэг юм их яриад байх юм. Яг намын жагсаалтын ард нуугдаад нөгөө нэр нүүр муутай болчихсон, иргэдийн итгэлийг даах чадваргүй гэдгээ харуулчихсан, харуулсан ийм хүмүүс чинь энэ намын жагсаалтын ард ороод ирэх юм биш үү? Бид чинь дээлийн өнгөө авахдаа дэлгүүрт ороод дээлийн өнгө авахдаа хүртэл нэг бүр нэг барьж үзэж байж, имэрч үзэж байж авдаг улсууд шүү дээ. Яах вэ тэр шууд сонгох нь яах вэ, тэгээд бидэнтэй ирээд л уулзаад санал авах л юм байна. Тэгээд намын жагсаалтад орсон улсууд чинь бид нартай яаж уулзах юм уу? Бид ер нь тэгээд хүн дугуйлах юм уу, нам

дугуйлаад тэгээд нөгөө намд өгсөн санал маань хүн болоод явчих юм уу гээд ийм их эргэлзээнүүд бол байгаа юм. Хамгийн гол нь тэр сонгуулийн хуулиараа тодорхой болгох юм уу эсвэл Улс төрийн намын тухай хуульдаа үүнийг нэлээн тодорхой болгож тэр намын боловсон хүчний бодлого, тэр нэр дэвшүүлэх зарчим эд нар бол нэлээн тод ил тод тодорхой болгох асуудлыг л нэлээн бид бас яримаар юм шиг байх юм. Тэгээд яг Үндсэн хуулийн энэ заалттай бол нэг их холбогдож ярихгүй ч байж магадгүй. Гэхдээ тэр Сонгуулийн хууль, Улс төрийн намуудын тухай хуульдаа энэ боловсон хүчний бодлого тоглоомын дүрэм нь ил тод байх, тэр нэр дэвшүүлэлт нь ил тод байх гээд 2 дахь асуудал нь.

3 дахь асуудал нь нөгөө Сонгуулийн хууль дээр Нямаа Энхболд гишүүний өргөн барьсан хуулиараа намын жагсаалтад байгаа хүнийг нэр дугуйлна гээд бас ороод ирчихсэн юм байна лээ. Ороод ирчихсэн байгаа. Тэгээд яг тэр техникийн боломж чинь байгаа юм уу, үгүй юм уу гэдгийг л хөдөөгийн иргэд нэг их асуугаад байгаа юм. Тэгээд бид нар энэ 37 нам байна. 37 нам бүгдээрээ нэр дэвшүүллээ гэхэд энэ чинь тэгээд 50 хүнтэй гэдэг чинь бараг 1800 гаруй хүний нэр жагсах нь байна шүү дээ. Тэгээд үүнийг чинь тэгээд тэр яг та бүхний оруулсан Сонгуулийн хуулиар намын жагсаалт ч гэсэн тэр 50 хүний жагсаал, нэг нам 50 хүн жагсаана, 37 нам гэхэд энэ чинь бараг л ингээд 1800 гаруй санал болоод явна. Тэгээд үүнийг чинь тэгээд энэ үед иргэд уншиж гүйцэх үү, үгүй юү? Тийм техникийн нөхцөл байгаа юм уу, үгүй юм уу. Та нар намын жагсаалтын ард хүн дугуйлах боломжтой болж байгаа гэж яриад байгаа юм. Тэгээд сүүлдээ энэ чинь явж явж байгаад нөгөө техникийн боломж байхгүй гээд бас одоо өөрчлөгдөөд явчихгүй биш биз дээ гэсэн ийм их болгоомжлолууд их байгаад байгаа юм.

Нөгөө талдаа хөдөөгийн иргэдтэй ярьж байхад бас энэ пропорциональ

тогтолцоог оруулж байгаа бол намуудын үүрэг хариуцлага нэлээн бас өндөрсгөх хэрэгтэй. Босгыг 3-5 хувь байлгах хэрэгтэй. Тэрнээс 3-аас доош тийм босго тавих юм бол бас энэ их зохимжгүй, боломжгүй, зохимжгүй эд нар гэсэн зүйл гэж яриад байгаа юм. Үүнийг цаашидаа бид нар тэр Сонгуулийн хууль, Улс төрийн намуудынхаа хуулиуд дээр бол ярих болов уу гэсэн ийм бас саналууд нэлээн их гараад байгаа юм.

Тэгэхээр би түрүүний яриад байгаа тэр 2 асуудалдаа хариулт авъя. 1 дүгээрт тэр энэ 126 хүн гэдгийг та бүхэн ямар судалгаа, шинжлэх ухааны нотлогдсон тоо суурь судалгаан дээр үндэслээд гаргаад ирэв, ямар арга, аргачлал тооцоод ингээд 126 гээд гаргав. 152-ыг гарахаар нөгөө язгуурын арга 152 гэж хэлээд байгаа юм гээд байсан. Одоо 126 болчихоор нөгөө язгуурын арга нь өөрчлөгдөөд өөр арга руу орчихсон уу, үгүй юү гэсэн ийм асуултууд байна.

Тэр 2 дугаарт, тэр би хэлээд байгаа тэр ер нь энэ олныг төлөөлөх гэдгээ бүр тодорхой болгоод Үндсэн хуульдаа ч гэсэн шууд сонгоно гээд байгаа юм. Тэр шууд буюу олныг төлөөлөх гэдгээ бүр тодорхой болгоод ингээд томилж болохгүй юм уу? Олныг төлөөлөх гэхээр чинь олныг төлөөлнө өө гэдэг чинь ингээд шууд сонгох гээд байгаа юм уу, яаж сонгох гээд байгаа юм бэ гэдэг нь тодорхойгүй бүрхэг юм шиг санагдаад байх юм.

Тийм учраас би тэр Үндсэн хуульд байгаа үгийг нь аваад шууд буюу олныг төлөөлөх аргаар сонгоно гээд. Ингээд тодорхойлж, томъёолж болохгүй юу? Та бүхэн ажлын хэсэг дээрээ, Байнгын хороон дээр бас энэ талаар нэлээн бас ярилцсан уу үгүй юү гэсэн ийм асуултууд байгаа.

Л.Мөнхбаатар: Содномын Чинзориг гишүүний асуултад Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга

Нямаагийн Энхболд хариулъя. Ажлын хэсэг нэмж хариулж болно шүү.

Н.Энхболд: Баярлалаа. Түүхээ санах хэрэгтэй. Хэлэлцэж эхэлсэн. Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуулийн төсөл дээр бид нар ажиллаж байгаа Улсын Их Хурал, Төрийн байгуулалтын байнгын хороо, ажлын хэсэг. Засгийн газраас 152 гишүүн гэж оруулж ирэхдээ энэ нэлээн сайн судалгаа, тэгээд нөгөө куб аргачлал энэ тэр гээд олон юм тал талаас нь хийж байгаад өнөөдөр Монголын нөхцөлд хамгийн тохиромжтой байгаа тоо нь энэ байна гэдэг ийм юм оруулж ирсэн. Бид нар тэгж ойлгож байгаа.

Хэлэлцүүлгийн явцад бол энэ тоо бас нааш цаашаа болж байна. Ялангуяа иргэдтэй уулзаад ирсний дараа ирж байгаа саналууд зөвхөн уулзалт биш бичгээр 11-11-ээр, захидлаар, олон саналууд ирж байгаа. Үүний гол санаа бол холимгийг ойлгож байна, дэмжиж болно. 152 бол хэтэрхий их байна гээд нөгөө шинжлэх ухааны аргаар бодож ирсэн тоог маань олон нийт, иргэдийн зүгээс, сонгогчдын зүгээс тийм таатай хүлээж авахгүй байгаа, энэ нь судалгаагаар харагдаж байгаа.

Ингээд Улсын Их Хурал дээр ярьсан. Гишүүдийн дунд ч ярьсан. Их Хуралд суудалтай намуудын хүрээнд ярьсан. Тэгээд бид нар бүлэг дээрээ ярьсан шүү дээ. Хариултынхаа талыг нь та өөрөө мэдэж байгаа. Энэ хэмжээнд байя, 76-гаа, тойргоо бол ямар ч тохиолдолд бууруулж болохгүй. Энэ төлөөлөл, газар нутгийн иргэдийн төлөөлөл байх ёстой. Эндээсээ үүдээд 152 биш юм бол хэд байх вэ гээд ер нь уулзалтууд дээр, бусад газрууд дээр гарч байсан саналуудыг ингэж дундажлаад харахад 120 хавьцаа, 120 хавьцаа л тоонууд гарч байгаа. Ингээд зөвшилцөж явсан. Энэ үндсэн дээр 126 гэдэг тоо гарч ирсэн. Энэ бид нар бүгдээрээ оролцсон, ганц ажлын хэсэг ч хийгээгүй, бүлгүүд дээрээ ярьсан, намын удирдлагуудынхаа түвшинд ярьсан. Мааш

нарийн яг ийм аргачлалаар тийм, судалгааны хувьд бол саяын миний хэлснийг хэлж болно. Аргачлал гэвэл энэ дээр 152-ыг тооцсон шиг тийм нарийн олон аргачлалаар тал талаас нь тооцож үзээгүй гэдгийг бол ил тод хэлэх ёстой гэж бодож байна.

Шууд гэдэг үгний талаар та ярилаа. Яах вэ, Үндсэн хуульд тийм үг байгаа. Энэ шууд гэдэг үгийг та бас их олон жил маргаан явсан. Цэц дээр хэд хэдэн удаа наашаа цаашаа тайлбарласан, шийдвэр гарч байгаад. Одоо нэгдсэн ойлголт бол шууд гэдгээр бол зөвхөн тойргоос сонгогдож байгаа хүнийг сонгох тухай ойлголт бол хаана ч яригдаагүй. Иргэн өөрөө биеэ даагаад өөрөө шууд саналаа өгөх жагсаалтад байна уу, хүний нэрд байна уу, өгөх энэ ойлголтыг ерөнхийд нь шууд гэж ойлгосон байгаа.

Одоо тэгэхээр энэ дотор нь Засгийн газраас орж ирсэн пропорциональ, мажоритар хоёроо 1-ийг нь шууд гээд, нөгөөдхийг нь шууд бус гэнэ гэдэг бол их ойлгомжгүй байдал үүсгэнэ. Шууд гээд нэрлэхээр тэр нь өөрөө Үндсэн хуульд таарч байгаа юм шиг. Нөгөөдөх нь шууд бус болохоор Үндсэн хуульд нийцэхгүй байгаа юм шиг ийм ойлголт гарч ирэх нь ойлгомжтой. Эрх зүйн зохицуулалт талаасаа. Тэгэхээр бид нар тэр шууд гэдэг үгийг тойргоос сонгогдох нэр дэвшигчдийн хувьд хэрэглээгүй. Ерөнхийдөө шууд гэдэг Үндсэн хуулийнхаа том ойлголтын дотор пропорциональ нь ч байж болно, мажоритар ч болно гэж ингэж нэгдсэн ойлголттой байгаа учраас энэ асуудал өнөөдөр яригдаад Байнгын хороо дээр яригдаад, дундуур нь завсарлага авч дахиж яригдаж байгаад тэр олныг төлөөлөх гэсэн үг орж ирсэн. Олныг төлөөлөх гэдэг үгийн талаар түрүүн та бас ажилтай гараад сонсоогүй бололтой. Би нэлээн дэлгэрэнгүй тайлбар өгсөн. Улсын Их Хурлын дарга дээрээс нь их дэлгэрэнгүй тайлбар өгөөд үүнийг албан ёсоор Их Хурлын протоколд оруулах

тухай чиглэл өгсөн. Энэ нь өөрөө эргээд юунд хэрэгтэй юм бэ гэхээр дараа нь энэ чинь юу гэсэн үг вэ, ямар учир, ямар ойлголт үүний цаана байдаг вэ гэдгийг хэзээ нэгэн цагт асуудал үүсвэл тайлбарлахад нотолгоо нь болох гэж хэлэх юм уу даа ийм тайлбар зүйлүүдээ бол бид нар түрүүн нэлээн дэлгэрэнгүй ярьчихсан. Чинзориг сайд аа.

Тэгээд ер нь бид нарын Засгийн газраас оруулж байсан мажоритар, пропорциональ гэдэг үгээрээ явчихъя гэхээр аль болохоор Үндсэн хуульдаа гадаад хэлний үг олныг оруулмааргүй байна гэдэг нэг санаа.

Нөгөө талаар ер нь мажоритар гэдэг бол бас дараа нь яг энэ үгээр ингээд Үндсэн хуульд орчихвол мажоритар гэдэг энэ гадаадаар хэрэглэж байгаа үг маань өөрөө дотроо их олон янзын ойлголттой, олон утгатай гээд энэ талаар түрүүн бас их дэлгэрэнгүй ярьсан. Тэгэхээр би давтахаа болиод, тэр мажоритар гэдэг үг дотроо багтаж байгаа олон хувилбарын нэг болох манайд хэрэглэгдэж байгаа тухайн тойргоосоо хамгийн олон санал авсан нэр дэвшигч сонгогддог энэ аргыг бид нар олныг төлөөлөх гэдэг ийм Монгол үгээр нэрлэе гэж тал талаас нь ярьж байгаад шийдсэн. Хэлний зөвлөлийнхөнтэй ч бас энэ талаар тодорхой хэмжээгээр санал солилцсон байна лээ, манай гишүүд. Тэгээд энэ үг бидний ойлгож ирсэн мажоритар түүн дотроо тухайн тойрог дээрээ эс үгүй бол тухайн сонгуулийн хэсгээс хамгийн олон санал авсан хүнийг сонгох энэ аргаа хэрэглэж байгаа, энэ аргаа нэрлэж байгаа ийм томъёолол гэж ойлгож явъя. Үүнийгээ Үндсэн хуульд оруулъя. Ингээд цаашидаа нэг ойлголттой болоод хэрэглээнд оруулаад явъя гэсэн ийм нэгдсэн байр суурьтайгаар бид нар оруулж ирж байгаа юм.

Үндсэн хууль дотор энэ олонхын тухай, тэгээд янз бүрийн ойлголтыг 4-ний 3-аар, 3-ны 2-оор, энгийн олонхоор,

хуралдаанд оролцсон гишүүдийн олонхоор жишээ нь хуралдаанд оролцсон гишүүдийн олонх гэхэд бол тэр Улсын Их Хурлын гишүүдийн олонх зарим тохиолдолд болохгүй байгаа байхгүй юу. Тэгээд ийм тэр бүх юмнууд бүгдээрээ тэр мажоритар гэдэг ерөнхий тийм ойлголтын доор яваад байгаа юм. Тэгээд энэ дотроосоо салгаад яг хэрэглэж байгаа, сонгуульд хэрэглэж байгаа, санал тоолж, хүнийг сонгосонд тооцож байгаа аргаа бид нар олныг төлөөлөх гэдэг үгээр явъя гэж л тохироод оруулж ирсэн. Одоохондоо чихэнд бас дасаагүй болохоор, урьд нь хэрэглэж байгаагүй болохоор содон сонсогдож байгаа байх. Ер нь цаана нь ийм санаа байгаа шүү гэдгийг би давхар хэлье.

Нэг зүйл дээр бол Чинзориг гишүүнтэй санал нэг байна. Би түрүүн ч бас хэлсэн. Бид нар өнөөдөр ганцхан Үндсэн хуулийн энэ өөрчлөлтийн асуудлыг яриад байгаа биш яг таны саяын хэлсэн шиг манай сонгогчдын ярьж хэлж, санаа зовж байгаа шиг энэ намын тухай хууль, Улс төрийн намын тухай хууль, тэдгээрийн санхүүжилтийн тухай хууль, Сонгуулийн хууль энэ юмнууд иж бүрнээрээ, багцаараа тэгээд хоорондоо их уялдаа холбоотой батлагдаж байж, бид нарын хүсээд яриад байгаа гишүүдийн тоо нэмчихвэл түүнээс гарах үр дүн тэнд харагдана. Гишүүдээ хэсгийн тойргоос хэсгийн жагсаалтаар сонгох гэж санал болгож байгаа энэ асуудал маань батлагдвал тэндээс гарч ирэх үр дүн нь бас энэ намын хууль, сонгуулийн хууль, энэ бүх юмтай хоорондоо уялдаж байж сайн үр дүн гарна гэсэн ийм л итгэл үнэмшилтэйгээр Улсын Их Хурал энэ хуулиудыг ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Нямаагийн Энхболд дарга гүйцээж хариулъя. 2 минутад багтааж гүйцээж хариулъя.

Н.Энхболд: Ийм итгэл үнэмшилтэйгээр заримыг нь Улсын Их Хурал санаачилж, заримыг нь Монгол

Улсын Ерөнхийлөгч санаачлаад ингээд энэ хаврын чуулганы хугацаанд энэ хуулиудаа бүгдийг нь цогцоор нь, багцаар нь, тэгээд хоорондоо уялдаа холбоотой гаргах нь өөрөө бид нарын Үндсэн хуулийн хуульд оруулах гэж байгаа өөрчлөлт, үр дүнгээ авчрах гол суурь нь энэ бүгдийг нь хамтад нь уялдаа холбоотой батлах асуудал байгаа юм гэсэн хариулт өгье. Энэ дээр тантай санал нэг байна.

Л.Мөнхбаатар: Содномын Чинзориг гишүүн тодруулж асууя. Тодруулж асуух асуух хугацаа 2 минут байгаа.

С.Чинзориг: Тэгэхээр яах вэ, бид энэ гишүүдийн тоог нэмэгдүүлэх асуудлыг тайлбарлахдаа төлөөллийн чадамж нэмэгдэнэ гэж л бас яриад байгаа юм л даа. Энэ ажлын хэсгүүд дээр. Би бас нэг их тэр нь тэгж ярих нь бас буруу ч юм уу гэж бодоод байх юм. Тэгээд одоо энэ олныг төлөөлөх аргаар сонгоод ирэхээр чинь нөгөө талдаа тэр иргэдийн төлөөлөх чадамж нэмэгдэж байгаа чадамж маань сонгогдох төлөөлөх тэр хувь процент чинь их буучихна шүү дээ. Олныг төлөөлөх гэдэг чинь тэгээд хэдэн хувийг хэлэх юм? Олон хүн өрсөлдөөд нийт сонгогчдын 10 хувь авсан хүн бол тэгээд л олныг төлөөлсөн, олныг нь төлөөлсөн гээд гишүүн болон болох асуудал гараад ирнэ шүү дээ. Тэгэхээр наадах чинь нөгөө төлөөллийн нэмэгдэж байгаа чадамж маань иргэдийнхээ нөгөө саналыг авч байгаа тэр төлөөлөл чинь нөгөө талаасаа их л сулрах л юм руу явчих болов уу гэж би бодох юм. Одоо бол олныг төлөөлнө гээд ингээд оруулчихаар нийт тойрог дээр нэр дэвшигчдээ сонгож байгаа, иргэд нэр дэвшигчдээс тэдэн хувиас доошгүй санал авсан бол Их Хурлын гишүүнээр сонгогдоно гэсэн тийм босго эд нар бол байхгүй болно л гэсэн үг байна шүү дээ.

Тэгэхээр наадах чинь 10 хувийн, олон хүн өрсөлдсөн бол 10 хувийн санал авсан ч хүн олныг төлөөлсөн гээд гишүүн болох, 15 хувийн санал авсан хүн ч гэсэн

олныг төлөөлнө гээд. Нөгөө талдаа бид нар гишүүдийн тоог нэмэгдэж байгаа чинь иргэдийн төлөөллийг нэмэгдүүлж байна гэж, төлөөллийг чадамжийг нэмэгдүүлж байна гэдэг атлаа нөгөө төлөөлөх мандат маань нэлээн тийм суларчих юм руу болоод явчих юм биш биз дээ, сөрөг тал нь нөгөө талдаа. Олныг төлөөлнө гэхээр чинь наадах чинь үндсэндээ босгоо тавихгүй л гэсэн үг рүү явлаа шүү дээ. Тэгэхээр тэгээд 10 хувийн санал авсан хүн бол, 15 хувийн санал авсан бол олныг төлөөлсөн гээд ингээд. Хэдийгээр төлөөллийн тоо нэмэгдэж байгаа ч гэсэн төлөөлөх нөгөө чадамж маань нэлээн суларчих тийм юм руу явчих юм биш биз дээ. Би бол нөгөө талдаа тийм бас сөрөг юм гарах юм байна даа гэж л бодоод байгаа юм.

Л.Мөнхбаатар: Тодруулгад Нямаагийн Энхболд дарга хариулъя.

Н.Энхболд: Төлөөлөх чадамж гэж бид нар нэг гишүүний ард хэдэн сонгогч байна вэ гэдгээр нь дүгнэж ярьж байгаа. 92 онд Үндсэн хууль батлагдахад 1 гишүүний ард 23 орчим мянган гишүүн байсан бол одоо тэр нь 2 дахин нэмэгдээд 45 болчихож байгаа нь өөрөө сонгогдсон гишүүний иргэн төлөөлөх чадамжийг 2 дахин бууруулчихсан байна гэж үзэж энэ утгаараа ойлгож байгаа.

Гишүүнээ сонгохдоо таны санаа зовоод байгаа гээд байгаа энэ аргыг хэрэглээд л сонгож байгаа шүү дээ. Одоо өнөөдөр ч гэсэн бид нар. Тэр аргаа л олныг төлөөлөх гэдэг үгээр илэрхийлж байгаа юм. Түүнээс биш тэр энэ үгийг хэрэглэлээ гээд бид нарын одоо гишүүн сонгож байгаа арга маань өөрчлөгдөхгүй, өөрчлөгдөхгүй. Бид нар бүгдээрээ яг тийм аргаар сонгогдсон. Тухайн тойргийн гишүүний 50 дээр нэмэх нь 1 биш тэр тойргоос тойрогт нэр дэвшсэн хүмүүс хэн нь сонгогчдоос хамгийн олон санал авсан байна, тэр нь сонгогдож байгаа. Энэ одоо хэрэглэж байгаа аргаа л ингэж нэрлэе гэж тогтоож байгаа юм.

Дээр нь тэгээд олонхыг гэдэг үгээ хэрэглэх гэхээр 50 дээр нэмэх нь 1 гэдэг ерөнхий ойлголт явчих гээд байна. Энэ маань өөрөө дараа нь Үндсэн хуульд сууцхсан хойно буруу зөрүү ойлголт өгөөд, буруу тайлбарлаад бас янз бүрийн асуудал гарна шүү гэдэг болгоомжлолын үүднээс бид нар зориуд тэр мажоритар гэдэг ерөнхий малгайн доор явдаг олон аргуудаас өнөөдөр хэрэглэж байгаа аргаа хамгийн оновчтой болгож хэрэглэж байгаа л ийм нэр томъёо гэж ойлгож болно.

Сонгуулийн хуулиа гаргахдаа бол бид нарт бас аргууд байна. Аравхан хувиар сонгогдох энэ тэр боломжийг бас хааж болно. Хамгийн олон санал авсан, гэхдээ нийт сонгогчдын тэдээс доошгүй хувийн санал авсан сонгогдсонд тооцно гэж ийм заалт оруулж болно. Үүнийг бол бид нар сонгуулийн хуулиараа ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Цэндийн Сандаг-Очир гишүүн асуултаа асууя.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. 152-оо 126 болгож байгаа юм байна. Ирэх 7 хоногт ахиад тойрогтоо ажиллана. Ард иргэд 126-г хүлээн зөвшөөрөхгүй бол яах вэ, ахиад багасга гээд байвал яах вэ? Гишүүд ирээд 126-г хүлээж авахгүй байна гэвэл улс төрийн намууд ахиад зөвшилцөх үү, ахиад тоогоо бууруулъя гэж. Энэ дээр ямар бодолтой байна. 126 боллоо гэхэд Улсын Их Хурлын шийдвэр гаргах чадамж сайжирна гэж яриад байгаа юм. Яг яаж сайжрах юм, яаж дээшлэх юм? Парламентын өөрийнх нь чадамж яаж бэхжих юм, сайжрах юм. Энэ гарч байгаа хуулийн чанар яаж сайжрах юм, яаж алдаа мадаггүй, цоорхойгүй хууль батлах юм, энэ нь яаж дээшлэх юм, үүнийг яг яаж дээшлэх юм. Ерөнхий л сайжирна гэж яриад байгаа болохоос биш яг ингэж сайжрах юм гэж ярьж байгаа хүн ерөөсөө сонсогдохгүй байна л даа. Яг ингэж сайжрах юм. 152, 126 болсноор.

Гишүүдийн ёс зүй яаж сайжрах юм? 126 болсноор. Гишүүдийн үүрэг хариуцлага яаж сайжрах юм, яг ингээж сайжрах юм гэж хэлж чадахаар байна уу? Ямар тайлбар өгөхөөр байна? Энэ дээр та бүхэн нэг хариулт өгөөч.

Түүнээс ерөнхий байдлаар л төлөөлөх чадвар нь сайжирна л гэж байна. Чадамж нь сайжирна л гэж байна. Ингээд ерөнхий яриад байгаа болохоос биш яг ингээж ингээж сайжрах юм гээд яриад. Үнэхээр ингээж сайжрах юм гэвэл 2 гараа өргөөд ч дэмжихэд бэлэн л байна л даа, ард иргэд. Тийм яг бодитой ийм тайлбар байхгүй болохоос эргэлзээд байна шүү дээ. 76 чинь одоо хариуцлагагүй байгаа учраас ахиад 76-г нэмж, хариуцлагагүй хүнийг нэммээргүй байна л гээд байгаа байхгүй юу. Тиймээс ингээж, ингээж сайжрах юм гээд яривал бас ард түмэн чинь ойлгоно шүү дээ.

Тэгээд зарим нэг ажлын хэсгийн гишүүд 126, 152 болсноор хулгай ингээж арилах юм гэж яриад байгаа юм. Энэ хулгайны чинь асуудал тоондоо байгаа юм уу? Тэгээд 152, 126 болчихоор хулгай гарахгүй байна гэж хэн хэлээд байгаа юм? Үүнийг тайлбарлаж өгөөч. Хулгай буурах юм, авлига буурах юм гэж. Авлига, хулгай чинь тоондоо байгаа гэж би ойлгохгүй байна. Үнэхээр хариуцлагагүй гэдэг юм уу, ёс зүйгүй гэдэг юм уу, хувийн ашиг сонирхлыг бодсон нөхдийг нэр дэвшүүлдэг, тэр нь сонгогдож гарч ирдэг байвал тэр 76 ч байсан, 152 ч байсан хулгайгаа хийгээд л явна шүү дээ. Тэгээд би бол энэ хулгай луйвар багасна гэдгийг бас сайн ойлгохгүй л байна. Үүнийг бас тайлбарлаж өгөөч? Тухайлбал Доржханд гишүүнийг бас хулгай луйвар багасах юм гэж ингээж ярьж байсан. Яаж багасах юм. Энэ дээр тодорхой хариулт өгөөч. Ингээж ингээж багасах юм гээд. Хамаа алга. Тэгвэл ингээд үнэхээр тэгээд өнөөдөр үнэхээр гоё өөрчлөлт хийхийн тулд ярьж байж болно. Ингээд өөрчиллөө гэхэд магадгүй үүний чинь дараа, жилийн дараа, нэг жилийн дараа бид нар энэ үр

дүнг нь хараад сууж байна. Цаг хугацааны л асуудал. Нөгөө өнөөдрийн гоё ярьж байсан тайлбарууд амьдрал дээр үнэхээр бодит утгаараа хэрэгжиж чадаж байна уу, үгүй юү гэдгийг бид нар цаг хугацааны л асуудлаар хэмжигдэж шүүгдэж гаргаж ирнэ шүү дээ. Үнэхээр хулгай, луйвар буурах нь уу, үнэхээр гишүүдийн хариуцлага сайжирсан уу гээд л. Жилийн дараа л энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн чинь үр дүн амьдрал дээр харагдаад л эхэлнэ дээ. Тэр үед нь бас өнөөдөр энэ ярьж байгаа улсууд юу гэж тайлбарлах юм бол, ийм тайлбар авъя.

Л.Мөнхбаатар: Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн гишүүн Тогмидын Доржханд асуултад хариулъя.

Т.Доржханд: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Улсын Их Хурлын гишүүдийн тоо өссөнөөр авлига, хулгай буурах уу асууж байна. Буурна, буурна. Яаж буурах юм бэ, яг юу болоод байгаа юм бэ гээд. Яагаад авлигатай, хулгайтай болчихсон юм бэ гэдгээ бүгдээрээ нэг дүгнээд үзчихье. Сүүлийн 2 жилийн хугацаанд Хөгжлийн банкны хулгай гарлаа, 2 их наяд байхгүй. 40 их наядынхаа орлогыг хилийн гадаа алдчихсан, нүүрсний хулгай. Цаашаа маш олон асуудлууд байгааг та ч мэдэж байгаа, би ч мэдэж байгаа. Хаанаас юу, яаж үүдэлтэй, хэн хийгээд байгаа юм, хэн бэ гээд. Хөгжлийн банк бол 100 хувь төрийн өмчийн компани юм. 16 он хүртэл яг ЖДҮ сан шиг байсан юм. Банкны лицензээ ч аваагүй байсан юм. Дарга шийддэг байсан юм. 100 хувь төрийн өмчийн компани.

2 дугаарт нь, Эрдэнэс Тавантолгой компани байна. 19 их наяд төгрөгийн оффтек гэрээ нууцаар байгуулчихсан, та ч мэдэж байгаа, би ч мэдэж байгаа. Тэгэхдээ 5 сарын өмнө та ч мэдэхгүй байсан, би ч мэдэхгүй байсан, хэн ч мэдэхгүй байсан, 19 их наяд. Өнөөдөр парламент өнөөдөр шинээр 2023 онд 1,3 их наяд төгрөгийн хөрөнгө

оруулалт хийнэ гэж явж байхад тэнд зөвхөн 1 компанийн шийдвэрээр 19 их наядын хөрөнгө оруулалтын шийдвэр явж байгаа шүү дээ. Та парламентын гишүүн, би парламентын гишүүн. Гэтэл парламентын төсвийг чинь шийдэх ёстой шүү дээ, бид шийдэж чадахгүй байна шүү дээ. Энэ хаана тохиолдож байсан юм. Энэ Африкт тохиолдож байсан юм. Латин Америкийн орнуудад тохиолдож байсан юм. Яагаад тохиолдож байсан юм, яагаад вэ гэхээр хяналтаа тавьж чадахгүй байсан юм. Хэн хяналт тавих ёстой юм. Засгийн газар өөртөө хяналт тавих юм уу эсвэл иргэдийг төлөөлсөн институц буюу парламент нь хяналтаа тавих ёстой байсан юм уу? Өөрөөр хэлэх юм бол парламент нь хяналтаа тавьж чадаагүй юм.

76 гэдэг тоо чинь өөрөө цөөхөн байгаа, цөөхөн болохоор хуйвалдаад байгаа юм, хулгай үүсэж байгаа юм. Үүнийг манай энэ ажлын хэсэгт орсон бас судлаач нар хэлнэ. Тооны хүмүүс бол хэлнэ. Хуйвалдааны онолоор тухайн шийдвэр гарч байгаа олонлог 120-оос доошоо байх юм бол хуйвалдаан үүсдэг. Хулгай гарсан байна, гардаг юм байна. Олон улсын парламентын түүхүүд бас ийм байгаа. Хэрвээ тухайн шийдвэр гаргагч нь 120-оос доошоо байх юм бол авлига, хулгай нүүрлээд байдаг, 800-аас дээшээ гарах юм бол тэнд шийдвэр гарч чаддаггүй, хар бараан зах болчихдог. Маш энгийн жишээ Энэтхэг байгаа. Хүмүүс ингээд Доржханд гишүүн ээ, Монгол Улс ердөө 3.4-хөн сая хүн амтай. Гэтэл Хятадыг хар, Энэтхэгийг хар. Эд нартай харьцуулах юм бол Монгол чинь тав, аравхан л гишүүнтэй байх ёстой шүү дээ. Харин ч буулга гэдэг юм ярьдаг. Гэтэл Хятад бол парламентын засаглалтай орон биш ээ. Энэтхэг бол мөн, 1,3 тэрбум хүн амтай. Гэтэл Энэтхэг нийт парламентын гишүүд нь 788 байгаа юм. Яг ингээд хуулиа баталдаг нь 545 гишүүнтэй байгаа юм. Гэтэл яг энэ тооныхоо харьцаагаар аваад үзэх юм бол 15-20 мянган хүн тэнд уг нь шийдвэр

гаргах болчихоод байна шүү дээ. Стадион дүүрэн хүн шийдвэр гаргаж чадах уу? Болдоггүй байхгүй юу. Тэгэхээр тоо чинь өөрөө учиртай юм, үндэслэлтэй юм. Тэгэхээр 800-аас дээшээ бол шийдвэр гардаггүй юм байна гээд дэлхийн парламентууд 800-аас дээшээ байхгүй, парламентын засаглалтай улсууд. Харин 120-оос доошоо байж байж авлига, хулгай үүссэн байна гэж дэлхийн түүхүүд байна. Энэ судлаачид бас тогтоочоод байна.

Гэтэл манайх 76 гэдэг тоо гаргаж ирсэн, 92 онд. Яаж гаргаж ирсэн юм, судлаачид гаргаж ирсэн юм уу эсвэл олонхоороо шийдээд явчихсан юм уу гэдгийг архивыг нь ухааж үзлээ. Гэтэл тухайн үеийн Улсын Бага Хурлын гишүүд 51-үүлээ байсан. Тэд нараас гаргаж ирсэн ажлын хэсэг Чимэд гуай ахалж байсан. Тэгээд Санжийн Баяр гэдэг хүн тэр ажлын хэсэг дээр байсан, би биечилж бас уулзсан. Яг юу болсон юм бэ гэдгийг асуусан. Тэгэхэд 120 гэдэг тоо гаргаж ирсэн юм гэж анх. Дараа нь явсаар байгаад нөгөөдөх нь 100 руу орж ирсэн байна. Тэгсэн нөгөө хууль тогтоогч нар чинь маань орж ирээд ерөөсөө 51-ээс дээшээ болгож болохгүй, эдийн засгийн нөхцөл байдал маань муу байна гээд. Тэгээд дундажлаад 76 дээр тохирсон юм гээд. Ерөөсөө л дундажлачихдаг.

Өнөөдөр олон хүмүүс ярьж байна. 108 гэдэг тоо бурхны тоо ярьж байна. 99 гоё тоо гээд л гоё, гоё тоонууд яриад л байх шиг байна. Үгүй юм. Одоо судалгаан дээр шинжлэх ухаан дээрээ үндэслээд шийдвэрээ гаргах хэрэгтэй. Хулгайтай байх юм уу, авлигатай байх юм уу, аль эсвэл гоё тоогоо хөөгөөд ингээд явдаг байх юм уу гээд. Тийм болохоор уг нь ХҮН намын байр суурь 152 байсан. Зөвшилцлийн үр дүнд, 126 болж байгаа. 126-аас доошоо буух юм бол авлига, хулгай чинь хэвээрээ байна, хяналт тавьж чадахгүй ээ.

Би танд тов тодорхой бас нэг баримт хэлье. Өнөөдөр Хөгжлийн банкны хулгай яаж гарсан юм бэ? Иргэд мэдэхгүй байсан, 10 жил баахан шалгалт хийсэн, үүнийг би хамгийн анх өөрөө бланк дээрээ санаачлаад явсан гишүүний хувьд процессыг нь сайн мэдэж байгаа юм. Яагаад вэ гээд тэгэхээр энд хулгай байсан гээд. Тэгээд анх удаагаа парламентын түүхэнд бид нар нотлох баримтын шалгалт, хяналтын сонсгол хийсэн. Гурван 7 хоног явсан. Иргэдэд мэдээллийг нь өгсөн. Өнөөдөр Монгол Улсын түүхэнд анх удаагаа Ерөнхий сайд байсан эрх мэдэлтнүүдээсээ авхуулаад 80 хүн нээлттэйгээр шүүх дээр байцаагдаж байна, асуудал нь явж байна. Хэзээ ийм түүх байсан юм, Монголд. Байгаагүй биз дээ.

Өнөөдөр мөн эзэн холбогдогчтой нүүрсний хэрэг хуулийн байгууллагад явж байна. Хэзээ ийм байсан юм. Цаашаа яагаад ийм болчихсон юм гэхээр бид нар хяналтаа тавиад эхлээд явж байгаа байхгүй юу. Гэтэл 3 дахь хяналтын хороо руугаа орохоор боллоо. Гэтэл Доржханд гишүүний тоо боломжгүй юм байна. 2 л түр хороонд орох боломжтой юм байна. Хянан шалгах. 3 дахь боломжгүй. Яагаад вэ? Парламентын гишүүдийн тоо чинь цөөхөн байна, үр дүнд нь цөөнх чинь цөөхөн байна. Өнөөдрийн тогтолцоогоор нэг нам дийлэнхийг авч яваад байна. Парламентын хяналтыг хэн тавьдаг юм, дотроо цөөнх шүү дээ. Үгүй ээ, тэгээд давжаа парламент дотор бүр жижигхэн ийм цөөнхтэй тэгээд Улсын Их Хурлын гишүүн нь хоёрхон Түр хороонд орж байна шүү дээ. Яагаад юм, гишүүдийн тоо чинь цөөхөн байна шүү дээ. Үгүй ээ, тэгвэл яаж бид нар хяналтаа дахиж тавих юм?

Одоо өнөөдөр яриад байгаа Боловсролын зээлийн сан дээр хяналт шалгалтын түр хороо ажиллуулмаар байгаа. 10 их наядын ковидын төсөв дээр тавимаар байгаа. Дээрээс нь өмнөх тэр нууцаар хийгдсэн янз янзын бондуудын эх үүсвэр, Төв банктэй холбоотой асуудлаар

тавилаар байгаа. Маш олон асуудлууд байна, байна. Гэтэл боломжгүй байна шүү дээ. Яагаад гэхээр хяналтаа тавьж чадахгүй байна шүү дээ. Парламентын үндсэн үүрэг юу юм бэ, 1 дүгээрт, хууль батална, 2 дугаарт төсвөө батална, 3 дугаарт хяналт шалгалтаа тавина. 1 дэхээ бол хийчхээд байна, ямар ч байсан, чанартай чанаргүй ч гэсэн. 2 дахиа бол яах вэ батлаад л байна. Жил болгон алдагдалтай төсөв батлаад л яваад байна. Өр үүсгээд л яваад байна. 3 дахь нь бол байхгүй байна. Байхгүй байгаа болохоор нэг байлгахын тулд өнөөдөр хяналт шалгалтаа тавьж байж, хулгайтайгаа тулж байж, цаашаагаа авлигагүй болох боломж нь парламент юм. Парламент гэдэг бол иргэдийн төлөөлөл болохоос биш парламент бол дарга нар биш юм. Парламентыг төрийн эрх барих дээд байгууллага гээд ойлголцсон болохоос биш төр гэдэг чинь парламент биш шүү дээ. Энэ чинь Засгийн газар шүү дээ. Засгийн газар дээр чинь бүх тэр эрх мэдлүүд нь байгаа шүү дээ. Хулгайч нь тэнд байгаа шүү дээ, яг үнэнээ хэлэхэд.

Үгүй ээ, тэгээд хэн нь энд хяналт тавих юм. Иргэд чадахгүй шүү дээ, бөөнөөрөө ингээд чадахгүй. Харин энэ дээр хяналт тавиарай гээд бид нарыг мандат өгөөд иргэдийн төлөөлөл болоод бид нар энд ирж байгаа шүү дээ. Чадахгүй байна шүү дээ, яагаад гэвэл тоо чинь цөөхөн байна. Үгүй ээ, тэгээд хуучнаараа явъя гэх юм бол энэ авлига, хулгай чинь хэвээрээ л байна шүү дээ. Хөгжил байхгүй.

Парламентын гишүүнээр 3 жил сонгогдоод явж байна. Хулгай л ярьдаг боллоо шүү дээ, хөгжил ярих ямар ч боломж байхгүй. Тэгээд үүнийгээ өөрчилж гээд тэгэхэд чинь үгүй ээ, өмнөх тогтолцоо маань гоё юм гэсэн байдлаар. Үгүй ээ, тэгвэл иргэдийнхээ амьдралыг хар л даа. Тэгээд ийм байдлаар бүгдээрээ ажил хэрэгч байдлаар судалгаан дээр сууриалаад явмаар байна. Тэгээд цаашаа

бол энэ өөрчлөлтөө хийвэл, зоригтой хийх хэрэгтэй.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд гишүүн хариулъя.

Н.Энхболд: 2 дахь хэлэлцүүлгийн дараа тойргоор яваад ирээд иргэдийн зүгээс дахиад янз бүрийн санал гарвал яах вэ гэж асууж байна. Дахиад ярьцаана. Мэдээж бид нар тэр саналыг харгалзах гэж л ингэж явж, судалгаа хийж, санал бодлыг нь сонсож байгаа учраас дахиад ярьж таарна. Ямархуу санал ирэх бол гэдгийг бол би хэлж мэдэхгүй байна. Тийм учраас бага байвал яах вэ, их байвал яах юм, дахиад багасгах юм уу гэдэг юман дээр бол би одоогоор хариулж мэдэхгүй нь. Энэ бол манай миний, эс үгүй бол манай Байнгын хорооны дангаараа хариулт өгөөд байхад нэг тийм зохимжтой хариулт олдохгүй болов уу гэж бодож байна.

Тэгэхдээ эхнээсээ жишээ нь өнөөдөр төрийн эрх барьж байгаа Ардын намын зүгээс энэ том шинэчлэлийг хийе, эхэлье гэж санаачилга гаргаад улс төрийн манлайлал бусад намуудтай хамтраад үзүүлээд явж байгаа энэ тохиолдолд явал системээ цаашдаа боловсронгуй болгох вэ гэдэг дээр илүү анхаарч, 3 дугаар хэлэлцүүлгийн 3 дугаар санал асуулгын дүнг тойрч ярихдаа үүнийгээ илүү анхаарч ажиллах болов уу гэж би зүгээр бодож байна, 1 дүгээрт.

2 дугаарт, хуулийн чанарын тухай асуудал ярьсан. Сая бараг хариулчихлаа даа. Зүгээр би нэг ийм жишээг, жишээ нь орон нутагт уулзаж байхдаа хүмүүст хэлээд явахаар бас ойлгоод, энэ тайлбар хүрээд байх шиг байгаа юм. Цөөхөн байгаа өнөөдөр 11 байнгын хороотой, ингээд дээд тал нь 19 гишүүнтэй, доод тал нь 10 гишүүнтэй Байнгын хороо байна шүү дээ, манайд. 1 гишүүн 2-3 Байнгын хороонд харьяалагдаж байна. Үнэхээр хуулийнхаа чанар дээр анхаарахад бол Их Хурлын гишүүний

ажил их амархан ажил гэж боддог юм шиг байгаа юм уг нь. Юм хийе, чанартай хууль гаргая, судалъя, үзье, харьцуулъя гэвэл бас тийм их хөдөлмөр шаардах ажил шүү дээ. Тэгээд энэ талаас нь бодоод үзвэл, жишээ нь 3 Байнгын хороонд харьяалагдаж байгаа гишүүн 2 өдрийн дотор тэр 3 Байнгын хороонд суугаад Байнгын хороо хуралддаг өдрүүдэд, тэгээд чанартай хууль гаргахад, хувь нэмрээ оруулахад нэлээн тийм амаргүй л ажил. Тэгээд энэ дээр ч гэсэн одоо тооны нэмэгдсэн чанарын асуудал харагдах болов уу гэж би бодож байгаа. 10 гишүүнтэй Байнгын хороо 6 цуглаж ирцээ бүрдүүлээд 4 нь шийдвэр гаргаад явах нь дээр үү? Жишээ нь Засгийн газраас орж ирсэн хувилбар явсан байлаа гэж бодоход 20 гишүүнтэйгээс 11 нь орж ирээд тэгээд ядаж 6-аас олон гишүүнээр санал гаргаад дараагийнхаа шатанд асуудлаа шилжүүлэх үү гэдэг дээр би чанарын ялгаа гаргана л гэж боддог.

Ер нь ийм судалгаа байдаг юм байна лээ. Бид нар бас энэ хуулийг боловсруулах хугацаандаа олон улс орнуудын парламентын үйл ажиллагаанд хийсэн шинжилгээ, дүгнэлт, судалгаануудыг үзэж байсан. Олон улсын парламентын холбооны зүгээс гаргасан судалгаанууд дээр ч байдаг. 1 гишүүнд ногдож байгаа эрх мэдэл хувьчлаад үзэхэд 1-ээс дээш хувь байвал тэнд заавал энэ бид нарын өнөөдөр яриад байгаа энэ зовлон бэрхшээлүүд гардаг, хуйвалддаг бүлэглэдэг, хулгай зэлгий хийдэг, 1 хүний эрх мэдэл их болчихоор тэрийгээ ашиглаж ёстой нөгөө хувийнхаа бүлэглэлийнхээ төлөө ингээд зориулаад байх боломж нь илүү нэмэгддэг гэж. Өнөөдөр манайх 76 гишүүнтэй 100 хувь гээд бодоход 1 гишүүн нь 1,3 байгаа. Өндөр байгаа байхгүй юу. Их харьцангуй их өндөрт тооцогдоно. Хурал маань цөөхөн гишүүнтэй болохоор тийм байгаа. 100-аас дээш гараад явчихвал тэр 1 хувиас доош ороод 0 хэдэн хувьтай болоод ирэхээр эрс тэр Улсын Их Хурлын

парламентуудын ажил нь жинхэнэ хууль тогтоох, шалгах ажилдаа илүү төвлөрдөг. Нөгөө янз бүрийн буруу зөрүү сонирхлоор эрх ашгийн зөрчилд ордоггүй, эрх мэдэл нь буурчихаар тэрийгээ ашиглаж нөлөөлөх юмнууд нь багасдаг.

Өнөөдөр манайд хийгдэж байгаа ялангуяа төрийн өндөр албан тушаалтнуудын орооцолдоод байгаа хэрэг өөрснөө хэрэг шууд шийдвэр гаргаад хийчихсэн хэргүүд ерөөсөө биш шүү дээ. Авлига, хээл хахууль, хулгайн хэргүүд. Дандаа нөлөөллийн хэргүүд байхгүй юу. Тэгэхээр тоо олон болно гэдэг тэр 1 хүнд ногдох нөлөөлөл буурна гэдэг нь угаасаа цаагуураа шинжлэх ухааны үндэстэйгээр ахиц гарах юм гэдгийг харуулж байгаа ийм тоо л гэж би бол ингэж бодож энэ асуудлыг дэмжиж яваа. Ингэж тайлбарлаж яваа.

Тэгээд мэдээж нөгөө намууд дээр үнэхээр тэр ёс зүй, хариуцлага, сонголт шалгуурын асуудал бол намууд дээр дийлэнх ачаа нь ирнэ. Муу хүмүүс дэвшүүлээд л жагсаалтад муу хүн оруулаад л тойрог дээр муу юм дэвшүүлээд л байвал тэгээд тэр нь тэртээ тэргүй л улс төрд эзлэх орон зай, амьдрах орчин нь хумигдаад л яваад байна гэсэн үг шүү дээ. Тийм учраас миний жишээ нь Байнгын хороон дээр ярьсан зүйлүүдээс, ажлын хэсэг дээр ярилцсан зүйлүүдээсээ бодоод дахин дахин хэлээд байгаа нь бид нар энэ хэдэн хуулиудаа бүгдийг нь багцаар нь баталж байж л энэ үр дүндээ хүрнэ. Түүнээс 1-ийг нь баталж орхичхоод, нөгөөдхийг нь орхиод юм уу, 1-ийг нь сайн, нөгөөдхийг нь муу хийгээд явбал бас л энэ 30 жилд бий болсон энэ уур амьсгал, сэтгэлгээг өөрчлөх, засаж залруулахад төвөгтэй л байна гэж бодож байгаа юм.

Г.Занданшатар: Цэндийн Сандаг-Очир гишүүн тодруулъя.

Ц.Сандаг-Очир: Би асуултдаа бодитой яг өөрчлөлт хийснээр, тоог

нэмснээр, тогтолцоог өөрчилснөөр гишүүдийн ёс зүй ингэж сайжрах юм, гишүүдийн хариуцлага ингэж дээшилэх юм, парламентын чадавх ингэж сайжрах юм гээд ийм бодитой хариулт олж авч чадсангүй л дээ. Хулгай ингэж буурах юм гээд, хулгай нэг их тоондоо ч биш байх. Хулгайчид энэ дотор ороод ирсэн тохиолдолд 152 нь байна уу, 76 нь байна уу хулгайгаа хийх л байх. Тийм хулгайч гарахгүй байх нөхцөлийг л бүрдүүлэх ёстой. Сонгууль нь тийм болдог л байх ёстой. Улс төрийн намуудын тэр байдлаас нь л шахдаг байх ёстой л гэж бодож байгаа.

Нөгөө талаас үндсэндээ би бол энэ удаагийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг парламентад ганцхан суудалтай ХҮН намын бараг санал санаачилгад тулгуурлаж хийгдэж байгаа шүү гэж би хэлж байгаа юм, харж байгаа юм. Бүхэл бүтэн 60 суудалтай олонх эрх барьж байгаа нам, 1 суудалтай ХҮН нам ийм том тогтолцооны өөрчлөлтийг санал санаачилга гаргаж, тайлбар мэдүүлгийг хийж, ингэж ХҮН намд баяр хүргэе, сайн байна. Доржхандад. 1 суудалтай хэр нь ийм томоохон өөрчлөлтийг Үндсэн хуульд хийж чадаж байна гэдэг бол бас. Тэгэхээр хүндээ байдаггүй нь харагдаж байгаа байхгүй юу. 1 хүн ч байсан томоохон өөрчлөлтийг яаж хийж болдог юм бэ гэдгийг. Яаж тайлбарлахаас бас харагдаж байна шүү дээ. Яаж ойлгуулахаас харагдаж байна шүү дээ. Яах вэ, тогтолцоондоо байна гээд байгаа юм. Би бол хүндээ байгаа л гэж ойлгож байгаа, хүндээ байгаа, асуудал.

Улсын Их Хурлын хүлээн зөвшөөрөгдөх легетим чанар нь өнөөдөр юу байгаа билээ. 152 болчихоор, 126 болчихоор бас чадвар чадамж нь дээшлээд явчихна гэж би олигтой харахгүй л байна. Тэгээд яах вэ, цаг хугацааны хувьд шүүгдээд харагдах байх. Аяндаа нэг жилийн дараа хойтон өдийд бид нар ямар болоод, ямар өөрчлөлтөд

хүрэв, хүсэж байсан үр дүндээ хүрч ...
/минут дуусав/

Г.Занданшатар: Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулиар Улсын Их Хурлын дарга ард иргэдийн санал бодлыг нэгтгэж, чуулганы хуралдаан дээр мэдээлэл хийж болно гэж байгаа. Тэгээд сая бас асуулт, хариултын явцыг харахад нөгөө тооноос болоод л бүх юм болохгүй байгаад байгаа гэдэг бол өрөөсгөл дүгнэлт болно.

Улсын Их Хурлын гишүүд нийт 21 аймаг, 197 сум, нийслэлийн 9 дүүрэгт ажиллаж 62672 санал авсан байна. Үүнийг бүгдийг нь нэгтгэсэн. Ди парламент цахим систем парламент цэг мн санал асуулгын цэц, цахим шуудан, албан бичиг, суурин утас, олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулж 273 иргэн саналаа ирүүлсэн. Түүнчлэн 104 мянган төрийн албан хаагч саналаа илэрхийлсэн. Тэгэхээр нийтдээ Үндсэн хуулийн өөрчлөлтийн төсөлд 167268 санал ирээд байна. Тэгээд энэ саналуудыг нэгтгээд дүгнээд үзвэл энэ сонгуулийн холимог тогтолцоог бол дэмжих хандлагатай байна. Хосолмол тогтолцоог. Гишүүдийн тоо нэмэхийг 152-ыг дэмжихгүй байгаа нь харагдаж байна. Яг энэ юмыг хэлж байгаа байхгүй юу Сандаг-Очир гишүүн.

Энэ Улсын Их Хурлын гишүүдийн чинь ёс зүй, чуулганы хуралдаандаа оролцож байгаа байдал, судалгаа тооцоо бодитой байдлыг ярьж байгаа байдал, 120-оос доошоо байхаар л авлига гаараад байдаг гэсэн юм бас байхгүй. Авлигын индексээр гайгүй хуучин социалист Эстони улс 101 гишүүнтэй, Молдав 101 гишүүнтэй. Тийм учраас энэ өөрчлөлт нэн ялангуяа энэ ард иргэдийн зүгээс, эрдэмтэн судлаачдын зүгээс, ажлын хэсгийн зүгээс нэг юмыг их тод ойлгож, манай гишүүд ч гэсэн яримаар байгаа юм. Энэ ингэж цогц өөрчлөлт болж байж, Улс төрийн намын тухай хууль, Улс төрийн намын тухай хууль, Сонгуулийн

хууль, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт бусад эрх зүйн шинэчлэлүүд ингэж цогцоороо байж байж энэ реформ амжилттай болно. Энэ авлигатай тэмцэх, ил тод байдлыг хангах, хяналттай тогтолцоог бий болгоно. Өөрөөр хэлбэл Улс төрийн намын тухай хуульд нэр дэвшүүлэх хороо гэж бие даасан хараат бус хороо бий болж байж одоо энэ тэр нэр дэвшүүлэлт чинь дарга, цэрэг нар нь орчихдог ч юм уу. Нэр муутай хүн орчихно энэ тэр гээд байгаа юм чинь тэр тухайн кластер нэгж хүмүүсийн саналыг авч төлөөлөх чадамжийг хангаж байж яахгүй бол. Улс төрийн намын дотоод ардчиллыг хангана гэж байгаа чинь тэр нэр дэвшүүлэх хорооноос эхэлнэ.

Тэр Сонгуулийн хууль дээр тэр нэр дэвшигчийн шалгуур үзүүлэлтийг бий болгоно. Ийм цогц асуудлуудаар үүнийг шийднэ шүү гэж ард иргэд хэлж байгаа юм. Тэгэхгүй бол ингээд л Үндсэн хуульд өөрчлөлт оруулчхангуут маргааш нь гайхамшигтай юм болчихдог юм биш. Хөгжлийн банкны хэрэг энэ тэр шууд 1 гайхамшигтай хүн оруулж ирээд илрүүлээд нээчихсэн ч юм биш.

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний цөөнхийг оролцуулж гэж цөөнх гэдэг үг анх орсон, цөөнхийг оролцуулаад 4-ний 1 нь санаачилбал түр хороо байгуулна. Мөрдөн шалгах түр хороо. Анхны төсөл дээрээ бол нотлох баримт цуглуулах, гэрч дуудах, эрх бүхий мөрдөн шалгах түр хороо гэж нэрлэж байсан юм. Тэгээд хэлэлцүүлгийн явцад Үндсэн хууль дээр үг үсэг болгоны хууль зүйн техникийн хувьд энэ деталиудыг хасаад, хянан шалгалтын хуульдаа орсон. Энэ хууль батлагдаж гарах гэж энэ хууль гараад алах юм байна, болохгүй гэж бараг 2 жил гацаасан. Германы, Америкийн тэр university gate public-аас авхуулаад бүх хуулийг нь судалж байгаад энэ хуулийг өргөн байршуулсан. Ингээд 2 жил гацаж байж,

2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр батлагдсан юм. Ингээд 2022 оны 01 сарын 01-ний өдөр энэ хууль хүчин төгөлдөр болж эхлэхэд Хөгжлийн банкны Хяналт шалгалтын ажлын хэсэг анх байгуулагдсан. 04 дүгээр сарын 15-нд Хөгжлийн банкны хяналт шалгалтын түр хороо байгуулсан. Ингээд энэ Хөгжлийн банкны асуудлаар бас мөрдөн шалгах, нотлох баримт цуглуулах, гэрч дуудах ажил явж байгаад сая 3 үе шаттай нээлттэй сонсгол хийлээ. Анхных болохоор мэдээж алдаа оноо байсан асуудлууд гарсан байхыг үгүйсгэхгүй. Ингэж парламентын хяналт шалгалтын тогтолцоо чинь 19 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр одоо л бэхжиж байгаа байхгүй юу. Энэ чинь 8 жил болж хэрэгжиж байж энэ хяналт шалгалтын тогтолцоо бий болно.

Одоо энэ Парламентын судалгааны хүрээлэн, энэ судалгааны алба чинь энэ нээлттэй сонсголуд зохион байгуулах, парламентын хяналтыг чангатгах, авлига, хээл хахуультай тэмцэх энэ бүх үндсийг бий болгож байгаа.

Нүүрсний асуудлаар 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдөр Хяналт шалгалтын түр хороо байгуулсан. Тэгээд л түүн дотроос энэ мэдээллүүд, хэдэн их наяд энэ тэр гэдэг юм чинь тэнд хяналт шалгалтын хороон дээр яригдсан. Эхлээд тэгж байгуул, тэр чинь нүүрс тээвэр ложистикийн асуудал гэж байгуулагдсан. Тэгэхээр тэр дотроо тэр олон асуудлууд гарсан. Тэгэхээр энэ бүхэн маань байна шүү дээ. Ер нь явж явж Их Хурал дээр л энэ шүгэл үлээгдэж, мэдээлэл задарч, энэ дотроо ярьсан юмнуудаас энэ Хөгжлийн банкны ч, нүүрсний ч, 2010 онд төсөв хэлэлцэж байхад л үед энэ хяналт шалгалтын хороо чинь оффтекийн гэрээ энэ тэрийг ярьж ингэж эхэлсэн шүү дээ.

Тэгэхээр Их Хурал ингээд л нэг ерөөсөө мэдээж дэлхий дээр сайн нэртэй парламент байдаггүй. Яагаад гэвэл

ардчилал бол өрсөлдөөн учраас дандаа тэн хагас нь ч юм уу шүүмжлэгдэж байж гарч ирдэг учраас сайн нэртэй байхгүй л дээ. Тэгэхээр 1 зүйлийг би онцолж хэлмээр байгаа юм. Энэ тоо нэмэх, 1 дүгээр бодит шалтгаан бол санал хаягдаж байгаа явдал. Төлөөлөх чадвар байхгүй байгаа. Мааш олон шалтгааныг энэ дээр авлига, хээл хахууль олон юм. Дараа нь ингээд нэг өдөр сайхан болчихгүй гэдгийг анзаарах.

Учир шалтгаан нь 45 хувь нь, нийт сонгогчдын 45 хувийн санал өгсөн хүмүүсийн 45 хувийн санал аваад нийт суудлын 82 хувийг авчихаар, парламентад тэр олон улс төрийн үзэл бодлыг төлөөлөх төлөөлөл, улс төрийн өнцгүүдийн төлөөлөл байхгүй болчихож байна. Ингэхээр цөөнхийн хяналт байхгүй болчихоор энэ авлигатай ч бай аливаа засаглалын хяналт, Үндсэн хуулийн хамгийн чухал механизм бол хяналтын механизм бол цөөнхийн хяналт байхгүй юу. Засгийн эрхийн төлөө өрсөлдөж байгаа ардчиллын өрсөлдөөний зарчмын хамгийн том нь цөөнхийн. Тэгэхээр энэ цөөнх байхгүй байгаа учраас үүнийг л хийж байгаа юм. Үүнийг л ард иргэд шаардаж байгаа юм. Үүнийг ард иргэд хэлсэн учраас би энэ үгийг дамжуулж байгаа юм. Тийм учраас 85 хувийг төлөөлж байгааг. Гэтэл тэр төлөөллийг пропорционалиар нэмэгдүүлчихье гэхээр ийм өргөн уудам нутаг дэвсгэртэй газар нутаг дээр энэ 76-гаа бууруулж болохгүй байна. 76-гаа хэвээр үлдээе.

Харин тэр улс төрийн үзэл бодол, нийгмийн кластер бүлгүүдийн ашиг сонирхлын бүлэглэлийг 50-аар нэмж оруулъя. Энэ бол нэг тайлан болох ёстой. Үүнийг бол ард иргэд мааш сайн хүлээж авч байна лээ. Энэ талаасаа бол. Сонгуулийн тогтолцоог дэмжиж байгаа учраас.

Тэгээд бусад нь тэр ил тод байдлыг бий болгох, оролцоог нэмэгдүүлэх, төлөөлөх чадварыг хангах, Засгийн газартаа хяналт тавих, чадавхыг сайжруулах, давхар дээлтэй байгаа

учраас гүйцэтгэх засаглалд тавих хууль тогтоох байгууллагын хяналтыг бэхжүүлэх тоо нэмэх зайлшгүй шаардлага гарч байна. Энэ эрх мэдлийн харилцан уулзалт дээрээ гэх мэтчилэн энэ тайлбаруудаа бол илүү өргөн хэмжээнд бас манай гишүүд ярьж байхгүй бол зөвхөн л ингээд нэг өрөөсгөл талаас нь тайлбарлавал бас ард иргэдэд ойлгогдохгүй байж болзошгүй. Үүнийг анхаармаар юм байна лээ. Ард иргэд үүнийг бол онцлон дэмжиж хэлээрэй гэж онцолсон.

Өчигдөр Эстонийн гадаадын, Европын Элчин сайд нар уулзахдаа ч гэсэн ардчилал бол өртөгтэй байж болно. Гэхдээ нэг хүний юм уу бага тогтолцооноос асар их илүү бага зардал хэмнэгддэг юм шүү. Энэ авлигын зардлыг бууруулдаг юм шүү гэж хэлж байсан байгаа юм.

Ингээд Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуултаа асууна. Пүрэвдорж гишүүн санал хэлнэ.

Б.Пүрэвдорж: Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хэлэлцүүлгээр Ховд аймгийн 10 сум, дээрээс нь Эрдэнэт хотод иргэдтэй уулзалт хийлээ. 1600 орчим иргэнтэй уулзалт хийсэн. Тэгээд энэ дээр энэ болгон дээрээ би иргэдээс гарыг нь өргүүлээд, саналыг нь асуугаад явсан байгаа. Тэгээд 152-ыг дэмжиж байгаа хүн 1600 хүнээс цорын ганц байна. Ховд аймгийн Ховд сумын Тлеухан гээд хуучин дарга байсан нэг хүн байгаа.

Тэр 126, 108, 98 гэсэн би энд энэ тоонууд дээр бол нэг нийтдээ 50 орчим хүн л гар өргөж байна, 1600-аас гуравхан хувь. Тэгээд олон сумууд дээр бол дэмжихийг ерөөсөө 1 ширхэг ч гараа өргөөгүй бас хэд хэдэн сум байна. Ховд аймгийн Алтай сум дээр, би ер нь хөдөөгүүр явахдаа 98 хүртэл өөрөөр хэлбэл 100-аас дээш давуулж болохгүй, 98 хүртэл нэмж болох юм гэдэг ийм л зүйлийг яриад явсан. Тэгээд Алтай сум

дээр тэр 152, 126, 108 дээр ерөөсөө гар өргөхгүй. Тэгээд нөгөө нэг Алтай сумын Өлзий ах намайг үнэхээр дэмждэг, миний фен учраас ингээд хамгийн урд суучихсан хүмүүсээс нуугдчихсан ингээд гараа өргөж байна. Иймэрхүү байдлаар л хандаж байна шүү дээ.

Тэгээд иргэдийн бас санаа бодлыг бас онцлох санаа бодлуудыг хэлье. Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын Эрдэнэчулуун гуай Улсын Их Хуралд суудалтай 3 нам тохироод шийдчихдэг юм биш ээ, ард түмэн дургүй байна. Тэгээд та нар ингээд шийдчихдэг юм бол тэндээ сонголтын асуудлыг чинь дараа нь ярина шүү гэж байна.

Ховд аймгийн Мөст сумын Баасандорж энэ 2 луу адилхан овогтой байдаг юм. Улаан Баасандорж нь шүү, 108 гишүүдээ байж болох юм гэсэн ийм зүйлийг ярьж байна. Болд-Эрдэнэ соёлын төвийн үйл үйлчлэгч 2 мянган м2 байрыг ганцаараа цэвэрлээд 400 мянган төгрөг авч байна. Цалингаа нэмээч, Номин сайд аа гэж дамжуулж өгөөч ээ гэж хэлж байна.

Алтай сумын Дандар гуай Үндсэн хуульд өөрсдийнхөө эрх ашгийг харж өөрчлөлт оруулж байна. 76-аараа баймаар байна. Ядаж сумын иргэд сумын даргаа сонгодог энэ заалтыг иргэдийн төлөө оруулахгүй байж яахаараа өөрсдийнхөө эрх ямбыг дээшлүүлэх тийм өөрчлөлтийг хийдэг юм бэ гэж.

Үенч сумын Хөх үзүүр багийн Баттулга эгч Монголын хууль бол маш энэрэнгүй байна. Дээр дооргүй хулгай хийж байна. Тэгээд хулгайчийг ингээж тэмдэглэмээр байна гээд. Хаана ч явсан энэ хулгайч байна гээд тэмдэглэмээр байна.

Булган сумын Баяраа ах социализмын үед 42 хуультай болоод байсан бол 800 гаруй хуультай байна. Тэгээд ерөөсөө энэ хууль чинь амьдрал

дээр ерөөсөө хэрэгжихгүй байна шүү дээ. Энэ тал дээрээ хэрэгжилтийг хангах тал дээр Их Хурал сайн ажиллах ёстой гэсэн ийм байр суурийг хэлж байна.

Цэцэг сумын Жамбалсүрэн гуай би МАН-ын гишүүн ээ, 152 болгох юм бол би санал өгөхгүй шүү гэж манай Ардын намынханд дайгаад өгөөч ээ гэж хэлж байна.

Дарви сумын Батзориг гэдэг хүн ард түмэн татвар төлөөд байдаг, 76 гишүүн буруу зарцуулаад байна. 152 болгох юм бол бүр буруу зарцуулна гэж сануулж байна.

Мянгад сумын иргэдтэй уулзахад бол асуулт асуусан, санал хэлсэн бүх хүмүүс бүгдээрээ энэ Халзан бүргэдэйн суудал дээр маш тийм дургүйцэлтэй байна шүү. Энэ дээр бас энэ Засгийн газар, аймгийн удирдлагууд анхаарах ёстой. Мянгад сумын Баярсайхан 98 гишүүнтэй байвал болж байна. Тэгээд ноднин тэтгэвэр 15 хувиар нэмсэн. Гэтэл энэ хооронд 50 мянган төгрөг байсан иуудай гурил 110 мянган төгрөг болоод 120 хувиар өсчихсөн байж байна. Тэгэхээр энэ тэтгэвэр, цалингаа нэмж байж л энэ Үндсэн хуулийн өөрчлөлтөө хийгээрэй л гэж байна.

Дараа нь Ховд аймгийн Ховд сумын өндөр настан Базар гуай 76 гишүүн бүгдээрээ хуралдаа суухгүй байна. Гишүүд маш хариуцлагагүй байна. Тэгээд хурлын ирцийг 3-ны 2-оор ирцээ бүрдүүлээд, тэгээд хуулиа 3-ны 2-оор батлах юм бол хууль илүү чанартай болно гэсэн ийм саналыг хэлж байна.

Жаргалант сумын иргэн Нарантуяа Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хэлэлцүүлэгт манай Ховд аймаг дээр болсон.

Ховд аймагт нийтдээ 182 хүн оролцсон. Дандаа төрийн албан хаагчид албан дарамтаар шаардлагаар тэнд

оролцоод ихэнх нь дэмжсэн болоод ингээд явсан. Ер нь бол Үндсэн хуулийн хэлэлцүүлгийг маш хариуцлагагүй хийдэг шүү гэдгийг хэлж байна.

Эрдэнэт хотын иргэн Буяндэлгэр гуай, Эрдэнэт хотод би бас уулзалт хийсэн. Тэгээд Эрдэнэт хотын иргэн Буяндэлгэр гуай мөрийн хөтөлбөрөө биелүүлээгүй намыг ерөөсөө дахиж сонгуульд оруулахгүй баймаар байна. Тэгээд дээрээс нь сонгогчдын 3-ны 2-оор Их Хурлын гишүүнээ буцааж татдаг ийм зүйлийг Сонгуулийн хуульдаа болон бусад хуульдаа оруулмаар байна гэсэн ийм саналыг хэлж байна. Тэгээд хөдөөгүүр ярьж байхад би бол 100-аас дээш гарахгүй 98 байх тухай л яриад явсан. Өөрөөр хэлбэл хөдөөгийн иргэд бол ард түмний амьдрал хүнд хэцүү байж байхад энэ тоогоо нэмдэг, жагсаалтаа нэмдэг энэ Их Хурал өөрсдийнхөө эрх ямбыг нэмдэг л ийм зорилгоор Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийж байна. Энэ бол буруу байна гэж яриад байгаа. Тийм учраас би өчигдөр аргаа бараад ер нь бол бүх Их Хурлын гишүүд 126 руу бүгдээрээ ингээд 100 хувь бараг явж байх шиг байна. Тэгээд аргаа бараад өчигдөр Төрийн байгуулалтын байнгын хороо дээр 98 гэсэн саналыг гаргасан боловч нэг ч хүн дэмжихгүйгээр унагаасан байгаа. Ийм байдалтай байна. Тэгээд ер нь бол одоогийн энэ 2 дугаар хэлэлцүүлгийн дараа манай Их Хурлын гишүүд бүгдээрээ очно. Тэгээд энэ Их Хурлын гишүүддээ нэг зүйлийг л шаардмаар байна. Эдийн засгаа сайжруулах тэр ажлаа хий. Нийгмийн асуудлыг шийдвэрлэх тэр зүйлүүдээ энэ Их Хурал баталж, хууль болон бусад шийдвэрүүдээ гарга.

Дээрээс нь нэгэнт та нар эрх мэдэл авч байгаа бол хүүхдийн мөнгийг 100 хувь олго. Цалин тэтгэврээ нэм. Тэгээд яг хэдний өдөр энэ улсын төсвийн тодотголыг оруулж ирэх юм. Тэр тодотголоороо яаж яаж хэдэн хувиар энэ тэтгэврээ цалингаа нэмэх юм. Энэ зүйлийг бүгдийг нь шаардаж байж л энэ

Үндсэн хуулийн өөрчлөлт тэртээ тэргүй кнопоор. Энд сууж байгаа Их Хурлын гишүүд ерөөсөө л нэг хөдөөд очихлоороо л энийг дэмжсэн юм шиг юм л яриад байх юм. Тийм юм ерөөсөө байхгүй байгаа шүү дээ. Тэгээд 80 хувь нь дэмжсэн ч гэх шиг. Үгүй ээ, энэ дөнгөж гуравхан хувь нь л 1600 хүнээс 50 хүн л гар өргөж байна шүү дээ. Гишүүдийн тоог нэмэхийг. Ийм байж байхад чинь ерөөсөө 1 ийм харалган байдлаар асуудалд хандаж байгаад маш их харамсаж байна. Тийм учраас энэ 2 дугаар хэлэлцүүлгийн дараа гишүүд чинь орон нутагт очиход цалингаа л нэмүүлж ав. Тэтгэврээ л нэмүүлж ав. Тэгэхгүй бол тэртээ тэргүй эд нар энд хөдөөгийн ард түмэн.../минут дуусав/

Г.Занданшатар: Үг хэллээ. Пүрэв-Очирын Анужин гишүүн.

П.Анужин: Баярлалаа. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаар бид ард иргэдийнхээ саналыг сонсож, ярилцаад ирлээ. Ард түмний амь амьжиргаа хүнд, орлого бага, цалин тэтгэвэр хүрэлцэхгүй, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ огцом өссөн. Эдгээрийг дагалдаад иргэдийн маань сэтгэл санаа тогтворгүй, уур бухимдалтай ийм цаг үеийн амаргүй нөхцөл байдалд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт яригдаж байна. Гэсэн хэдий ч ард иргэд маань Үндсэн хуульдаа гар хүрч, нэмэлт, өөрчлөлт оруулах энэхүү үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, цаг заваа гаргасан. Ер нь ямар ч хүнд үед улс орныхоо эв нэгдлийн төлөө, улсынхаа эрх ашгийн төлөө нэгдэж чаддаг энэ түүх бол Монголын ард түмний саруул ухааны түүх гэж би бодож явдаг. Энэ ч талаасаа миний сонгогдсон Сонгинохайрхан дүүргийн ард иргэд маань энэ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах энэ түүхэн үйл ажиллагаанд маш идэвхтэй оролцож, өөрсдийнхөө саналыг бидэнд хэлж, бидэнтэй нээлттэй ярилцсан явдалд бас өнөөдөр талархаж байгаагаа та бүхэндээ илэрхийлье гэж бодож байна.

Бид заавал энэ тогтолцооны өөрчлөлт хийх шаардлагатай юу, үгүй юу гэдгийг иргэдтэйгээ ярилцаж тайлбарлахад иргэд маань тогтолцооны өөрчлөлтийг бол дэмжсэн. Гэхдээ тогтолцооны өөрчлөлт хийгээд чанарын өөрчлөлт гарах уу гэдгийг бол ийм хэрсүү асуултыг биднээс бол асууж байсан. Маш ихээр. Чанарын өөрчлөлтийн цаана тоог нэмээд одоогийн энэ байгаа төр засгийн нүүр царай, төр засгийг бүрдүүлж байгаа энэ хүмүүсийн ухамсар өөрчлөгдөх үү гэдэг энэ асуултыг ер нь бол явсан тойрог бүхэн ярьсан байна лээ. Ард түмнийг бухимдуулж байгаа гол зүйл бол энэ ард түмнээ тайван сэтгэх боломжгүй, амар амгалан амьдруулах ийм нөхцөл байдлыг өнгөрсөн энэ 31 жилд бид огт бүрдүүлж чадаагүй. Ийм ч учраас бас энэ ард түмэн энэ том өөрчлөлтийг ярих манатай ийм байдалд бас орж, өнөөдөр энэ байдалд бол хүрч ирсэн байна. Тэгээд ямар ард түмэн байна. Тийм төр засаг байна гэж бид хэлдэг. Тэгэхээр хэчнээн бид нар тоог нэмсэн ч гэсэн өнөөдрийн л энэ төр засгийг бүрдүүлж байгаа өнөө л хүмүүс ороод ирэх вий гэдэг энэ болгоомжлолыг хүмүүс хэлсэн. Тэгэхээр бид нар энэ тогтолцооны өөрчлөлтөө чанартай өөрчлөлт болгоё гэвэл энэ хүмүүсийнхээ амь амьжиргааны асуудалд яаралтай анхаарах хэрэгтэй. Энэ тогтолцооны өөрчлөлтөө бид нар хэрэгжүүлбэ л гэх юм бол хүмүүсийнхээ чанарыг өөрчлөх үндсэн суурь буюу хүмүүсийн амь амьжиргааны асуудлыг л анхаарч яаралтай өөрчлөх хэрэгтэй. Ер нь энэ оюун санааны өөрчлөлт ухамсрын өөрчлөлтийг хийе гэвэл бид нар энэ ахуйн өөрчлөлтийг л амжилттай хийж, хүрэлцээтэй цалин, өвддөггүй хүүхэд, гэртээ амар амгалан байдаг энэ нөхцөлийг бүрдүүлэхгүйгээр бид нар уур уцааргүй Монгол хүн, тайван нийгэм ийм оюун санааны өөрчлөлтийг бол ярих ямар ч боломжгүй гэдгийг бас хэлж байгаа юм. Ийм учраас бид нар энэ өөрчлөлтөө дагалдуулаад яаралтай ард иргэдийн хүсэж байгаа хангалттай цалин тэтгэвэр тэгээд энэ нийгмийн бусад

асуудлуудыг бол шийдэх ёстой гэж ингэж үзэж байгаа юм.

Хоёрдугаарх нь бол асуулт юм. Энэ юу вэ гэхээр улс төрийн намуудын оролцоог нэмэгдүүлнэ л гэдэг гол зүйлийг хэлээд байгаа юм. Энэ удаагийн өөрчлөлтөд. Гэтэл иргэд маань тийм их төлөвисөн намууд байгаа юм уу. Монгол оронд өнөөдрийг хүртэл бас байж ирсэн намууд чинь ихэнх голдуу нэг компанийн, нэг хүний ийм намууд байна. Тэгэхээр улс төрийн намуудын оролцоо идэвхийг нэмэгдүүлнэ гээд байдаг. Яг энэ байдал чинь жинхэнэ нөхцөл байдал дээрээ ямар байна вэ гэдгийг асууж байгаа юм. Тэгэхээр би энэ тал дээр тодруулга авах гэсэн юм.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд гишүүн яасан. Байнгын хорооны дарга. Сая яг энэ Байнгын хорооны санал, дүгнэлт. Өчигдөр төсвийн хүрээний мэдэгдэл, жилийн төлөвлөгөө хэлэлцсэн тээ. Хэнээс асуусан билээ. 2 дугаар хэлэлцүүлэг дээр Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж л сая өөрчлөлт орсон өөрчлөлттэйгөө. Доржханд гишүүн асууна. Нэгмөсөн хариулчихъя. Догмидын Доржханд гишүүн алга байна. Хаслаа. Хавдисламын Баделхан гишүүн асуултаа асууя. Дараа нь нийлүүлээд хариулчихъя.

Х.Баделхан: Баярлалаа. Ер нь гишүүдийн тоог нэмэх, сонгуулийг холимог тогтолцоотой болгох асуудал бол олон жил яригдсан. Бүр 1992 онд анхны Үндсэн хуульд өөрчлөлт оруулж байхад л энэ асуудал яригдсан юм байна шүү дээ. Дараа нь ер нь би 2008 онд сонгогдсоноос хойш ер нь олон удаа энэ яригдсан. 2019 онд Үндсэн хуульд өөрчлөлт оруулах үед бол бас яригдаад, яг өөрчлөх даваан дээр зарим гишүүд татгалзаад ингээд болоогүй юм. Ер нь энэ удаа тэгээд 126 болгоод өөрчилье гэсэн саналыг оруулж байгаа юм байна. Ер нь улс төрийн намуудын оролцоог нэмэгдүүлье. Иргэдийн төлөөлөх

чадварыг нэмэгдүүлье. Гишүүдийн эрх мэдлийн төвлөрлийг бууруулъя. Парламентын чадавхыг сайжруулъя. Хуулийн чанарыг сайжруулъя. Нийгмийн бүлгийн төлөөллийг оролцуулъя гэж ингээд гишүүдийн тоог нэмэгдүүлэхээр болж байгаа юм байна.

Ер нь иргэдтэй уулзахад иргэдийн хүсэж байгаа зүйл бол хамгийн гол нь иргэд бол шинэчлэлийг хүсэж байгаа. Ер нь шударга ёсыг хүсэж байгаа. Ер нь энэ ард иргэдийн амьдрал хэзээ сайжрах вэ гэдгийг л ер нь хүсэж байгаа л даа. Хамгийн гол нь төр тогтвортой байгаасай гэж. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд манай төр их тогтворгүй байсан. Нэг Засгийн газрын ажилласан хугацаа бол бараг дунджаар 1,5 жил. Иргэдийн амьдрал сайжраагүй ээ. Сонгууль болгоны өмнө хуулиа өөрчлөөд ерөөсөө ингээд тогтворгүй байдал бий болсон. Тийм учраас энэ бүхнийг, бүх зүйлийг өөрчлөхийг бол иргэд хүсэж байгаа юм. Тийм учраас ер нь энэ удаа бид нар Үндсэн хуульд өөрчлөлт хийвэл хийгээд, дорвитой өөрчлөлт хийгээд, ер нь дахиж ер нь Үндсэн хуулийг оролдмооргүй байна. Миний санал бол. Энийг Үндсэн хуулийн заалтыг бол ягштал хэрэгжүүлмээр байна. Тухайлбал бид нар 2019 онд ярьж ярьж байгаад Үндсэн хуульд өөрчлөлт оруулаад, дараа нь зарим заалтыг нь бол хэрэгжүүлээгүй. Батлагдсан зарим заалтыг нь бол дараа нь өөрчилсөн. Тухайлбал бид ярьж ярьж байгаад энэ хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалыг бол хоорондоо эрх мэдлийг нь ялгаварлая.

Ялангуяа хууль тогтоох эрх мэдэлтэй гишүүд тэр гүйцэтгэх засаглалд орохгүй байя гэж ярьж ярьж байгаад бид нар энэ 4 гишүүн нь сайд болно гэж бид нар хуулийн төсөл оруулсан. Үндсэн хуульд. Гэтэл дараа нь өөрчлөөд бүгд бүх гишүүд ингээд давхар дээлтэй, Засгийн газраас гишүүн болсон байгаа. Тэр удаагийн Үндсэн хуулиар өөрчилсөн зарим заалт бол одоог хүртэл

хэрэгжихгүй. Хууль нь батлагдаагүй байгаа. Тухайлбал улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын эрх зүйн үндэслэлийг бол хуулиар тогтооно гэж. Энэ 2019 онд Үндсэн хуульд ийм өөрчлөлт оруулсан ч өнөөдөр 4 жил болж байхад энэ хууль нь гараагүй. Энэ заалт нь хэрэгжээгүй ийм байдалтай байна. Тийм учраас миний хүсэж байгаа хүсэлт бол ерөөсөө Үндсэн хуульд бид нар энэ удаа өөрчлөлт оруулбал дахин ер нь өөрчлөхгүйгээр бид нар нэг хэсэг ажилламаар байна. Энэ удаа бол нэлээн дорвитой өөрчлөлт оруулж байгаа. Олон жил яригдсан асуудлыг шийдэж байгаа. Иргэдээс санал авсан. Энэ бол ард түмний хууль. Тийм учраас Үндсэн хуульдаа энэ удаа өнөөдрийн Төрийн байгуулалтаас оруулж байгаа саналыг дэмжээд явуулаад, ер нь цаашидаа бид нар Үндсэн хуульд гар хүрмээргүй байна гэсэн ийм саналтай байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Санал хэллээ. Баагаагийн Баттөмөр гишүүн алга байна. Цогт-Очирын Анандбазар гишүүн алга байна. Дашидондогийн Ганбат алга байна. Хаслаа: Ням-Осорын Учрал гишүүн.

Н.Учрал: Үндсэн хууль бол нийгмийн зөвшилцлийн гэрээ. Тэгээд нийгмийн бүлгүүдийн саналыг сонсож, тухайн хэрэгцээ шаардлагад үндэслэж, зөвшилцлөөр батлах ёстой. Тийм ч учраас иргэд сонгогчд бас нэлээдгүй олон уулзалтуудыг Их Хурлын гишүүд хийлээ. Тэгээд миний хувьд ч гэсэн сонгогдсон тойрогтоо энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийн талаар бас байр суурийг илэрхийлж, нээлттэй саналуудыг сонссон. Тэр Үндсэн хуульд Улсын Их Хурлын гишүүн бол бүх ард түмний төлөөлөгч гэж заасан. Гэсэн хэдий ч өнгөрсөн 30 жилийн хугацаанд Их Хурлын гишүүд бол сууц өмчлөгчдийн холбооны дарга нар шиг, бизнесийн нэг компанийн төлөөлөл шиг ажилласаар өнөөдрийг хүрсэн. Лифтний шинэчлэл, тээврийн засвар ярьдаг, Их Хуралд нөлөөтэй

асуудлуудаа шийдүүлж чаддаг зарим хэсэг бүлэг хүмүүс шаардлагагүй газар шаардлагагүй олон хөрөнгө оруулалтуудыг тавьсаар байгаад улсын төсвөө 76 жижиг тойрогт хуваачихсанаасаа болоод нөгөө үндэсний хэмжээнд тулгараад байгаа том асуудлууд шийдэгдэж чадаагүй өнөөдрийг хүрсэн. Энэ бол тухайн бүлгүүдийн ашиг сонирхлыг л сонсоогүйтэй холбоотой. Манай улс шиг ийм өргөн уудам газар нутагтай улсад газар нутгийн төлөөлөл, цаашидад хүн амын төлөөлөл, мөн тэр нийгмийн бүлгүүдийн төлөөлөл гэсэн энэ төлөөллийг хангаж байж сонгогчдын санал гээгдэхгүйгээр Их Хурлаар хэлэлцэж байгаа хуулиуд батлагдаад, тухайн хуулиуд нь амьдрал дээр хэрэгждэг.

Тэгэхээр бид нар баталж байгаа хуулиудаа ч гэсэн зөв эрэмбэлж чадахгүй байгаа нь юутай холбоотой вэ гэвэл энэ жижиг тойрогтой л холбоотой. Цаашидад батлагдсан хуулиудын хэрэгжилт олон дүрэм журмууд буюу нөгөө хөл гаргүй олон хуулиудаас болоод хэрэгжиж чаддаггүйг гүйцэтгэх засаглал хүртэл харж байгаа юм. Тэгэхээр өнгөрсөн 30 жилийн хугацаанд бид ингэж явж ирлээ. Миний хувьд 2016 онд Их Хуралд сонгогдохдоо 1 дүүргийн 8 хороог л төлөөлж байсан. Ингээд 2020 онд бол 28 хороог төлөөлж байсан. Тэгэхдээ энэ зөвхөн тойргоос сонгогдсон. Гэхдээ Их Хурлын залуу гишүүний хувиар залуучуудынхаа бодлогын асуудлуудыг орхиж болохгүй гэдэг утгаараа би бас энд нэг тойрог биш, нийт залуучуудыгаа төлөөлж байгаа гэдэг утгаараа Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг ахалж батлуулсан. Тухайн үед залуу багш нарын холбооны тэргүүн олон багш нар бас санал бодлоо хэлдэг байсан учраас Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийг батлуулсан. Ингээд тэр зорилтот бүлгүүд рүүгээ чиглэсэн үйл ажиллагаанууд дээр илүү бас анхаарал хандуулахыг л зорьсон.

Өнөөдөр өнгөрсөн 30 жилийн хугацаанд нэг удаа л нэг малчин сонгогдсон гээд гишүүд хэлж байна. Түүнээс хойш малчид Их Хуралд суув уу. Яг багш нар Их Хуралд суув уу. Яг өнөөдөр хөгжлийн бэрхиээлтэй иргэдийн төлөөлөл энэ Их Хуралд орж ирэв үү. Ингээд тэдний зовлон бэрхиээлийг мэдэхгүйгээр бид нэг их уран цэцэн болоод, бүх салбарыг мэддэг царайлаад мэддэг ч юм шиг, мэддэггүй ч юм шиг ийм 30 жилийг өнгөрөөчихсөн байна шүү дээ. Тэр шилэн ажиллагааг сая явуулаад нэг зүйлийг хатуу ойлгосон. Шилэн ажиллагааны үр дүнд 136 мянган мөр өгөгдөл ил боллоо. Бид нар нээлттэй мэдээлэл, нээлттэй өгөгдөл дээр зөв дүгнэлт, үнэлэлт дүгнэлт, анализ хийх чадваргүй болчихож. Сургаар асуудалд ханддаг болчихож. Тэгээд энэ болгоноос хараад үзэхээр тусгай хамгаалалттай газруудыг ил болголоо. Хөдөө аж ахуйн санг ил болголоо. Жижиг дундын санг ил болголоо. Боловсролын зээлийн сан ч ил болж байх шиг байна. Ингээд маш олон буюу нийтдээ Засгийн газрын 5 сан ил болчихсон. Гэтэл энэ сангууд дээр иргэд олон нийт үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөгөө эдлээд, үнэлэлт, дүгнэлт хийгээд явахаар тойрч тойрч явж байгаад урд сууж байгаа нэг Их Хурлын гишүүний компани л болоод таарчихдаг. Нөгөө газар эзэмшиж байгаа нь дахиад л нэг Их Хурлын гишүүний. Тухайн хүмүүс зөвхөн компаниа төлөөлдөг бизнесийн эрх ашгаа л төлөөлдөг болчихлоо шүү дээ.

Тэгэхээр би энэ ажлын хэсгээс юу гэж асуух гээд байна вэ гэхээр түрүүн Тэмүүлэн гишүүн бас хэлсэн. Үнэхээр жагсаалтаар орж ирж байгаа тэр 50 чинь өнөөдрийн энэ гоё яриад байгаа шигээ тэр малчдын төлөөлөл чинь байх юм уу. Хөгжлийн бэрхиээлтэй иргэдийн төлөөлөл чинь байх юм уу. Үүнийгээ хатуу хуульчилж өгөөч гэж иргэд хүсэж байгаа юм. Үгүй бол Үндсэн хуулиа баталчхаад, Сонгуулийн хууль дээрээ мурьчих вий дээ гэж байна шүү дээ. Мурьсаар байгаад сурчихсан. Тэгэхээр одоо бид баталгааг нь

энэ протоколд үлдээх ёстой. Би нэг зүйлээс айж байгаа юм.

Өнөөдөр Их Хурлын гишүүдийн ихэнх нь бараг уяач. Тод манлай уяач нар. Бүгдээрээ малгайтай шүү дээ. Тэгээд нөгөө малгайтууд чинь орж ирээд малчдын төлөөлөл гээд ороод ирэх вий дээ. Нөгөө мал малладаггүй, морь уядаггүй нөгөө уяач нар чинь би малчин байна гээд дөрөө хувилгаад, зүсээ хувилгаад. Шохой барьж хичээл заагаагүй байж би багшийн төлөөлөл гээд ширлээд ороод ирэх вий дээ. Энэ цагт ард түмэн энэ хуулийг дэмжихгүй шүү. Өнөөдөр уул уурхайн баялгийг иргэддээ тэгш хүртээмжтэй хүргэнэ гээд бид нар олон жил ярилаа. Өнөөдөр 93 хувийн уул уурхайн бүтээгдэхүүнээс хамааралтай эдийн засгаа яаж төрөлжүүлэх вэ гэж байна. Яг энэ байдлаараа явсаар байгаад тун удахгүй дэлхийд 1 тэрбум доллароор үнэлэгдэх технологийн компани тэслэнэ шүү. Энэ цагт нэг ичгэвтэр байдалд орох вий дээ. Монголын эдийн засаг уул уурхай юм гэж олон жил орилсон хүмүүс. Нэг технологийн компани тэрбум доллароор 1 аппликэйшн зарна шүү. Удахгүй дэлхийд.

Би энийг протоколд үлдээж байна. 15 жилийн дараа тухайн үеийн Их Хурлын гишүүд нөгөө Учрал гэдэг нөхөр ярьж байсан. Манайд 5 компани бий болчихжээ гээд яриад суух өдөр бол тун удахгүй л гэдэгт бол би бүрэн дүүрэн итгэдэг. Тийм учраас технологийн салбарын төлөөлөл орж ирнэ гэдгийг юугаар батлах юм бэ. Тэгэхгүй бол нөгөө нэг улс төрчид чинь дахиж зүсээ хувилгаад би инженер байна гээд ширлээд ороод ирэх вий дээ. Зүсээ хувилгаад. Нэг чагнуур барьж үзээгүй мөртөө би эмч байна гээд ороод ирэх вий дээ. Тэгээд дараа нь нэг бөөн асуудал болох вий. Тэгэхээр ажлын хэсгээ нээлттэй, хаалттай жагсаалтыг аль алиныг нь зөвшөөрч байгаа юм байна энэ хуулиар. Тэгэхээр Сонгуулийн хууль дээр энийг ярина шүү. Ард түмэн намын ард нуугдах биш. Нам ард түмнийхээ тэр сайн нэр дэвшигчийн ард нуугдах сонгууль

болох гэж байгаа шүү. Удахгүй. Намын нэр хүнд унасан учраас. Аль аль нам юм. Харин сайн нэр дэвшигч нарын, сайн бүлгийн төлөөллийн энэ нөлөө бүхий хүмүүсийн далбаан дор нам нуугдсан сонгууль буюу ард түмэн өөрсдийгөө төлөөлүүлэх хүнээ өөрсдөө сонгодог ийм сонгууль 2024 онд болно. Тийм учраас энэ дээр ямар баталгаа гаргах юм бэ гэдгийг зайлшгүй хэлэх ёстой. дараа нь.../минут дуусав/

Г.Занданиатар: Санал хэллээ. Дамдины Цогтбаатар гишүүн. Нямаагийн Энхболд дарга. Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга.

Н.Энхболд: Учрал гишүүний асуултад хариулъя. Тэгээд саяын ярьсан зүйлүүдийн гол нь сонгуулийн хуулиар зохицуулагдах асуудлууд руу чиглэж байна. Ер нь бүх газар яг л ийм л яриатай байгаа. Намын жагсаалт гэж юмаар давуу талуудыг нь ойлгож байна. Ингээд нийгмийн янз бүрийн төлөөллүүд орж ирнэ. Олон янзын байр суурь илэрхийлэгддэг болно. Улс төр харьцангуй тогтвортой, төвөгтэй асуудлууд парламент дотроо яригддаг. Гудамжинд янз бүрийн үйл явдал болдоггүй. Төр тогтвортой байх болзлыг хангах нэг нь шүү. Бүх зүйл нь биш ганцхан энэнээс болоод бүх юм сайн болчихно гэж байгаа юм биш. Нэг чухал хүчин зүйл бол энэ парламентад төлөөл нь аль болохоор олон давхарга бүлгийг хамаарсан ийм байх ёстой гэдэг дээр бол хүмүүс бүгдээрээ хэлж байгаа юм. Тэгээд саяын Учрал гишүүний ярьсан тэр жишээ нь нүүрээ хувиргаад ороод ирэхгүй байх энэ бололцоог бол намууд л бий болгох ёстой. Тийм учраас бид нарын манай Байнгын хороон дээр л яригдсан гол зүйлүүдийн нэг нь энэ намуудын төлөвшлийн асуудал, намуудын хариуцлагын асуудал байгаа юм. Сонголт шалгуурын асуудал байгаа юм. Энэ өөрөө намуудыг сахилгажуулахаас өөр аргагүй болгоно гэж бодож байгаа. Ер нь ч тийм байна лээ. Бусад ийм тогтолцоо хэрэглэж

байсан улс орнуудын юм харахад. Хамгийн наад зах нь гэхэд жишээ нь одоохондоо би хэлж мэдэхгүй байна. Гэхдээ жишээ нь Сонгуулийн хууль дээр Улсын Их Хурлын тухай, Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай зохицуулалт дээр сахилгагүй, хариуцлагагүй байгаа хүмүүсийг заавал сонгогчдод хүрэлгүйгээр нам нь өөрөө хариуцлага тооцож чаддаг ийм тогтолцоо руу орвол намын төлөвшилд маш том алхам болно гэж би боддог. Энэ дээр юу тус болох вэ гэхээр нөгөө жагсаалт. Дараагийн хүнээ оруулах боломжууд. Буруу хүн дэвшүүлсэн байвал дараа нь өөрснөө нийгмийн дотор эзлэх орон зайгүй болох тухай асуудал гээд олон зүйлийг бодож байж зөв хүмүүсээ сонгодог ийм л тогтолцоо руу, ийм л төлөвшил рүү чирэх ёстой юм байгаа юм. Энэтэй уялдуулаад тэр дахин дахин бид нарын яриад байгаа энэ хуулиуд багцаараа ганцхан сонгуулийн тогтолцоогоо өөрчлөөд, хүний тоо яриад ингээд дуусчих учир байхгүй.

Намын хууль, тэр дотор намын санхүүжилттэй холбоотой асуудлууд, сонгуулийн хууль эд нар багцаараа хамт хоорондоо уялдаатай байж байж бид нарын яриад хүсээд байгаа энэ өөрчлөлтүүд ирнэ. Түүнээс мэдээж Үндсэн хуульд одоо ярьж байгаа нэмэлт, өөрчлөлт орчхоод маргаашаас нь эхлээд амьдрал сайжирчихна гэж байхгүй. Цаг хугацаа шаардана. Өнөөдөр нийгэм дотор үйл ажиллагаа явуулж байгаа намууд маань ямархуу байгаа билээ. Тэд нар төлөвших хэрэгтэй. Тэд нар бид урьдынх шигээ байвал болохгүй байна гэдгийг ойлгож эхэлж байгаа гэж би бол найдаж байгаа. Аль болохоор зөв, хариуцлагатай, сахилгатай байж чадах, олон нийтийн итгэлийг хүлээж чадах тийм хүмүүсээ дэвшүүлж байж нам сонгуульд ялна. Тэгэхгүй дараа нь орон зайгүй болно. Ийм утгаар энэ олон намууд бүгдээрээ Монголд 30 гаруй нам байж байгаа. Дийлэнх нь энэ асуудлыг дэмжээд явж байгаагийн цаана 2, 3 удаа 2 ч удаа тунхаг хамтарсан гаргалаа. Олон удаа цуглаж

ярилаа. Бүгдээрээ энийг ойлгож, энэ нийгмийн шинэ шаардлагад нийцсэн улс төрийн хүчнүүд байна гэж бодож энд оролцож байгаа л гэж найдаж байгаа.

Тэгэхээр энэ холимог тогтолцоог оруулснаар тиймэрхүү намуудын төлөвшил Би түрүүн бас Анужин гишүүн асуусан болохоор нь энэ талаар нь бодож давхар хэлж байгаа юм. Намуудын төлөвшилд холимог тогтолцоо чухал үүрэг гүйцэтгэнэ. Тэрийг анзаарахгүйгээр цаашдаа намууд үйл ажиллагаа явуулбал өөрснөө л орон зайгүй болно. Хэзээнээс эхлэх вэ гэдгийг нь цаг хугацаа харуулах байх. Алдаж, онох л биз. Гэхдээ урт хугацаандаа бол энэ заавал үр дүнгээ өгнө гэсэн байдлаар хандаж ажлын хэсэг дээр, Байнгын хороон дээр энэ асуудлуудыг ярьж ийм санал оруулж байгаа юм аа л гэж хэлье дээ.

Г.Занданшатар: Ням-Осорын Учрал гишүүн тодруулж асууна.

Н.Учрал: Залуучууддаа тэр дундаа мэдээлэл технологийн салбарынхантай уулзсан. Надад нэг зүйл хэлж байгаа юм. Ах нар амьд ертөнцийг эзэлчихсэн. Юу ч үлдээгүй юм байна лээ. Өнгөрсөн 30 жил. Бид нарт ядаж виртуал ертөнцийг үлдээчхээч гэж байгаа юм. Бид нар тэр ертөнцдөө ажиллаж амьдаръя, ядаж гэж байгаа юм. Тэгэхээр Их Хурал дээр тэр Инновац, цахим бодлогын байнгын хороо гэдэг Байнгын хороо 2024 онд мэргэжлийн инженер, мэдээллийн технологийн салбарын төлөөлөл болсон Их Хурлын гишүүдээс бүрдээсэй гэж би чин сэтгэлээсээ хүсэж байгаа юм. Тэгэхээр улс төрийн намуудаас тэр дундаа парламентад суудалтай намуудын дарга нар аа Сонгуулийн хууль дээр ширлэхгүй шүү. Тэгэхээр энд ажлын хэсгийнхэн байгаа. Энэ дандаа залуучууд байна. Манай шилдэг залуучууд. Та нар ажлын хэсэгт бас дахиад ажиллах байх. Тэгэхээр ажлын хэсгийнхэн хариулаач ээ. Сонгуулийн хуулийн үеэр шилжүүлэхгүй шүү. Би инженер байна гээд гарч ирдэг

улс төрчдийг *NO* шүү. Тэрийг сайн хэлээрэй. Тэр нийгмийн бүлгүүдийг оруулж ирэхгүй бол энэ өөрчлөлт чинь үр дүнд хүрэхгүй шүү. Тэгэхээр энэ холимог тогтолцоо бол бидний хамгийн том зорилго бол тэр гадаадад байгаа монголчуудын төлөөллийг, тэр багш нарын, эмч нарын, тэр технологийн инженерүүдийн, салбар бүрийн төлөөллийг оруулах гэж энэ хуулийг хийсэн болохоос биш 50 хүнд Их Хурлын гишүүний албан тушаалыг өгөх гэж 126 болгоогүй гэдгийг үргэлж санаж явах ёстой.

Тийм учраас манай ажлын хэсэгт байгаа хүмүүс бүгдээрээ залуучууд та нар хэлээрэй. Би энэ Их Хурлын гишүүдээс бүр шаардана. Сонгуулийн хууль дээр хатуу байна шүү. Тэгэхгүй Үндсэн хууль хийчхээд, одоо Үндсэн хууль болчихсон юм чинь яах вэ дээ гээд 50 хүнийг Их Хурлын гишүүн болгож өгөх гэж байгаа тогтолцооны өөрчлөлт энэ ерөөсөө биш шүү. Тийм учраас ажлын хэсгээс хариулт авмаар байна.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд гишүүн .

Н.Энхболд: Дараа нь тэгээд ажлын хэсгийн залуучууд тэрэнд нь хариулна биз ээ. Нэг юмыг бид нар ойлгох хэрэгтэй. Одоо бид нар яг хуулиар зохицуулж чадах юм юу вэ гэхээр квотын асуудал байгаа. Нэр дэвших үед нь. Гэтэл яг сонгох нь бол сонгогчдын эрх байгаа. Чи заавал үүний төлөө заавал энэ мэргэжлийн төлөө саналаа өг гэж шаардах ийм бололцоо байхгүй. Яаж тэр хүмүүсээ оролцуулах вэ гэхээр зөв л хүмүүсээ сонгож зөв жагсаалт л намд гарах ёстой. Одоо яриад байгаа бүх төлөөллийг болж өгвөл багтаасан. Тэгж байж тэр жагсаалтаараа санал авч байж, яг бид нарын энэ хүсээд байгаа мэргэжил, мэргэжлийн төлөөллүүд, үеийнхний төлөөлөл, нийгмийн бүлгүүдийн төлөөлөл орно. Энийг хийдэг аргууд бас байна. Жишээ нь бас хуулиасаа

эхлэхэд Сонгуулийн хуулиасаа
эхлэхэд.../минут дуусав/

Г.Занданшатар: Уг нь Байнгын хороо хариулах ёстой. Тэгэхдээ ажлын хэсэг Сайнзориг дарга бас сонгуулийн ажлын хэсэгт байгаа биз дээ. 87. Пүрэвжавын Сайнзориг.

П.Сайнзориг: Учрал гишүүний асуултад хариулъя. Тэгээд сая бараг Нямаагийн Энхболд дарга бараг хариулчихлаа. Мэдээж Үндсэн хууль дээр бас детальчлах асуудал нарийвчлан зохицуулах боломжгүй. Бид хэд бас гол концепцын суурь зохицуулалтаа хийгээд, энийгээ бас Сонгуулийн хуулиараа нарийвчлан зохицуулах, сая Нямаагийн Энхболд дарга хэллээ. Сонгуулийн хууль дээр бас бүлгүүдийн болоод хүн амын үе үеийн төлөөлөл гэдэг юм уу, тодорхой бас бүлгүүдийн төлөөллийг оролцуулах. Энэ өөрөө эргээд том бас улс төрийн соёл болж цаашидаа төлөвших байх. Улс төрийн намуудын төлөвшилд бас нөлөөлөх байх. Дээрээс нь зүгээр Засгийн газраас Сонгуулийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бас нэр бүхий гишүүдийн санаачилсан төсөлд саналаа өгөхдөө жендерийн эрх тэгш байдлыг бас хангах чиглэлдээ бас анхаараач гэдэг саналаа бас өгчихсөн байгаа. Тэгэхээр ерөнхийдөө бас энэ удаагийн Сонгуулийн хууль бас таны ярьж байгаа шиг бас нийгмийн олон талын бүлгүүдийн төлөөлөл оролцох, энэ хууль тогтоох үйл ажиллагаанд оролцох, энд дуу хоолойгоо хүргэх.../минут дуусав/

Г.Занданшатар: Энэ Сонгуулийн хууль, Улс төрийн намын тухай хуулиараа зохицчихно л доо. Улс төрийн намын бас дотоод ардчилал, нэр дэвшүүлэх процесс, нэр дэвшүүлэх хороо энэ тэртэй олон улсын жишиг бол улс төрийн нам жинхэнэ ард түмэн, дотоод ардчилалтай тэр мэргэжил сонирхлын бүлгүүд үзэл бодлын төлөөлөл болгох хэрэгтэй юм байна лээ. Дашидондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Энэ чинь Үндсэн хуулийн хэлэлцүүлэг ингээд 2 дахь хэлэлцүүлэг нь явагдаж байна гэж ойлгож байна. Үндсэн хуулийг өөрчлөхийн тулд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа бол ийм олон хэлэлцүүлэг дамждаг юм байна. Бүүр 4 хэлэлцүүлэг хийдэг юм байна. Тэгээд эхний хэлэлцүүлэг нь дөнгөж явж байхад л энэ Засгийн газар өөрийнхөө өргөн барьсан Үндсэн хуулийнхаа нэмэлт, өөрчлөлтийн төслийг 126 болгохыг нь зөвшөөрөөд байгаа юм уу. 156 гэдэг ямар үндэслэлтэй тоо вэ гэж би асууж байсан. 50, 50 ямар учраас ийм байх юм бэ гэж асууж байсан. Тухайн үед нь тэгсэн гэсэн гээд л займчуулаад л өнгөрсөн. Тэгээд Засгийн газар бас энэ өргөн барьсан төслийнхөө ач холбогдлыг нийт ард иргэдэд очиж тайлбарламаар байгаа байхгүй юу. Тэгэхээр эндээс юу урган гарах вэ гэвэл энэ Засгийн газарт чинь ард түмэн ч итгэхгүй байна. Энэ Улсын Их Хурал ч итгэхгүй байна л гэсэн үг. Тэгж л хариулж байна гэж ойлгох хэрэгтэй.

Нөгөө талаар бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэд хэдэн удаа хийсэн. 2019 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг яг Үндсэн хуулийнхаа дагуу хийсэн байх гэж бодож байна. 2022 онд 8 сард хүмүүсийн амралтын цагаар, анхаарал суларчихсан үед Үндсэн хуулийг хулгайлсан. Үндсэн хуулийн цэц гээд манаач нь байдаг. Тэр 4-өөс илүүгүй гишүүн давхар дээлтэй байж болно гэсэн энэ заалтыг 4 гэсэн тоог хэн авсан бэ. Хэн өөрчлөлт оруулсан юм тэрийг. Тэрийг энэ Үндсэн хуулийн юуг ажлын хэсэг гээд байгаа энэ хүмүүс надад тайлбарлаад өг дөө. Хэн тэрийг тогтоосон юм. Хуулийг тогтоосон юм. Би бол Үндсэн хуулийг бол засаглал хуваах зарчим гэж үзэж байгаа. Эрх мэдлийг хуваарилж байгаа зарчим, эрх мэдлийг хуваарилсан гол зүйл бол тэнд л байна. Энэ бол харилцан хяналттай хууль тогтоох, гүйцэтгэх засаглал, шүүх засаглал байх ёстой гэж үзэж байгаа юм. Тэгээд өнөөдөр энэ засаглалууд чинь бие биедээ харилцан хяналт тавьж чадаж

байна уу. Энэ Засгийн газарт хяналт тавьж үнэхээр чадахгүй байна шүү дээ.

Тэгээд манай иргэд сая явж байхад хэлж байна лээ. Яасан айдаггүй, яасан ичдэггүй хүмүүс вэ гэж байна лээ шүү дээ. Үгүй ээ, энэ ард түмэн чинь эмнэлэгт ингээд л очерлоод л, ор олдохгүй, хавдар нь дийлдэхгүй ийм хүнд хэцүү байхад л энэ Засгийн газрын сайдууд чинь Японд биеэ үзүүлээд л явж байна шүү дээ. Сумо үзээд л. Тэгээд энэ хууль хяналтын байгууллагаа хар л даа. Өнөөдөр бүлэглэлүүдийн гарт орчихсон. Би Увсын ард түмэн бол маш ажилсаг сайхан ард түмэн гэж боддог. Хэдэн үе шат дараалаад Увсынхан атгаж байсан. Одоо тэр үгээ хэлж, үзэл бодлоо илэрхийлсний төлөө Баянхонгорын Мөнх-Эрдэнэ шоронд л байна шүү дээ. Одоо бас миний амыг хаах гээд байгаа юм уу, яах гээд байгаа юм бас дуудаад байгаа. Би чинь Улсын Их Хурлын гишүүн хүн.

Улсын Их Хурлын гишүүн хэлсэн үгэндээ хариуцлага хүлээдэггүй. Тийм ч байх ёстой. Чөлөөтэй хэлж ярьж байх ёстой ард түмний үгийг. Хаана тэнд юу ярина, үүний дуу хоолой нь болж байх ёстой. Бид нарт л итгэж л юмаа ярьж байна шүү дээ. Энэ Занданшатар гишүүн, Адьяасүрэн гишүүн бид 3-ыг очиход бол үгүй ээ, 40, 50-уулаа ингээд л очерлож байгаад л хэлж байна лээ шүү дээ. Тэгээд хар л даа өнөөдөр цагдаа нар ямар байна. Тэр Өвөрхангайд цагдаад байцаагдаж байсан хүн, 15 настай охин амиа хорлосон байна шүү дээ. Хэрэв тэр хүнийг байцааж байгаа бол хамгаалалтад байх ёстой шүү дээ. Ийм л цагдаатай байна. Энэ шүүхийг хар. Тэр Үндсэн хууль чинь өөрөө биелэгдэж байгаа юм уу. Биелэгддэг үү. Тухайлбал бид нар чинь дайны эсрэг ийм хуультай. Дайныг дэмжихгүй байх ёстой. Тэр дайныг эсэргүүцээд, үгээ хэлээд, үзэл бодлоо илэрхийлж байгаа энэ залуучуудыг тэрний хүчинд манайд гуравдагч орны тэргүүнүүд айлчилж байна шүү дээ. Та нар зөв замаар яваач ээ, яваад өгөөч ээ энэ залуучууд чинь хүсээд байна. Зөв байна

гээд. Гэтэл ямар байна. Үгүй ээ, тэр эрүүгийн рецетив гэмт хэрэгтнүүдээр дарамтлуулаад л, үгүй ээ яагаад ийм байгаа юм. Яагаад гэвэл харилцан хяналттай засаглал байхгүй болчихоод байгаа байхгүй юу. Одоо хар л даа. Тэр ЖДҮ авсан хүмүүсийн тал нь буцаад л ороод ирчихсэн байгаа шүү дээ энэ Улсын Их Хуралд.

Тэр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 2022 оны 8 сард хийхдээ бол манай Жангийн хэдэн нөхдүүд хамаг юмаа худалдаж байгаад л хийсэн шүү дээ. Ер нь энд нам гэж байгаа юм уу энэ улс оронд чинь. Энэ намууд чинь бүгдээрээ бүлэглэлүүдийн гарт орчихсон байна гэж би үзэж байна. Хэн намын дарга, хэн юу байхыг тэнд л тогтоож байна шүү дээ. Шүүх бол ерөөсөө гар хурууны үзүүрээр хөдөлж байна. Энэ эрх барьж байгаа хүмүүсийн. Энэ хүмүүсийн амьдрал ямар их ядуу байна вэ. Энэ өөрчлөгдөх үү. Энэ намууд чинь яагаад төлөвшихгүй байна вэ. Энэ бүгдийг очоод тайлбарлаад өгөх хэрэгтэй шүү дээ та нар. Үгүй ээ тэгээд л одоо аль ч учраа ойлгодог ч юм уу, ойлгодоггүй ч юм уу. Тэр охин намын хэдэн нөхөд л өдөр, шөнөгүй л зурагтаар л гараад л, олон юм яриад байх юм. Үндэслэлтэй тайлбар хэлж байгаа юм нэг ч алга байна шүү дээ. Үзээд хараад байхад. Зүгээр л хүмүүсийн тархийг угаах, толгойг угаах ийм л юм болж байна шүү дээ.

Энэ Оросын ард түмэн гэж ямар сайхан ард түмэн байлаа. Одоо тархиа угаалгаад ямар болчихсон байна. Хэдэн жилээр хөгжлөөсөө хоцорч байна шүү дээ. Тэгэхэд манай улс орон чинь ямар билээ дээ. 2, 3 мянган жилийн төрийн тогтолцоотой, түүхтэй. Тэгэхэд энэ хэдэн стануудаас доор байна шүү дээ бид нар. 200 мянган хүн гадаадад амь амьдралаа авч явах гээд чадалтай, чадвартай хүмүүс нь гадагшаа гараад явчихсан байна. Тэр хүмүүст санал өгөх боломж нь байхгүй байна. Тэгээд энэ үндэслэлүүдээ. Одоо яагаад 126 юм.

Яагаад 50 юм. Яагаад 76 юм. Өмнө 156 байхдаа 50, 50 байсан нь ямар учиртай юм. Тэрийг та нар тайлбарлаад өг л дөө. Би бол бүгдийг нь л мэдэж байна. Тэгээд л нэг айхгүй, ичихгүй болсон хэдэн зомби компаниуд бүгд л Хөгжлийн банкнаас хулгай хийсэн байна лээ. Нэг сүрхий, сүрхий компаниуд гээд байсан тэр нь.../минут дуусав/

Г.Занданишатар: Жигжидийн Батжаргал гишүүн. Та чинь ер нь үзэл бодлоо илэрхийлчхээж байгаа юм биш үү. Юу асуусан бэ. Нямаагийн Энхболд дарга хариулах уу. Цөөнхөд хүндэтгэлтэй хандаж бүх юмыг нь яриулж байгаа шүү дээ. Түүнээс яг Үндсэн хуулийн өөрчлөлттэйгөө уг нь холбогдолтой л юм яривал сайн байна.

2022 онд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаагүй л дээ.

Н.Энхболд: Тэгээд би өнөөдөр өчигдөр, уржигдар болсон ажлын хэсгийн хуралдааны дүнгийн талаар Байнгын хорооны хуралдааны дүнгийн талаар л хариултууд өгч байгаа. Урьд өмнөх юмтай тэр тусгайлан ярих сэдэв байх гэж бодож байна Ганбаа гишүүн ээ.

Г.Занданишатар: Дашдондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Үгүй ээ, үгүй. Энэ ардчилал гэдэг чинь бол алдаагаа засдаг л ийм л тогтолцоо л доо. Тэгээд өмнө нь баахан алдаа гаргачихсан. Энэ юмаа тайлбарлаад, ийм ийм учиртай юм шүү гэж хэлээд, ингэж ард түмнийг гэгээрүүлэх хэрэгтэй байна шүү дээ. Тэгэхгүй бол манай ард түмэн чинь халамж авсаар байгаад л Гандангийн тагтаа шиг болчихсон байна шүү дээ. Энэ юмнуудыг чинь байхгүй болгох юм. Эрх чөлөөгөө тэгээд юугаар л бол юугаар зарчих ийм хэмжээнд очсон байна шүү дээ. Тэр Үндсэн хуулийн цэцийнхэн ямар байна тэ. Хүссэн өөрчлөлтийг нь л хийж өгдөг шүү дээ. Энд ч гэсэн тэр ЖДҮ

авчихсан нөхөд, бүгд л хулгай хийсэн хүмүүс. Тэр том, том компаниуд гээд байгаа. Тэд нар нь бүгдээрээ л тэр татвар төлөгчдийн мөнгөөр байгуулсан банкийг авчихсан байна лээ шүү дээ. Тэгээд ийм юмнууд чинь өөрчлөгдөх юм уу, яах юм. Энэ өөрчлөлт орсноор.

Г.Занданишатар: Нямаагийн Энхболд дарга. Сайжрах юм уу, ямар үр дүн гарах юм бэ л гээд байна.

Н.Энхболд: Үндсэн хуульд оруулж байгаа өөрчлөлт бол би түрүүн дахин дахин хэлээд байгаа. Энэ өөрчлөлт Намын тухай хууль, Сонгуулийн хууль энэ бүгд цогцоороо нийлж байгаад л өнөөдөр нийгэмд тулгараад байгаа, түүний дотор Ганбат гишүүний асуугаад байгаа энэ хулгай зэлгийг багасгах энэ юманд тодорхой хэмжээгээр үр дүнгээ өгнө гэж л бодож тооцож байгаа. Түрүүн гишүүд асууж байна. Яг яаж өгөх гээд байгаа юм бэ гээд. Би зүгээр нэг л жишээн дээр бас тайлбарлах гэж оролдсон л доо. Их Хурлын гишүүдийн тоо цөөхөн болохоор нэг Их Хурлын гишүүнд ноогдох эрх мэдэл, нөлөө нь их болчихоод байгаа юм. Энэ ойлгомжтой. Тэгээд нөгөө нөлөөтэй, эрх мэдэлтэй хүн чинь тэрийгээ буруу ашиглаад, тэр нь яг тодорхой яривал таны хэлсэн шиг тийм хулгай, хээл хахууль энэ юм руу тэмүүлэхэд нь тэдэнд нь бас хүчин зүйл болоод байгаа байхгүй юу. Түрүүн би бас нэг жишээ хэлсэн. Та түрүүн сонсоогүй байгаа байх. Энэ олон улсын парламентуудын дунд хийсэн судалгаагаар үзэхэд парламентын нэг гишүүнд ноогдож байгаа эрх мэдэл 1-ээс дээш хувь байхаар тэнд гарцаа байхгүй янз бүрийн ийм буруу булхай, эрх мэдлээ ашиглах, ашиг сонирхлын зөрчилд орох юм нь илүү байна гэдгийг нь судалгаагаар тогтоочихсон юм байдаг юм байна лээ. 1-ээс доош орохоороо тэр нь харьцангуй өчнөөн бага байна, төчнөөн бага байдаг ийм судалгаанууд байдаг юм байна лээ. Жишээ нь манайх ямар олон 100 гишүүнтэй болж чадах биш. Гэхдээ л жишээ нь Засгийн газраас оруулж

ирснээс 2 дахин их гишүүнтэй болчихсон байхад, дор хаяж тэр нөлөө нь нөгөө нөлөөгөөрөө хуулиа зөрчих.../минут дуусав/

Г.Занданиатар: *Байхгүй ээ. Жигжсидийн Батжаргал гишүүн.*

Ж.Батжаргал: *Баярлалаа. Тэгэхээр Үндсэн хуулийн өөрчлөлтийн төслөө иргэд олон түмэндээ танилцуулаад, өөрчлөх гээд байгаагийн учир шалтгааныг танилцуулаад, харилцан ярилцаад ингээд ажиллаад ирсэн. Мэдээж бид нар энэ 30 жилийнхээ үйл явцад нэг томоохон дүгнэлт хийгээд, бодлогын чиглэл дээрээ нэлээн том өөрчлөлт хийсэн. Тэгвэл энэ бодлогын чиглэлийг хангаж авч явах тогтолцоо талдаа бас анхаарах ёстой, шийдэх ёстой зүйлүүд байна. Үүнийгээ шийдэх ёстой гэдэг энэ байр суурь талаасаа нэлээн асуудалд хандсан. Тэгэхээр пропорциональ гэдэг юм уу, мажоритар энэ 2 систем хоёулаа давуу хийгээд сул талтай. Гэхдээ нэгнийх нь давуу тал нөгөөгийнхөө сул талыг нөхөж байгаа. Тийм учраас байж болох хамгийн бага хийдэлтэй тийм тогтолцоо байж болох юм байна гэж иргэд, олон түмэн бол энэ талаас нь хараад байгаа юм байна лээ. Гэхдээ үүнийг бид шинээр, анх удаагаа хэрэглэж байгаа зүйл биш. Бас тодорхой хэрэглэж үзсэн. Гэхдээ хэрэглэхдээ бид нар энэ 2-ыг хослуулж авч явахдаа харилцан тэнцлийн балансыг нь олж харалгүй хэрэглэснээс хамаараад, үүний утга учрыг бас төдийлөн хүртээж гэдэг юм уу, мэдрүүлж чадаагүй хүмүүс. Тийм учраас одоо бид иргэд олон түмэн дээр дахиад очихдоо 60/40-ийн учир шалтгаан, 152-ыг 126 болгосны учир шалтгааныг их тодорхой, шинжлэх ухааны үндэслэлтэй, бас энэ ирээдүйд хүлээгдэж байгаа засаглалын чадамж талдаа тусгалыг нь олж ярих ёстой. Үүний чинь үр өгөөж юунд байгаа юм бэ гэдэг. Энэ тал дээр би ажлын хэсгийг нэлээн тийм бодитой хариулт өгчих болов уу гэж бодоод байна.*

2 дахь зүйл. Үндсэн хуульд нэг айхтар заалт байгаа юм. Засгийн бүх эрх ард түмний мэдэлд байх тухай. Үүнийгээ өөрөө шууд буюу сонгож байгуулсан эрх барих төлөөллийн байгууллагаараа дамжуулж эдэлнэ гэж. Сая Үндсэн хуулийн өөрчлөлтийг ард түмнээр очиж хэлэлцүүлэх үйл явцад Их Хурал хандсан хандлага ч ерөөсөө гол шалтгаан нь үүн дээр байсан. Үнэхээрийн энэ улс орны амьдралыг зохицуулж байгаа эх хууль нь юм бол энэ хуулийг ард түмнээр хэлэлцүүлбэ. 2 дугаарт тэр засгийн эрх ард түмний мэдэлд байх энэ зарчмыг цаашид улам төгөлдөржүүлж хангах ёстой юм байна. Ингэхийн тулд санал гээгдээд байгаа энэ үйл явцыг арилгах шинэ тогтолцоог бүрдүүлэх асуудлыг нь шийдэх нь зөв юм байна. 40 хэдэн хувийн ард түмний санал авчхаад 82 хувийн суудал эзлээд, сууж байгаа үйл явц угаасаа биш юм байна. Тэгвэл тэр гээгдээд байгаа 50 хэдэн хувийнх нь төлөөлөл ямарваа нэгэн байдлаар орж ирж эндээ юмаа ярьж чаддаг тийм сонгуулийн тогтолцоо, эрх зүйн орчныг нь бүрдүүлж өгөх ёстой юм байна гэж ингэж үзсэн.

Тийм учраас би энэ талаас нь харж дэмжсэн гэж. Ард түмэн юуг биднээс шаардаад байгаа вэ гэхээр зэрэг наад ярьж байгаа зүйл чинь үнэхээрийн бас боломжтой зүйл яригдаад байна. Үүнийг энэ Үндсэн хуулийн өөрчлөлт батлагдаж, ёсчлогдсон цагаас эхлээд дагуулж өөрчлөлт оруулах тэр хууль, эрх зүйн зохицуулалтуудынхаа жагсаалт юмнуудыг гаргаж цаг алдалгүй хийх ёстой. Наад нийгмийн бүлэг, давхруудын төлөөллийг хангая гээд байна. Наад намын жагсаалтаар гэдэг юм уу ерөөсөө Их Хуралд нэр дэвшиж байгаа хүмүүсийнхээ босго шаардлагыг дээшлүүлэх ёстой юм. Жгсаалтаа ил тод болгох ёстой юм. Эдгээр асуудлууд тэр Улс төрийн намын тухай хуульд чинь, Сонгуулийн тухай хуульд чинь бүр тов тодорхой коэффициентэлж орох шаардлагатай байна. Ингэж байж

бидний асуудал баталгаатай ярьж, хэлж байгаа зүйлүүд хангагдах учиртай. Тэгж байж та нарын яриад байгаа ирээдүйн тэр сайжралтын чинь асуудлууд хийгдэх бололцоо, боломж нь хангагдана гэдэг ийм зүйл яриад байгаа юм.

Тийм учраас одоо эндээс харин энэ өнөөдрийн чуулганы хуралдааны тэмдэглэлд оруулъя. Их Хурал ер нь цаашид энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийн үзэл санааг дагаж хийх ёстой эрх зүйн өөрчлөлтүүдээрээ баталгаатай баталгаажуулна гэдэг тэр баталгаага гаргах ёстой. Тийм учраас би бараг өнөөдрийн энэ хэлэлцүүлэгт бэлтгэх тэр тогтоол дотор энэ чиглэлийн юмнууд эд нарыг яаж судалж, яаж оруулах юм гэдэг юмыг бас томъёоллоор нь тусгаж оруулах нь зүйтэй болов уу гэсэн ийм бодол байгаад байна. Энэ үеэр иргэд, олон түмнээс яригдсан асуудал бол аж амьдралын асуудал байсан. Үүнийг ирээд тов тодорхой бүлэг дээрээ ярьж нэгтгээд, холбогдох газрууддаа чиглэл өгч, энэ чиглэлээр хийгдэж байгаа судалгаа тооцооных нь асуудлуудыг тодорхой тойм, томсгосон тооцоотой мэдээллүүдийг авсан. Энэ асуудлуудыг нь ч гэсэн бид цаг алдалгүй цааш нь бодитой шийдэл болгож гаргаж энэ улс орны эдийн засаг, иргэдийн аж амьдралыг өөд татах асуудал дээр бас ойрын хугацаанд тов тодорхой шийдвэр гаргах ёстой. Энийг ч гэсэн бид ер нь өнөөдөр тов тодорхой урьдчилсан байдлаар шийдэл юмнуудаа дуугарах ёстой гэж ингэж ойлгож байна. Энэ дээр бас ямар байр суурь байгаад байгаа юм бэ. Ийм 2, 3 зүйл дээр тайлбар хариултыг нь авъя.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд дарга, Байнгын хорооны дарга хариулъя.

Н.Энхболд: Засгийн газраас ирүүлсэн Үндсэн хуулийн өөрчлөлтийн төслийн үзэл баримтлал бүхэлдээ сая Батжаргал гишүүний хэлсэн энэ эерэг өөрчлөлтүүдийг авчрахад чиглэсэн тийм

өөрчлөлтүүдийг хийх эрх зүйн суурийг тавьсан ийм үзэл баримтлал болсон гэж үзэж Байнгын хороод, ажлын хэсэг тэр дотор Төрийн байгуулалтын байнгын хороо хандаж ажилласан. Санал бол нэг байна гэдгийг хэлье. Эхлээд. Тогтоолд оруулах зүйлүүдийн хувьд бид нар ярьж байгаад Байнгын хорооноос тогтоолын төсөл оруулж ирж байгаа. Тэгээд гишүүд ярьж байгаад Үндсэн хуулийн өөрчлөлтийн сэдвийн хажуугаар өөр ийм ийм зүйлүүдийг бас хамт энэ хугацаанд хийх ёстой. Судалгаа, санал авахдаа сонсох ёстой гэсэн ийм зүйлүүдийг оруулах шаардлагатай байна гэж үзвэл тэр нээлттэй байж байгаа. Гишүүд тодорхой санал гаргавал тогтоолыг хэлэлцэх явцдаа бид нар тэмдэглэж аваад, тогтоолдоо тусгаад хэлэлцүүлээд явах боломж байгаа л гэж харж байна.

Г.Занданшатар: Баярлалаа. Түрүүн Ганбаатар гишүүн ч хэлээд байсан. Тэр үндсэн хуулийн 3.1 засгийн бүх эрх мэдэл ард түмний мэдэлд байна гэдэг бол ардчилсан Үндсэн хуулиуд бол засгийн бүх эрх мэдэл ард түмнээс эх сурвалжтай байна гэсэн агуулгаар ойлгуулсан. Тэгээд шууд бүгдийг дандаа мэдэлд байна гээд нөгөө ард нийтийн санал асуулгаар ч юм уу шийдээд байна гэсэн агуулга биш. Төрийн бүх эрх мэдэл ард түмнээс эх сурвалжтай байна. Суурь нь ард түмэн, сонгууль гэсэн агуулгатай гэж Үндсэн хуулийн тайлбарт бичсэн байна. Тэгж ойлгохгүй бол бүгд ард нийтийн санал асуулгаар явах юм шиг ойлгогдоод байна. Дамдины Цогтбаатар гишүүн.

Д.Цогтбаатар: Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгэхээр сая тойргоороо явж Сүхбаатар дүүргийнхээ бүх 20 хороо дээр явж ажилласан. Иргэдийнхээ санаа бодлыг сонсож ажиллалаа. Тэгэхээр 1 зүйлийг энэ дээр аягүй тодорхой бид нар яримаар байна. Манай лав сонгогчид их тодорхой хэлж байна. Юун 152 вэ. 152 гэдэг ийм тоо байхгүй шүү гишүүн минь энийг очиж хэлж өгөөрэй гэдгийг хэлж байгаа юм.

Тэгээд үнэхээр ингээд иргэдийн очоод уулзаад ярьж байхад тэтгэвэр тэтгэмж нь хүрэхгүй, инфляц маш өндөр хувь хэмжээтэй, үнийн өсөлт тийм учраас маш өндөр. Хүмүүсийн амьдрал үнэхээр амаргүй байна. Тэгээд ийм амаргүй байхад иргэд бол тэтгэвэр тэтгэмж, цалингаа нэмүүлье гэж ярьж байгаа. Гэхдээ цалингаа нэмүүлье гэж ярихдаа иргэд 100 хувь нэмээд өгөөч, 2 дахин нугалаад нэмээд өгөөч гэж ярихгүй байгаа шүү дээ. Тэгсэн Улсын Их Хурлын гишүүд очсоноо орон тоогоо 2 дахин нэмье, 100 хувь нэмье, нэг удаагийн үйлдлээр 100 хувь нэмье гэж яриад ирж байна. Юу яриад байгаа юм бэ гэдэг асуудал ярьж байна шүү дээ. Иргэд ёс суртахуунтай байна. Биднээс ёс суртахуун шаардаж байна. Тэгээд нэгэнт галт тэрэг хөдөлсөн бол тэр 152 чинь байхгүй шүү. Нэгэнт галт тэрэг хөдлөөд бүх намууд энэ дээр ойлголцоод, тэр тоогоо нэмнэ гээд явж байгаа юм бол ямартай ч гэсэн 152 байхгүй. Тэрнээсээ тэгэхээр ёстой ханатал нь яаж буулгаж болох вэ энэ дээрээ л та нар анхаарч ажиллаарай гэдэг хатуу захиасыг иргэд өгч байна.

Пропорционалийн асуудал дээр бас яг тэгж байгаа юм. Пропорциональ сонгуулийн тогтолцооны асуудал дээр. 50, 50 гэж байхгүй шүү гэдэг асуудлыг бол маш хатуу, маш ойлгомжтой ярьж байна лээ. Тэгээд улс төрчид очихоороо нийгмийн ийм бүлэглэл багтахгүй байна, орохгүй байна, ийм бүлэглэлийг оруулах ёстой гээд яриад байгаа юм. Тэгсэн сонгогчид өөдөөс хэлж байгаа юм. Үгүй ээ, тэд нарын чинь орох, орохгүйг та нар биш бид нар сонгуулиараа шийддэг юм. Бид сонгоно. Байр байраа мэдэцгээе гэдэг асуудал ярьж байгаа байхгүй юу. Өөрөөр хэлбэл ингээж хэлж байгаа юм. Тэр тооно, хаалга, оймсныхоо ангийнхныг цөөлөөрэй гээд тэгж байгаа юм. Ард иргэд чинь аль хэдийн тэнд хэлц үг, нэр томьёо оноод, олоод хэлчихсэн байж байна. Тэр яагаад тооно, хаалганы асуудал гараад байгаа гэхээр яг ард түмэн ингээж хэлж байгаа байхгүй юу. Зөндөө олон удаа тэр янз

бүрийн улс төрчид чинь бас орж ирж байсан. Орж ирээд итгэл хүлээхүйцийг нь өөр намын зөндөө л улсуудыг орж ирэхэд бие даагч байсан ч гэсэн бид нар итгээд оруулж байсан. Зөндөөг нь бидний шалгуурыг даваагүй, оруулаагүй. Бид нар тэр олонхынхоо саналыг өгөлгүйгээр зөндөөг нь оруулаагүй байхгүй юу. Тэрийг чинь бид шийдсэн юм. Та нар шийддэг юм биш гэдэг энэ асуудлыг ярьж байгаа юм.

Тийм учраас хаалгаар хөөгөөд гаргасан хүмүүсийг та нар тооноор оруулж ирэх гэж байгаа юм уу. Яасан их сонгодоггүй юм тэгвэл ингээд сонгуулна гэж оруулах гээд байгаа юм уу гээд аль хэдийн тэр тооно, хаалга, оймсны ангийнхан гээд нэрлэчихсэн явж байна шүү дээ. Тэгэхлээр энэ дээр бас энэ 50, 50 гэж байхгүй шүү. Хэрэв тэр ахиад галт тэрэг чинь хөдөлчихсөн байгаа бол энэ харьцаагаа эрс буулгаж өгөөрэй гэдэг асуудал ярьж байгаа юм.

3 асуулт байна. Яг энэнтэй холбогдсон. Төсөв нэмэхгүй байж болно гэдэг яриа яригдаж байна. Энэ бол харин чухал санаа гарч ирж байна. Жинхэнээсээ ингээж төсөв нэмэхгүйгээр явж болж байгаа юм уу. Энэ бодитой, үндэслэлтэй судалгаа хийчхээд яриад байгаа юм уу. Тэгсэн 126 гэдэг тоо яриад байна. Энэ тоо бас яг хаанаас гараад ирэв. Энэнээс бага тоо байж болдоггүй юм уу. Яагаад 125 биш жишээлбэл. Багасгая л гээ л дээ. 123, 122, 110 ч юм уу биш яг 126 юм. Яагаад тэгвэл 127 биш юм. Тэгэхээр энэ тоо хаанаас гарч ирсэн юм. Энийг бас асуумаар байна.

3 дахь нь ингээж байгаа юм хүмүүс. Одоо жагсаалт ярихаар, жагсаалтаар нэг их цэвэрхэн хүмүүс орж ирнэ гээд. Тэр жагсаалт чинь угаалгын машин юм уу. Тэр жагсаалтад орчихоор хүн нь цэвэрхэн болчихдог юм уу. Тэгэхлээр тэр жагсаалтыг оруулж ирэхдээ тэр хариуцлага нь хаанаа байх юм бэ. Хэн хүлээх юм бэ. Тэгээд надаас асуусан. Та энэ жагсаалтаар орж ирж байгаа

хүмүүсээ тийм цэвэрхэн хүн байна гэж та жишээлбэл хариуцаж хэлж чадах уу гэхээр нь би үнэнээ л хэлсэн. Одоо нэр нь тодроогүй байгаа, хэн нь орж ирэх, орж ирэхгүй байгаа хүмүүсийн өмнөөс би яаж хариуцлага хүлээх юм. Би мэдэхгүй гэсэн. Тэгэхээр энэ дээр нэг зүйлийг асуумаар байна. Одоо урьд нь манайх 2 ч удаа жагсаалттай сонгууль явуулж байсан. Өөрөөр хэлбэл жагсаалт гэдэг элемент орсон пропорциональ тогтолцоотой бас сонгууль явуулж байсан. Тэгэхлээр тэр жагсаалтад орж байсан хүмүүс хэрэг төвөгт орж шалгагдаж байгаагүй юм уу. Нээрээ тийм ялгаа байгаа юм уу. Тэр жагсаалтад л орсон бол дандаа тийм цэвэрхэн хүмүүс байсан юм уу. Энэ дээр надаа нэг хариу өгөөч. Баярлалаа.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд дарга.

Н.Энхболд: Төсөв нэмэхгүй байх, нэмэх тухай асуудлаар Засгийн газраас оруулж ирсэн төсөл дээр ч дагалдсан тооцоо байхгүй. Ямар нэгэн албан ёсны тооцоо, судалгаа хийсэн зүйлүүд байхгүй байгаа. Лав ажлын хэсэг дээр, Байнгын хороо дээр тийм тоонууд ирээгүй. Тэгэхээр ер нь зүгээр ерөнхий ойлголт бол аль болохоор хамгийн бага хэмжээнд би зүгээр миний хувийн бодол шүү. Жишээ нь 76 гишүүний, би тойрогтоо хүмүүстэй уулзаж явахдаа ч гэсэн тийм л байр сууриа илэрхийлсэн. Гишүүдийн тоо нэмэгдлээ гэж бодоход жишээ нь, тэр туслах, зөвлөх, бие төлөөлөгч нарын тоог цөөлөөд, тэр нийт зардлаа аль болохоор бага байлгах түвшинд байж болно. Ийм арга хэрэглэж болно. Механик аргууд. Зүгээр огт бүр тас нэмэгдэхгүй байна гэж би лав худлаа хэлж чадахгүй гэдгээ хэлж ирсэн. Үүнийг хүмүүс ойлгож хүлээж авч байна лээ. Тэгээд хэрэв тогтолцооныхоо ажлыг ийм байдалд оруулж байгаа бол энэ тоотой уялдаатай гэдгийг ойлгож байна. Нэгэнт тоо нь хөдлөх нь их, бага хэмжээгээр хөдлөх нь ойлгомжтой бол энэ дээр зардал тодорхой хэмжээгээр нааш цаашаа болно

гэдгийг бас ойлгож байна. Яаж тайлбарлахаасаа л болж байна лээ. Тэгэхээр би энэ дээр яг өнөөдөр сууж байгаад төсөв огт нэмэгдэхгүй гэж хэлж мэдэхгүй байна. Цогтоо гишүүн ээ нэгдүгээрт.

Хоёр дугаарт 126-гийн талаар түрүүн зөндөө олон удаа ярьчихсан. Зөндөө олон удаа ярьсан. Та байгаагүй байсан юм болов уу. 3, 4 удаа харцуулаа. Маш товчхон хэлэхэд Засгийн газраас оруулж ирсэн саналыг бид нар бариад санал авахаар явсан. Иргэдийн дийлэнх нь 152 үгүй ээ гэсэн ийм байр суурьтай байгаа. Хаана ч очсон тийм юм байж байгаа. Нэг анхаарах зүйл юу вэ гэхээр 2 зүйл дээр бол надад бол жишээ нь анхаарагдсан. Би бол гишүүдэд анзаарагдсан учраас Байнгын хороод, ажлын хэсэг дээр байр сууриа тэгж илэрхийлж байсан болов уу гэж бодож байна. Тоог багасгана гэдэг нь ойлгомжтой бүгдэд нь. Тэгээд ирсэн хойно нөгөө орон нутагт байгаа, тойрогт байгаа хүмүүстэй уулзсан.

Шуудангаар бусад харилцах сувгуудаар ирсэн санал онолуудаас тоо бага байх юм бол тэгвэл хэд хавьцаа байж болох вэ гэдгийг янз бүрээр ярьсан. Засгийн газраас оруулж ирэхдээ бол нэлээн судалгаатай олон орны судалгаа, бүр улс төрийн шинжлэх ухаанд хэрэглээд гээд хэлсэн тэр куб язгуурын арга энэ тэр гээд юм нэлээн судалгаатай том тоо гаргаж ирсэн. Тэрийг нэгэнт дэмжихгүй байгаа тохиолдолд тэгвэл яах вэ гэдэг нь энэ хугацаанд бас зөвшилцөл, ойлголцол, бусад нөхцөл байдлуудаа харгалзаж үзэж байгаад нэг тоо тогтоох ийм шаардлага гарч байгаа. Энэ дээр юуны түрүүнд намуудын хэмжээнд ойлголцсон нэг баримжаа авах зүйл бол өнөөдөр байгаа 76 тойргоо хөндөхгүй байх ёстой. Ингэж байж нөгөө орон нутгийн, газар нутгийн төлөөллийг хангана гэсэн ийм зарчим яригдсан. Намууд дээр.

Тэгээд дараа нь тэгвэл нэмвэл гэж үзэж байгаад олон гарч ирсэн саналуудаас дунджаар үзэхэд энэ хавьцаа юм байна гэсэн ийм тоогоор оруулж ирээд л явж байгаа. Үүнийг бол маш нарийн тооцоо, шинжлэх ухааны үндэстэй гаргачихсан, барьчихсан тийм юм байхгүй. Улс төрийн аливаа асуудалд тал талаасаа хэлэлцэж байгаад хамгийн бололцоотой, буулт хийсэн, ойлголцсон, зөвшилцсөн энэ түвшиндээ тогтоодог энэ байдлаар л гарч ирж байгаа тоо гэж ойлгож болно. Миний хувьд бол хувь хүний хувьд бодоход бол энэ боломжийн тоо юм болов уу гэсэн бодолтой, дэмжээд ингээд явж байгаа.

Жагсаалтад байгаа хүмүүсээ хэн хариуцах вэ гэж. Бас би түрүүнд хэд хэдэн удаа хэллээ. Бид нар ганцхан энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийн тухай асуудлыг ярихгүй. Энэтэй хамт Намын тухай хууль, Сонгуулийн тухай хууль гээд хэд хэдэн хуулиудыг зэрэг хооронд нь уялдаа холбоотой баталж байж, сахилга хариуцлагын ажил, ёс зүй, шалгуур, хэн хариуцлага хүлээх юм гэх мэтчилэн олон зүйлийг тусгасан ийм багц хуулиудаар энэ эерэг үр дүн гарах зүг рүүгээ л явах хэрэгтэй гэж бодож байгаа эцсийн дүндээ. Тэгээд тэр намын шийдвэр гаргадаг байгууллагууд хамгийн том үүрэгтэй байх болно. Энэ тохиолдолд. Үүнийг аль хэсгийг нь аль хүртэл хэсгийг нь намуудын тухай хуулиар зохицуулах вэ. Аль хүртэл хэсгийг нь намууд өөрсдөө дотроо зохицуулж байх вэ гэдгийг бид нар ёстой нөгөө Намын тухай хууль, Сонгуулийн тухай хуулийн юман дээрээ тал талаас нь ярьж байж л шийдэх асуудал гэж бодож байгаа. Маш товчхон хэлбэл эцсийн дүндээ хариуцлага хүлээх хүмүүс нь намын удирдлага, ялангуяа саяын өөрийн чинь асуусан асуулттай холбоотой энэ асуудал дээр бол намуудын удирдлага, шийдвэр гаргадаг байгууллагууд эд нар л гол үүрэгтэй, гол улс төрийн хариуцлага хүлээдэг ийм субъектүүд байна гэсэн ойлголттойгоор би жишээ нь манай Байнгын хороон дээр

тэр хуулиуд яригдах байх л гэж бодож байна.

Тэр дээр бол надад тоо алга. Манай аль аль намуудаас жагсаалтаас орсон хүмүүс тэрийг тоо гаргаж болох юм. 3 дугаар хэлэлцүүлэг дээрээ хэрэв энэ шийдвэр гаргахад шаардлагатай тоо гэж үзвэл түрүүчийн 2012 онд холимог тогтолцоогоор явуулсан сонгуулийн үеэр намуудаас жагсаалтад орсон нөхдийн хэдэн хувь нь өнөөдөр хэдэн хувь нь хэрэгт төвөгт орсон явж байна вэ гэдгийг хэдүүлээ гаргаж үзье, ер нь бол, тийм. Ажлын хэсэг.

Г.Занданшатар: Санал хураалт 2 хүний асуулт хариултын дараа санал хураалт явна. Гишүүд чуулганы танхим цуглаарай. Ажлын хэсэг хэн хариулах вэ?

Н.Энхболд: Доржханд гишүүн.

Г.Занданшатар: Доржханд гишүүн хариулъя.

Т.Доржханд: Баярлалаа. Цогтбаатар гишүүний асуултад маш тодорхой хариулмаар байна. Тэр жагсаалтаар цэвэрхэн хүмүүс орж чадах юм уу, үгүй юм уу гэдэг асуудалд хөндсөн байна гэнэ. Тэгэхээр энийг хэн шийдэх юм бэ гэхээр улс төрийн намууд шийднэ, шийдвэрээ гаргана. Саналыг бол магадгүй улс төрийн намын удирдлагууд оруулах ёстой байх. Энэ дээр харин би нэг зүйлийг маш тодорхой хэлмээр байна. Тухайлбал Улсын Их Хуралд суудалтай ХҮН намын зүгээс бид жагсаалтыг бол худлаа ярьж, хулгай хийдэггүй, попдоггүй, гал барьдаггүй, сумнаас айдаг, зугтдаг, иргэдэд таалагдахын төлөө, оноо авахын төлөө явдаг биш эсрэгээрээ энэ улсын төлөө зүтгэдэг, зориг гаргадаг, эрх ашиг дээр нэгдэж чаддаг, гал барьдаг тэр улс төрчдийг нэр цэвэр улс төрчдийг оруулна гэдгээ бол би илэрхийлж байгаа, оруулна. Ингэж байж улс орон хөгжинө, явна.

Бодлого ярьдаг, бодлогыг санхүүжүүлдэг, бодлого, хөгжил ярьдаг ийм улс төрчид мэргэжилтнүүд орж ирэх ёстой. Энэ дандаа залуучууд бас биш юм. Турилагатай парламентын гишүүд бас дотор нь байх ёстой юм. Турилага бас байх ёстой юм. Ийм байдлаар бол уриалж байгаа юм. ХҮН намын даргын хувьд танай намын даргад уриалсан, хүлээж авсан. Хамтарсан санамж бичиг зуръя гэж байгаа. Ардчилсан намын даргад бас уриалсан, хариугаа удахгүй өгөх байх гэж бодож байгаа. Бусад улс төрийн намуудын удирдлагуудтай бас холбогдсон. Бүгдээрээ дэмжиж байна, дийлэнх нь дэмжиж байна, болж байна гээд. Тэгэхээр энэ бол улс төрийн институцийн хийх ёстой зүйл. Энийгээ бид нар нэр төртэй хийж чадна гэж итгэж байгаа.

2012-оос 16 онд энэ маань өөрөө нэг удаагийн тохиолдлоор хаалгаар хөөсөн нөхөд тооноор ороод ирлээ гэдэг ийм шүүмжлэлээс болоод мөн тухайн үеийн улс төрийн тохирооноос болоод бид нар зөв алхмаасаа ухарсан байдаг 2016 оны сонгуулийн өмнө. Гэтэл олон улсад энэ 2 дахь удаагаа явж байж жагсаалт чинь цэвэрхэн болоод, иргэд итгэдэг, цаашаа хөгжил ярьдаг. Дэлхийн чиг хандлага бол өнөөдөр зөвшилцлийн ардчилал, зөвшилцлийн парламенттай байж хөгжил ярьдаг юм байна. Тэгэхгүй хэн оноо авах вэ, хэн харлуулах вэ, хэн ард түмэнд таалагдсан үг хэлэх вэ гээд явах юм бол тэнд хөгжил ярих ямар ч боломжгүй. Хулгай л ярьдаг гээд. Бид нар зөндөө хулгай ярилаа шүү дээ. Ийм болохоор одоо бүгдээрээ хөгжлийнхөө төлөө хамтдаа байдаг ийм парламентыг бэхжүүлэх хэрэгтэй байгаа юм. Ийм болохоор өнөөдөр хөгжил ярьдаг, бодлого ярьдаг тэр мэргэжилтнүүдийг оруулж ирэх хэрэгтэй байгаа юм. Ингэхээр энэ дээр бол улс төрийн намууд өөрсдөө манлайллаа үзүүлээд явах бүрэн боломжтой, цаашидаа бол парламентдаа итгэх итгэл бол сэргэнэ гэж харж байгаа юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Дамдины Цогтбаатар гишүүн тодруулж асууя.

Д.Цогтбаатар: Доржжанд гишүүнд баярлалаа. Гэхдээ Доржжанд гишүүнээ та хүний, хүний эрхийн ямар ноцтой зөрчил яриад байгаагаа өөрөө нэг бодоод үз дээ. Та намын даргын үед ингээд жагсаалт оруулж ирээд, давхар 76 хүн орох нь л дээ. Тэгсэн та энэ жагсаалтынхан нь бол цэвэрхэн, энэ 76 нь бол хулгайч шүү би энийг хариуцахгүй байна гээд та өөрийнхөө намын хүмүүс дотор ийм ялгаа гаргах нь байна шүү дээ. Уг нь зүүгээрээ бол жагсаалт ч цэвэрхэн, 76 ч цэвэрхэн байх ёстой. Энэ 76-г бүгдийг нь энэ намын Бага хурлаар оруулахдаа энэ хүмүүс итгэл даахуйц хүмүүс гэж оруулж байгаа. Түүнээс хулгайч байх нь хамаагүй гэж лав л би л лав нэлээн юу олон намын бага хуралд ингээд сууж байхад урьд нь би өөрөө дэвшээгүй зөндөө хүмүүс ингээд л дэвшүүлээд л явж байхад хэзээ ч энэ хулгайч байж магадгүй хамаагүй гээд дэвшүүлж байсан нэг ч тохиолдол байхгүй.

Тэгэхээр зүгээр наад үг чинь өөрөө хүний эрхийн аягүй ноцтой зөрчил ярьж байгаа байхгүй юу. Та ингээд оруулахдаа энэ хулгайч, энэ хулгайч биш ангиллынхан гэж ялгах гээд байгаа болж байгаа байхгүй юу. Эсхүл би огт буруу ойлгоод байгаа юм уу?

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 9 дүгээр ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт багш, сурагчдадаа сурлагын өндөр амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе. Анандбазар Цогт-Очирын Анандбазар гишүүн. Энэ намын сурталчилгааны өдөр биш, энэ Үндсэн хууль хэлэлцэж байхад бүр ингээд дараагийн асуудал. Жагсаалтаа тэр Сонгуулийн хууль дээр ярь.

Ц.Анандбазар: Бид өнөөдөр Монгол Улсын тулгуур хууль Үндсэн хуулиа хэлэлцэж байна. Үндсэн хуулийн өөрчлөлтийг 3 удаа хийлээ. Ямар нэгэн хөгжлийн тулгуур Монгол Улсын Үндсэн хууль юм бол яагаад ийм ойрхон гурвын гурван удаа өөрчлөлт хийдэг хууль байдаг юм бэ? Энэ ажлын хэсэг болгон хариуцлага хүлээдэг хүн гэж ер нь байна уу? Тухайн цаг үед тааруулаад жижиг юм хараад, зорилго нь тодорхой бус, тухайн улс төрчдөд тааруулсан ийм өөрчлөлт хийдэг хуулийг Үндсэн хуульд байлгаж болохгүй. Алсын хараа байхгүй, бизнесийн төлөвлөлт байхгүй, ард түмний амьдралыг хэрхэн өөрчлөх нь тодорхойгүй, эдийн засгийн шинэтгэл хийх ямар ч зорилго байхгүй. Зөвхөн зардал чирэгдэл, дээр нь парламентын хямрал авчрах ийм өөрчлөлтийг санал болгож байна гэж харж байна.

17 онд давхар дээл гээд л Үндсэн хуулийг өөрчилсөн, бүгд санаж байгаа. Давхар дээлтэй бол хамгийн сайн болно л гээд явсан. 76 хүн цөөдөөд Монгол Улсын хөгжил зогсчоод байгаа юм ерөөсөө байхгүй. Тэгээд цаг үе болох болгонд л хэдэн улс төрчдөд тааруулж, Үндсэн хуулиар оролдож болох юм уу? Хэрвээ үнэхээр оролдох үндэслэлтэй юм бол энэ чинь нийгэм, эдийн засгийн гүн гүнзгий шинжилгээ хийсэн байх ёстой. Энэ чинь суурь багана нь шүү дээ Монголын ард түмний хөгжлийн. Тэр шинжилгээ ер нь хаана байна вэ? Монголын ард түмэнд дээшилсэн тоо ганцхан л байна. Монголын ард түмний хүн ам зүй 3 сая давсан байна. Өөр ард түмний кармад орчихсон, амьдрал нь дээшилчихсэн нэг ч зүйл алга. Өдөр болгон Үндсэн хуулиар оролдоод ийм явган өөрчлөлт хийгээд байх юм бол бид яаж хөгжих вэ ер нь.

Тиймээс хөгжлийн бодлогод дүн шинжилгээ хийсэн энэ ажлын хэсгийнхний тоог сонсмоор байна. Хуурай цаасан дээр ажилладаг хуульчдын зүгээс ийм юм оруулж ирээд байвал эдийн засаг чинь чирэгдчихдэг юм. Ер нь энэ бүх хууль

гэдэг чинь хүний амьдралд нөлөөлж, эдийн засгийг нь өөд нь татаж байж л хуулийн өөрчлөлт болдог болохоос биш, хэн нэгнийг сонгож, хэн нэгнийг дарга болгохын тулд үйлчилдэг хууль хэрэггүй шүү дээ. Үндсэн хуулиа өөрчлөөгүй улсууд дэлхий дээр хамгийн их хөгжссөн байна. Үндсэн хуулиа оролдсон улс болгон доройтсон байна. Ер нь сонгодог утгаараа тэр гишүүдийн ажлын хэсгийнхний ярьж байгааг сонслоо. Санал гээгддэггүй сонгууль гэж ер нь хаана байдаг юм бэ? Ямар үлгэр яриад байгаа юм. Дэлхийн хүн төрөлхтөн өнөөдөр санал гээгддэггүй ямар ч сонгуулийн тогтолцоо олоогүй байна.

Харин пропорциональ тогтолцоо их хийх юм бол Скандинавын хойгийн орнууд байна. Ялагч гэж байхгүй болоод Засгийн газраа байгуулж чадахгүй 4 жилд 5 удаагийн сонгууль хийгээд, тарж байгаа парламент хүртэл байна шүү дээ. 76 хүн үг хэлэхэд бүтэн 2 өдөр болж байна. 152 болчихвол Монгол Улсын Их Хурал хагас жилд нэг хууль ч баталж чадахгүй. Парламентын хямрал руу түлхэж байна шүү дээ. Ард түмэн элэг дөрвөөрөө мөлхөж байна. Эдийн засаг үнэхээр хүндрэлтэй байна. Хөдөөгийн ард түмэн бол ялангуяа маш их бухимдалтай байна. Тэд бол одоо юу гэж хэлж байна гэхээр лам, нам 2 толгой эргүүлээд, наадам сонгууль 2 Монголын ард түмнийг мөлхүүлээ гэж хэлж байна. Алийн болгон ингэж ард түмнээрээ болоод амьдралаараа тоглох вэ. Ажлын хэсэгт энэ эдийн засгийн дүгнэлт, хөгжлийн дүгнэлтийг үнэхээр серьезно хармаар байна. Нэг л сайхан юм яриад байх юм. Яг үнэндээ энэ чинь ард түмэн ойлгож байна шүү дээ. Сонгогдоод гарч чадахгүй хүмүүс жагсаалтын ард орох гээд байна. Үнэхээр тэр жагсаалт гэдэг юм цэвэр цэмцгэр байдаг гэж дэлхийн түүхэнд байхгүй шүү дээ. Харин ард түмний шүүлтүүрээр ороод, тойргоосоо гарч ирж байгаа хүмүүс чинь харьцангуй цэвэрхэн байдаг. Юундаа сандраад гэнэт ийм олон тоо нэмэх гээд байгаа юм бэ?

Үнэхээр өөрчлөлт хийх гээд байвал энэ Үндсэн хуулийн өөрчлөлтөөр дараах өөрчлөлтийг хийхгүй бол дэмжихэд боломж муутай. Бид энэ том хуулиудыг өөрчлөх гэж байвал ард түмний амьдралд тодорхой дүгнэлт, бодлогын өөрчлөлт хийж байж л хөдлөх хэрэгтэй байна. Хөдөөгийн ард түмэн бол маш хүнд амьдралыг туулж байна. Дэлхий даяар дайн болж, дэлхийн цаг агаар өөрчлөгдөж байна. Хойд мөсөн далай, өмнөд мөсөн далай хайлж зун дэлгэр цагийг Европт хүртэл мэдэхгүй болж байна. Цалин тэтгэвэр үнэхээр хаанаа ч хүрэхгүй байна. Ард түмний амьдрал маш хэцүү байна шүү дээ. Жасрай гуайн Засгийн газрын үед 1 их наяд байхад Жасрай гуай хонгилын үзүүрт гэрэл гарч байна гэж хэлж байсныг ахмад гишүүд бол санаж байгаа байх.

Одоо бид 20 их наяд төгрөг батлаад байна. Үгүй ээ, тэгээд цалин хэдээр нэмэгдчихээд байгаа юм бэ? Цалин нэмэхээр инфляц нэмэгддэг гэж ямар ч эдийн засгийн ойлголт байхгүй юм яриад байх юм. Цалингаа ядаж 2 дахин доод тал нь нэмж байж Үндсэн хуулийн өөрчлөлт ярих ёстой. Яагаад цалин нэмэхээр үнэ нэмэгдээд байна гэхээр бизнес нь ашиггүй болчихоод, алдагдалд орчихсон байгаа хувийн хэвшил хэдхэн төгрөгийн дагуулаад үнэ нэмж байгаа болохоос биш энэ хөөрөл болж байгаа юм биш. 2 дахин цалингаа нэмчих юм бол энэ инфляц чинь өөрөө аяндаа унана. Эдийн засгийн дорвитой шийдэл байхгүй, улс төрийн ийм шийдэл гаргалгаа гаргаж ерөөсөө болохгүй.

Ер нь энэ хуулийг үнэхээр хөдөлгөө гэж бодож байвал эргээд хөдөөгийн ард түмэнд очиж сонгогчдодоо танилцуулах маш тодорхой үндэслэл хэрэгтэй байна. Саяхан 152 гэж байснаа яагаад 126 болчихож байгаа юм бэ? 152-ын шинжлэх ухааны үндэслэл нь хаана байна вэ? 126 болгосон шалтгаанаа тайлбарла. 126 болдог юм бол 108 ч болно шүү дээ.

Тоогоор тоглоод жагсаалтын ард нуугдах гээд байгаа хүмүүс энийг өөрчилмөөр байна. Цалин хөлсийг бодлогын хэмжээнд 2 дахин нэмэгдүүлэх тухай маш тодорхой юм сонсмоор байна. Төрийн албан хаагчид сая хүрэхгүй төгрөгийн цалингаар амьдарч байна. Тэтгэврийн зөрүү дэндэж байна. Малчдын орлого гэж алга боллоо. Малын гаралтай түүхий эд шалан дээр унаж, 4 жилийн турш замдаа хий эргэлээ. Хониныхоо арьсыг боловсруулж чадахгүй, чүдэнзээ үйлдүүлж чадахгүй, ноосыг нь угаааж чадахгүй байж Үндсэн хуулиа өөрчлөх гээд байдаг гэж гаднынхан дооглож байна. Хөдөө очоод ичиж байна. 76 хулгайчаа яая гэж байхад дахиад юу яриад байна гэж асууж байна. 76 хулгайч гэж дуудуулмааргүй байна. Ядахдаа очоод ийм юм шийдлээ гэж тодорхой юмтай ирмээр байна. Ялангуяа энэ төсвийн хууль хэлэлцэж байгаа үед маш тодорхой шийдэл авч байж энэ асуудлыг яримаар байна. Малын гаралтай түүхий эдийг бодлогын хэмжээнд гаргаж ирэхгүй бол цаашидаа хөдөө аж ахуй үнэхээр хүнд болж байна. Нэг малчин ярьсан.../минут дуусав/

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Жигжидсүрэнгийн Чинбүрэн, Хүрэлбаатарын Булгантуяа, Энхтайвангийн Бат-Амгалан нарын урилгаар БЗД-ийн 36 дугаар хорооны иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд сайн сайхныг хүсэн ерөөе. Нямаагийн Энхболд дарга асуултад хариулна. Байнгын хороон дарга асуултад хариулна.

Н.Энхболд: Монгол Улсын Их Хурал Засгийн газраас Монгол Ардын намын дарга Оюун-Эрдэнийн ахалж байгаа Монгол Улсын Засгийн газраас оруулж ирсэн хуулийн төслийг хэлэлцэж байгаа. Хуулийн дагуу, дэгийнх нь дагуу Улсын Их Хурлаас гаргасан шийдвэрийн дагуу энэ асуудлыг хэлэлцүүлээд, нэг

энгийн үгээр хэлбэл эцсийн дүнг нь нэг гаргаадхаач гэсэн үүрэг өгсний дагуу тэр ажлын хэсэг, Байнгын хороо ажиллаж байгаа. Тэгэхээр саяын Анандбазар гишүүний асуусан асуултыг бид нар нэгэнт орж ирсэн хуулийг үзэл баримтлалынх нь хүрээнд тэрийг гаргасан үндэслэлүүд, шалтгаануудынх нь хүрээнд ярьж байгаа учраас саяын гишүүний асуулт бол ажлын хэсэг рүү биш Байнгын хороо руу тэр тусмаа биш, Монгол Улсын Засгийн газарт ямар үндэслэлээр, ямар үзэл баримтлалаар, ямар судалгаа, тооцоогоор ийм тоо оруулж ирсэн бэ, ийм санал гаргаж ирсэн бэ гэж тавих асуулт байна гэж харж байна. Надад өөр хэлэх юм алга.

Г.Занданшатар: Цогт-Очирын Анандбазар гишүүн тодруулна.

Ц.Анандбазар: Хөдөөгийн сэргэлтийн бодлогын хүрээнд 1 хүүтэй моргейжийн зээлийн асуудлыг сэргээх хэрэгтэй байна. Малын гаралтай түүхий эдийг үнэд оруулахын тулд ноосоо боловсруулж, арьс ширний үйлдвэрээ ашиглалтад оруулмаар байна. Сум бүрд сүү гэдэг хөтөлбөр хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Үнээгээ саадаг хүн байхгүй болчихоод байна. Маш тодорхой бодлого хийж, малын тэжээл, малын тэжээлийг тариалах бодлогыг 3 бүсэд хэрэгжүүлэхгүй бол болохоо больчихоод байна. Эдийн засгийн том бодлого хийж ажлын байраа нэмэгдүүлмээр байна. Эгийн голын усан цахилгаан станц, төмөр зам гээд том бодлогууд дээр ажлын байр гарсан хөдөлмөрийн том фронтыг нээх хэрэгтэй байна. Маш тодорхой санал би асуугаад байна. Ерөөсөө юу ч хариулахгүй байна. Ийм эдийн засгийн үндэслэлтэй байх юм бол дэмжиж болно. Түүнээс биш хэдэн даргын тоо нэмэх гэж байгаа бол энэ боломжгүй. Яагаад ажлын хэсгээс асуугаад байхад юм хариулахгүй байгаа юм бэ? Нэг малчин ярьж байна малын тоо нэмэгдэхээр малаа цөөл гэж хэлдэг юм та нар. Одоо танай улс төрийн бэлчээр чинь томдоод байна, улс төрчдөө

цөөл гэж байна. Энэ чинь малын бэлчээр нь даахгүй байхад чинь улс төрчдийнхөө тоог нэмэх гэж байдаг ийм замбараагүй юм байж болох юм уу? Үгүй ээ шууд байхгүй юу. Тэгээд тодорхой тоо сонсмоор байна ажлын хэсгээс.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд дарга, тодорхой тоо сонсмоор байна гэнэ. 126 ямар үндэслэлтэй юм бэ л гэж асуугаад байна.

Н.Энхболд: 126-г асуугаагүй. Эдийн засгийн үндэслэл энэ талаар ямар юу үндэслэж.../үг тасрав/

Г.Занданшатар: Түрүүн асуусан юм 126-г та тэмдэглэж ав.

Н.Энхболд: 126-г одоо би 7 дахь удаагаа хариулах гэж байна, Тийм 7 дахь удаагаа хариулах гэж байна. Нэлээн дэлгэрэнгүй хариулсан байгаа. Тэр эдийн засгийн тооцоо судалгаа бол яг үнэнийг хэлэхэд Анандбазар гишүүнээ манай Байнгын хорооны хариуцсан асуудал биш. Би дахиад хэлье. Энэ Засгийн газраас боловсруулж оруулж ирсэн. Боловсруулахдаа тэр эдийн засгийн, улс төрийн, нийгмийн бүхий л талынх нь харилцааны сайн мууг дэгнэсэн, шинжилгээ судалгаа хийсэн, тэрнийхээ үндсэн дээр оруулж ирсэн хууль гэж бодож байгаа, найдаж байгаа. Тэрийг нь ороод ирсэн хойно нь яаж хэлэлцэх нь Улсын Их Хурлын Дэгээр, хэлэлцэхдээ юу юун дээр нь анхаардаг юм гэдгийг нь бас тэр Дэгээр хуулиар зохицуулчихсан. Энэ хүрээнд л ажлын хэсгийн 9 хүн ажилласан юм. Түүн дотор нь тэрний эдийн засгийн үндэслэлийг нь нягтал, тооцоог нь шалга тийм байхгүй болохоор бид нар тэр лүү нь ороогүй, орох ч тийм эрх зүйн зохицуулалт ч байхгүй л дээ.

Г.Занданшатар: Тийм Лхагвын Мөнхбаатар гишүүн, дараа нь санал хураалттай.

Л.Мөнхбаатар: Өнөөдөр хэлэлцэж байгаа Монгол Улсын Үндсэн хуулийн өөрчлөлтийн төсөлтэй холбогдуулан 2 зүйл хэлье. Үндсэн хуулийн өөрчлөлтийг бол хийж болно. Гэхдээ оруулж байгаа энэ өөрчлөлт нь бол Үндсэн хуулийнхаа нийт агуулга, хэлбэр, бичилт, томъёоллын хувьд бол нэг цогц байх ёстой. Цогц байх ёстой. Ер нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тоолондоо л өөр өөр бичилт томъёоллуудыг оруулаад байх юм бол энэ өөрөө хоорондоо зөрчилтэй л байдлууд үүснэ. Ер нь Үндсэн хуулийн үг, өгүүлбэр, нэр, томъёо бүүр өөрөө цаанаа гүн гүнзгий утга агуулгатай, утга агуулгатай. Ийм учраас энэ шинээр оруулж байгаа нэр томъёо бүр дээр Их Хурлын гишүүд, Байнгын хороод бол сайтар нягталж үзэж, нухацтай хандах ёстой гэж би бодоод байгаа юм.

Энэ оруулж ирсэн төслөөр ийм өгүүлбэр байна л даа. Монгол Улсын Их Хурал 1 танхимтай байна, 126 гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг олныг төлөөлөх гэж байгаа юм, олныг төлөөлөх болон хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын 76 гишүүнийг олныг төлөөлөх, 50 гишүүнийг хувь тэнцүүлэн хуваарилах сонгуулийн аргын үндсэн дээр сонгоно гээд өөрчлөн найруулчихсан. Тэгэхээр энд Үндсэн хуульд 2 төрлийн шинэ нэр томъёо орж ирж байна тийм ээ. 1 дүгээрт нь олныг төлөөлөх болон хувь тэнцүүлэн хуваарилах гэсэн шинэ нэр томъёо Үндсэн хуульд орж ирэх нь. Ийм 2 шинэ нэр томъёо. Энэ бол яах вэ агуулгаараа мажоритар болон пропорциональ гэдгийг л олныг төлөөлөх болон хувь тэнцүүлэн хуваарилах гэсэн ийм 2 шинэ үгээр ингээд орлуулж байх шиг байгаа юм.

Тэгэхээр 2 дугаарт бас энэ сонгуулийн тогтолцоо болон сонгуулийн арга гэсэн шинэ нэр томъёо бас энэ Үндсэн хуульд орж ирж байна. Тэгэхээр Үндсэн хуульд нэгэнт бичигдсэн энэ үг, өгүүлбэрүүд бол энд Үндсэн хуульд ингээд

суугдаад явахаараа цаашаа ингээд тогтсон ингээд хэллэг болоод явна. Тэгэхээр энэ 2 үгнүүдийг шинээр орж байгаа үгнүүдийг их оновчтой томъёолох нь бол их чухал байгаад байгаа юм. Ийм шаардлага ч бас байна. Тийм учраас энэ зөв томъёолж бичихгүй бол цаашидаа бол энэ асуудлууд үүснэ.

Ингээд хуулийн төслийг ингээд уншаад үзэхээр энэ нэг зүйл дотор хоорондоо зөрчилдсөн ийм заалтууд бас байгаад байна. Ийм нэр томъёо, өгүүлбэр байгаад байгаа юм. 1 дүгээрт нь энэ олныг төлөөлөх буюу хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоогоор явуулна гэж бичихээд, дараагийн өгүүлбэр дээр нь болохоороо хувь тэнцүүлэн хуваарилах сонгуулийн аргын үндсэн дээр сонгоно гээд нэг өгүүлбэр дотор ийм 2 өөр агуулгатай нэр томъёо ингээд ороод ирсэн байна. Тэгэхээр 1 бол тогтолцоо гэж бичнэ, үгүй бол арга гэж бичих ёстой шүү дээ. Тэгэхгүй бол нэг өгүүлбэр дотор 2 зүйл бичиж болохгүй.

Нөгөөтээгүүр энэ анх өргөн дээр баригдсан төсөл дээр бол Засгийн газрын төсөл дээр бол арга гэж гээд ороод ирсэн байсан шүү дээ. Одоо энийг нь бол ингээд тогтолцоо гээд ингээд засчихсан байна. Тэгэхээр тогтолцоо гэдэг үгээ ер нь нэр томъёоны хувьд яаж ойлгох юм бэ гэдэг асуудал байгаа юм. Яах вэ тогтолцоо гэдэг үг маань бол нөгөө систем гэдэг үгтэйгээ л ерөнхийдөө дүйж ойлгох, хамгийн ойрхон дүйж ойлгох үг нь бол нь тэр шүү дээ. Систем гэдэг үг шүү дээ тийм ээ. Ингээд энэ сонгуулийн энэ тогтолцоо дээр энэ мажоритар буюу энэ олныг төлөөлөх гээд, хувь тэнцүүлэх буюу пропорциональ гэдэг ийм ойлголтуудыг гээд ороод ирсэн. Эд нар бол өөрөө энэ тогтолцооныхоо л хэлбэрүүд нь байгаа байхгүй юу. Мажоритар, пропорциональ буюу олныг төлөөлөх, хувь тэнцүүлэх гэдэг чинь өөрөө тогтолцооных нь хэлбэр байтал тогтолцоо гэдэг үгийг оруулаад ирэхээр энэ чинь өөрөө агуулга нь өөр

болчхоод байна. Ингээд нэр томъёогоо хэдүүлээ бас авч үзэхгүй бол болохгүй нь.

Тэгэхээр энэ цаашидаа бид энийг энэ хэлбэр гэдэг хэрвээ үгийг авах юм, аваад явах юм бол олныг төлөөлөх болон хувь тэнцүүлэн хуваарилах хэлбэрээр явуулна гэж бичдэг юм уу ийм байдлаар бичихгүй бол ингээд 2 өөр, нэг өгүүлбэр дотор 2 өөр томъёолол яваад байхаараа энэ хоорондоо зөрчилтэй зүйл болно гэдгийг Байнгын хороо, энэ ажлын хэсэг анхаарахгүй бол бас би болохгүй байна гэж бодож байгаа юм. Энэ ч үүднээсээ аливаа нэр томъёо нэг мөр ойлгогдох ёстой, олон салаа утгагүй, их ойлгомжтой, оновчтой томъёологдох ёстой гэдэг агуулгаар нь би энийг би хэлж байгаа юм. Ер нь бол яах вэ энэ бичилтийн хувьд бол жаахан нуруу ийм хэлбэрийн техникийн хувьд бол жаахан төвөгтэй бичигдсэн байна. Ер нь бол Үндсэн хуулийг та бүхэн маань бүгдээрээ мэднэ. Үндсэн хуулийг ингээд анхаараад үзэхээр Үндсэн хууль бол их богино өгүүлбэртэй, маш оновчтой томъёологдсон байдаг. Маш оновчтой. Энэ болгонд чинь өөрөө цаанаа том агуулгыг илэрхийлж байдаг, утга агуулгыг илэрхийлж байдаг. Ийм зүйл байна. Энийг бол 3 дугаар хэлэлцүүлгийн үед Төрийн байгуулалтын байнгын хороо, энэ ажлын хэсэг бол анхаарч, энэ чиглэлээр бол ажиллахгүй бол энэ дээр хоорондоо зөрчилтэй ийм заалтууд байна гэдгийг хэлье.

2 дугаар зүйл бол энэ Үндсэн хуульд өөрчлөлт оруулах ёстой асуудал оруулах асуудал өнөөдөр ч яригдаж байгаа зүйл биш л дээ. 2022 оны 6 дугаар сард 21 намын удирдлагууд цуглаад, 4 бүлэг асуудлаар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулъя гэдэг асуудал дээр тохиролцож, гарын үсэг зурцаасан. Энэ хүрээнд ингээд энэ асуудал эхэлсэн. Эндээс энэ 4 бүлэг асуудал дотроос өнөөдөр бол зөвхөн тоо, тогтолцоотой холбоотой асуудал л орж ирсэн байна. Энд орхигдсон нэг зүйл бол тухайн асуудлын 4 дээр нь байсан. Энэ төрийн

бэлгэ тэмдгийн асуудал буюу энэ төрийн сүлдний асуудлыг хөндөж тавьсан. Энэ бол би их чухал асуудал гэж би бодож байгаа юм. Энэ ч агуулгаар нь бас би энэ дээр өөрийнхөө санал бодлоо хэлчихье гэж бодож байна.

Ер нь төрийн бэлгэ тэмдэг гэдэг бол өөрөө өнө удаан, өнө удаан түүхтэй, соёл уламжлал бүгдийг нь багтаасан ийм л агуулга ойлголт шүү дээ. Монгол хүн бүрийн сэтгэл зүрхэнд байгаа тэр зүйл бол Монголчуудын төрийн сүлд. Гэтэл одоогийн маань бид нарын төрийн сүлд бол 30 жилийн түүхтэй. Манай улс бол өөрөө 2220-иод жилийн түүхтэй ийм эртний түүхтэй улс. Гэтэл сүлд маань 30 жилийн л түүхтэй байгаад байгаа юм. Тэгэхээр төрийн сүлд бол Монголчуудын маань төрийн сүлд бол би соёмбо гэж бодож явдаг юм. Ер нь судалгаа шинжилгээний хүрээнд ч гэсэн аваад үзэхээр бол Монголчуудын уламжлалт сүлд шүтээн бол төрийн соёмбо юм. Ер нь бол соёмбын эхлэлийг ингээд аваад үзэхээр бол Хүн гүрнээс эхлэлтэй. Хүннүгийн үеийн эх сурвалжид тэмдэглэснээр бол нар сар 2-ыг бол шүтээнээ болгож байсан. Өглөө наранд мөргөдөг, үдэш саранд мөргөдөг. Нар буцах үед буюу нар, сар 2-ыг хоёуланг нь нуурт тусах үед нь тахиж их хүчийг олж авлаа гэсэн ийм эх сурвалжууд байгаа.

Үүний дараа Их эзэн Чингисийн үед буюу Их Монгол Улсын үед бол нар, сар дээр нэмэгдээд гал болсон. Ингээд энэ 3 бол Монголчуудын шүтээн болон хөгжиж ирсэн.

Үүний дараа 1686 онд Өндөр гэгээн Занабазар 90 үсэгтэй соёмбо үсгийг зохиосон. Энэ соёмбо үсгийг хураангуйлсан, энэ соёмбо тэмдэг бол өөрөө Монголчуудын гүн ухааны гол агуулгатай ийм сүлд шүтээн. Энэ цагаас хойш соёмбо.../минут дуусав/

Г.Занданшатар: Сүлд соёмбын асуудал яригдаагүй учраас энэ чинь

хэлэлцэх эсэх биш 1 дүгээр хэлэлцүүлэг. Баасандорж даргаа тэр тогтолцоо арга гээд аргын үндсэн дээр гэж яг хэлэх юм уу, тэр нь хэний хэлээд байгаа юу бас үндэслэлтэй байгаа шүү дээ. Ажлын хэсэг Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн.

Ж.Сүхбаатар: Би зүгээр ажлын хэсгийн гишүүн биш ч гэсэн өчигдөр Байнгын хороон дээр бол асуудал тавиад нэлээн олон цаг энэ асуудлыг ярьсан юм Мөнхбаатар гишүүнээ. Тэгээд яах вэ энэ сонгуулийн эрх зүй, сонгуулийн байгууллагад бас энэ дотор ажиллаж байж байгаа хүмүүс дотроос хамгийн олон жил ажиллаж үзсэн хүн нь би байгаа байх. Тэгэхээр тэр утгаараа бол юу ярьсан юм бэ гэхээр эхний орж ирсэн төсөл маань бол болохгүй байсан юм. 2 ойлголт байгаа юм. Парламентын сонгуулийн тогтолцоог юугаар явуулах юм бэ гэдгийг нь хэлж өгөх шаардлага байсан юм. 2 дугаарт нөгөө 76, 50 эд нар гээд заачихаар зэрэг гишүүний сонгууль гэж бас тусдаа ойлголт байдаг байхгүй юу. Тэгэхээр бид нар ямар зорилго тавьсан бэ гэхээр парламент Улсын Их Хурлын сонгууль нь өөрөө ямар тогтолцоогоор явуулах юм гэдгийг нь хэлж тэр мажоритар, пропорционалийг бол Монголчлоод олныг төлөөлөх болон хувь тэнцүүлэх хуваарилах тогтолцоогоор явуулна гэж. Тэр нь олныг төлөөлөх гэдэг нь яагаад тэгсэн юм гэхээр олонх болохгүй байсан юм гэхээр ерөнхийдөө харьцангуй олонхоор бид сонгож яваа. Тэгэхээр аль нэгэн юмыг хаахгүйн тулд олонх ч утга оруулж болно. Бас хамгийн олон ч утга оруулж болох учраас олныг төлөөлөх гэж явж байгаа.

Тэр хувь тэнцүүлэн хуваарилах гэдэг бол угаасаа энэ пропорционалийг бол ойлгодог юм бол сонгууль дээр бол, жоохон юу яаж байхгүй юу тийм ээ. Хувь тэнцүүлэн хуваарилах бол пропорциональ тогтолцооны гол агуулга бол үндэсний хэмжээнд юм уу, бүсчилсэн байдлаар намуудын нэрийн жагсаалтаар бол хувь тэнцүүлэн суудал хуваарилдаг арга

байдаг. Сонгуулийн системийг юу гэж бол хуваадаг вэ гэхээр та өөрөө мэднэ шүү дээ. Үндсэн 2 төрөлд хуваагаад эсвэл хосолмол холимог болдог пропорциональ гээд. Тэгэхээр парламентын сонгууль өөрөө бол тогтолцоогоороо бол мажоритар, пропорциональ гэсэн энэ 2 тогтолцооны үндсэн дээр явагдана гэдгийг нь заачхаж байгаа юм.

3 дугаарт нь бол яах вэ манай онцлог болгоод яг гишүүдийнхээ тоог хуваарилж байгаа юу, яг ялгаж байгаа учраас энэний хэчнээн нь мажоритар юм бэ, пропорционалиар сонгох юм бэ гэхээрээ гишүүний сонгуулийг задлахдаа арга гэдгийг нь хэрэглэж байгаа юм. Парламентын сонгууль бол өөрөө ийм 2 тогтолцоо дээр явагдана. Гэхдээ энэ дотроосоо 76 мандат нь бол тэр мажоритар сонгуулийнхаа аргаар явагдана. Тогтолцоог чинь салгаж байгаа арга нь бол сонгуулийн арга нь бол яг түрүүний тэр хэлдэг гол саналыг тооцдог аргачлалаараа ялгагддаг байхгүй юу. Сонгуулийн тэр хувь тэнцүүлэн хуваарилна гэдэг чинь х... систем буюу тэр саналын хуваалтын тэр саналыг тооцох аргачлал дээрээ энэ ялгагддаг.

Тэгэхээр Англи дээрээ ч гэсэн, Орос дээрээ ч тэгсэн орчуулахдаа Сонгуулийн хуулиуд дээр энийг сонгохдоо тэрний үндсэн тэр аргын үндсэн дээр гэж заадаг байхгүй юу. Шууд сонгох гэдэг юм уу, тэр аргын үндсэн дээр. Тэгэхээр яг Англи дээрээ тэр bases, Оросын тэр основной гэдэг тэр юун дээрээ ингээд бичдэг учраас тэр аргын үндсэн дээр ингэж заагласан ялгаатай. Тэгэхээр энд 3 санаа байгаа. Парламент бол 1 танхимтай, 126 гишүүнтэй, бүрэлдэхүүн нь бүрэлдэхүүн нь 126 байна. 2 дахь нь бол 1 танхимтай парламент байна. 3 дахь нь бол парламентын сонгуулийн тогтолцоо бол 2 тогтолцооны тогтолцоогоор явагдана. 3, 4 дүгээрт нь бол 76 гишүүн нь бол тэр дотроо мажоритар аргын үндсэн дээр тэд нарыг тооцож сонгоно. Гэхдээ иргэд сонгоно шүү дээ.

Дараагийн заалт дээр бол Монгол Улсын иргэд шууд өөрсдөө оролцоод сонгоно гэгчихсэн байгаа. Тэгэхээр ийм учраас тэр аргын үндсэн дээр сонгоно гэж байгаа юм. Аргыг хэрэглэх замаар гэсэн үг. Ийм байдлаар ингээд энэ хамгийн байж болох томъёолол гэдэг дээр бид нар олон цаг манай гишүүд маргалдаж, тал бүрээс нь ярьж, маш олон Их Хурлын дарга хүртэл өөрөө ч оролцсон. Ингээд хийсэн юм тэгээд. Тэрнээс биш тогтолцоо, арга 2 нь зөрчилдөөд байгаа юм байхгүй. Тэр тогтолцоо дотор чинь арга нь ороод гол шалгуур нь болоод явчихдаг. Тэгээд задлаад бичсэн юм нь л энэ. Энэнээс өөр сайн томъёолол байвал та бичээд бас өгчих хэрэгтэй байна. Ажиллахаас гадна. Манай гишүүд өөрсдөө сайн ажиллах хэрэгтэй шүү дээ. Өчигдөр бол бид онол арга зүйн талаас нь ярьсаар байгаад энэ нь арай зөв юм байна гэдэг ийм л шийдэл хийсэн юм.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Энэ Мөнхбаатар даргын ерөнхий санаа бас тэр эцсийн хэлэлцүүлэг дээр анхаарна биз. Гол агуулга нь тэр 21.2 дээр Улсын Их Хурлын гишүүнийг 4 жилээр сонгоно гээд 21.2, 21.1 хоёрын хооронд юу хууль зүйн техникийн хувьд нэг тийм сонгоно гэдэг үгийг давхцахаар тэр хоёрыг л бас эцсийн хэлэлцүүлэг дээр их холбож анхаарахгүй бол тогтолцоо, арга, тэгээд зарчим 3 чинь нэг ийм 3 тусдаа орчих гээд байна гээд байгаад нь бас анхаарах юм байж магадгүй. Тийм. 21.2 дээр Улсын Их Хурлын гишүүнийг ард иргэд ингээд 4 жилийн хугацаагаар сонгоно, чөлөөтэй, нууцаар гээд ингээд байгаа шүү дээ. Өмнө нь ингээд сонгоно гээд дахиад орох гээд байна гэдгийг нь сайн л бас нягталж үзье. Энэ 7 хэмжиг, 1 огтлохгүй бол Үндсэн хуулийн үг, үсэг дээр. 76 гишүүнийг гэгчээж байгаа учраас, тэрнийгээ сайн нягталж байгаад, тэгээд дахиад л нягтлаад байхад буруудах юм байхгүй.

Ингээд гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, хариулт авч дууслаа. 2 дахь хэлэлцүүлэгт оруулсан төслийн зүйл, хэсгийг заалт тус бүрээр нь дэс дараалан санал хураана.

Байнгын хороод, Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналыг тусад нь хэлэлцүүлэхгүй бөгөөд хамтатгаж хэлэлцүүлнэ. Ингээд санал хураалтдаа бэлдэцгээе. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулиар Улсын Их Хурлын гишүүд Үндсэн хууль хэлэлцэж байхад биечлэн оролцох бөгөөд заавал өөрийн биеэр санал өгнө. 57 гишүүний ирцтэй байж хурлыг хүчин төгөлдөр гэж үзнэ. 57-гоос дээш гишүүний ирцтэй байж хурлыг хүчин төгөлдөр гэж үзнэ. Тамгын газар ирц бүрдэж үү? Тийм. Тэгэхээр биечлэн оролцож байж ирцийг картаар биш, биечлэн оролцсон оролцоноор тооцох. 62 хүн байна уу, тоолов уу?

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Монгол Улсын Үндсэн Хуульд оруулах өөрчлөлтийн төслийн заалт.

1. Монгол Улсын Үндсэн хуулийн хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“1. Улсын Их Хурал нэг танхимтай байна. Улсын Их Хурлын гишүүдийн далан зургааг мажоритар аргаар, далан зургааг пропорциональ аргаар сонгоно.”

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжээгүй санал байна. Тэгээд дэмжээгүй саналыг дэмжье гэж гэсэн саналын томъёоллоор санал хураана одоо. Ингээд санал хураалт явуулна. Төслийн заалтаараа санал хураах юм уу тийм ээ? Журмын тухай хуулиар тийм байна уу?

Байнгын хорооныхоо саналаар биш үү? Төслийн заалтаар хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн, дэмжихгүй бол 152-ыг дэмжихгүй байна гэж унана гэсэн үг. Үгүй ээ, үгүй, дэмжихгүй. Энэ төслөөрөө санал хураалт явуулна. Байнгын хороогоор биш. Төслийн 76-г мажоритар, 76-г пропорциональ аргаар сонгоно буюу 152 гэсэн саналыг, энэ бодитой саналыг нь дэмжинэ, дэмжихгүй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалт.

Зөв, зөв. Ингээд төслийн санал дэмжигдсэнгүй. Журмын тухай хуулиар төслөөр нь санал хураагдах ёстой юм байна. Байнгын хорооны саналаар биш. Тийм учраас энэ санал унасан.

Одоо 1.1 төслийн. Байнгын хорооны саналаар санал хураалт. Төслийн 1 дүгээр зүйл буюу хорин нэгдүгээр зүйлийн нэг дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

1.Монгол Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг олныг төлөөлөх болон хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоогоор явуулна.

Улсын Их Хурлын далан зургаан гишүүний олныг төлөөлөх гишүүнийг олныг төлөөлөх, тавин гишүүнийг хувь тэнцүүлэн хуваарилах сонгуулийн аргын үндсэн дээр сонгоно. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд, Ширнэнбаньдын Адьшаа, Жамбын Батсуурь, Тогмидын Доржханд, Хишгээгийн Нямбаатар, Даваажанцангийн Сарангэрэл, Дуламдоржийн Тогтохсүрэн, Одонгийн Цогтгэрэл, Баттөмөрийн Энхбаяр. Цаашид Ажлын хэсэг гэнэ. Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал байна. Асуулт байхгүй. Түүрүүн асуулт, хариулт ингээд өдөржин явуулчихсан юм. Санал хураалт явуулах

уу? 126 гэсэн цэг, таслалаар нь эцсийн хэлэлцүүлэг дээр уншина шүү дээ бүүр. Санал хураалт явуулах уу? Санал хураалт. 61 гишүүн дэмжиж, 61 гишүүн дэмжиж төслийн санал дэмжигдлээ.

Ингээд хоёр дахь хэлэлцүүлэгт оруулсан төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрээр санал хурааж дууслаа. Угаасаа нэг заалттай. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэхдээ Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль, зарчмыг баримталж, иргэдэд төслийн талаар саналаа чөлөөтэй илэрхийлэх бололцоог олгож, иргэд, улс төрийн нам, олон нийтийн байгууллагын оролцоог хангаж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол мэдээлж ажиллахыг Улсын Их Хурлын нийт гишүүд, Улсын Их Хурлын Тамгын газарт чиглэл болгож байна.

16.10 цаг

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалдаа орёе. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Тогмидын Доржханд танилцуулна.

Т.Доржханд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдөр

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлтэй хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2023 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Улсын Их Хурлын 2023 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 37 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдоор ахлуулан, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Ж.Батсуурь, Т.Доржжанд, Х.Нямбаатар, Д.Сарангэрэл, Д.Тогтохсүрэн, О.Цогтгэрэл, Б.Энхбаяр нарын бүрэлдэхүүнтэйгээр Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан болно.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлтэй хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэгт заасны дагуу Байнгын хороод 2023 оны 5 дугаар сарын 17, 18-ны өдрүүдэд хэлэлцэж санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд ирүүлсэн.

Байнгын хороо 2023 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу Байнгын

хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцлээ. Байнгын хорооны хуралдааны үеэр ажлын хэсгээс гаргасан зарим зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг засаж, сайжруулах шаардлагатай гэж үзэн Монгол Улсын Их Хурал дахь Монгол Ардын нам бүлэг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.4 дэх заалтын дагуу 2 цагийн завсарлага авсан. Завсарлагааны хугацаанд ажлын хэсэг хуралдаж, саналын томъёоллыг дахин оруулж ирсэн тул Байнгын хороо үргэлжлүүлэн хуралдаж санал, дүгнэлтээ гаргалаа.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсгээс Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 16.4-т заасны дагуу нийтэлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдөх журмын тухай хуулийн 16.4-т заасны дагуу агуулга бүхий 1 дүгээр зүйл нэмэх, төслийн 2 дугаар зүйлийг 3 дугаар зүйлд болгож, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуулийг шинэчлэн батлах хүртэлх хугацаанд тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг дагаж мөрдөх, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг үндэслэн олныг төлөөлөх мажоритар, хувь тэнцүүлэх хуваарилах буюу пропорциональ тогтолцоог хослуулан явуулах зохицуулалтад Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль болон холбогдох бусад хуулийн тогтоомжийг нийцүүлэх ажлыг Улсын Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хэлэлцэн шийдвэрлэх агуулгаар өөрчлөн найруулах зэрэг нийт 5 зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Х.Нямбаатар, Г.Занданшатар,

Ж.Сүхбаатар, С.Амарсайхан, Г.Ганболд нар хуулийн төсөл болон зарчмын зөрүүтэй саналын томъёололтой холбогдуулан асуудалд асууж, хариулт авлаа.

Байнгын хороо зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг нэг бүрчлэн хэлэлцсэн бөгөөд олонхын санал авсан зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт болон зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд дэг журамтай байна шүү. Ажлын хэсгийн гишүүд өмнөхтэй нь овог нэр, албан тушаал, ажил яг адилхан. Дээр нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Ганбатыг харин түрүүн танилцуулаагүй байх. Ганбат дарга оролцож байгааг протоколд дахиж тэмдэглэж үлдээе, протоколд тэмдэглэлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлт энэ зарчмын зөрүүтэй 5 саналтай. Дараа нь 3 асуудалтай. Тэгээд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна. Горимын санал Ширнэнбаньдын Адьшаа, Одонгийн Цогтгэрэл. Одонгийн Цогтгэрэл гишүүнээр тасаллаа. Одонгийн Цогтгэрэл гишүүн горимын санал.

О.Цогтгэрэл: Журмын тухай хууль нь орж ирж байна л даа. Энэ дээр 3 зүйл зарчмын 3 зарчмын зөрүүтэй саналтай. Өчигдөр бид нар ажлын хэсэг дээр бас зарим зүйлүүдийг ярьсан. 126 гэдэг утга бүхий Үндсэн хуулийн үндсэн тоо бүхий заалтыг 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулиас эхэлж хэрэгжих ёстой энэ заалт буюу ер нь энэ 23 онд ч бай, 24 онд ч бай ээлжит бус сонгуулийн тухай яриа байж болохгүй гэдэг утгаас энэ зүйл, заалтыг заавал энэ хуулийн төсөлд оруулъя. 24 оны ээлжит сонгуулиас энэ зүйл, заалт хамаатай гэдгийг өчигдөр ажлын хэсэг дээр бас нэлээн нарийн деталь ярьсан. Яг одоо орж ирж байгаа энэ зарчмын зөрүүтэй саналын томъёолол дээр редакцын хувьд бас шууд тэгж ойлгогдохооргүй ийм томъёоллоор ороод ирчихжээ. Томъёолол бол шууд тэгж ойлгогдохооргүй, дам утгаар ойлгогдож байгаа.

Тэгэхээр Улсын Их Хурлын дарга тэгэхээр бид нар бас ажлын хэсэг дээр энийг нэлээн нухацтай ярьсан ийм зүйл, заалт байгаа. Тэгэхээр сая бас ажлын хэсгийн гишүүдтэй бас ярилцлаа. Тэгэхээр дараагийн хэлэлцүүлэгт энэ асуудал орж ирэхэд та гүйцээн боловсруулах чиглэл заавал өгөх хэрэгтэй байна. Энэ асуудлыг дахин ярилц гэдэг. Аль эсвэл тийм чиглэлгүй бол бид нар Ардчилсан намын бүлэг энэ асуудлаар завсарлага авахаас өөр аргагүй ийм нөхцөл байдал үүсэж байна.

Г.Занданшатар: 2 дахь саналд. Ойлголоо. Ер нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт аливаа асуудлыг бас цөөнхөд хүндэтгэлтэй хандаж, олонхын зарчмаар шийдэх ийм зарчмыг баримталж байгаа. Тийм учраас энэ ажлын хэсэг дээрээ тохирсон заалтууд дээр бас өөрчлөлт орсон. Тэр нь эргэж дахин боловсруулах шаардлагатай бол тухайн асуудлаар санал хураалт явуулахад гүйцээн боловсруулах чиглэл өгье гэж тохиръё. Үндсэн хуулийнхаа өөрчлөлтийг ярьчихсан ч, Дагаж мөрдөх журмын тухай хууль

дээр завсарлага авах нь бол бүх асуудлаа ахиад удаашируулах учраас ингээд ойлголцоод явчихъя гэж ойлгоод байна. Ингээд бүгд тэгж ойлголоо шүү ажлын хэсэг тийм ээ. Ажлын хэсгийн дарга зөвшөөрлөө, тэгж тохирлоо. 2 дугаар асуудлаар гүйцээн боловсруулах чиглэл өгнө. Бүлгийн дарга уг хэлсэн юм чинь Ганбат дарга. Түрүүн зөндөө хэлчихсэн юм чинь. Сайн байна, баярлалаа.

Одоо ингээд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 5 санал байгаа. Нэгийг нь гүйцээн боловсруулах чиглэл өгөх нь гэж үзэж байгаа.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Байнгын хороо дэмжсэн санал байна.

1.Хуулийн төсөл дараах агуулга бүхий 1 дүгээр зүйл нэмэх:

1 дүгээр зүйл.2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 16.4-т заасны дагуу нийтлэлийн өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Энэ чинь ингээж явахгүй гэж тохирсон чинь яасан бэ? 2-ыг 3 болгоё гэдгээрээ ингээд л болч. Би энэ Баасандорж даргын төслөөрөө явчихъя гэж уг нь, Засгийн газрын төсөл чинь илүү юм байна гэж сүүлд нь хэлсэн чинь бүгд тэгж ойлголоо гэж бодсон шүү дээ. Ингээд явъя, энэ жсоохон маргаантай л юм байна лээ дээ. Яах вэ. Нөгөө Хууль тогтоомжийн хуулиар чинь нийтэлсэн

өдрөөс хойш 10 хоногийн дараа гэж байгаа байхгүй юу. Тэгээд тийм маргаан гараад байж магадгүй. За яах вэ, яах вэ. Санал хураалт явуулъя. Эцсийн хэлэлцүүлэг дээр л анхаарахаас. Санал хураалт. 58 гишүүн дэмжиж энэ заалт дэмжигдлээ. Би Баасандорж даргын энэ хуулийг хүчин төгөлдөр энэ хуулийг гээд Үндсэн хуулийн өөрчлөлт хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэж байгаа шүү дээ. Тэрүүгээрээ байж байхад бараг чимээгүй болчихмоор юм болов уу гэж бодож байсан юм. Тэгээд яах вэ би таны саналыг л уул нь дэмжсэн юм. Анхны оруулж ирсэн санал чинь зөв байсан юм байна гэж бодсон юм. Тэгсэн чинь хоёулаа бие биеийнхээ саналыг дэмжээд ингээд.

2.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн, 1 дүгээр зүйлийг 2 дугаар зүйл болгож доор дурдсанаар өөрчлөн найруулах:

2 дугаар зүйл.2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн Нэгдүгээр зүйлд заасан Их Хурлын гишүүний тоо Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдсан Улсын Их Хуралд хамаарахгүй. Санал гаргасан ажлын хэсэг. Энэ заалтыг гүйцээн боловсруулна тийм үү? Гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

3.Хуулийн төслийн 2 дугаар зүйлийн зүйлийг 3 дугаар зүйл болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

3 дугаар зүйл.2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуулийг шинэчлэн батлах хүртэл хугацаанд тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг дагаж мөрдөнө. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг үндэслэн олныг төлөөлөх /мажоритар/, хувь тэнцүүлэн хуваарилах /пропорциональ/ тогтолцоог

хослуулан явуулах зохицуулалтад Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг Улсын Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60 гишүүн дэмжиж энэ заалт дэмжигдлээ.

4 дүгээр зүйл. Энэ хууль Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн нэгэн адил хүчинтэй. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55 гишүүн дэмжиж энэ заалт дэмжигдлээ. Үгүй ээ, би ерөнхийд нь ойлгосон. Тэгэхдээ байна шүү дээ. Яах вэ энэ бол энгийн хууль учраас заавал 57 биш л дээ. Үндсэн хууль нь л 3/4. Эцэслэн батлахдаа 3/4-аар батлаад явчхаж болно. Энэ Б.Энх-Амгалан, Цогтбаатар үг хэлнэ гэж байгаа. Батлут. Балжиннямын Баярсайхан, Батлут 2 гишүүний. Балжиннямын Баярсайхан гишүүн.

Б.Баярсайхан: Уучлаарай даргаа тоног төхөөрөмж гацсан учраас саяын санал асуулгыг хүчингүйд тооцож, дахин санал хураалгаж өгнө уу.

Г.Занданшатар: Уг нь та дэмжсэн юм байна, дэмжсэнээр тооцоод явчихвал шууд 57 болчихлоо. Балжиннямын Баярсайхан гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Саяын санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулж байна. 86,2 хувийн саналаар, 86,2 хувийн саналаар өмнөх санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Одоо энэ чинь нөгөө ёстой супер мажорити гэдгээр л санал хураах гээд байна шүү дээ. Пүрэвдорж гишүүнээ, Пүрэвдорж гишүүн таны санал эсрэг гараад байна. Үгүй ээ, үгүй хүчингүй болчихсон. Одоо санал хураалт явуулна. Хүчингүйд тооцсон. Чинбүрэн гишүүн. Санал хураалт явуулъя. Сая саяын санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас 4 дүгээр зүйлийг батлах санал хураалтыг дахиж явуулна. Гишүүд анхааралтай. Техникийнхэн нэг төстийн санал хураалт

явуулчхаад явъя, зарим нь саатал үүсээд байна гэж байна. Техникийн шалгалтын төстийн санал хураалт явуулъя. Пүрэвдорж, Туваан, Чинзориг 3 гишүүн. Энэ 3 бол дээшээ, доошоо харж байгаа биз. Энэ техник зүгээр байна гэж үзлээ, төст дууслаа. Одоо санал хураалт явуулъя. Ганбаатар гишүүн зүгээр тайван алх алх, гүйж хэрэггүй. Санал хураалт. Батлах санал хураалт явуулж байна. 4 дүгээр зүйлийг батлах санал хураалт. Гишүүд үймүүлээд байгаарай. 59 гишүүн дэмжиж, 4 дүгээр зүйл батлагдлаа, дэмжигдлээ.

5.Төслийн 3 дугаар зүйлийг 5 дугаар зүйл болгон өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Дараарай, дараарай. 61 гишүүн дэмжиж санал дэмжигдлээ. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлж байна. Гишүүд ажлын хэсэгт баярлалаа.

16.16 цаг

“Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг гурав дахь бэлтгэх үүрэг, хугацаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Дараагийн асуудал орно. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Ажлын хэсэг байж байж болох юм байна. Бас энэ гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Амгалангийн Адъяасүрэн танилцуулна. Индэрт урьж байна.

А.Адъяасүрэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг Төрийн байгуулалтын байнгын хороо 2023 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаараа, Улсын Их Хурал 2023 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа тус тус хэлэлцэж, төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай журмын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.12 дахь хэсэгт заасны дагуу төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацааг тогтоосон Улсын Их Хурлын тогтоолыг баталж, төслийг Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлж, энэ тухай нийтэд зарлан мэдээлнэ гэж заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацааг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх хугацааг 2023 оны 5 дугаар сарын 22-ны өдрөөс 2023 оны 5 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл тогтоож гурав дахь хэлэлцүүлгийн бэлтгэл ажлыг хангахыг Монгол Улсын Их Хурлын 2023 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 37 дугаар тогтоолоор байгуулагдсан Ажлын хэсэг болон Төрийн байгуулалтын байнгын хороо, Улсын Их Хурлын Тамгын газарт, Монгол Улсын

Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг иргэдэд тайлбарлан таниулж, тэдний санал бодлыг сонсох ажлыг зохион байгуулахыг Улсын Их Хурлын нийт гишүүдэд даалгасан.

Байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй бөгөөд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх тогтоолын төслийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг хугацааг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна.

Байнгын хорооны саналаар Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалтдаа бэлдэнэ. Баасандорж даргыг суучихвал санал хураалт явуулчихъя. Санал хураалт. 60 гишүүн дэмжиж, тогтоолын төсөл батлагдлаа. Тогтоолыг уншиж танилцуулъя. Гишүүд анхааралтай сонсоорой.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлдэх үүрэг, хугацааг тогтоох тухай.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.12 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлдэх хугацааг 2023 оны 5 дугаар сарын 22-ны өдрөөс 5 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл хугацаагаар тогтоосугай.

2. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийн бэлтгэл хангахыг Монгол Улсын Их Хурлын 2023 оны 37 дугаар тогтоолоор байгуулагдсан Ажлын хэсэг болон Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо Н.Энхболд, Улсын Их Хурлын Тамгын газар Л.Өлзийсайханд тус тус даалгасугай.

3. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг иргэдэд тайлбарлан таниулж, иргэдийн санал бодлыг сонсох ажлыг зохион байгуулахыг Улсын Их Хурлын нийт гишүүнд даалгасугай.

Энэ тогтоолыг 2023 оны 5 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй. Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулга сонсонд тооцлоо.

Улсын Их Хурлын гишүүд ээ, эрхэм сайд нар аа, Улсын Их Хурлын нэр хүнд, үйл ажиллагаатай холбоотой ард иргэдээс гарч байгаа өргөн шүүмжлэлийг харгалзан Улсын Их Хурлын гишүүд болон сайд нар үүрэгт ажилдаа хариуцлагатай хандаж, хурал чуулгандаа идэвхтэй, цаг нартай оролцож, хариуцлага сахилгаа

өндөржүүлж ажиллахыг хатуу үүрэг чиглэл болгож байна.

Өчигдөр Төсвийн хүрээний мэдэгдэл, жилийн төлөвлөгөө хэлэлцэх үеэр сайд нарын оролцоотой холбогдуулаад манай Цэндийн Сандаг-Очир гишүүнээс эхлүүлээд зөв зүйтэй олон шаардлага тавьсан. Эцсийн эцэст Улсын Их Хурлын нэр хүнд та биднээс шалтгаалж байгаа. Ийм учраас энэ тойрогтоо ард иргэдийнхээ санал бодлыг сонсож, идэвх чармайлттай ажиллах хэрэгтэй. Тайлбарлан таниулах ажлыг тасралтгүй явуулах хэрэгтэй. Зарим гишүүд тойрогтоо дутуу хагас ажиллаж байгаадаа анхаарал дүгнэлт хийвэл зохино. Засгийн газар ч гэсэн ард иргэдээс гарч байгаа асуудлуудын санал шүүмжлэлийг хүлээн авч, нэн ялангуяа үнийн өсөлт, цалин, тэтгэвэр тэтгэмжтэй холбоотой, ард иргэдийн амьжиргаатай холбоотой, хүнд суртал чирэгдэлтэй холбоотой асуудлуудыг шуурхай шийдвэрлэх талаар өндөр анхааралд тавьж ажиллавал зохино.

Ийм учраас гишүүд нэн ялангуяа цаашидаа энэ Их Хурлын үйл ажиллагаандаа энэ тооноос чанар чинь чухал шүү, та бүхний үйл ажиллагаа чухал шүү гэдгийг ард иргэд анхааруулж байгааг хатуу санаж ажиллахыг анхааруулъя. Ингээд Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацаа тогтоох тухай тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд тогтсон хугацаанд тойрогтоо ажиллаж, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг иргэд, олон нийтэд тайлбарлан таниулж, иргэдийн санал бодлыг сонсох ажлыг зохион байгуулахаар болсныг иргэд, олон нийтэд үүгээр зарлан мэдэгдэж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг гурав дахь

хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлж байна. Энэ таны үүрэгт ажил шүү дээ. Энэ яагаад дандаа зардал чирэгдэл гэж байдаг юм.

16.26 цаг

Дараагийн асуудалд оръё оо.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшин танилцуулна аа.

Индэрт урьж байна.

Г.Амартүвшин: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн хуралдааныг хэлэлцэж анхны хэлэлцүүлэг бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2023 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Батжаргал хуулийн төсөлд хүүхдийн мөнгө тэтгэмжийг бүрэн тусгасан эсэх хүүхдийн тэтгэмж

нь нэгдсэн төсвийн зардалд ачаалал үзүүлж байгаа тул тус зардлыг нэгдсэн төсвийн зардлаас ирээдүйн өв санд шилжүүлж хүүхдийн хуримтлалтай болгох боломжтой эсэх үр дүнд нь төсвийн тэнцлийг сайжруулах боломжтой эсэх мөн Засгийн газрын өрийн хэмжээ хэмжээг хуулийн төслийн танилцуулгад дурдсан 49 хувьд барих боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Төсвийн хүрээний мэдэгдлийн хэлбэрлэлтгүй даган 2024 оны төсвийн төслийг боловсруулахдаа энэ удаагийн төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлж боломжтой эсэх талаар асуулт асууж хариулт авлаа.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын Их хурлын гишүүн Батжаргал Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь 60 гэснийг 51 болгож мөнгөн дүн тус тус бууруулах гэсэн зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсан баярлалаа.

Г.Занданишатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Сангийн сайд Болдын Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жигжидийн Ганбат. Ажлын хэсгийн нэрийг аваад ир. Санжаадорж дарга чинь Сангийн яаманд байгаа тэ. Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Мижиддоржийн Санжаадорж, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Чойгүнсэнгийн Чимэдсүрэн, Сангийн яамны Санхүү төсвийн судалгааны газрын дарга Ганболдын Золбоо, Эдийн засаг хөгжлийн яамны Макро эдийн Засгийн газрын дарга Лхагвабаярын Энхамгалан, Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Байгальмаагийн Одонтуяа.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна.

Зочид танилцуулъя. ШУТИС-ийн харьяа ахлах сургуулийн 12-ын Б, 12-ын В ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт сурагчид та бүхний сурлагын хувьд өндөр амжилт хүсье ээ. Сурах чиглэлийг эрхэм болговол хандах зүг өөрөө тогтоно гэж улам сайн сурч улам сайн мэдлэг оюун чадвартай, ёс зүйтэй Монгол Улсын ирээдүйн иргэн болж улс орноо хөгжүүлээрэй гэж хүсье.

Ингээд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт байхгүй.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана.

Зарчмын зөрүүтэй нэг санал байгаа. Гишүүд хүүхэд залуучууддаа хүндэтгэлтэй хандаж хурал чуулганыхаа ажилд идэвхтэй оролцож, санал хураалтдаа бэлтгэнэ үү.

Санал хураалт явуулна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төсвийн байнгын хороо дэмжээгүй санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн 8-д тусгагдсан Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь 2024-2028 онд “60” гэснийг “51” гэж тус тус өөрчлөх. Үүнтэй нийцүүлэн Засгийн газрын өрийн нийт хэмжээний 2024-2026 оны мөнгөн дүнг тус тус бууруулах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал.

Батжаргал гишүүн саналаа татчихгүй юм уу? Байнгын хороо дэмжээгүй юм байна. Ингээж болохгүй л дээ бас тэгвэл бид нар яах вэ санал хураалт явуулъя, гишүүд анхааралтай байгаарай Байнгын хорооны дэмжээгүйг дэмжье гэсэн саналын томъёоллоор, Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

60.9 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ. Ер нь өрийн удирдлагыг сайжруулах нь зүйтэй. Тэгэхдээ шууд ингээж тавьж болохгүй байх. Ингээд зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна.

16.31 цаг

Дараагийн асуудалд оръё.

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөр танилцуулна.

Эрхэм гишүүн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Баагаагийн Баттөмөрийг индэрт урьж байна.

Б.Баттөмөр: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх асуудлыг Улсын Их Хурлын 2023 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн. Эдийн засгийн байнгын хороо 2023 оны 10 дугаар тогтоолоор Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрөөр ахлуулж Улсын Их Хурлын гишүүн Доржханд, Өнөрболор, Цогтгэрэл, Чинзориг нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллалаа. Эдийн засгийн байнгын хороо 2023 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаараа дээрх тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасныг баримтлан явуулж дараах

дүгнэлтийг гаргана. Та бүхэнд танилцуулж байна аа.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Энхбаяраар боловсролын асуудлаар, Улсын Их Хурлын гишүүн Батлут нүүрсний экспортын асуудлаар, Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг Ашигт малтмалын бодлого, Эрчим хүч, боловсролын асуудлаар, Улсын Их Хурлын гишүүн Ганибал хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалт экспортын асуудлаар, Улсын Их Хурлын гишүүн Оюунчимэг Аялал жуулчлал, хөрсний бохирдлын асуудлаар, Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлгийн асуудлаар тус тус асууж санал хэлсэн болно.

Ажлын хэсгийн зүгээс Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдах улсын төсвийн эх үүсвэрээр санхүүжүүлэх төсөл арга хэмжээг Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд тусгах төр хувийн хэвшлийн түншлэл болон гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний бэлтгэл ажлыг хангах Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний биелэлтийг жигд зохион байгуулах Үндэсний баялгийн сангийн тогтолцоог бий болгох асуудлыг Засгийн газарт чиглэл болгосон зарчмын зөрүүтэй саналын томъёолууд болон тогтоолын төслийн хавсралтуудад тусгагдсан төсөл арга хэмжээнүүдийн нэр томъёог жигдлэх тоон үзүүлэлтүүдийн хувь хэмжээг өөрчлөх саналууд бэлтгэснийг Байнгын хорооны хуралдаанд оролцогчдын олонх дэмжлээ.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаатар Хөвсгөл аймгийн цахилгаан станцыг өргөтгөх, Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар тогтоолын төслийн I дүгээр хавсралтад шийдвэр гаргах бүх

түвшинд нийгмийн зөвшилцөлд үндэслэн төр, олон нийтийн хамтын оролцооны оновчтой тогтолцоог бүрдүүлэх талаар чиглэлд тусгах, Улсын Их Хурлын гишүүн Чинзориг Тогтоолын төслийн 2 дугаар хавсралт дахь эмнэлгийн барилгуудын санхүүжилтийн эх үүсвэр дээр ангиллыг солих, Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэн, Чинзориг нараас Өвөрхангай аймгийн Хужирт сумыг Улаанбаатар-Арвайхээрийн чиглэлийн замтай холбох, Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлэг барих, Улсын Их Хурлын гишүүн Ганибал Баруунурт-Сүхбаатар чиглэлийн авто зам гүүр барих, Улсын Их Хурлын гишүүн Бат-Эрдэнэ Булган, Орхон, Хишигөндөр, Гурванбулаг чиглэлийн авто замыг эхлүүлэх, Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин Дорноговь аймгийн Хөвсгөл суманд Гэрэлт говь металлургийн коксын үйлдвэр, үйлдвэрлэл технологийн парк байгуулах, Улсын Их Хурлын гишүүн Батлут Улаанбаатар, Шар хөтөл, Эрдэнэт чиглэлийн авто зам барих гэсэн санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж Ховд аймгийн Цэцэг сумыг хэвтээ тэнхлэгийн замтай холбох санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлала.

Г.Занданшатар: Ажлын хэсгийг танилцуулъя.

Чимэдийн Хүрэлбаатар Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Болдын Жавхлан Сангийн сайд, Хишигээгийн Нямбаатар Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цэрэнпилийн Даваасүрэн Барилга, хот байгуулалтын сайд, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан Боловсрол шинжлэх ухааны сайд, Сандагийн Бямбацогт Зам, тээврийн хөгжлийн сайд, Жамбалын Ганбаатар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хүрэлбаатарын Булгантуяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хаянгаагийн Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Баттогтохын Чойжилсүрэн Эрчим хүчний сайд, Содномын Чинзориг Эрүүл мэндийн сайд, Жамьянхорлоогийн Сүхбаатар Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын Авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир спортын үндэсний хорооны дарга, Цахим хөгжил харилцаа холбооны сайд Ням-Осорын Учрал, Буяагийн Тулга Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга, Гантөмөрийн Түвдэндорж Эдийн засаг, хөгжлийн дэд сайд, Мөнхөөгийн Батбаяр Соёлын дэд сайд, Жигжидсүрэнгийн Сандагсүрэн нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан I дүгээр орлогч, Сүхбаатарын Цогтгэрэл Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг орлон гүйцэтгэгч. Байгаа, байхгүйг нь бүртгэхгүй яасан юм бэ. Энэ байгаа, байхгүйг нь бүртгэ. Асуудлууд болохоор өөрсдөө танилцуулаад явна биз дээ. Ажлын хэсэг.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу. Тасаллаа.

Хавдисламын Баделхан гишүүнээр тасаллаа. Даваажанцангийн Сарангэрэл гишүүн асуулт асууна.

Д.Сарангэрэл: Баярлалаа. 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний асуудлаар би өчигдөр орой байр сууриа илэрхийлсэн. Хүний хөгжил дээрээ бид анхаарах цаг болсон. Энэ үнийн өсөлттэй холбоотой ард иргэдийн ахуй амьдрал, цалин мөнгө, ахмадын тэтгэвэр, хүүхдийн мөнгө гээд тулгамдсан асуудлууд байгаа. Энэ талаар өчигдөр байр сууриа илэрхийлчихсэн. Одоо би энэ тойрогтой холбоотой асуудлаар үгээ хэлэх шаардлагатай байна. 2015 онд одоогоос 8 жилийн өмнө гэсэн үг. Гэр хорооллын газрыг дахин төлөвлөж барилгажуулах ийм хөтөлбөр эхэлсэн. Ингээд 8 жилийн хугацаанд 15 мянган өрхийн 45 мянган хүн тэнүүчилсэн байдалтай 8 жил амьдраад ингээд явж байна. Тэгээд асуудал юундаа байна гэвэл 263 га газрыг чөлөөлүүлчихсэн. Хашиаг нь буулгаад, байшинг нь буулгаад, гэр орныг нь нүүлгэчихсэн. Ингээд барилгажуулна гэж хэлээд 45 мянган хүн 8 жил хөдөө хөхөрч, гадаа гандаж байгаа гэж ойлгож болно. Асуудал юундаа байна гэвэл хууль номын дагуу тэр барилгажуулалтын, дэд бүтцийн ажлыг төр хийх ёстой. Энэ ажлыг хийж өгөхгүй 8 жил болсны улмаас Яармагийн 5 хороо 4, 5, 6, 7, 8 дугаар хорооны 15 мянган өрхийн 45 мянгаар иргэн өнөөг хүртэл орон гэргүй амьдарч байна. Орон гэр харьяалах газар байхгүй байгаа учраас хүүхдүүдийнх нь сургууль, цэцэрлэгийн асуудал, харьяаллын асуудал орхигдсон. Ер нь өөрөөр хэлэх юм өрх гэрийн хэвийн бүтэн амьдрал өнөөдөр нэг мөр эвдэгдчихсэн 8 жилийг ардаа үдсэн гэсэн үг. 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд би хүний хөгжлийн төлөвлөгөөг, хүний хөгжлийн талаар бодлого гаргах ёстой гэж ингэж бодож байна. Энэ дэд бүтэцтэй холбоотой асуудлыг, инженерчлэлийн шугам сүлжээтэй холбоотой асуудлыг хэрхэн яаж шийдэх вэ? Төлөвлөгөөнд хэрхэн яаж тусгаж байгаа вэ? Энэ талаар би хариулт аваад тодруулъя. Баярлалаа.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? Баттөмөр дарга уу. 83. Эдийн засаг,

хөгжлийн яамны Макро эдийн Засгийн газрын дарга. 83.

Л.Балчинлуvsан: Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын дарга Балчинлуvsан. Сарангэрэл гишүүний асуултад хариулъя. 2024 оны жилийн төлөвлөгөөнд хүний хөгжлийг чухалчилж, тэргүүлэх чиглэлийн нэг болгож тодорхойлсон байгаа. Энэ хүрээндээ сая хэлсэн цэцэрлэг, сургууль, боловсролын салбарын хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлийн бодлого арга хэмжээнүүдийг маш сайн тусгаж өгсөн. Мөн дээрээс нь энэ гэр хорооллын дэд бүтцийг сайжруулахтай холбоотой ажлууд тусгагдсан байгаа. Жишээлбэл гэр хорооллуудын дэд бүтцийг 55 мянган айлын инженерчлэл, дэд бүтцийн шугам сүлжээг хэрэгжүүлнэ гэх зэрэг ажлууд тусгагдсан байгаа.

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн хариулъя. Ажлын хэсэг.

Б.Баттөмөр: Сарангэрэл гишүүний асууж байгаа зүйтэй. Одоо үнэхээр инфляцид идэгдэж ард иргэдийн амьдрал өдрөөс өдөрт доройтож байгаа. Энэ чиглэлд бид нар бас үзэж анхаарсан. Ялангуяа Улсын Их Хурлын даргаас бас үүрэг чиглэл өгсөн. Энд бол өөрөөр хэлбэл энэ инфляц үнийн өсөлтийг хязгаарлах чиглэлээр Улсын Их Хурлаас Засгийн газарт чиглэл өгөх нь зүйтэй гэсэн ийм чиглэлийг өгсөн. Бид бас ажлын хэсэг хуралдаад Засгийн газар бол энэ нийлүүлэлтийн гаралтай инфляцдаа Засгийн газар нийлүүлэлтийн гаралтай инфляцдаа онцгой анхаар. Энэ дээр тодорхой арга хэмжээнүүдийг тохируулгын арга хэмжээнүүдийг авах ёстой. Мөн Монгол банканд бол юу гэхээр мөнгөний бодлогоор энэ ханиш уналт энэ тэр дээрээ онцгой анхаарч ажиллах, төсөв мөнгөний уялдааг хангах чиглэлээр бас ажилла гэсэн энэ үүргийг энэ тогтоолд оруулаад ингээд явж байгаа.

Г.Занданшатар:

Даваажсанцангийн Сарангэрэл гишүүн тодруулна аа.

Д.Сарангэрэл: Би та бүхэнд хууль сануулъя. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 14.4.2 дугаар заалт. Хот, суурин газар, дүүрэг, хорооллын чанартай инженерийн болон нийгмийн дэд бүтэц нийтээр ашиглах барилга байгууламж барих. 2 Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны журмын 4.8 дугаар заалт. Сонгосон талбайд улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах инженерийн болон нийгмийн дэд бүтцийн төрийн нийтийн зориулалттай барилга, байгууламж, инженерийн бэлтгэл арга хэмжээг тухайн шатын Засаг дарга хариуцан хэрэгжүүлнэ. Өөрөөр хэлэх юм төр энэ инженерийн чиглэлийн ажлыг хийх ёстой юм билээ. Энийг хийгээгүйгээс болоод бүхэл бүтэн 5 хорооны 15 мянган өрхийн 45 мянган иргэн 8 жил орох оронгүй оочих аяагүй байгаа. Тийм учраас 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнийхөө асуудалдаа та бүхнийг миний энэ хэлсэн зүйлийг онцгойлон анхаарахыг хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Хэн хариулах юм бэ. Санал юм даа тээ. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Бид нар маш чухал баримт бичиг хэлэлцэж байгаа. Энэ бол ирэх оны хөгжлийн бодлого, төлөвлөлт. Тэгээд сая бас Сарангэрэл гишүүний ярьж байгаа ч яг үнэн. Ялангуяа энэ гэр хороолол, агаар, хөрсний бохирдолтой холбоотой асуудлыг энэтэй үүдээд эцсийн шийдэл нь гээд дэд бүтэцжүүлэх энэ асуудал руу үнэхээр бүгд анхаарлаа хандуулж орохгүй бол бүх юмны үндэс нь өнөөдөр агаар, хөрсний бохирдол болж байна шүү дээ. Хөрс эрүүл хүн эрүүл гэдэг. Гэтэл өнөөдөр хөрсний бохирдол өөрөө хамгийн гамшигийн түвшинд хүрээд үндэсний аюулгүй байдлын түвшний

асуудал болж байна. Сая манай Чингэлтэй дүүргээс сонгогдсон манай Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатар гишүүн бид нар санаачлаад хөрсний асуудлаар шийдэл гарах үүднээс Төрийн ордонд 800 гаруй хүнтэй уулзалт хүртэл хийхэд маш ноцтой, ноцтой мэдээлэл ярьж байна. Одоо гэхэд нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд 144 мянга нь нүхэн жорлон байна. Энэнээс нэн ойрын үед яаралтайгаар 2 мянган нүхэн жорлонг хэрвээ засаж янзлахгүй, халахгүй энэ өвчлөл нян өвчний өвчлөлөөр өвдөгсдийн тоо 4, 5 дахин нэмэгдэнэ гэсэн тооцоо судалгааг эрдэмтэд гаргаад бидэнд өдөр бүр анхааруулж байна. Бид энд анхаарал хандуулахгүй нэг л жорлон яриад байгаа юм шиг, попроод байгаа юм шиг юм яриад байна л даа. Гэтэл жорлон үндэсний чуулган сая болж байна. Тэгээд энд зарцуулж байгаа хөрөнгө мөнгө бас хангалтгүй байна. Би түрүүн Эдийн засгийн байнгын хороон дээр асуусан чинь зөвхөн уг нь 4 тэрбум төгрөгөөр энэ хөрсний бохирдлыг бууруулахаар Байгаль орчин, аялал жуулчлалын яам дээр 2023 онд мөнгө тусгасан гэсэн 1 тэрбум орчим төгрөгөөр зөвхөн Орхон аймагт л салбарын сайдын чиглэлээр хэдэн нүхэн жорлонг өөрчилсөн гэж байна. Уг нь нийслэл Улаанбаатар хотын энэ гэр хорооллуудын нүхэн жорлон, энэ лагийг өөрчлөх 4 тэрбум тусгагдсан. Энэ нь өөрөө гэр хорооллын асуудал биш болоод байна. Энэ нь өөрөө энэ гүний ус, ундны ус руу ороод Улаанбаатар хотын 1 сая 500 гаруй мянган хүн амын дунд энэ ундны усаар дамжсан нян, өвчлөл, гэдэсний өвчлөл. Энийг дагаад хавдрын өвчлөлүүд өнөөдөр маш эмзэг байдалтай бараг аюулын дохио болоод ороод ирчхээд байна л даа. Тийм учраас энэ 2024 оны хөгжлийн төлөвлөгөө дээр Улаанбаатар хотын дэд бүтэц, хөрөнгө оруулалт оруулж хөхиүлэн дэмжих гэсэн ерөнхий заалт 6.2,2, 6.2,2.3 гэсэн 2 дээр л байгаад байгаа юм. Тэгээд өчигдөр би Сандагсүрэн даргаас, Нийслэлийн Засаг даргын орлогчоос асуусан. Бас тодорхой хэмжээгээр хөрөнгө мөнгө хэдийгээр суусан ч гэсэн

төрийн хэмнэлтийн хуулийн хүрээнд санхүүжилтийн мөнгө 1 дүгээрт бараг байхгүй, бага байгаа, татагдчихсан.

2-т нь Барилга, хот байгуулалтын яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, нөгөө Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо гэх мэт хэд хэдэн газарт ингээд хаана яг ямар зохицуулалт хийх нь тодорхойгүй ийм байгаад байгаа учраас нэгдмэл нэгэн зорилготой, нэгдмэл 1 төлөвлөгөөтэй, нэгдмэл 1 бодлого, стратегитай энэнтэй тэмцэхгүй бол бид хэчнээн их мөнгө эрүүл мэнд, нийгмийн эрүүл мэнд зарцуулна гэдэг анхан шатанд тэгье гэдэг, хавдрын эмд зарцуулъя гэдэг сургууль, цэцэрлэг, хүүхдийн хоол үйлчилгээ гэдэг. Гэтэл үүний үндэс суурь нь өөрөө өнөөдөр хөрсний бохирдол болчихоод байна шүү дээ. Ундны усаар дамжсан нянгийн болон хөрсний бохирдлын асуудал хамгийн эмзэг, хамгийн ноцтой түвшинд байна гээд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, манай эрүүл мэндийн байгууллагууд энэ Мянгань Сорилтын Сангийн тэр судалгаанууд бидэнд харуулаад байна. Тийм учраас энэ асуудлыг бид үнэхээр онцгой түвшинд авч үзэж, бодлогоор санхүүжилт тусгаж эхний ээлжид энэ нүхэн жорлонг халах, тэр хог хаягдлын үйлдвэрээ яаралтай барих төсвүүдийг 2024 оны хөгжлийн хөтөлбөр дээр онцгойлон оруулж өгч, энэ асуудлыг шийдэх хэрэгтэй байна гэсэн санал хэлэхийг хүсэж байна. Энийг тэгээд энийг бүр би онцгой тэмдэглэж байна. Тэгээд төсөв хэлэлцэх үед яг энэтэй холбоотой ийм төсөв хөрөнгө суулгаж 2024 онд тэдэн нүхэн жорлонг халж, энэ хог боловсруулах үйлдвэрээ бариад, тэгээд ийм үр дүнд хүрнэ гэдгээ бид яг тодорхой болгох хэрэгтэй байна гэдгийг хэлмээр байна аа. Баярлалаа.

Ш.Занданшатар: Санал хэлчихлээ тийм ээ. Цэвэгдоржийн Туваан гишүүн.

Ц.Туваан: Энэ дээр 3, 4 асуулт тодруулъя. Энэ Үндсэн хуульд 2019 оны

өөрчлөлтөөр орчихсон энэ Баялгийн сангийн асуудал. Энэ асуудал бас энэ хөгжлийн төлөвлөгөө дотор орж ирж байх шиг байна. Бас дэмжигдсэн санал дотор харагдаж байна. Тэгэхээр энэ асуудал чинь яг тодорхой, энэ чинь төлөвлөгөө юм чинь төлөвлөгөө дотор тодорхой хугацаатай, бүр эзэнтэй ингээд заасан зүйл заалт байна уу. Яг энэ Баялгийн сантай холбоотой. Энэ дээр нэг хариулт авъя. Энэ асуудал ер нь тэгээд орхигдчихоод ингээд яваад байгаа.

Дараагийн асуудал нь энэ хөдөө орон нутгийн Монгол бараг 21 аймаг бүгдээрээ мал аж ахуй эрхэлж байгаа. Энэ дээр энэ малын гаралтай, хөдөөгийн малчдын маань бэлдэж өгсөн иргэдийн хүнсний хэрэгцээг хангах энэ мах, сүү гээд юм байна маш чухал. Энэнээс гадна хамгийн гол юм энэ хөнгөн үйлдвэрүүддээ уг нь авч ашиглах ёстой арьс шир, ноос ноолуур гээд энэ хөдөө аж ахуйн гаралтай энэ түүхий эд бүтээгдэхүүнүүд чинь ямар ч үнэгүй болчихоод байна. Хог хаягдал шиг болчихоод байна. Ерөөсөө энэ бухимдлын нэлээд шалтгааныг энэ эзэлнэ шүү. Яагаад гэхлээр энэ иргэдийн бэлтгээд энэ чинь бас нэлээн л хэцүү байгаа шүү дээ. Өнөөдөр гэхэд зуны эхэн сар гарах гэж байгаа энэ цагт гэхэд л ямар айхтар цас шуургатай байна. Ийм үед зовон барин бэлдэж өгсөн тэр малчдын түүхий эдийг ашиглахад зориулсан үйлдвэр хаана байна. Дарханы арьс ширний цогцолбор гээд том цогцолбор дээр улс бодлого гаргаад төрийн байгууллагын шийдвэрүүд гараад ингээд яваад байдаг. Энэ яагаад ахидаггүй юм бэ. Энэ ямар нэгэн өөр улсын харь орны бодлого биш шүү дээ. Энэ манай Монголын л бодлого шүү дээ. Тэгээд энэ яагаад ингээд явахгүй байгаа юм. Энэ талаар яг энэ хөгжлийн төлөвлөгөөнд тодорхой тусгасан юм байна уу. Энэ зэрэгцүүлээд тэр Эмээлтийн гээд. Тэгээд л ингээд л 2 туулай хөөж байгаад л хоосон хоцорно оо. Эхлээд ядаж нэг юмаа бас ингээд ажилд оруулаад явмаар байна. Энэ чинь өөрөө Монголын малчдын бэлдэж байгаа, гарч байгаа энэ түүхий эдийн тал

хувийг цааш нь боловсруулах ийм нэмүү өртөг шингээх үйлдвэр шүү дээ.

Дээрээс нь энэ Төв аймаг дээр явагдаж байгаа энэ Төв аймаг Мөнгөнморьтын зам, мөнгөнүүдийг нь өгчихсөн. Дээрээс нь энэ ашиглалтад орох хугацаа нь болчихсон. Энэ яагаад хаанаа гацаад байгаа юм бэ гэдэг нэг асуулт байна.

2 дугаарт нь энэ Төв аймгийн Жаргалант сумаас сумын уулзвараас эхлээд гаралтай тэр Орхон аймаг хүрэх зам. Энэ өөрөө маш чухал зам байна лээ шүү дээ. Юу гэхээр яг тэр замд нь байгаа сумдуудыг бас холбохоос гадна эдийн засгийн үр ашиг маш сайтай 100-гаад километр товчилсон ийм зам байна лээ шүү дээ. Энэ хооронд хэчнээн бензин тос яах вэ тээ. Тэгэхээр энэ зам дээр зөвхөн гаднын хөрөнгө оруулалт гээд орхих биш, өшөө бас энэ хөгжлийн төв төлөвлөгөөнд өөр эх үүсвэрээс оруулах юм байна уу.

Дараа нь энэ нэг жижигхэн, жижиг ч юу байх вэ дээ бас л орон нутагт хүнд асуудал. Тэр нь юу вэ гэхлээр энэ манай төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа энэ барилгууд чинь Төв аймгийн Лүн, Угтаалцайдам сум дээр баригдсан 2 цэцэрлэгийн барилга байна. Байшин нь баригдаад л зогсчихсон. Гадагшаа гардаг цахилгааны юм нэг ч байхгүй, дулааны шугам сүлжээнд холбох юм нэг ч байхгүй. Тэгэхээр иймэрхүү байдалтай юмнууд хийгээд байна. Энэ дээр ямар арга хэмжээ авах вэ гэдэг. Энэ дээр 1 дүгээрт нэгэнтээ ажлын хэсэг дээр бас сайд нар орж ирсэн учраас энэ зүйлийг тодруулъя.

Л.Мөнхбаатар: Туваан гишүүний асуултад хариулъя. Баагаагийн Баттөмөр дарга хариулъя.

Б.Баттөмөр: Туваан гишүүний асуултад хариулъя. Их чухал чухал асуудал асуулаа. Энэ баялгийн сангийн тухай асуудлыг бол Эдийн засаг, хөгжлийн яамнаас оруулж ирээгүй юм. Ажлын хэсэг бид нар санаачлаад энэ

баялгийн сангаа байгуулъя гэсэн ийм зүйлийг энэ тогтоолын төсөлд оруулсан. Яг хэзээ вэ гэхээр зэрэг энэ онд Баялгийн сангийн тухай хууль өргөн баригдсан, хэлэлцэгдэж байгаа шүү дээ тийм ээ. Тэгээд ер нь Их Хурлын дарга дээр байгаа. Хэлэлцэгдээд явж байгаа. Ажлын хэсэг байгуулаад явж байгаа байх. Энийг бид нар энэ хаврын чуулганд багтаагаад баталчих юм бол үүний хэрэгжилт ингээд цаашаа явна. Баялгийн сангаа бол стратегийн томоохон орд газруудтай холбож өгье гэсэн ийм зүйлийг. Тэр Хармагтайн ордууд, Асгатын орд тэгээд бусад энэ стратегийн гэж Ашигт малтмалын тухай хуулийн 6.1-д заасан тэр стратегийн ордуудынхаа ашиглалттай энийг холбож өгье. Баялгийн сангаараа дамжуулаад хүнийхээ хөгжилд хөрөнгө оруулъя. Эрүүл мэндийн салбарт хөрөнгө оруулъя. Боловсролд оруулъя. Шинжлэх ухаанд оруулъя. Энэ хүүхдийн мөнгө гээд энэ юм байна. Тэгээд баялгийн сан маань цаашаа өсөж байдаг, арвижиж бай байдаг энэ тогтолцоо руу явъя гээд энийг тогтоолын төсөлд ажлын хэсэг оруулаад сая Эдийн засгийн байнгын хороогоор дэмжигдээд ингээд явж байгаа. Энэ бол бодит ажил болно. Энэ бол Монгол Улсын хөгжлийн нэг том гарцын нэг гэж ингэж үзэж байгаа.

Дараагийн асуудал бол юу гэхээр энэ арьс ширний цогцолборын асуудал байгаа юм. Эдийн засаг, хөгжлийн яам, Хүрэлбаатар сайд яамны улсууд нэмээд хариулна биз. Энэ тогтоолын төсөлд бол Дарханы арьс ширний цогцолбор, Эмээлтийн цогцолбор гэж 2 цогцолбор явж байгаа. Дарханых нь бол ингээд зогсолтын байдалтай байгаа. Сая Ерөнхий сайдад асуулга тавиад бас хариултуудыг авчихсан байгаа. Хүнс, хөдөө аж ахуйн яам бол энэ дээр ажиллаж байгаа. 33 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн гэж байгаа. Тэгээд энийг ингээд цаашаагаа авч явъя. Ер нь сүүлд гарч байгаа санаачилгаар бол хэсэгчилж энийг оруулъя. Эхний ээлжид хонь, ямааны

арьсыг боловсруулдаг үйлдвэрийг нь эхэлж ажилд оруулъя. Энэ дээр гаднаас бас тодорхой аж ахуйн нэгжүүд, Италийн тэр хөгжлийн санхүүжилт өгдөг байгууллагуудтай бас яриад, хөрөнгө босгох энэ чиглэлийн ажлууд явж байгаа. Тэр Эмээлтийн чиглэлийн асуудлыг манай Хөгжлийн яам ярина биз.

Замтай холбоотой асуудлыг сая Туваан гишүүн асуулаа. Энийг бол сая Бат-Эрдэнэ гишүүн, Батлут гишүүн санаачилга гаргаад, гишүүд нөгөө зарчмын зөрүүтэй санал гараад Эдийн засгийн байнгын хороо дээр энэ 25 дугаар зүйл одоо санал хураалт явна. 2 дугаар хавсралтын 4.3.24-д заасан Төв аймгийн Жаргалант сумын Жаргалантын уулзвараас эхтэй Орхон аймгийн авто замын Орхон сумын уулзварт төгсөх хучилттай 100км авто зам барих, тэгээд санхүүжих дүн нь 75 тэрбум төгрөг гээд оруулчихсан явж байгаа. Манай Хөгжлийн яамныханд хариулж болно. Үлдсэн асуултуудад.

Л.Мөнхбаатар: Туваан гишүүний асуултад нэмж хариулъя. Хэн хариулах вэ. Өөрийнхөө өмнөх дугаараа өргөөд, хэн хариулах юм. Ажлын хэсгийн гишүүн хэн бэ. Хэд вэ наадах чинь. 86 дугаар микрофоныг өгье. Албан тушаал нэрээ хэлээд гишүүний асуултад хариулаарай.

Б.Анар: Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Анар. Туваан гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Эмээлтийн эко аж үйлдвэрийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх төсөл гээд хөгжлийн төлөвлөгөөнд туссан байгаа. Техник эдийн засгийн зураг төсөв бол урьдчилсан зураг төсөв хийгдсэн. Дэд бүтцийн ажлуудыг хийж эхэлнэ гэж байгаа. Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр хэлэлцээр нь хийгдээд явж байгаа. Төсөлд нийт шаардлагатай санхүүжилтийн хувьд 154 сая ам.доллар. 100 сая ам.долларыг

Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр төсөлд шаардлагатай суурь дэд бүтцийг бүтээн байгуулалтын ажлуудыг хийнэ. Энэ суурь дэд бүтэц дээр хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд өөрсдөө ирээд нэмэлт бүтээн байгуулалтын ажлаа хийгээд цаашдаа төр хувийн хэвшлийн түншилэлээр хэрэгжүүлээд явах боломжтой ийм төсөл байгаа.

Л.Мөнхбаатар: Тодруулахаас өмнө зочин танилцуулъя. ШУТИС-ийн харьяа ахлах сургуулийн 12^а ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт багш, сурагчид та бүгдэд сурлага, хөдөлмөрийн өндөр амжилт хүсэн ерөөе.

Цэвэгдоржийн Туваан гишүүн тодруулж асууя.

Ц.Туваан: Монголчууд хэлдэг. 2 туулай хөөгөөд, хоосон хоцорно гэж. Энэ юугаа сая тэр Эмээлт гэдгийг ингээд яриад явж байна. Тодорхой мөнгө төгрөг яригдаж байна. Дархан дээр тодорхой мөнгө төгрөг яригдсангүй ээ. Дархан дээр юм байна уу. Эхлээд явсан, хэдэн жил болсон энэ юмаа яагаад явуулахгүй Тэгээд сүүлдээ дахиад нэг юм оруулж ирээд ингээд бүр аль ч үгүй дахиад хэдэн жил болох вий. Хэдэн жил малчид энэ бэлдсэн энэ хайран сайхан түүхий эдээ хээр, хөдөө гадаа жалга, гуунд хаях асуудал болох вий. Энийгээ нэг Монгол улс хөдөө аж ахуйн орон юм бол энэ дээрээ нэг төлөвлөгөөний гол үндсэн хэсэг болгоод ингээд нэг дорвитойхон юм аваадхаач. Энэ чинь Монголын л хөрөнгө шүү дээ. Монгол Улсын л бүтээгдэхүүн. Монголчуудын л бүтээсэн бүтээгдэхүүн шүү дээ. Тэгэхээр энийг нэмүү өртөг яах юман дээр Дархан дээр тодорхой яг мөнгө төгрөг юу байна

Л.Мөнхбаатар: Хэн хариулах вэ. 86 дугаар микрофоныг өгье. Ажлын хэсгээс хариулъя.

Б.Анар: Эдийн засаг, хөгжлийн яам Анар. Туваан гишүүний асуултад бас нэмж хариулъя. Дарханы арьс ширний цогцолборын дэд бүтцийн бүтээн байгуулалтын төслийг үргэлжлүүлнэ гээд тусчихсан байгаа. Мэдээж хуучин энэ бас хуучин хувийн хэвшлийн хэрэгжүүлээд явж байсан төсөл байгаа. Бид нарын ойлгож байгаагаар бол Хөдөө аж ахуйн яам бол энэ ТЭЗҮ-г шинэчлээд хийлгүүлчихсэн байгаа. Италийн хувийн хэвшлийн банкнаас санхүүжилтийн эх үүсвэрийг бас хөөцөлдөж байгаа ийм асуудал байгаа. Эхний ээлжийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын асуудлыг шийдвэрлэнэ гээд Засгийн газрын тогтоол бол Эрдэнэт үйлдвэрээс шийдвэрлэнэ гэсэн ийм тогтоол гарчихсан байгаа. Нийт эх үүсвэрийн хувьд бусад эх үүсвэрээс гээд ийм олон төрлийн санхүүжилтийн эх үүсвэрүүд байх юм байна лээ. Тэгэхээр энэ нь нийт ганцхан улсын төсөв гэж тавьж болохгүй. Бусад эх үүсвэрээс гээд 59,2 тэрбум гэсэн ийм эх үүсвэрийг тавиад тусгачихсан байгаа.

Л.Мөнхбаатар: Асуултад хариуллаа. Одоо Нанзадын Наранбаатар гишүүн асуултаа асууя. Дамбын Батлут гишүүн хүрээд ирээрэй.

Н.Наранбаатар: Бидэнд хамгийн нэг тулгамдсан асуудал бол энэ цөлжилтийн асуудал. Манай Улсын нийт газар нутгийн 70, 80 хувь нь энэ чинь хуурайшаад цөлжчихлөө гэж Байгаль орчны яамнаас танилцуулаад байгаа шүү дээ. Тийм учраас энэ цөлжилтийг сааруулах, гадаргын усыг хуримтлуулах, нөгөө Орхон Говь, Хэрлэн Говь төслүүдийг урагшлуулах ажлууд дээр ирэх оны үйл ажиллагааны төлөвлөгөө дээр ер нь ямар ажлууд тавигдаж, ямар хөрөнгө мөнгө сууж байгаа юм. Би ойлгохдоо бол энэ 2 томоохон төслийн ТЭЗҮ хийгдээд зураг төсөв нь энэ жил хийгдэж дууссан байх ёстой гэж ойлгоод байгаа юм. Тэгээд ирэх жил үргэлжлүүлээд энэ төслүүд маань яаж

цаашаа явах юм бол. Яаж та бүхэн төлөвлөж байгаа вэ. Сүүлийн жилүүдэд ялангуяа энэ баруун аймгууд, говийн бүс нутгуудаар ер нь бараг нэгхэн улиралтай болсон. Ганц хавар гэдэг ийм улиралтай л болчихлоо шүү дээ. Тэгээд шороо тавиад, шөнөдөө хүйтэн, хуурайшилт ихтэй, тоосжилт ихтэй ийм асуудлууд хурцаар тавигдаж байна аа. Энэ Ерөнхийлөгчийн санаачилгаар “Тэрбум мод” хөтөлбөр хэрэгжээд явж байна. Энэ “Тэрбум мод”-той холбоотойгоор ямар хөрөнгө төсөв бас энэ ирэх жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд сууж байна вэ. Гол нь усгүй бол бидний яриад байгаа өнөө томоохон бүтээн байгуулалт, боловсруулах үйлдвэрүүд, газар тариалан, тэрбум мод энэ бүх ажлууд чинь цаашаа явахгүй шүү дээ. Тийм учраас бид энэ хуурайшилт, цөлжилттэй тэмцэх, энэ усны асуудал дээрээ бол онцгой цаашидаа анхаарч явахгүй болохгүй. Хамгийн гол нь бид энэ томоохон бүтээн байгуулалтад усны асуудал эрчим хүчний асуудал байгаа юм.

Дараагийн дугаарт энэ иргэдтэйгээ бид чинь дахиад очоод уулзах нь Үндсэн хуулийн хэлэлцүүлэг, 2 дахь удаагийн хэлэлцүүлэг гээд. Тэгээд түрүүн явахад хамгийн гол асууж байсан зүйлүүд дээрээ ямар хариулттай очих юм бэ. Хэдхэн зүйлийг л ярьж байсан шүү дээ. Цалин нэмэх, тэтгэвэр нэмэх, хүүхдийн мөнгийг тэгш хуваарилах гэсэн л гол 3 асуудал ярьж байсан. Энэ дээрээ ямархуу бодлого шийдвэр баримталж байгаа гэж ярьж очих юм бэ. Одоо бол Үндсэн хуулийн асуудал яриад нэг их сонин биш л байгаа. Гол нь ийм асуудлууд дээр ялангуяа говийн бүс нутаг дээр энэ цөлжилт, хуурайшилттай яаж тэмцэх вэ. Энэ цалин, тэтгэврийг яаж нэмэх юм. Хүүхдийн мөнгийг яаж тэгш олгох вэ гэдэг дээр сая бид очоод танилцуулахдаа эдийн засгийн байдал сайжирч байгаа. Графикууд 8, 9 график бүгдээрээ дээшээгээ. Экспорт нэмэгдэж байгаа. Төсвийн орлого давж биелж байгаа гээд сайхан сайхан юмнууд яриад, танилцуулсан. Зөрүүлээд л асууж байгаа

шүү дээ. Хэрвээ эдийн засаг ингээд сайжраад энэ валютын нөөц сайжирч байгаа бол яагаад цалин, тэтгэвэр, хүүхдийн мөнгөө нэмж өгөхгүй байгаа юм бэ гэдэг асуудлыг л ярьж байгаа шүү дээ. Тийм учраас бид энэ дээр ямар хариулттай очих вэ гэдэг.

Дараагийн нэг асуудал бол энэ хилийн боомтууд руу ялангуяа энэ Өмнөговь аймагт байдаг хилийн боомтуудын бүтээн байгуулалттай холбоотой ямар ажлууд ирэх жил хийгдэх вэ. Нөгөө мухар төмөр замууд нь нийлэх юм уу. Боомт дээр хийгдэх бүтээн байгуулалтын ажлууд нь орц, гарцыг нэмэгдүүлэх, барилга байшин, дэд бүтцийн асуудал гээд энэ асуудлууд дээр ямар ажлууд хийгдэхээр ирэх жил төлөвлөж байгаа вэ гэсэн ийм асуудлууд байна. Тэгээд дараа нь тодруулъя.

Л.Мөнхбаатар: Асуултад хэн хариулах уу. Ажлын хэсгийн ахлагч Баагаагийн Баттөмөр дарга хариулъя.

Б.Баттөмөр: Би тэр устай холбоотой асуултад хариулт өгье. Үлдээж байгаа асуулт нь манай Хөгжлийн яам хариулт өгнө биз дээ. Энэ хөгжлийн төлөвлөгөөнд Онги Цагаан бургастай нь устай холбоотой асуудлаар орж ирсэн. Гадаргын усыг ашиглах гэсэн ийм ганц заалт орж ирсэн юм. Тэгээд бид нар ярьж байгаад Онги цагаан бургастайгаар хязгаарлаж болохгүй ээ. Монгол Улсын цөлжилт, хуурайшилт гээд энэ бүх юмны бас нэг тодорхой үйлс нь юутай холбоотой вэ гэхээр Монголоос эх авч байгаа ус бүгд гадагшаа гараад явчихдаг. Миний ойлгож байгаагаар бараг нийт усны бараг 80 хэдэн хувь нь бол гадагшаа гараад явчихдаг. Төвийн чиглэлийнх нь бүгд Сэлэнгэ гээд Байгаль нуур луу гараад явчихдаг. Зүүн чиглэлийнх нь Хэрлэн гээд далайн нуурт очоод цутгачихдаг. Тэгэхээр Монгол Улсын энэ газрын хагалбар дээр байгаа цаг уурын их эрс тэс уур амьсгалтай. Энийг байгаль орчны зохистой харьцааг хангахын тулд яах вэ

гэхээр зэрэг энэ гадаргынхаа усыг гол мөрнийхөө ус дээр цөөрөм байгуула. Монголдоо нэг хэсгийг нь авч үлдэх. Энийг тэр газар тариалан бусад ажилд зарцуулах. Тухайлбал Гэгээн нуур гэж ингээд л байгуулж байх үед л гол мөрөн ширгэчихнэ гээд л бөөн шүүмжлэл болж байсан. Тэр гэгээн нуур өнөөдөр Монголын экологид маш их ач холбогдолтой ийм төсөл болсон шүү дээ. Энд усны шувууд байнга ирж амьдардаг болсон. Загас, жараахай үржиж байгаа. Байгаль орчных нь экологи бол маш их сайн болсон үр дүнтэй байдаг. Ийм учраас энэ Сэлэнгэ, Ерөө, Хараа гээд энэ гол мөрнийхөө нэг хэсэг усыг бас Монголдоо авч үлдэх ийм төсөл бол байдаг юм байна лээ. Социализмын үед ч хийгдсэн байдаг. Дараа нь зах зээл эхлээд ч хийгдсэн байдаг. Энэ төслүүдийг бас ажил болгоё. Энэ үүднээс энэ том гол мөрнийхөө усны тодорхой хэсгийг авъя гэсэн утгаар энд гадаргын усны хуримтлалыг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээ, судалгааны ажлыг эрчимжүүлэх гэсэн ийм агуулгатай заалтыг энэ тогтоолын төсөлд нэмж оруулсан юм. Тэгээд мэдээж хаягдал ус ашиглах үйлдвэр байгуулах төслийг манай Хөгжлийн яамнаас оруулж ирсэн. Энийг бид нар дэмжээд явж байгаа. Бусад асуудлуудад нь яамныхан хариулна уу.

Л.Мөнхбаатар: Хариултаас өмнө зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учралын урилгаар ерөнхий боловсролын “Тэрэлж боардинг” сургуулийн сурагчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт сурагчид та бүгдэд сурлага, хөдөлмөрийн өндөр амжилт хүсэн ерөөе.

Нанзадын Наранбаатар гишүүний асуултад нэмж хариулъя. Хэд вэ. 83 уу. Ажлын хэсгийн 83 дугаар микрофоныг өгье.

Л.Балчинлувсан: Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын дарга Балчинлувсан.

Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Байгаль орчны асуудал бол 2024 оны тэргүүлэх чиглэлийн хамгийн чухал заалт болж 8 дахь бодлогын тэргүүлэх чиглэл буюу ногоон хөгжлийг дэмжинэ гэж орж өгсөн байгаа. Үүний хүрээнд 4 голлох ажлуудыг би ерөнхийд нь хэлж өгье. Тэгэхээр ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ. Үүний хүрээнд тэрбум мод болон цөлжилтийг сааруулах, элсний нүүдлээс хамгаалах, хамгаалалтын зурвас байгуулах гэх зэрэг ажлууд багтсан байгаа. Мөн гадаргын усны хуримтлалыг нэмэгдүүлнэ. Үүний хүрээнд Онги цагаан бургастайн төслийг эхлүүлнэ гэсэн ажил орсон. Мөн ашиглалтад өртөмтгий амьтан, ургамлын ашиглалтын нөөцийг бүсчилсэн бий болгоно гэсэн тийм бас нэг зорилт орсон байгаа. Мөн дээрээс нь байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. Үүний хүрээнд хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр, байгальд ээлтэй нөөцийн хэмнэлтэй ногоон бүтээгдэхүүн үйлдвэрлэл үйлчилгээнд дэмжлэг үзүүлнэ зэрэг ийм гол гол ажлууд орсон байгаа.

Л.Мөнхбаатар: Тодруулах юм уу. Нанзадын Наранбаатар гишүүн тодруулж асууя. Нэг минут.

Н.Наранбаатар: Тэгэхээр өнгөрсөн жил Засгийн газрын тогтоолоор Өмнийн говийн хөгжлийн бүсийн зөвлөл гээд байгуулагдчихсан байгаа шүү дээ. Тэгээд 1 удаа хуралдсан. Дахиж хуралдаагүй байгаа. Энийгээ цааш нь хуралдуулаад, усны асуудлаа яримаар байна. Боловсруулах үйлдвэрийн асуудлаа яримаар байна. Хил боомтын асуудлуудаа яримаар байна. Даланзадгад хотын төвд Шинжлэх ухаан технологийн харьяа сургууль байгуулчихсан. Тэгээд Ерөнхий сайд ноднин очоод шавыг нь тавьчихсан. Тэгээд энэ ажил бас хөрөнгө төсөв нь шийдэгдээгүй. Оюутолгойн гэрээний хүрээнд бас шийдчих бололцоо байгаа. Тэгээд энэ дээр бас цаашаа ажлыг нь явуулах энэ тэр гээд олон асуудлуудаа

цааш нь ярих хэрэгтэй байна. Цалин, тэтгэвэр тэтгэмж дээр баримталж байгаа нэг бодлогынхоо талаар хэлээдхээч. Одоо сонгогчидтой очоод уулзахад юу ярих юм. Ямар хариулт өгөх юм.

Л.Мөнхбаатар: Тодруулгад хариулъя. Ажлын хэсгээс хэн хариулах юм. Монгол Улсын Шадар сайд Чимэдийн Хүрэлбаатар хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Өмнийн говийн Хөгжлийн бүсийн зөвлөл байгуулагдсан. Үүнийг Боомтын сайд хариуцаад ажиллаж байгаа. Тулга сайд ажиллаад явж байгаа гэдгийг хэлье. Үүний дараагийнх нь цалин, тэтгэврийг ер нь яаж энэ жилийн төлөвлөгөөнд оруулж өгсөн бэ гэдэг ийм асуулт байгаа. Ер нь жилийн төлөвлөгөө дээр бид нар төрийн албан хаагчдын цалин, ахмадуудынхаа тэтгэврийг ер нь инфляцынхаа түвшинтэй уялдуулаад нэмнэ гэдэг ийм бодлогыг оруулж ирж байгаа. Ер нь инфляцын түвшинтэй уялдуулаад цалин тэтгэврээ нэмэхгүй явахаар эргээд энэ нь их нэлээд тийм сөрөг нөлөө үзүүлээд байгаа. Хувь хүмүүсдээ ч тэр.

Л.Мөнхбаатар: Гүйцээгээд хариулчихъя. Монгол Улсын Шадар сайд нэмж хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Ер нь Засгийн газар бол цалин тэтгэврийг цаашид үнийн түвшинтэй уялдуулаад нэмнэ гэдэг ийм бодлогоо бол баримталж байгаа. Үүнийгээ бодлогоддоо оруулаад өгчихсөн байгаа. Харин цаашидаа харин зарим жилд нь нэмээд, зарим жилд нь нэмдэггүй ийм зүйлээс л татгалзах ёстой. Ер нь жил болгон үнийнхээ инфляцтай нийцүүлээд нэмээд явахаар болдгийг бас өмнөх хэдэн жилийн туршилага харуулж байгаа шүү дээ. Тийм учраас цаашидаа Засгийн газар цалин, тэтгэврийг үнийн түвшинтэй уялдуулаад нэмдэг ийм практик руу шилжинэ гэдгээ хэлье. Энэ жилийн хувьд

гэвэл Засгийн газар төсвийн тодотгол хийх эсэх тухай дээрээ эцэслэн шийдвэр гаргаагүй байгаа. Яагаад вэ гэхээр төсвийн тодотгол хийгээд, жоохон мөнгөө эргээд зарчихаар үнийн өсөлт явагдана, ханишинд нөлөөлнө. Энэ нь эргээд макро эдийн засгийнхаа тогтворжуулалтыг сөрөг нөлөө үзүүлчих болов уу гэж үзэж байгаа. Ийм учраас эцсийн шийдвэр Засгийн газар гаргаагүй байгаа гэдгийг би хэлье.

Л.Мөнхбаатар: Дамбын Батлут гишүүн асуултаа асууя. 2 гишүүн асуулт асуусны дараа санал хураалт явагдах тул гишүүд танхимдаа орж ирээрэй.

Д.Батлут: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төсөлд өгсөн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн өгсөн тэр зөвлөмжөөс би нэг асуулт асууя. Бид бүхэн 2024 онд ирэх онд 50 сая тонн нүүрс экспортолно. Тэгээд эдийн засгийн өсөлтийг 6,5 хувьд хүргэнэ гэж тооцсон байна. Хятад Ард Улс бол сүүлийн 3 жил нүүрс нөөцлөлтийн хэмжээндээ бол нөөцлөлтийн хэмжээгээр нэлээн дээд түвшинд хүргэчихсэн байгаа гэсэн мэдээлэл байгаа. Мөн коксожсон нүүрсийг бусад улс орнуудаас 63,8 сая тонныг импортлож авсан байдаг. Нүүрсний маань үнэ бас зах зээл дээр бага зэрэг уналттай байгаа гэсэн мэдээллүүд байгаа. Тэгэхээр бид нар энэ зорилтуудаа ирэх ондоо бүрэн хангаж чадах юм уу. Яг 50 сая тонноо хүргэж, экспортолж чадах уу. Энэ бодлогын яам нь өөрөө энэ дээр ямар тооцоолол хийж байгаа юм бэ гэдэг талаар хариулт өгөөч ээ.

2 дугаарт нь бид нар Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд эрчим хүчний сэргэлтийн бодлогыг авч хэрэгжүүлэхээр явж байгаа. Ярьж байгаа. Эрчим хүчний сэргэлтийн хүрээнд олон усан болон дулааны цахилгаан станц барьж байгуулах, өргөтгөл хийх ажлууд явагдана. Одоогийн нөхцөл байдал бол манай эрчим хүчний систем үнэхээр хүнд байгаа. Уул уурхай станцуудын хооронд

өр авлага үүсчихсэн. Тарифын өсөлтийг бүрэн дүүрэн шийдэж чадаагүй. Бэлэн мөнгөний урсгал багасчихсан. Цалин мөнгө нэмэгдэхгүй байгаа гээд олон асуудлуудтай тулж байгаа. Тэгтэл бид нар энэ Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд харин энэ эрчим хүчний салбараа дотор нь бас цэгцлэх боломжууд байгаа харагдаад байгаа юм. Би урьд нь бас ярьж байсан. 9 тэр сэргээгдэх эрчим хүчний компанитай байгуулсан гэрээний асуудал. Энэ гэрээг хэзээ тасалбар болгох юм бэ. Бид дор хаяж энэнээсээ эхлэхгүй бол ерөөсөө болохгүй байгаа. 1квт цахилгаан эрчим хүчийг бид нар төвийн эрчим хүчний систем дээрээ 305-550 төгрөгөөр авч байна гэдэг чинь юу гэсэн үг юм бэ. Арай шударга биш байгаа биз дээ. Нийт эрчим хүчний нийлүүлэлтийн 3 хувийг тэр компаниуд нийлүүлчхээд, бэлэн мөнгөний урсгалынх нь 27 хувийг аваад явчихдаг. Үгүй ээ, энэ чинь арай л дэндүү шударга бус зүйл гэж харж байгаа. Энэ дээр ямар арга хэмжээ авах юм бэ. Эрчим хүчний сэргэлтийн бодлого дор хаяж эндээсээ авхуулаад эхлэх ёстой гэж харж байгаа шүү гэдгээ хэлье ээ. Энэ дээр нэг хариулт аваадахъя.

3 дугаарт нь бид нар ирэх онд хөгжлийн тэргүүлэх чиглэлээ хүний хөгжил рүү чиглүүлж байна. Хүний хөгжлийн асуудал дээр эрүүл мэндийн асуудал хамгийн чухал. Өнөөдөр дэлхийн 183 улсаас хавдрын өвчлөлөөрөө Монгол улс тэргүүлж байх жишээтэй. Өвчлөгчдийн 72,5 нь хожуу үедээ оношлогддог гээд маш их эрсдэлтэй түвшинд байгаа. Нас баралтын түвшин ч гэсэн өндөр байгаад байгаа юм. Гэтэл бид нар нийгмийн эрүүл мэндийн тухай хуульгүй, нийгмийн соён гэгээрэлтэй холбоотой ямар нэгэн асуудлыг идэвхжүүлэхгүйгээр цаашидаа юу ч хийж чадахгүй. Бид нийгмийн соён гэгээрэл, нийгмийн эрүүл мэндийн асуудлыг тавьж байж хүн ардаа эрүүл мэндийн талаар соён гэгээрүүлдэг. Цаашидаа зөв хэв маягт амьдрах, ажиллах, бүхий л нөхцөл байдлуудыг бүрдүүлэх тэр боломжуудыг

бүрдүүлнэ. Тэгэхээр ирэх жил энэ чиглэлээр ямар ажлууд хийгдэх юм бэ. Яг энэ нийгмийн эрүүл мэндийнхээ тухай хуулиа ч гэсэн оруулж ирж, бид нар батлуулж чадах уу гэдэг дээр хариулт өгөөч ээ.

Хамгийн сүүлд нь Засгийн газраас Аж үйлдвэр технологийн паркуудыг байгуулж байгаа. Энэ паркуудын ажил ер нь ямар шатад явж байгаа юм бэ. Манай Эрдэнэт үйлдвэрлэлийг түшиглээд гидрометалургийн химийн үйлдвэрлэлүүд байгуулна гэсэн. Энэ үйлдвэрлэлүүд 2025 онд ашиглалтад орох уу. Одоо яг гүйцэтгэлийн хувь нь ямар түвшинд явж байгаа юм бэ гэдэг дээр хариулт авъя. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Ганбаатар сайд түр хүлээж байгаарай. Зочин танилцуулъя. Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Улс төр судлалын 4 дүгээр дамжааны оюутнуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгдийн хичээл, сурлагад өндөр амжилт хүсье.

Асуултад хариулъя Ганбаатар сайд хариулах уу.

Ж.Ганбаатар: Би эхлээд хариулчихъя. Уул уурхайн яамнаас бол 2024 онд нүүрсний экспортын хэмжээг 45,1 сая тонн гэж гаргаж өгсөн. Тэгээд ер нь Сангийн яам болоод Эдийн засгийн хөгжлийн яам бол 50 сая тонн орчим гэж тодорхойлж байгаа. Ер нь уул уурхай өөрөө бид манай салбар ер нь 60, 70 сая тонныг ч гэсэн гаргах бүрэн боломжтой. Гэхдээ зүгээр мэдээж та бүхэн сайн мэдэж байгаа Батлут гишүүн ч гэсэн өөрөө мэдэж байгаа. Тээвэр логистик, хил гаалийн асуудал, худалдан авагч улсын бодлого гэдэг зүйл хамгийн гол байна. Гэхдээ бид нар энэ 45,1-ийг нэлээн тийм олон талын баримтуудыг судалж байж 45,1 гэдэг тоог гаргаж өгсөн. Түүнээс биш Монгол Улс өөрөө 60, 70 сая тонныг

ч гэсэн гаргах бүрэн боломжтой. Уурхайнуудын хүчин чадлыг хэлж байгаа шүү. Хятад улсын нийт хэрэгцээ та бас сайн мэдэж байгаа байх. 6,4 тэрбум 1 жилийн хэрэгцээ нь. Тэрний ойролцоогоор 450 сая тонн коксжсон нүүрсний хэрэгцээ байдаг. Үүний экспортоос авч байгаа нь ойролцоогоор 80 сая, сүүлийн үед 100 сая тонн коксожсон нүүрсийг экспортоор авах төлөвлөгөөтэй байгаа юм байна лээ. Тийм учраас коксожсон нүүрсний хувьд 40 хувийг нь, экспортынх нь 40 хувийг нь Монгол улс хойд бүс гэсэн утгаар нь, хойд бүсийн гангийн үйлдвэрүүдээр хангах бүрэн боломжтой. Сүүлийн үед энэ гишүүдэд ирж байгаа мэдээллүүд энэ Австралийн нүүрснүүд Хятад, Индонезийн нүүрснүүд Хятад улсын хэрэгцээг их нэлээн байна. Тэр бол урд бүс дээр. 2 дугаарт дийлэнх нь эрчим хүчний нүүрс байгаа гэдгийг бас Батлут гишүүнд хэлье.

Ер нь 50 сая тонн нүүрсний төлөө Уул уурхайн яам болоод манай бүх л яамдууд хамтраад энийг гаргахын төлөө хичээнгүйлэн ажиллана. Ерөнхий сайд Хятад улсад айлчлахад бид бас энэ талын гэрээ хэлэлцээрүүдийг хийх талаар бас төлөвлөгөө боловсруулаад ажиллаж байгаа гэдгийг хэлье ээ.

Эрдэнэт үйлдвэрийн, үйлдвэр технологийн паркийн хувьд бид бүх зүйлийг нь гаргаад батлаад өгчихсөн байгаа. Эрдэнэт үйлдвэр зүгээр яах вэ төлөвлөгөө дээр бол Эрдэнэт үйлдвэрийн энэ уул уурхайн металлургийн химийн үйлдвэрийн цогцолборыг 100 хувь гэж тавьсан байгаа. Энэ 100 хувь биелүүлэх ажлыг Уул уурхайн яам, Эрдэнэт үйлдвэрийг шахааж ажиллана. Бусад үйлдвэр технологийн паркуудын хувьд Засгийн газар байршлуудыг нь зарлах ёстой. Бусад байршлуудын хувьд тэр бусад газрууд нь шаардлага хангасан тэр юунуудаа гаргаж өгөөгүй байгаа. Тийм учраас байршлуудыг зарлах хэмжээнд арай хүрээгүй байна аа. Хариулт дууслаа. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Хариулт хангалттай юу. Эрчим хүчний чиглэлээр асуусан асуултад хариулъя. Чойжилсүрэн сайд хариулъя.

Б.Чойжилсүрэн: Батлут гишүүний асуултад хариулъя. Батлут гишүүний ярьж байгаа асуудлууд бүгдээрээ үнэн. Ажиллаж байгаа 6 нарны станц, 3 салхины станцыг төвийн эрчим хүчний системд холбочихсон байгаа. Эдгээр аж ахуйн нэгжүүдэд үнээ буулгаач ээ, эрсдэлээ хуваалцъя гэдэг ийм шаардлагуудыг хүргүүлсэн. Гэхдээ өмнөөс бол Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль, эрх зүйн орчинд бизнесийнх нь орчинд бид нар энэ хөрөнгө оруулалтыг хийсэн гэдэг ийм тайлбарыг тавьдаг. 2 талаасаа ингээд зөвшилцөл, ойлголцол шаардлагатай байгаа. 2 талаасаа жоохон хатуу тулж байгаа. Засгийн газрын тогтоол гарсан. 2023 оны 1 дүгээр улиралдаа багтааж танилцуул гэсэн. Энэ хөрөнгө оруулагч нар нь бас гадаадын том банкнууд байгаа. Үндэстэн дамнасан корпорацууд байгаа учраас эд нартай хэл амаа ололцохын тулд 2 улирлаар сунгая гэж. Тухайлбал 2023 оны 2, 3 дугаар улиралд бид нар үргэлжлүүлэн ажиллаад, 3 дугаар улирлын төгсгөлд Засгийн газарт танилцуулна гэсэн ийм баримжаа чиглэлтэй байгаа. Ингэхгүй бол санхүүгийн асуудал, техникийн хувьд ч хүндрэл үүсгэж байгаа шүү дээ. Бидний захиалсан хугацаанд эрчим хүч нийлүүлдэггүй. Яг хэрэгцээгүй үед бол нийлүүлчээд нийт орлогын 27 хувийг авчихсан ийм хүндрэлүүд байгаа. Тэгээд үргэлжлүүлээд ажиллаж байна. Үнээ буулга гэдэг ийм шаардлагыг бол залгагдсан байгаа 9 станцын тухайд тавьж байгаа. Бас намайг ажил авахаас өмнө тусгай зөвшөөрөл авчихсан байгаа 11 аж ахуйн нэгж буюу сэргээгдэх эрчим хүчин дээр 3 салхины, 8 нарны станцын тухайд. Эднийг одоохондоо бид нар холбож чадахгүй байгаа. 2 үндсэн шалтгаан байгаа нь бид нарсалхи зогсвол эсвэл нар орох юм бол чадал захиалж

чадахгүй байгаа. Энэ асуудлаа бид нар ямар ч байсан шийдье гэсэн ийм шийдэл олсны дараа та бүхнийг эргэж холбогдоно. Төвийн эрчим хүчинд залгуулах талаар тэр тухайн үед нь ярьж гэсэн ийм байр суурьтай байгаа.

Л.Мөнхбаатар: Нэмж эрүүл мэндийн чиглэлээр асуусан асуултад хариулъя. Хэн хариулах вэ. Ажлын хэсгээс. 83 дугаар микрофоноо өгье. Ажлын хэсгийн 83.

Л.Балчинлуvsан: Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын дарга Балчинлуvsан. Эрүүл мэндийн чиглэлээр хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна гээд тэргүүлэх чиглэлийн 3-д эрүүл мэндийн асуудлуудыг маш чухлаар тавьсан байгаа. Үүнийхээ хүрээнд хамгийн чухалчилж эмийн чанарын асуудлыг ер нь нэн чухлаар тавигдана. Үүнийхээ хүрээнд эмийн нийлүүлэлт, худалдан авалтыг оновчтой зохион байгуулж, эмийн чанарыг сайжруулан олон улсын гэрээний худалдан авалтыг оновчтой нэвтрүүлнэ гэсэн ийм чухал заалтуудыг оруулж өгсөн.

2 дугаарт эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ гээд. Энэ хүрээнд нөгөө гадагшаа, дотогшоо Монголдоо эмчлэгдэх боломжгүй өвчний нэр төрлийг багасгаж, 126 нэр төрлийн Монголд эмчлэгдэх боломжгүй өвчин байгаагаас 2024 онд тэрийг 3-4-өөр буулгая гэсэн тийм зорилт тавьсан гол гол арга хэмжээнүүд тусгагдсан байгаа. Мөн таны дурдсан сая тэр Хавдар судлалын эмнэлэг, бусад шаардлагатай эмнэлгүүдэд хөрөнгө оруулалтыг хийнэ гэж төлөвлөсөн байгаа.

Л.Мөнхбаатар: Дамбын Баттулгад гишүүн тодруулж асууя. Нэг минут.

Д.Батлут: Энэ нүүрс гаргалтын төлөвлөлттэй холбоотой асуудлыг бас

манайхан нэлээн сайн бодсон биз дээ. Тал талаас нь. Манай хил гаалийн нэвтрүүлэх чадвар, тээвэр ложистикийн ямар байгаа билээ. Яг тэгээд 50 сая тонндоо хүрч л байвал одоо Монгол улсад сайн хэрэгтэй байгаа. Тэгээд энийг бас төлөвлөж бодсон байх гэж бодож байгаа юм. Эрүүл мэндийн салбарын хүн байхгүй учраас бас сайн төдийлөн хариулт өгсөнгүй. Ер нь тэр эмийн чанар шаардлагатай холбоотой асуудал чухал уу чухал. Тэгэхдээ нийгмийн эрүүл мэнд бол түүнээс чухал асуудал байхгүй юу. Магадгүй эрүүл мэндийн салбарын бараг 60, 70 хувь нь нийгмийн эрүүл мэндийн асуудлаар хуулиар зохицуулж тэр соён гэгээрлийн ажлыг хийснээрээ бид нар илүү томоохон үр дүн, нөгөө өвдөхөөс өмнөх арга хэмжээнүүдийг нэлээн сайн авах боломжууд байгаа байхгүй юу. Тэгээд энэ тал дээр ямар арга хэмжээ хийх вэ. Тэр нийгмийн эрүүл мэндийн тухай хуулиа оруулж ирэх үү гэхээр тодорхой хариулах хүн байхгүй байгаад байх юм. Олон удаа л энэ асуудлыг ярьж байгаа.

Эрчим хүчний сайдын хувьд тэр сэргээгдэх эрчим хүчнийхээ нөхдүүдтэй нэг ярилцаж тохиролцоод үнэ ханшийг нь бууруулаад, энэ дотоод дахь энэ асуудлаа цэгцэлчихвэл болж л байна.

Л.Мөнхбаатар: Одоо Хавдисламын Баделхан гишүүн асуултаа асууя.

Х.Баделхан: Баярлалаа. Өнгөрсөн жил Ерөнхий сайд маань манай аймагт очоод хилийн боомтуудтай танилцсан. Хятадын талын Даянгийн боомт, Оросын талын Цагаан нуурын боомттой танилцаад газар дээр нь иргэдтэй уулзсан. Тэгээд боомтуудыг тохижуулна, хөгжүүлнэ гэж ярьсан. Яг энэ тал дээр ирэх жил төлөвлөгөөнд орсон хийх юм байна уу. 1 дүгээрт.

2 дахь нь бол тэр Даянгийн боомт, Оросын хил залгах Цагаан нуурын боомт 2-ыг холбосон зам барих асуудал яригдаж

байгаа. Энийг бол Хятадын тал маш их сонирхож байгаа. Хятадын талын зам бол яг хил дээр 2 урсгалтай олон улсын зам ирсэн. Тэгээд Хятадын Шинжаан мужийг Оросын цэвэртэй Сибирьтэй холбогдох тийм асар их сонирхолтой байгаа. Энэ 2 мужийг холбосон хамгийн дөт зам бол тэр Даян, Цагаан нуурын зам байдаг юм байна. Энэ замыг барина гэж бас ярьсан. Тэгээд энэ төлөвлөгөөнд орсон уу гэж.

Дараагийн асуудал бол энэ нутгийн зам төслийн хүрээнд. Нутгийн зам төслийн хүрээнд бол манай аймагт Сагсай, Улаанхус, Цэнгэл чиглэлийн 80км замыг бол барина гэж. Энэ бол манай Засгийн газрын мөрийн хөтөлбөрт орсон. Зураг төсөв нь бэлэн болсон. Одоо ирэх жил энэ ажил эхлэх үү. Энэ ковидоос болоод бид нар энэ ажлыг эхэлж чадаагүй 2024 онд эхэлнэ гэж иргэдтэй очоод уулзахад бид нар ийм хариу өгч байгаа. Ирэх жилийн төлөвлөгөөнд энэ зам орсон уу. Энэ ер нь хэзээ баригдах вэ гэсэн 2 дахь асуудал.

3 дахь онд бол манай аймгийн нисэх онгоцны буудал олон улсын статустай байсан. Нэг үедээ бол энэ Казахстан Өлгий хооронд бол тогтмол онгоц нисдэг байсан. Сүүлийн үед энэ нислэг зогсчихлоо. Энэ олон улсын статус нь байна уу, үгүй юү. Тэгээд энэ манай аймгийн нисэх буудлын талаар ер нь цаашидаа ямар бодлоготой байдаг юм бол. Ирэх жилийн төлөвлөгөөнд орсон зүйл байна уу гэж ийм 3 асуулт асууя. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Баделхан гишүүний асуултад хариулъя. Зам, тээврийн яамнаас л асууж байна даа. Хэн байна. Батболд дарга байгаа юу. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батболд хариулъя. 91 дүгээр микрофоныг өгье.

С.Батболд: Баделхан гишүүний асуултад хариулъя. Өлгий хотын нисэх буудлын ажлын үргэлжилж байгаа мөнгө

үргэлжлээд суугдахаар явж байгаа. Ер нь ганц Өлгий биш, бусад энэ онд хэрэгжиж байгаа ажлууд бүгд үргэлжлээд явж байгаа. Тэр бүгд тусаж байгаа.

Л.Мөнхбаатар: 3 асуулт асуусан. Нөгөөдөх нь нисэх буудалтай холбоотой асуулт байсан. Нутгийн замтай холбоотой асуудал. Олон Улсын нисэх буудал буюу 4С гээд.

С.Батболд: Эийтдээ энэ 2024 оны жилийн төлөвлөгөөнд манайхаас 134 төсөл, арга хэмжээний санал явуулсан. Яг энэ төлөвлөгөөнд 36 төсөл арга хэмжээ явж байгаа. Энэ дотор саяын таны хэлсэн зам арай ороогүй байна.

Л.Мөнхбаатар: Нутгийн зам төслийн талаар асуусан. Тодорхой замын трасс асуугаад байх шиг байна. Тэнд нь их тодорхой хариулчих.

С.Батболд: Нутгийн нутгийн зам хөтөлбөрийн хүрээнд ч гэсэн орсон замууд бас энд тусаагүй байж байгаа. Гол нь олон улсын болон улсын чанартай замууд үргэлжилж байгаа болон шинээр 24 төсөл орсон явж байгаа. Энэ бол яг нутгийн зам хөтөлбөр гэхээсээ илүү нөгөө төв замтайгаа холбогдож байгаа гэдэг нэрээр орсон ийм авто замын 24 төсөл байж байгаа. Нийтдээ 668,9 км авто замын ажил туссан байж байгаа.

Л.Мөнхбаатар: Хавдисламын Баделхан гишүүн тодруулж асуух уу. Тодруулж асууя 1 минут.

Х.Баделхан: Тодруулаад асуучихъя. Яг Засгийн газрын мөрийн хөтөлбөрт орсон шүү дээ. Нутгийн зам төслийн хүрээнд манай аймгийн Цэнгэл сум хүртэл нийтдээ Сагсай, Улаангом, Цэнгэл гэж 3 сумд бол 80 км зам зураг төсөв нь бэлэн болсон. Энэ ажил бол ирэх жил ядахдаа 10 км зам тавьж энэ нутгийн зам төслийг бол эхлүүлмээр байна л даа. Энэ дээр ер нь төлөвлөгөөнд орсон юм байна уу гэж.

Л.Мөнхбаатар: Баделхан гишүүний асуултад хариулъя. Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батболд хариулъя. Ажлын хэсгийн 91 дүгээр микрофоныг өгье. Их тодорхой асуулт асуугаад байна шүү дээ. Энэ дээр их тодорхой хариулчихмаар байна.

С.Батболд: Баделхан гишүүний асуултад хариулъя. Энэ хөтөлбөрт байгаа. Бид нар энэ төслийг явуулсан. Гэхдээ энэ төлөвлөгөөнөөс түрүүний миний хэлсэн 134 төслөөс манайхаас 36 л орсон байж байга. Бусад нь хасагдчихсан байж байгаа. Тэгээд таны хэлсэн энэ төсөл бол манайхаас явуулсан саналд байгаа. Энэ орж ирж байгаа төсөл дотор байхгүй байна.

Л.Мөнхбаатар: Тэгэхээр Зам, тээврийн яамнаас явуулсан бичиг дээрээ байгаа юм байна шүү дээ. Тэгээд Эдийн засаг, хөгжлийн яамнаас хэрхэн яаж хасагдсан юм бэ. Энэ талаараа тайлбар мэдээллээ өгчих. 83 ажлын хэсгийн 83 дугаар микрофоныг өгье. Эдийн засаг, хөгжлийн яамны төлөөлөл хариулъя.

Л.Балчинлуvsан: Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын дарга Балчинлуvsан. Баделхан гишүүний асуултад хариулъя. Нийт хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдах ажлуудыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан нь хуулийн дагуу бид нар шалгаруулсан байгаа. Үүнд юу вэ гэхээр Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.10.2-т жилийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээнүүд нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон, хариуцах эзэнтэй, ТЭЗҮ, зураг төсөв нь батлагдсан тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл арга хэмжээг эрэмбэлсэн байх гэсэн ийм шаардлага байдаг учраас энэ Улаанхус

чиглэлийн зам нь ТЭЗҮ нь хийгдээгүй зам байсан. ТЭЗҮ, зураг төсөв нь хийгдээгүй тийм ажил байсан гэдэг.

Л.Мөнхбаатар: Гүйцээгээд хариулчихъя. Ажлын хэсгийн 83 дугаар микрофоныг өгье.

Л.Балчинлуvsан: Хуулийн циклийн дагуу жилийн төлөвлөгөөнд 1 сарын 15-ны дотор хариуцсан яамдууд төсвийн ерөнхийлөн захирагч нар манай яаманд саналуудаа ирүүлэх ёстой байдаг. Бид нар тэр ирүүлсэн саналуудын мэдээлэл дээр үнэ үндэслэн энэ шалгаруулалтаа явуулдаг байгаа. Тухай хариуцсан яамдаас нь ийм мэдээллүүд ирсэн байгаа.

Л.Мөнхбаатар: Хавдисламын Баделхан гишүүн тодруулж асууя. 1 минут.

Х.Баделхан: Үгүй ээ, энэ чинь ерөөсөө яамны захиалгаараа зураг төсөв, ТЭЗҮ хийгдээд зураг төсөв бэлэн болсон зураг төсөв нь батлагдсан шүү дээ. Тэгээд энэ яамдууд хоорондоо мэддэггүй юм уу. Зураг төсөв бүх юм бэлэн. Энэ жилээс ажлаа эхэл гэж бүх юмаа хийчихсэн шүү дээ. Өнөөдөр чуулганы танхим дээр зураг төсөв бэлэн биш байна гээд сууж байх нь ямар учиртай юм бэ. Энийг оруулж өгөөч гэсэн хүсэлттэй байгаа. Бүр Ерөнхий сайд очихдоо амлаад явчихсан шүү дээ.

Л.Мөнхбаатар: Нэмж хариулах юм уу. Хэрвээ тодорхой санал байсан бол Байнгын хороон дээр зарчмын зөрүүтэй саналаа гаргаад оруулах боломж байсан. 28 санал хураагдана. Баделхан гишүүнд Эдийн засаг, хөгжлийн яамныхан тодорхой мэдээллээ өгөөрэй. Одоо Буланы Бейсен гишүүн асуултаа асууя.

Б.Бейсен: Дарга аа, энэ салбарын сайдууд нь байж байвал бас зүгээр байна. Засгийн газрын гишүүд энэ бас ирсэн байх ёстой юм байна. 1 дүгээрт Уул уурхайн сайдаас асуумаар байх юм. Манай аймагт

Асгатын мөнгөний ордыг ашиглалтад оруулна гэсэн бараг 30-аад жил хайгуулын ажил гээд яваад байх юм. Сонгууль болгон дээр тэгээд ашиглалтад орох гэж байна гээд ард иргэдийг хуурдаг. Энэ өндөр хүчдэлийн асуудал, замын асуудлыг шийдсэн болов уу энэ талаар асууя. Нөгөө талаар тэр ногоон орсон юмнууд дулаан харийн хар тугалганы үйлдвэр баригдсан байгаа шүү дээ. Эзэнгүй байж байгаа. 2, 3 жил болж байна. Хятадын компанийн эзэн нь баригдаад явчихсан. Тийм юм байгаа. Нөгөө талаар Цэнгэл сум дээр мөн адилхан алтны том уурхай ашиглалтад орж байгаа. Энэ ер нь Монгол Улсын төсөвт юм оруулдаг болов уу. Бас л оффтейк гэрээгээр зарчихсан юм болов уу. Энэ талаар тодорхой мэдээлэл авъя.

Энэ боловсролын сайд бас байхгүй байна. Энэ хөдөөгийн сургуулиудын компьютер, тоног төхөөрөмж гээд ерөөсөө байхгүй болсон. Энэ талаар төсөв дээр юм тавигдсан юм болов уу.

Эрүүл мэндийн сайд дээр мөн адилхан. Эмнэлгүүд гүйцэтгэлийн санхүүжилтээр санхүүжнэ гээд яриад байгаа. Гэтэл оношилгооны тоног төхөөрөмж юу ч байхгүй. Энэ тал дээр энэ жилийн 2024 оны төсөв дээр юм тавигдсан байна уу. Бид нар 2024 онд тавина гээд ярьчихсан байгаа. Сая Монголд эмчлүүлж болохгүй өвчин гээд 23 өвчний жагсаалт 26 өвчний жагсаалт ярьж байна л даа. Энэ дээр тодорхой хэмжээний юм тавьж өгөхгүй бол зарим хавдартай Монголд үнэхээр эмчилж болохгүй өвчтөнүүдийг гадагшаа яваад аав, ээж нь хамаатан садан фэйсбүүкээр, албан байгууллагаар ингээд гуйлга гуйгаад явдаг. Энэ дээр тодорхой хэмжээний төсөвт тавьж өгөөд, энийг шийдэхгүй бол хавдар чинь ихсэж байна. Монголд эмчлэх үнэхээр боломжгүй юмнууд байна шүү дээ. Энийг шийдэх тал дээр юм тавигдсан уу?

Соёлын сайд байхгүй байна. Хүрлээ сайдаас бас асууя. Энэ сумууд дээр соёлын

төвүүд баригдаж байгаа. Дэлүү нь, Улаанхус, Бугат сумууд дээр. Энэ сандал ширээ нь байхгүй, цогцоор нь шийдэхгүй ийм юм барьчхаад байх юм. Энийг энэ жилийн төсөвт тавина гээд түрүүн Соёлын сайд ярьж байсан. Тавьсан юм болов уу. Яасан юм бол 2024 оны төсөв дээр. Аль эсвэл энэ жил шийдчихэж байгаа юм болов уу. Дараа нь энэ малчид ярьж байгаа нь ерөөсөө малын түүхий эд хаягдаж байна. Арьс шир ноос. Энийг ядахдаа нэг бүсийн хэмжээнд үйлдвэр барих боломж бий юу. Энийг төлөвлөсөн юм байна уу. Энэ цалин, эрүүл мэнд, боловсрол, төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг нэмэхгүй бол үнэхээр бүгдээрээ цалингийн зээлтэй. Байдал хүнд байна шүү дээ. Инфляцын түвшин тэр өргөн хэрэглээний бараа нь нэмэгдчихсэн. Мэдээжийн шалтгаан нь нэмэгдчихсэн. Энийг хувиар биш сүлжээгээ 2 дахин нэмж байж энэ цалинг нь нэмэхгүй бол жирийн иргэдийн шаардаж байгаа нь тэр асуудал байна. Дараа нь энэ жил манай аймагт пресс өвч 50 мянга, хорголжин 80 мянга хүрсэ. Ногооннуур сумын Ачит нарын сав газрын хадланг өвөлжингөө хаддаг. Энийг намартаа энэ нэг ядахдаа 400, 500 сая төгрөг тавьж өгөөд тэр хадланчдад өгвөл өвс тэжээлээ эрт бэлдчих боломж байгаа байхгүй юу. Ховдод мөн адилхан. Тэр Хар нуурын сав газраас хадлан бэлдэх боломж бий шүү дээ. Гэтэл энэ жил малчдад үнэхээр хүнд байдалтай байна. Энэ дээр анхаарах төсөв тавих боломж байна уу ер нь. Цаашидаа төлөвлөж байгаа юм байна уу. Энэ талаар асууя.

Л.Мөнхбаатар: Булганы Бейсен гишүүн дараа нь, дараа нь гэсээр байгаад нийтдээ бараг 8 асуулт тавьчихлаа. Хэн хариулах вэ. Ганбаатар сайд хариулъя. Дараа нь нэмж хариулъя. Ажлын хэсэг.

Ж.Ганбаатар: Бейсен гишүүний асуултад хариулъя. Энэ Асгатын мөнгөний ордны хувьд Уул, уурхайн яамнаас ямар бодлого барьж байгаа вэ гэхээр Эрдэнэс Монгол компани

өөрийнхөө хөрөнгөөр 10,5 тэрбум төгрөгөөр хайгуулын ажлыг үргэлжлүүлж байгаа юм. 2024 онд хийж дуусгана. Ямар шаардлага байгаа вэ гэхээр Асгатын мөнгөний орд маань өөрөө ер нь хайгуулын ажлыг нэмэгдүүлснээр нөөц нь өсөх бүрэн боломжтой гэж Уул, уурхайн яам үзэж байгаа юм. Энэ нөөц нь өссөнөөр ямар давуу талууд үүсэх вэ гэхээр гаднын болоод дотоодын хөрөнгө оруулагчдын сонирхол эрс дээшилнэ. Олон жил бараг 1997 оноос хойш энд ямар нэгэн зүгээр л яриад л байсан болохоос биш огт тэнд юу байгаа юм, яг нөөц нь нэмэгдэх юм уу, үгүй юу. Одоо яг тэр мөнгөө дагаад цаана нь яг юу байгаа юм. Уг нь бол сонирхож байгаа тал маш их байгаа. Тийм ч учраас төсвийн мөнгөөр биш шүү дээ. Эрдэс Монгол компани өөрийнхөө хөрөнгөөр энэ жил 10,5 тэрбум төгрөг тавьчихсан байгаа. Энэ мөнгөөр хайгуулын ажлыг үргэлжлүүлээд, өргөтгөөд тэр нөөцийг нь нэмэгдүүлж тогтооно. Тэрний дараа гаднын болон дотоодын хөрөнгө оруулалтуудад саналуудаа тавина. Яг энэ дэс дараалалтай ажил үргэлжлээд явж байгаа юм. Энийг би бас Аубакир гишүүнд бас яг тухайн үед нь юуны Үйлдвэржилтийн байнгын хороо дээр тодорхой хариултуудыг өгч байсан. Энэ хүрээнд энэ ажил хийгдээд явж байгаа гэдгийг хэлье. Хариулт дууслаа.

Л.Мөнхбаатар: Нэмж хариулъя. Монгол Улсын Шадар сайд Чимэдийн Хүрэлбаатар нэмж хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Бейсен гишүүний асуултад хариулъя. Зарим зүйлүүдийг 2024 оны төсөв дээр суулгах уу гэсэн ийм асуулт байгаа. Тэгээд өнөөдрийн хэлэлцүүлэг бол энэ жилийн төлөвлөгөө. Үүний өмнө бид нар төсвийн хүрээгээр ярьсан. Яг төсөв дотор одоо яг энэ дээр энийг тэр тэр сумуудад баригдсан соёлын төвүүдийн доторх ширээ, сандал, тоног төхөөрөмжийг төсөв дээр тавина гэж хэлэх арай л болохгүй болов уу гэж бодож байна. Тэгээд энийг 2024 оны төсөв дээр

орж ирэхээр яригдана гэдгийг би 1 дүгээрт нь хэлье.

2 дугаарт нь ер нь тэр яамдууд бол энэ чиглэлийнхээ төлөвлөлтийн ажлыг хийгээд явж байгаа гэдгийг би хэлмээр байна.

Л.Мөнхбаатар: Та тодруулах уу. Бейсен гишүүн тодруулж асууя. Бейсен гишүүний микрофоныг өгөөрэй.

Б.Бейсен: Соёлын төвүүд нь баригдчихсан байгаа байхгүй юу. Ашиглалтад өгчихсөн. Тэгээд нөгөө яамдууд тавьж өгөхгүй байна. Энийг цогцоор нь шийдэх тал дээр анхааръя гэж байна. Нөгөө талаар Ганбаатар сайд тэр Дулаан харын хар тугалганы үйлдвэр гээд том үйлдвэр баригдчихсан байгаа байхгүй юу. Тухайн үед тэнд чинь 1976 онд Оросынхон яагаад 8 тонн алттай гээд тогтоосон байна. Тэгээд Хятад эзэн нь баригдаад явчихсан тийм асуудал байгаа. Одоо Цэнгэл дээр баригдаж байгаа тэр алтны уурхай гээд том уурхай баригдчихсан. Энэ төсөвт юм орж байна уу? Ер нь энэ талаар улс анхаарч байгаа юм байна уу. Оффтейк гэрээгээр зарчхаад гадаадынхан ашиглах гээд байна уу энийг. Энэ талаар тодорхой мэдээлэл авъя гэсэн юм.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсэг хариулъя. Ажлын хэсгийн 93 дугаар микрофоныг өгье.

М.Мэндбаяр: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Мэндбаяр. Бейсен гишүүний асуултад хариулъя. Дулаан харын хар тугалганы үйлдвэр болон Цэнгэл сумын алтны ордын ашиглалтын талаарх мэдээллийг Бейсен гишүүнд дэлгэрэнгүй байдлаар нь албан тоотоор манайхаас хүргүүлье. Яг одоо товчхондоо хариулахад бол аль аль нь үйл ажиллагаа явахгүй, зогсож байгаа. Манай дээр Уул уурхайн яам болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Ашигт малтмал

газрын тосны газрын байгаа мэдээллээр манайд ирүүлж байгаа мэдээллээр бол үйл ажиллагаа явуулаагүй икс тайлантай байгаа гэсэн мэдээлэлтэй байгаа.

Л.Мөнхбаатар: Балжиннямын Баярсайхан гишүүн асуултаа асууя. Дараа нь санал хураалт явагдана. Нийтдээ 28 санал хураалт байгаа.

Б.Баярсайхан: Баярлалаа. Энэ зарчмын зөрүүтэй саналд энэ Завханы нэг гол ажил би яриад байна. Энэ ажил Эдийн засгийн байнгын хороо дээр өгч амжаагүй байна. Тэгээд энийг ямар байдлаар энэ ажлаа оруулах юм. Арц суурь боомтын шинэчлэлийн ажлыг энэ 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгамаар байна. Энэ 2021 онд ярьж байсан. Загастайн давааны 6,1 тэрбум төгрөгийг суулгах юм уу. Энэ Арц суурь боомтынхоо 8,5 тэрбум төгрөгийн шинэчлэлийг хийлгэх юм уу гээд ингээд Засгийн газар мэдэж байсан шүү дээ. Тэгээд энэ Арц суурь боомтын шинэчлэлийн ажлыг нь оруулж өгөөч ээ. Мөн манай Идэр сумаас төв замд холбогдох 12 км авто зам, мөн Нөмрөг, Сонгиноос Арц суурь хүртэлх 167 км авто замын зургийг, ТЭЗҮ-г би өөрөө санал өгч ингээд бүх юм нь гарчихсан байгаа зураг нь. Тэгээд энэ ажлууд орсон уу гэдгийг ажлын хэсгээс асууя. Мөн энэ цэвэрлэх байгууламж баригдаж байгаа. 10 аймаг, 5 аймгийн төв дээр. Гэтэл энэ Польшийн Засгийн газартай хэрэгжүүлж байгаа энэ ажил дээр аймаг болгон дээр 1, 1 сая еврогийн ажил дутсан. Санхүүжилт дутчихсан байгаа. Энэ асуудал энэ 2024 оны хөгжлийн төлөвлөгөө дээр орж байна. Санхүүжилт нь. Энэ ажил хийгдэх үү гэдгийг бас асууя. Улиастайгаас Алтай хүртэлх 198 км авто зам Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр баригдах ёстой. Энэ яагаад 42 км гэж ороод байгаа юм бэ. Бусад километрүүд нь хаана, хэзээ хийгдэх гээд байгаа юм. Эсвэл санхүүжилт нь байхгүй болчихсон юм уу. Энэ дээр бас тодорхой хариулт авмаар байна.

Л.Мөнхбаатар: Баярсайхан гишүүн Завхан аймгийн Арц суурь боомтын шинэчлэлттэй холбоотой асуулт асууж байна. Ер нь бол зарчмын хувьд Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэх үед зарчмын зөрүүтэй саналаа хураалгаад ингээд дэмжүүлээд явах боломж байсан. Гэхдээ энэ чиглэлээр нь ажлын хэсгийн ахлагч хариулт өгөх үү. Баагаагийн Баттөмөр дарга хариулт өгье.

Б.Баттөмөр: Эдийн засаг, хөгжлийн яамнаас орж ирсэн санал дээр Арц суурийн зам бол орж ирээгүй. Тийм учраас ажлын хэсэг дээр бол нөгөө цаад талын гадаад, дотоод эх үүсвэртэйгээ бүх зүйл уялдаж явдаг учраас нэмээд байх боломж байгаагүй юм. Тэгээд яагаад оруулж ирээгүй, яах гэж байгааг бол яам нь өөрсдөө хариулах нь илүү оновчтой байх.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгээс нэмж хариулъя. Зам, тээврийн яам нэмж хариулъя. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батболд хариулъя. Ажлын хэсгийн 91 дүгээр микрофон өгье.

С.Батболд: Баярсайхан гишүүний асуултад хариулъя. Алтай Улиастай чиглэлийн энэ замын 42 км нь орсон байж байгаа. Энэ яагаад хасагдчихав гэх дээр Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Ховд, Улаангом, Алтай, Улиастай гээд 2 зам байгаа. Тэгээд санхүүжилтээсээ болоод энэ хэсэг нь Алтай Улиастай чиглэлийнх 42км-ээр орсон. Энэ Азийн хөгжлийн банкны бүс нутгийн авто зам хөгжүүлэх төслийн энэ 3 дахь шатын төсөл гэж явж байгаа. 4 дэх шатын төсөл бас яригдаж байгаа. 4 дэх шатын төслөөр энэ замыг үргэлжлүүлэхээр Сангийн яам, Азийн хөгжлийн банктай бид нар одоогийн байдлаар ярьж байгаа. Мөн таны дараагийн нэг асуудал нь тэр Арц сууриас Нөмрөг хүртэлх энэ зам мөн Азийн хөгжлийн банкны 4 дэх шатын

төслийн хүрээнд банктай яригдаж явж байгаа. Тийм учраас энд орж ирээгүй байгаа.

Л.Мөнхбаатар: Тодруулах юм уу? Балжиннямын Баярсайхан гишүүн тодруулж асууя. Нэг минут.

Б.Баярсайхан: Энэ магадлал, зураг, ТЭЗҮ хийгдчихсэн ажлууд чинь тухайн жилийнхээ төсөвт ороод явдаг биз дээ. Улиастай сум Богд, Чигэстэй голын төмөр бетон гүүрний барилга угсралтын ажлын шинэчилсэн төсөв. Нөмрөг, Улиастай чиглэлийн энэ авто зам, Идэр сумын энэ 12 км авто замын энэ бүх зургууд нь гарчихсан байж байна шүү дээ. Тэгээд яагаад дараагийн дараагийн ажлуудад ингэж тавигддаг юм бэ. Ер нь Ховд аймаг, Увс аймаг манай аймгаас хамаагүй хөгжилтэй бүх сумдууд нь нийслэлтэйгээ холбогдчихсон байгаа шүү дээ. Тэгээд яагаад Завханы ажил гэхээр ингээд 42км болгочихдог юм. Арай дэндүү нутаг усны ийм ялгаварлал гаргаад байгаа юм биш үү. Энэ болохгүй шүү дээ ингэж. 167 км авто замыг Азийн хөгжлийн банкнаас санхүүжүүлнэ гээд Говь-Алтай, Завхан 2-ын дунд 18км л санхүүжилтийн дутуу байсан шүү дээ. Тэгээд яагаад өнөөдөр энэ 42 болчихсон юм.

Л.Мөнхбаатар: Баярсайхан гишүүний асуултад нэмж хариулъя. Батболд дарга хариулъя. Ажлын хэсгийн 91 дүгээр микрофоныг өгье.

С.Батболд: Баярсайхан гишүүний асуултад хариулъя. Бид нар түрүүн хэлсэн 142 төсөл явуулснаас энэ хасагдаад 36 төсөл болсон гэдгийг хэлсэн. Тэгэхээр манайхаас бол бид нар зурагтай, төсөвтэй бүх л ажлаа явуулж байгаа. Тэгээд сая энэ Сангийн яамныхны тэр шалгуур үзүүлэлтээр ингээд хасагдаж байгаа байх. Тэр Арц суурь энэ тэрийнх бид нар Азийн хөгжлийн банктай ярьж байгаад 4 дэх шатын төсөл бол 2024 биш 2025 онд хэрэгжүүлэх төсөл явж байгаа.

Тэр дотор яригдаж явж байгаа асуудал байгаа.

Л.Мөнхбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Санал хураалт явагдана. Одоо дэмжсэн 3, дэмжээгүй 3 хүртэл гишүүн үг хэлж болно. Нийтдээ 28 санал санал хураалт явагдахаар байгаа шүү. Үг хэлэх гишүүн байна уу. Алга байна. Жигжидийн Батжаргал гишүүнээр тасаллаа. Гонгорын Дамдинням гишүүн үг хэлье.

Г.Дамдинням: Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай асуудал бид нар хэлэлцэж байна. Тэгээд би сая асуулт дээр асуусангүй ээ. Асуугаад ч яах юм. Яриад л яваад байдаг юм. Сайд нь солигдоод тэгээд бас үйл ажиллагаа нь жоохон гайгүй эрчимжээд явж байгаа Зам, тээврийн хөгжлийн яамныхан минь энэ жил энэ Дарханы замаа нэг дуусгаж өгөөрэй. Байнга хэлж байгаа. Хуучин байсан хэмжээтэй нь ижилхэн урсгалыг бол холбоод өгчихсөн байгаа. Энэ дээрээ санаа амраад зарим хэсэг дээрээ бол ажил жоохон эрчимтэй явж байгаа, зарим хэсэг дээр явахгүй байгаа шүү. Явахгүй байгаа. Та нар мэдэж байгаа. Ажлаа эрчимжүүлээрэй. Үгүй бол тэгээд л ярьдгаараа яриад л орилоод л явах л байх даа. Та нарыг шахаж шаардахаас ч өөр ажил алга. Би ямар Зам, тээврийн сайд ч биш. Тэгэхдээ та нар бас энэ ажлаа дуусгачих хэрэгтэй шүү дээ. 6 жил боллоо. Одоо ингээд 7 дахь руугаа орлоо. 410-хан километр зам. Ичиж үхмээр байхгүй юу. Тэгээд бас Зам, тээврийн яамныхаа энэ жилийн үнэлгээг хараарай та нар бас их өндөр байгаа юм. 1 дүгээр асуудал энэ. Энэ дээрээ ажиллаарай, сануулчихъя. Салахгүй шүү.

2 дугаар асуудал энэ Хүнс, хөдөө аж ахуйн яамныхан бас энэ Хэрэг эрхлэх газрынхан ч гэсэн оролцох ёстой болов уу. Энэ Дарханы арьс ширний цогцолбор байгаа юм. Сая Их Хурлын гишүүд тойроод орон нутгаар явахад бол бас Дарханы арьс ширний цогцолборыг дан

ганц Дарханы иргэд нэхээд байгаа юм биш. Хөдөө орон нутагт байгаа малтай бүхий л ард иргэд нэхэж байгаа юм. Тэгэхээр энэ арьс ширний цогцолбор бол дан ганц Дарханд ажлын байр нэмэгдэх гээд байгаадаа биш Монгол орны энэ хөдөө аж ахуй, мал аж ахуйн бараа бүтээгдэхүүнийг л үнэд оруулах гээд байгаа ийм л чухал үйлдвэр шүү дээ. Тэгээд энэ дээр Засгийн газар бас энэ холбогдох яамдууд санаачилгатай ажиллаарай. Ингээд 2024 он боллоо. Бид нар 2020 онд орж ирээд л Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн төлөвлөгөө батлаад л, тэгээд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлаад л явсан. Жил болгон тусна, жил болгон дандаа нэг шалтгаан хэлээд л хойшоо явна. Одоо жил хүрэхгүй хугацааны дараа сонгууль боллоо. Хийгдсэн юм юу ч байхгүй. Юугаа хэлж очих юм. Юу ярьж очих юм. Малчдадаа та нар юу хэлж уулзаж байгаа юм манай гишүүд. Засгийн газрынхан бас. Тэгээд энийгээ хийгээрэй. Ядаж нэг ахиц гаргаарай л гэж хүсье дээ. Тэгээд дэмжиж байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Батжаргал гишүүн зарчмын зөрүүтэй санал хураах үед үгээ хэлчихье. Санал хураалтаа явуулна гишүүд ээ.

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулья.

Нэг. Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал байна. Нийтдээ 28 санал байгаа.

Гишүүд картаа сугалахгүй шүү. Яг ирц тулчихсан байгаа шүү. Сая хэн сугалав.

**Эдийн засгийн байнгын хорооны
дэмжсэн санал**

1.Тогтоолын төслийн 2, 3, 4 дүгээр заалтыг 2 дугаар заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасгай:

1/Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд туссан улсын төсвийн эх үүсвэрээр санхүүжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгах;

2/Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд төр, хувийн хэвшлийн түншлэл болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр тусгасан төсөл, арга хэмжээнд шаардагдах бэлтгэл хангаж ажиллах;

3/Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс жигд ханган зохион байгуулж, түүний биелэлтийг бүтэн жилээр гаргаж, Улсын Их Хуралд танилцуулах.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөр, Доржханд, Өнөрболор, Цогтгэрэл, Чинзориг /цаашид ажлын хэсэг/ гэнэ. Санал хураалт. 69,2 хувиар санал дэмжигдлээ.

2.Тогтоолын төсөлд доор дурдсан агуулгатай 3 дахь заалт нэмэх:

“3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ц.Цэрэнпунцаг/-нд даалгасгай.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 78,9 хувиар санал дэмжигдлээ.

3.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын Монгол Улсын 2024 онд

баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн ерөнхий зүйлийн “төлөвлөж хэрэгжүүлэх,” гэсний дараа “нийлүүлэлтийн гаралтай үнийн өсөлтийг хязгаарлах,” гэж нэмж, мөн зүйлийн “мөнгөний бодлогын тохируулгыг оновчтой хийх,” гэснийг “мөнгөний бодлогыг төсвийн бодлоготой уялдуулах,” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг Санал хураалт 76,9 хувиар санал дэмжигдлээ.

Дэлгэрсайхан гишүүн санал хураалтад хүрэлцэн ирлээ.

4.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтад “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудын нөөцийг нарийвчлан тогтоож, эдийн засгийн эргэлтэд оруулах замаар Үндэсний баялгийн сангийн тогтолцоог бий болгоно.” гэсэн агуулгатай 2.3 дахь заалт нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг санал хураалт. 81 хувиар санал дэмжигдлээ.

5.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтад “Гадаргын усны хуримтлалыг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээний судалгаа, шинжилгээний ажлыг эрчимжүүлнэ.” гэсэн агуулгатай 8.1.5 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 83,3 хувиар санал дэмжигдлээ.

6.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.2.1.1 дэх дэд заалтын “Агаарын геофизикийн 1:200000-ны масштабын судалгааны ажлыг гүйцэтгэх” гэснийг “Орчин үеийн дэвшилтэт технологи ашиглан агаарын геофизикийн цогц судалгааны ажлыг гүйцэтгэх” гэж, мөн шалгуур үзүүлэлтийн “Талбай хамрагдалт” гэснийг “Нислэгт хамрагдсан талбай”

гэж, үр дүнгийн үзүүлэлтийн суурь түвшин “66” гэснийг “0” гэж, хүрэх түвшин “100” гэснийг “20” гэж тус тус өөрчлөх;

Санал гаргасан ажлын хэсэг.
Санал хураалт 81 хувиар санал дэмжигдлээ.

7.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.2.2 дахь заалтын “Зэсийн” гэснийг “Зэс, алт, мөнгөний” гэж өөрчилж, мөн заалтад Төсөл арга хэмжээнд “Хармагтайн зэс, алтны болон Асгатын мөнгөний ордыг ашиглалтад оруулах бэлтгэл ажил хангах” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Зорилтот түвшинд “100” гэж, Хариуцагч байгууллагад “УУХҮЯ” гэсэн 2.2.2.2 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг.
Санал хураалт. 74,4 хувиар санал дэмжигдлээ.

8.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.2.3.4 дэх дэд заалтын Хариуцагч байгууллагад “БШУЯ” гэж нэмэх;

Санал гаргасан ажлын хэсэг.
Санал хураалт. 83,7 хувиар санал дэмжигдлээ.

9.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.2.3.8 дахь дэд заалтын Төсөл, арга хэмжээний “парк” гэснийг “паркийн дэд бүтцийг” гэж өөрчлөх;

Санал гаргасан ажлын хэсэг.
Санал хураалт. 86 хувиар санал дэмжигдлээ.

10.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.2.3.9 дэх дэд заалтын Зорилтот түвшингийн “80” гэснийг “60” гэж өөрчлөх;

Санал гаргасан ажлын хэсэг.
Санал хураалт. 83,7 хувиар санал дэмжигдлээ.

11.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.3.2.5 дахь дэд заалтын Зорилтот түвшингийн “50” гэснийг “100” гэж өөрчлөх;

Санал гаргасан ажлын хэсэг.
Санал хураалт 81,4 хувиар санал дэмжигдлээ.

12.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.1.3.1 дэх дэд заалтын Шалгуур үзүүлэлтэд “Судалгаа хөгжүүлэлтийн ажлын үр дүнд бий болсон бүтээгдэхүүнийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлсэн төсөл” гэж, Хэмжих нэгжид “Тоо” гэж, Суурь түвшинд “20” гэж, Зорилтот түвшинд “50” гэж, Санхүүжилтэд “2,500.0” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилалд “Улсын төсөв” гэж, Хариуцагч байгууллагад “БШУЯ” гэж тус тус нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг.
Санал хураалт. 88,1 хувиар санал дэмжигдлээ.

13.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.1.3.1 дэх дэд заалтын Шалгуур үзүүлэлтэд “Үр дүнд суурилсан өрсөлдөөнт болон тогтмол санхүүжилтээр хийгдсэн Шинжлэх ухаан, технологийн /суурь, хэрэглээний, технологи/ судалгаа хөгжүүлэлтийн ажил” гэж, Хэмжих нэгжид “Тоо” гэж, Суурь түвшинд “350” гэж, Зорилтот түвшинд “450” гэж, Санхүүжилтэд “-” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилалд “Улсын төсөв” гэж, Хариуцагч байгууллагад “БШУЯ” гэж тус тус нэмэх;

Санал гаргасан ажлын хэсэг.
Санал хураалт. 88,1 хувиар санал дэмжигдлээ.

14.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.3.1.7 дахь дэд заалтын Санхүүжилтэд “62,493.82” гэснийг “19,388.4” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 83.3 хувиар санал дэмжигдлээ.

15.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 7.4.1.2 дахь дэд заалтын Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилалд “Улсын төсөв” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 85,7 хувиар санал дэмжигдлээ.

16.Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын 3.1.3 дахь заалтын Шалгуур үзүүлэлтэд “Судалгаа хөгжүүлэлтийн ажилд зарцуулах төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувь” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь онд “2022” гэж, Суурь түвшинд “0.13” гэж, Зорилтот түвшинд “0.2” гэж, Мэдээллийн эх сурвалжийг “ҮСХ” гэж, Мэдээлэл цуглуулах арга зүйд “Статистик мэдээ” гэж, Мэдээлэл цуглуулах давтамжид “Жилд нэг удаа” гэж, Хариуцах байгууллагад “БШУЯ” гэж тус тус нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 82,9 хувиар санал дэмжигдлээ.

17.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын Төсөл, арга хэмжээнд “Дорноговь аймгийн Хөвсгөл сумын “Гэрэлт говь” кокс, металлургийн үйлдвэр” үйлдвэрлэл технологийн парк байгуулах” гэж, Бодлогын үндэслэлд “ЗГҮАХ-3.2.7.1” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Үр дүнгийн үзүүлэлтэд 2022 он “-” гэж, 2024 он “100” гэж, Санхүүжилтэд “375 тэрбум төгрөг” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилалд “Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт”

гэж, Хариуцагч байгууллагад “УУХҮЯ” гэсэн 2.2.3.10 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин. Санал хураалт. Санал хураалт 85,4 хувиар санал дэмжигдлээ.

18.Тогтоолын төслийн 2-р хавсралтын Төсөл, арга хэмжээнд “Баруун-Урт-Сүхбаатар чиглэлийн 61.9 км хатуу хучилттай авто зам, 24 у/м гүүр барих /Сүхбаатар-Баруун-Урт, Сүхбаатар сум/” гэж, Санхүүжилтэд “10 тэрбум төгрөг” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэсэн 4.3.1.20 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганибал санал хураалт 85,7 хувиар санал дэмжигдлээ.

19.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын Төсөл, арга хэмжээнд “Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилга барих” гэж, Санхүүжилтэд “25 тэрбум төгрөг” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэсэн 3.3.2 дахь заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн. Санал хураалт 81 хувиар санал дэмжигдлээ.

20.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын Төсөл, арга хэмжээнд “Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн хот хоорондын А0301 авто замаас Өвөрхангай аймгийн Хужирт сумтай холбох авто зам барих” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, суурь түвшин “0” гэж, Зорилтот түвшинд “20” хувь гэж, санхүүжилтэд “28 тэрбум төгрөг” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцагч байгууллагад “ЗТХЯ” гэсэн 4.3.1.20 дахь дэд заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэн, Чинзориг. Санал хураалт 78,6 хувиар санал дэмжигдлээ.

21.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын Төсөл, арга хэмжээнд “Өвөрхангай аймгийн Арвайхээр-Баянгол-Сайхан-Овоо-Мандал-Овоо чиглэлийн хатуу хучилттай авто замын ТЭЗҮ боловсруулах” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, Суурь түвшин “-” гэж, Зорилтот түвшинд “100” хувь гэж, санхүүжилтэд “4 тэрбум төгрөг” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцагч байгууллагад “ЗТХЯ” гэсэн 4.3.1.21 дэх дэд заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэн, Чинзориг. Санал хураалт 73,8 хувиар санал дэмжигдлээ.

22.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.3.2 дахь заалтын Төсөл, арга хэмжээнд “Хөвсгөл аймгийн дулааны станцыг 21 мвт-аар өргөтгөх” гэж, Санхүүжилтэд “16 тэрбум төгрөг”, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж тус тус нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаатар. Лхагвын Мөнхбаатар гуайн гаргасан санал юм байна шүү. Дэмжээрэй. Санал хураалт. 82,5 хувиар санал дэмжигдлээ.

23.Тогтоолын төслийн 2-р хавсралтын 3.3.2.2 дахь дэд заалтын “Улсын төсөв” гэснийг “Төр хувийн хэвилийн түншилэл” гэж, мөн хавсралтын 3.3.2.3 дахь дэд заалтын “Төр хувийн хэвилийн түншилэл” гэснийг “Улсын төсөв” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Содномын Чинзориг. Санал хураалт 76,2 хувиар санал дэмжигдлээ.

24.Тогтоолын төслийн 2-р хавсралтын 4.3.1 дэх заалтын Төсөл, арга

хэмжээнд “Булган-Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг” чиглэлийн 133.7 км хатуу хучилттай автозамын төгсгөл 67.8 км” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “-” гэж зорилтод түвшинд “50” гэж, Санхүүжилтэд “43,677.1” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилалд “Улсын төсөв” гэж, Хариуцагч байгууллагад “ЗТХЯ” гэж тус тус нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ. Санал хураалт 64,3 хувиар санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: 25.Тогтоолын төслийн 2-р хавсралтын 4.3.1.24 дэх дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Улаанбаатар-Шар хөтөл-Эрдэнэт чиглэлийн Төв аймгийн Жаргалант сумын Жаргалантын уулзвараас эхлэлтэй Сэлэнгэ аймгийн Орхон сумын А1001 авто замын Орхон сумын уулзварт төгсөх хатуу хучилттай 100 км авто зам барих” гэж нэмэх, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “-” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Санхүүжилтэд “75.17 тэрбум төгрөг” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Гадаадын зээл” гэж, Хариуцагч байгууллагад “ЗТХЯ” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ. Хавдисламын Баделхан гишүүн үг хэлэх гэсэн байна.

Х.Баделхан: Баярлалаа. Бид манай Засгийн газрын мөрийн хөтөлбөрт орсон, намын мөрийн хөтөлбөрт орсон нутгийн зам төслийн хүрээнд би түрүүн асуусан л даа. 80 км зам байгаа. Сагсай, Улаангус, Цэнгэл чиглэлийн зам гэсэн. Энийг түрүүн Эдийн засгийн байнгын хорооны Эдийн засгийн яамны тэр залуу буруу хэлж байна даа. Зураг төсөл байхгүй байна гэж. Зураг төсөл нь бэлэн. Энийг төсөлд

оруулах талаар та нэг чиглэл өгөөч.
Оруулмаар байна.

Г.Занданшатар: Цэндийн Сандаг-Очир гишүүн ээ. Ингээ ер нь анхны хэлэлцүүлэгт нь буцаах горимын санал гаргая. Энэ Үндсэн хууль хэлэлцэж байх ар хударгаар энэ чинь юу болчихсон юм бэ. Ингээд ийм горимын саналаар санал хураалт явуулна. Анхны хэлэлцүүлэгт буцаах горимын саналаар санал хураалт явуулна. Горимын санал гаргаж байна. Анхны хэлэлцүүлэгт буцаана. Анхны хэлэлцүүлэгт буцаах горимын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Баделхан гишүүн ч санал гаргасан. Энэ үлдсэн 4 саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч байна. Ерөөсөө энэ чинь ингээд Үндсэн хууль хэлэлцэж байх үед давхар хэлэлцсэн учраас бас энэ горимд. Ингээд энийг энэ асуудлыг гишүүд тийм саналтай байна л даа. Үгүй ээ энийг чинь үндэслэж төсөв хийх байхгүй юу.

Ирц байхгүй болсон байна. Цаашаа хэлэлцэх бололцоогүй болсон байна. Энэ чинь хугацаатай учраас 6 сарын 1 гэсэн хугацаатай учраас тэгэхдээ бас арай ч. Энэ асуудал ингээд хойшлогдлоо. Хууль санаачлагч байхгүй учраас.

Даргын дэргэдэх зөвлөлийн хурал хуралдана. Энэ асуудлыг авч хэлэлцэнэ. Даргын дэргэдэх зөвлөлийн гишүүд манай өрөөнд цуглая. Энэ асуудлыг авч хэлэлцэнэ.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Одоо даргын дэргэдэх зөвлөл хуралдана.

/17:27/

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН:ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА